

ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч таны амар амгаланг айлтган мэндчилье!

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Хурал Засаг даргаас эрх хэмжээнийхээ дотор хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэр, тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр байх бөгөөд түүнийг байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ” гэж заасан.

Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн эмхтгэлийг 7дахь удаагаа хэвлүүлэн олон түмэнд хүргүүлж байна.

Энэ эмхтгэлд Сэлэнгэ аймгийн Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс 2011 онд гаргасан нийтээр дагаж мөрдөх бодлогын чанартай тогтоол шийдвэрүүдийг оруулж байна.

Энэ нь нэг талаас Сэлэнгэ аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, гаргасан шийдвэрээ олон түмэнд хүргэх, нөгөө талаас сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийг танилцан судлах, үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ /2011 ОН/**

Сүхбаатар 2011 он

Гарчиг

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол

- 1) Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай
- 2) Ерөөгийн бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай
- 3) Хог хаягдлын норматив, хог хаягдал үүсгэсний төлбөрийн хэмжээ батлах тухай
- 4) Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- 5) Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг батах тухай
- 6) Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээ батлах тухай
- 7) Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ёс зүйн дүрэм батлах тухай
- 8) Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай
- 9) Тэмдэгтийн хураамжийн хэмжээг батлах тухай
- 10) Нэмэгдэл зардлыг санхүүжүүлэх тухай
- 11) Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2011 оны үндсэн чиглэлийн урьдчилсан гүйцэтгэл, 2012 оны үндсэн чиглэлийн төсөл
- 12) Аймгийн 2011 оны төсөвт тодотгол хийх тухай
- 13) Аймгийн 2012 оны төсвийн төсөл
- 14) Сэлэнгийн бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай
- 15) Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай
- 16) Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны ажлын тайлан

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол

- 1) 2011 оныг бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай
- 2) Аймгийн хурдан морины бүсийн уралдаан зохион байгуулах тухай
- 3) Хурдан моринд аймгийн цол олгох журам батлах тухай
- 4) Аймгийн хурдан морины эрсдлийн үнэлгээ тогтоох тухай
- 5) 2011 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай
- 6) Аймгийн Хүндэт тэмдэг бий болгох тухай
- 7) Ой тэмдэглэх тухай
- 8) Ой тэмдэглэх тухай
- 9) Зарим эхчүүдийг Алдарт эхийн одонгоор шагнуулах тухай
- 10) 2011 онд агнах, барих амьтны тоо тогтоох тухай
- 11) Хөтөлбөр батлах тухай
- 12) Журам батлах тухай
- 13) Иргэний танхим ажиллуулах тухай
- 14) Сүм байгуулах зөвшөөрөл олгох тухай
- 15) Таван хан уулсыг тахих тухай
- 16) Чацаргана дэд хөтөлбөр батлах тухай
- 17) Зөвшөөрөл олгох тухай
- 18) Ой тэмдэглэх тухай
- 19) Ашиглалтгүй барилгуудыг актлах тухай
- 20) Үндсэн хөрөнгийг шилжүүлэх тухай
- 21) Г.Бумцэндийн нэрэмжит болгох тухай
- 22) Аймгийн Хүндэт тэмдэгийг загвар батлах тухай
- 23) Баяр наадмын төсөв батлах тухай
- 24) Хөрөнгө зөвшөөрөх тухай
- 25) Хөрөнгө зөвшөөрөх тухай
- 26) Төсвөөс хөрөнгө гаргах тухай
- 27) Төлбөрийн хэмжээг бууруулах тухай

- 28) Мэргэжлийн комисс байгуулах тухай
- 29) Зарим эхчүүдийг эхийн алдар одонгоор шагнуулах тухай
- 30) Сэлэнгэ аймгийн Хүндэт иргэнээр өргөмжлөх тухай
- 31) Татварын орлогын бүрдүүлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- 32) Журам батлах тухай
- 33) Удирдамж батлах тухай
- 34) Ашиглалтгүй барилгыг худалдах тухай
- 35) Төлөвлөгөө батлах тухай
- 36) Сумдын ИТХ-ын ажлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай
- 37) Ой тэмдэглэх тухай
- 38) Ойн дэд хөтөлбөр батлах тухай
- 39) Сүм хийдийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- 40) Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай
- 41) 2012 онд үйлдвэрлэлийн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай
- 42) Аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай
- 43) Сүхбаатар сумын иргэдийн түлшний хэрэгцээг хангах зарим арга хэмжээний тухай
- 44) Аудитын газрын 2011 оны ажлын тайлангийн тухай
- 45) Ахмадын талаар авах зарим арга хэмжээний тухай
- 46) Барилга шилжүүлэх тухай
- 47) Ашиглалтгүй барилгыг худалдах тухай

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол

Сүлд

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 57

Сүхбаатар

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнгийн тухай аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбатын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТЭМДЭГЛЭХ НЬ:

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдэд тодорхой ахиц дэвшил гарч, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ нэмэгдэж, иргэдийн амьжиргааны түвшин дээшилж, аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2010 оны гүйцэтгэл 95.2 хувьтай, нийт хөтөлбөрийн гүйцэтгэл 72.8 хувьтай байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д” заалтыг үндэслэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэсүгэй.

2.Сонгуулийн бүрэн эрхийн үлдэж буй хугацаанд аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийг жигд хангаж, иргэнээ дэмжин өрх гэрээ тэтгэх, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлж байгаа ажлаа эрчимжүүлэн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил арга хэмжээг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбатад даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 58

Сүхбаатар

Ерөөгийн бүсийн хөгжлийн
хөтөлбөр батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 18, 2007 оны 38-р тогтоолуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.“Ерөөгийн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх зорилтуудыг бүсийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиг баримжаа болгон, хэрэгжүүлэх арга хэмжээг бүсийн сумдын хөгжлийн хөтөлбөр болон жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг Ерөөгийн бүсийн зөвлөл болон бүсийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.

3.Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

УДИРТГАЛ

Аймаг орон нутгийн хөгжлийн явц, үр дүнд үнэлгээ дүгнэлт хийж, хөгжлийн хэтийн төлөвийг тооцож, ирээдүйгээ илүү итгэлтэй харах боломжиндоо тулгуурласан урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагын үүднээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийн дагуу “Аймгийн 2021 он хүртлэх хөгжлийн хөтөлбөр”-ийг үндэслэж “Ерөөгийн бүс”-ийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулаа.

Ерөөгийн бүс нь 1.222.8 мянган га нутаг дэвсгэртэй 3 сум, 6 баг, нэг тосгонтой. 2011 оны 01-р сарын 07-ны байдлаар хүн амын тоо 10652 мянгад хүрсэн нь аймгийн нийт хүн амын 11.6 хувийг эзэлж байна.

“Карников” нэртэйгээр Ерөө сум 1924 онд, Хүдэр сум 1972 онд, Жавхлант сум 1976 онд тус тус байгуулагдсан түүхтэй. Ерөөгийн бүс нутагт аймгийн бүх газар нутгийн 29.7%, ойн нөөцийн 18.5 %, урсгал усны 25% шахам хувь энэ бүс нутагт ноогддог.

Ерөөгийн бүс нь хүн амын нягтрал багатай бүсэд тооцогддог бөгөөд Монгол Улсын дундажаар нэг хүнд 61 га газар, Сэлэнгэ аймагт 44.7 га, Ерөөгийн бүс нутагт 126 га газар тус тус ноогдож байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар 1000 хүнд ноогдох төрөлт 16.7%, нас баралт нь 5.4%, хүн амын жилийн цэвэр өсөлт 11.3% -аар өсч байна.

2010 оны Статистикийн судалгаанаас үзэхэд бүсийн хэмжээнд 143.4 мянган толгой мал тоологдсоноос малын тоо толгойг төрлөөр нь авч үзвэл:

- Тэмээ 0.004%
- Адуу 5.7 %
- үхэр 14.6%
- Хонь 56.7%
- Ямаа 22.8%-ийг тус тус эзэлж байна.

Аймгаас баримталж байгаа бодлого чиглэлийн дагуу Ерөөгийн бүсэд цэвэр эрлийз болон шилмэл омгийн малын өсөлт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа төдийгүй өнгөрсөн оны мал тооллогоор нийт малд эзлэх цэвэр эрлийз болон шилмэл омгийн мал 31.3 хувь буюу 60.8 мянган толгой хүрээд байна.

Сүүлийн үед уг бүс нутагт баруун аймгийн мал бүхий иргэдийн нүүдэл ихсэж болсон, нь малын тоо өссөнтэй холбогдуулан ургамлын бүтцэд өөрчлөлт орж, байгалийн нөхөн төлжих чадвар алдагдаж, олон төрлийн ургамал сүйдэж, малын бэлчээр, тэжээлийн нөөц хомсдох аюул тулгараад байна.

Иймээс Ерөөгийн бүс нутаг нь бүхэлдээ газар тариалан давамгайлсан бүс нутаг учирмал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Ерөөгийн бүс нь аймагтаа үр тарианы үйлдвэрлэлээр дээгүүрт ордог бүс нутгийн нэг төдийгүй, төмс, хүнсний ногоо үйлдвэрлэлт, мал аж ахуй болонуул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээрээ аймагтаа тэргүүлдэг бүс нутаг юм.

Ерөөгийн бүс нь жилд дунджаар 37.0 мянган тн үр тариа, 3.6 мянган тн төмс, 5.2 мянган тн хүнсний ногоо хураан авч аймгийн нийт төмсний ургацын 10.7 хувь, хүнсний ногооны 23.2 хувийг дангаараа үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна.

Ерөөгийн бүс нутагт Монгол Улсын төмөрлөгийн анхны үйлдвэрлэл болох Төмөртэйн хүдрийн орд, БТЕГ ХХК, жилдээ алтны 18-21 аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж, жилдээ 1.8 сая тн төмрийн хүдэр, 130-150 кг алт олборлож байна.

Ерөөгийн бүсийн алсын хараа нь төмөртэй хүдрийн орд газрыг түшиглэсэн аж үйлдвэрийн цогцолбор болгон хөгжүүлж, орчин үеийн төв суурин газрыг бий болгож, эрчимжсэн мал аж ахуй газар тариаланг хослон хөгжүүлэхэд оршино.

Энэ байр сууринаас хандаж боловсруулсан хөгжлийн хөтөлбөр нь :

- ❖ Эдийн засгийн бодлого
- ❖ Нийгмийн бодлого
- ❖ Засаглалын бодлого гэсэн 3 хэсгээс бүрдэж байгаа юм.

Ерөө бүсийн хөгжлийн хэтийн төлвийг 2011-2015,2016-2021 он гэсэн 2 үе шаттайгаар тодорхойлсон.

Хөгжлийн нэгдүгээр үе шат болох (2011-2016 он)–нуудад аж үйлдвэрийн бүс нутаг болгох үйлдвэрлэлийн суурийг бэхжүүлэн эдийн засгийн тогтвортой өсөлт хангаж, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

Хөгжлийн хоёрдугаар үе шат (2017-2021 он)–нуудад бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нэмэгдэж, эдийн засаг тогтворжиж, аж үйлдвэрийн бүсийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэн, орчин үеийн төв суурин газрыг бий болгон иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдэж чадна.

Нэг: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

1. Аж үйлдвэрийн салбар

Тэргүүлэх зорилт: Ерөөгийн бүсэд эдийн засгийн өндөр ач холбогдолтой ашигт малтмалыг олборлох болон боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар бүсийн болон аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний дундаж өсөлтийг нэмэгдүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат (2010-2015 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төмрийн хүдэр олборлох болон эдгээр ашигт малтмалыг боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг бий болгох.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх
- Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын ажил уурхайн олборлох технологид орон нутгийн газар ашиглалтын бодлогод тохируулсан нэгдсэн журам стандартыг мөрдүүлэх;

Хүрэх үр дүн: Эдийн засагт уул уурхайн салбарын оруулах хувь нэмэр өсөн нэмэгдэж, бүсийн хөгжлийн эдийн засгийн чадамж нэмэгдэж, боловсруулах аж үйлдвэрт дэвшилтэт технологи нэвтэрч, үйлдвэрлэл өснө.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх;

- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдийг өндөр технологи хэрэглэн бүрэн боловсруулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын зах зээлд нийлүүлэн өрсөлдөх;

Хүрэх үр дүн: Бүсийн барилгын салбарын үйлдвэр хөгжиж, уул уурхайн салбарын хөгжлийг дагасан жижиг дунд үйлдвэр хөгжиж, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж дотоодын зах зээлд өрсөлдөж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана.

2. Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

2.1 үр тарианы үйлдвэрлэл

Хөгжлийн 1-р шат / 2011-2015 он/

Тэргүүлэх зорилт: Тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж, энэ салбарын эдийн засгийн хөгжлийн таатай орчныг бий болгож, техник тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж, хураах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Газар тариалангийн үйлдвэрлэлд газар ашиглалт, шинэ техник технологийн шинэчлэлийн бодлого зохицуулалтын арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэх
- Бүсийн төд Хөдөө Аж Ахуйн техник засвар үйлчилгээний паркийг байгуулах
- Бүс нутагт улаан буудай, төмс, хүнсний ногооны элит үрийн аж ахуй эрхлэх компанийг хувийн ба төрийн өмчийн оролцоотой байгуулж, энэ төрлийн аж ахуй эрхлэгчдийг үрээр хангах нөхцөл бололцоог бүрдүүлэх
- Жавхлант сумыг хүлэмжийн аж ахуйн чиглэлээр хөгжүүлж, таримлын ургалтын хугацааг хурдасгах, ногоочдын орлогыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн фермерүүд бий болгоход хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, лизингээр болон түрээсээр өрхийн аж ахуй эрхлэгчдийг жижиг оврын трактороор бүрэн хангах ажлыг зохион байгуулах
- Зах зээлийн эрэлтэд нийцсэн шинэ нэр төрлийн таримлын сортыг тариалж, гадаад зах зээлд нийлүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирч тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн чадавхи нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат / 2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Тариалангийн үйлдвэрлэлд технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэх.
- Усалгаатай тариалангийн талбайг 1000 га-д хүргэж, баталгаатай ургац авах нөхцөлийг бүрдүүлж, цагаан будаа, гурвалжин будаа тариалах боломжийг бүрдүүлэх
- Тариалангийн ээлжлэн тариалах системийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх.
- Бүсийн төвд төмс, хүнсний ногоо, үр тариа тариалдаг иргэдэд техник үйлчилгээ үзүүлдэг “Техник үйлчилгээний төв”-ийг байгуулж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах

- Тракторч, комбайнч ба засвар үйлчилгээний мэргэжилтэй техникийн дунд боловсролтой ажилчдыг бэлтгэх сургалтын анги, танхимыг Ерөө бүсийн ХАА-н техник засвар үйлчилгээний төвийг түшиглэн байгуулж, орон нутагтаа мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх

Хүрэх үр дүн: ХАА-н машин техникийн хангамж, ашиглалт нэмэгдэж, техник-технологийн нэвтрүүлэлт сайжирч нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдана.

2.2 Мал аж ахуйн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р шат / 2011 -2015 /

Тэргүүлэх зорилт-1: Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барьж ашиг шим өндөртэй сайн үүлдрийн болон нутгийн шилмэл малыг тэжээл үйлдвэрлэлтэй хослуулан түлхүү хөгжүүлж, суурин ба хагас суурин хэлбэрээр мал аж ахуйг төрөлжүүлэн, бэлчээрийг зүй зохистой ашиглах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бусад аймаг, сумдаас нүүдэлэн ирж буй малчин айл өрхийн нүүдэл, суурьшлыг зохицуулах бодлогын арга хэмжээг боловсруулж дээд шатны байгууллагад санал уламжлаж, хэрэгжүүлэх арга хэмжээг авах.
- Мал аж ахуй салбар сайн үүлдрийн ба эрлийз мал сүргийг нийт малын тоо толгойг 70 хувь хүртэл нэмэгдүүлж, ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах бодлогыг баримтлах
- Сүү-мах, мах – сүүний үүлдрийн үхэр, гахай, шувуу, зөгий, туулай үржүүлэх чиглэлээр фермерийн болон өрхийн аж ахуй эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх, дотооддоо малын тэжээл үйлдвэрлэдэг цех байгуулах.
- Хүдэр суманд махны чиглэлийн лимузин үхэр үржүүлэх фермерийн аж ахуйг байгуулах
- Цөм сүрэг ба үржлийн хээлтүүлэгчийг өсгөх, бойжуулах, гүн хөлдөөсөн үрийг ашиглан зохиомол хээлтүүлэгийн үйлчилгээ эрхлэх зэрэг ажлыг шилдэг туршлагатай малчдын өрхийн аж ахуйн чадварлаг фермерүүдэд төрөлжүүлэн эрхлэх, материалаг нөхцлийг бүрдүүлэх
- Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох.
- Малын гаралтай түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг цех, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх.

Үр дүн: Эрчимжсэн мал аж ахуй, суурин болон хагас суурин фермерийн тоо тогтмол нэмэгдэж, бэлчээрийн доройтол багасан, бэлчээр ашиглалт малын чанар сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат / 2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хонины аж ахуйн чиглэлээр Орхон, Ерөө, Хангай, Баяд үүлдэрийн хонийг өсгөж, төрөлжүүлэх фермерийн аж ахуйг Жавхлант, Ерөө суманд хэрэгжүүлэх.
- Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн лабораторийн материаллаг бааз, эмийн хангамжийг бэхжүүлж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах замаар оношлогоо, шинжилгээг орон нутагтаа хийх.

Хүрэн үр дүн: Эрчимжсэн суурин маллагаатай шинэ хэлбэрийн хувийн хэвшлийн мал аж ахуйн суурь тавигдаж мах, сүүний үйлдвэрлэл сайжирна.

3. Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат / 2011-2015 он/

Тэргүүлэх зорилт-1: Жижиг дунд үйлдвэрлэлийг Ерөөгийн бүсийн тэргүүлэх чиглэлийн салбар болгон хөгжүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жимс, жимсгэнэ, самар, эмийн ургамал боловсруулах үйлдвэр, цехийг Хүдэр сумыг түшиглэн байгуулах
- Мод, модон материалаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг Бугант тосгоныг түшиглэн байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах
- Төмс, хүнсний ногоог жижиглэнгээр савлаж борлуулах цехийг байгуулж, Улаанбаатар хотын сүлжээ дэлгүүрүүдтэй гэрээ байгуулан нийлүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах
- Уул уурхайн үйлдвэрлэлийг дагасан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, туслах эд анги үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгоход бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэх
- Экспортын баримжаатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжих
- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа ажил үйлчилгээ худалдан авахад жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг оролцуулах.
- Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх бааз суурийг өрхийн аж ахуй эрхлэх замаар бий болгох.
- Сүү, төмс, хүнсний ногоо, мах боловсруулах, шахмал түлш, мал бордох, зоорины аж ахуй эрхлэх, жимс, жимсгэнэ тариалах, модны тарьц суулгац ургуулах, ноос боловсруулах, модон эдлэл, оёдлын үйлдвэрлэл эрхлэх аж ахуйг хөгжүүлэх.
- Гурил, гурилан бүтээгдэхүүн, жижиг, дунд үйлдвэрлэлийг байгуулах замаар бүсийн сум орон нутгийн хэрэгцээг бүрэн хангах

Хүрэх үр дүн: Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдэж, албан секторт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдэж, татварын бааз суурь өргөжнө.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэжээ:

- Том үйлдвэрүүдийн хэрэглээний жижиг хангамжийн үйлдвэрлэлийг гэрээгээр гүйцэтгэх үйлдвэрлэлийг бий болгох
- Уул уурхайн үйлдвэрлэлийг түшиглэн хэрэглээний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Хог боловсруулах үйлдвэрийг бүсийн сумдын төв хогийн цэгт байгуулан үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлэх

Хүрэх үр дүн: Өндөр түвшинд хүрсэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ бий болж, ажлын байр нэмэгдэнэ.

4. Өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Тэргүүлэх зорилт-1. Өрхийн аж ахуйг таатай орчинг бий болгож, ажилгүйдлийг бууруулж, иргэдийн амьжиргааны чадавхийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг зээлийн үйлчилгээ буюу бичил санхүү, зээлийн зуучлалын үйлчилгээг өрхийн үйлдвэрлэл үү чиглүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.
- Бүсийн иргэдийг модны тарьц, суулгац тарих, ургуулсан тарьцаа худалдах, ойжуулалтын ажлын төсөлд хамрагдах санаачлагад дэмжлэг үзүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх
- Гахай тахиа, зөгий, туулайны аж ахуй эрхлэх санал санаачлагыг дэмжих
- Хүдэр суманд загасны аж ахуйг бий болгох
- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор баг бүрт хөгжлийн сан байгуулах
- Барилгын модон материалыг орлох тоосго, блокны жижиг оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Ажлын байр шинээр нэмэгдэж, өрхийн аж ахуй эрхлэх, амьдралаа сонирхолтой иргэн бүрийн өмнө адил тэгш боломж нээгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Тэргүүлэх зорилт. Өрхийн аж ахуй эрхлэгч нь өөрийгөө тэтгэх чадвараа нэмэгдүүлж, зах зээлийн бие даасан харилцаанд оролцон үйлдвэрлэлээ өрөгжүүлэн аж ахуйн нэгж, пүүс компанийн зохион байгуулалтанд орох нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн аж ахуйд бүтээгдсэн хүнсний бүтээгдэхүүнийг нийслэл, бусад аймгуудад борлуулах боломж бүрдүүлэх.
- Өрхийн аж ахуй эрхлэгчид хорших, хамтрах замаар жижиг дунд үйлдвэр байгуулах, цаашлаад аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд орж, үйлдвэрлэлээ өргөжүүлэх нөхцөл бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Өрхийн аж ахуйн нэгжийн тоо, үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо, чанарын бүтэцэд өөрчлөлт орж ажилгүйдэл багассан байна. Хүн амын амьжиргааны түвшин дээшилж, чинээлэг фермерийн эзэд бий болсон байна.

5. Худалдаа үйлчилгээний хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн:

Хөгжлийн 1-р шат: / 2010 – 2015 /

Тэргүүлэх зорилт: Бүсийн хэмжээнд хүнсний барааны хангамж, хэрэглээний бүтцийг өөрчлөн сайжруулж, хүнсний болон ахуйн шинэ зохистой үйлчилгээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ, түүхий эдийн зах, үйлчилгээг хөгжүүлэх.
- Баяжуулсан болон зориулалтын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх.
- Худалдаа ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэг салбарын тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ стандартын шаардалаг хангасан хүнсний захтай болох
- Олон улсын стандартын шаардлага хангасан зочид буудлын тоог нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний баталгаат байдал хангагдаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээ сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат: /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт. Бүсийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж, хэрэглээний бүтцийг нийгмийн эрүүл мэндийн шаардлагад нийцүүлж боловсруулдаг болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хүнсний шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах.
- Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг бүлгийн хүмүүсийн хоол тэжээлийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг бий болгох.

Хүрэх үр дүн: Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хангамж, цөцгийн тосны хэрэгцээг бүрэн хангана.

6. Байгаль орчны бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

6.1 Агаар, ус, хөрс

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015/

Тэргүүлэх зорилт: Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдлын хэмжээг бууруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Агаар, ус, хөрсний бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт тавьж ажиллах.
- Хог хаягдал шатаах, бохир усыг ил задгай хаяхыг бүр мөсөн зогсооход
- Хог хаягдлыг ялган зөөх, тээвэрлэх, устгах, боловсруулах анхан шатны үйл ажиллагааг эхлүүлэх
- Түлшний шинэ технологи нэвтрүүлэх модыг түлшний хэрэглээнээс хасах чиглэлээр тодорхой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Хот суурингийн замыг цардах, ногоон байгууламжийг өргөтгөх замаар тоос дэгдэлтийг бууруулах.

Хүрэх үр дүн: Ард иргэдийн цэвэр аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Авто тээврийн хэрэгслээс гарч буй угаарын хийн зөвшөөрөгдөх хэмжээ, стандартад тавих байгаль орчны болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын үйл ажиллагааг сайжруулах, тоос дэгдэлтийг бууруулах замаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- Стандартад нийцсэн хог хаягдлын төвлөрсөн хогийн цэгийн тоог нэмэгдүүлэх, хамгаалалттай болгох

Хүрэх үр дүн: Байгаль орчны болон уур амьсгалын төлөв байдалд тавих хяналт сайжирч, иргэдийн идэвхи санаачилга нэмэгдэнэ.

6.2 Усны нөөц

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн нутаг дэвсгэрийн усны нөөцийг тогтоох усны эх үүсвэрийн тооллого явуулж уст цэгийн ашиглалт, хамгаалалтанд үзлэг судалгаа хийх

- Олон улсын болон ТББ-тай хамтран гадаргын усны бохирдолтын түвшинг тодорхойлох
- Ширгэж буй булаг шанд болон гол горхины эх ундаргыг хашиж хамгаалах, сэргээх ажлыг зохион байгуулах
- Усны нөөцөд түшиглэн экологид хоргүй услалтын систем барих, шинэчлэх замаар усалгаатай газар тариалан нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Усны нөөц тогтоосноор усыг, зөв зохистой ашиглах, усны чанарыг хамгаалах, хүн амыг цэвэр аюулгүй баталгаатай усаар хангах, хөдөө аж ахуйд усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэн хүн амын амжиргаа дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах хяналт зохион байгуулалтын бүтцийг бий болгож сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Рашаан, булаг шандын усны эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж экологийн ач холбогдол бүхий усны эх үүсвэрийг хамгаалтанд авах
- Орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хур тунадас үерийн усыг хуримтлуулан газар тариаланд ашиглах

Хүрэх үр дүн: Усны нөөцийг байгалийн аясаар нөхөн сэргээх нөхцөл бүрдэнэ.

6.3 Ойн нөөц

Хөгжлийн 1-р үе шат: /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жил бүр ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулж ойн хортон шавьжтай тэмцэх, устгах ажлыг нэмэгдүүлэх
- Ойн санг эзэмших, хамгаалах, нөхөн сэргээх иргэдийн нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх
- Хууль бус мод бэлтгэх, тээвэрлэхийг бүрэн зогсоох
- Жил бүрийн нийтээр мод тарих өдрийг хавар, намрын улиралд 2 удаа өрнүүлж, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээг авах
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байнгын эргүүл ажиллуулж, түймэр унтраах багаж хэрэгслээр хангах
- Ойн түймэр, хөнөөлт шавьжийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх
- Ойн өсөлтөнд тохируулан шинэ техник технологиор ойг ашиглах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Ойн химийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого барьж ажиллах
- Одоо байгаа мод үржүүлгийн газрын тоог нэмэгдүүлж, тарьц суулгацын чанарыг сайжруулах, гоёл чимэглэлийн модлог ургамлын суулгацыг бэлтгэх эхлэх
- Ойн ангийн үйл ажиллагааг сайжруулах, өргөтгөх
- Бүсийн хэмжээнд Ойн болон байгаль орчны мэдээллийн санг байгуулах

Хүрэх үр дүн: Ойн нөөц нэмэгдэж, зөв зохистой ашиглалт, байгалийн аясаар нөхөн сэргээгдэх нөхцөл бүрдэж, ойн химийн үйлдвэрлэлийн эхлэл тавигдана

Хөгжлийн 2-р үе шат: /2016-2021/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Уур амьсгалыг зөөлрүүлж хөрсний эвдрэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, ногоон зурвас байгуулах
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын чадавхийг дээшлүүлэх, шаардлагатай техник хэрэгслээр хангах
- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг нэвтрүүлэх
- Ойн нөөцийн ашиглалтыг сайжруулан дотоодын болон бусад орон нутгийн хэрэгцээг хангах
- Ойн ангийг түшиглэн хортон шавьжтай тэмцэх хэсэг байгуулах

Хүрэх үр дүн: Ойн нөөцийн хэвийн ургах нөхцөл бүрдэж, экологийн тэнцвэр хангагдана.

6.4 Биологийн төрөл

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Нэн ховор болон ховор амьтан болон өвс ургамлын тогтвортой байдал, хэвийн өсөлт, ургамалжилтыг хангахтай холбогдсон бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх
- Хуш, жодоо, гацуур зэрэг ховор модлог ургамал болон Хонин нуга орчмоос шинээр нээгдсэн биологийн зарим төрөл зүйлийг хамгаалах, үржүүлэх, нөхөн сэргээх

Хүрэх үр дүн: Устах аюулд орсон ахуйн ач холбогдолтой ан амьтан, ургамлыг зориудаар өсгөж үржүүлэх ажилд ахиц гарна.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он /

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутгийн байгалийн нөөц баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр судалгааг явуулж мэдээллийн санг бүрдүүлэх
- Сүүлийн үед ховордож байгаа ан амьтан, ургамлын нөөцийг тодорхойлж тэдгээрийг агнаж ашиглахыг хориглож шинжлэх ухааны үндэслэлтэй өсгөн үржүүлэх, аясаар нь ургах бодлого баримтлах

Хүрэх үр дүн: Орон нутгийн байгалийн экосистемийн тэнцлийг алдагдуулахгүйгээр байгалийн аясаар нөхөн сэргээх, үржих нөхцөлийг бүрдүүлж зүй зохистой ашиглах, хамгаалах ажил сайжирна.

6.5 Байгалийн эрсдэл

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгалийн аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолж, ард иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй хүргэх нөхцлийг бүрдүүлэх
- Байгаль цаг уурын онц ноцтой үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны тусламж болон хүнс, өвс тэжээл, техникийн бэлэн байдал, шатах тослох материалын байнгын нөөцтэй болох
- Хорт ургамал, шавьжийн голомт, хүн малын гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хүн, мал эмнэлгийг чадавхижуулах
- Байгалийн гамшигтай тэмцэх техник хэрэгсэлийг шинэчлэх

Хүрэх үр дүн: Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлж, учирч болох эрсдэлийг бууруулна.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он /

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгаль цаг уурын онц ноцтой үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны тусламж болон хүнс , өвс тэжээлийн байнгын нөөцтэй болох
- Байгалийн гамшиг ослын үед ажиллах техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх
- Байгалийн гамшгийн үед ажиллах техникийн бэлэн байдал, шатах тослох материалын нөөцийг байнга бэлэн байлгах

Хүрэх үр дүн: Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, хохиролыг бууруулах, шуурхай арилгах тогтолцоо бүрдсэн байна.

6.6 Газрын харилцаа

Хөгжлийн нэгдүгээр үе шат /2011-2015 он /

Тэргүүлэх зорилт: Аймаг, бүс, сумын түвшинд газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, эрх зүйн мэдээллийн санг бий болгож, газрын харьцааны асуудлыг төрийн зохицуулалтаар хөтлөнө.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
- Газрын нөөцийн менежментийг сайжруулж газрын мэргэжилтнүүдийг орчин үеийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах
- Тариалан болон суурин газарт кадастрын зураглал хийж эрх зүйн баталгаагаар ханган улсын бүртгэлд бүртгэж “Үндэсний газрын мэдээллийн сан” –гийн эх суурийг тавих.
- Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган бэлчээрийн газрыг малчин өрх, хот айлаар нь хувиарлан гэрээгээр ашиглуулах
- Эрчимжсэн мал аж ахуйн бүсийг тогтоож, фермерийн аж ахуйг эрхлэгчдэд газрыг нь эзэмшүүлэх.

Хүрэх үр дүн: Сумын газар зохион байгуулалтын жил жилийн төлөвлөгөө бодитой төлөвлөгдөж, газар ашиглалт хамгаалалтын түвшин сайжирч орчин үеийн багаж техникээр хангагдана

Тэргүүлэх зорилт-2: Бэлчээрийн талхагдал, хөрсний элэгдэл, эвдрэлд орсон талбайн ашиглалт, сайжруулалтыг төрийн хяналтанд байлгаж зохицуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бэлчээр ашиглалтыг харуулсан зураг хийж талхлагдсан бэлчээрийг чөлөөлөх, сайжруулах арга механизмыг оновчтой төлөвлөх нөхцлийг бүрдүүлэх
- Элэгдэл, эвдрэлд орсон тариалангийн талбай болон атаржсан газрыг нэрвэгдэлтийн зэргээр нь ялгаварлан тогтоож, шатлан сайжруулж, хөрсжүүлэх, олон наст тариалах төлөвлөгөөг бүс, сум, газар эзэмшигч байгууллага, иргэдийн хүчээр хийлгэж тогтмолжуулах
- Тариаланчад ашиглах боломжгүй талбайг эргэлтээс хасч, олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд оруулах
- Тариалангийн газрын хөрсийг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалж зурваслан тариалалтыг нийт эргэлтийн талбайн 70 хувьд хүртэл хамруулах

- Тариалангийн талбайн чийгийн алдагдлыг багасгах, салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалж сүрлийг хэрчиж хучих арга хэмжээг авч хэрэгжүүлэн нийт эргэлтийн талбайн 60 хувийг хамгаалах
- Хот суурин газарт газар эзэмшигчдийн эзэмшил газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгох арга хэмжээг газар эзэмших гэрээнд тусгаж хэрэгжүүлэх
- Хортон мэрэгчид, хөнөөлт шавьжны тархалтыг зогсоох, хор хөнөөлийг багасгах арга хэмжээг иргэд, аж ахуй нэгж, байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах арга хэмжээг авах.

Хүрэх үр дүн: Хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах, зардал бага шаардах арга хэмжээнүүд хэрэгжиж нөхөн сэргээлтийн ажил тогтмолжин, үржил шимтэй хөрсний алагдал харьцангуй багасна.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он /

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ХАА-н эдэлбэр газрын ашиглалтын төрөл тус бүрээр экологи-эдийн засгийн үнэлгээг хийж газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах
- Хөрсний үржил шимийг дээшлүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх
- Экологийн гаралтай бордоогоор хангаж, хэрэглэж сурах
- Газрын рентийг тодорхойлж иргэдэд мэдээллээр нээлттэй үйлчлэх.
- Газар түрээслүүлэгч, түрээслэгчдийн хоорондын харилцааны эрх зүйг боловсронгуй болгох
- Газрын биржийн үйл ажиллагааны эх суурийг бий болгох

Хүрэх үр дүн: Газартай харилцагчид кадастрын зургаар бүрэн хангагдаж ХАА-н бүтээгдэхүүнд экологи-эдийн засгийн үнэлгээг тооцдог болно.

7. Аялал жуулчлалын хөгжил, хэрэгжүүлэх

арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат: /2011-2015 он/

Тэргүүлэх зорилт-1: Гадаад, дотоодын аялагч, жуулчдыг хүлээж авах бааз, хотхоныг байгуулах, ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлэх, орон нутгийн онцлог, түүх дурсгал, үзэсгэлэнт газрууд болон уламжлалт ёс заншлыг сурталчилан, таниулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аялал, жуулчлалыг хөгжүүлэх боломжтой газар нутгийн судалгаа гаргаж, аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө боловсруулах
- Рашаан, сувилал- эко аялалын бүсийг тодорхойлох
- Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлалын бааз хотхоныг байгуулах нөхцлийг хангах
- Орон нутгийн онцлогт тохирсон шинэ төрлийн үйлчилгээ бий болгох нөхцлийг бүрдүүлэх, эхлүүлэх /өвлийн спорт, ан агнуур, загас агнуур, түүхийн дурсгалт газруудаар аялуулах гэх мэт/
- Ерөөгийн халуун рашааны эмчилгээний ач холбогдлыг тодорхойлж, орчин үеийн шаардлагад нийцсэн аялал жуулчлал- эмчилгээний бааз байгуулах
- Естэй, Минжийн рашааныг хамгаалах, зүй зохистой ашиглах боломжийг бүрдүүлэх

- Ерөө голын сав дагуу иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бүхий усанд орох наран шарлагын газрыг бий болгож, монгол зан ахуйг сурталчилах боломж нөхцлийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж нээгдэж, бүс нутгийн унаган байгаль, дурсгалт газруудын талаарх мэдээлэл нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он /

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутагтаа Монгол ахуйтай танилцах боломж бүхий музей, үзвэрийг бий болгож, гадаадынханд сурталчилах
- Тангуу, Сараалж, Гурван гол, Цамхаг, Хонин нуга, Ерөө голын эх зэрэг газруудад аялал жуулчлалын бааз байгуулах
- Хүдэр суманд цанын баазыг байгуулж, иргэдийг эрүүлжүүлэх
- Хүдэр сумын болон Жавхлант сумын Соронзон хадыг түшиглэн сувилалын газар нээн ажиллуулах
- Ерөө голын сав, Толгойт, Их алт, Өлөнт, Цамхаг зэрэг газруудад загас агнуурын спорт аялалыг хөгжүүлэх, ангийн отог байгуулах

Хүрэх үр дүн: Аялал жуулчлалын шинэ төрлүүд бий болж, жуулчдын тоо нэмэгдэнэ.

8. Дэд бүтцийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ,

хүрэх үр дүн

8.1 Зам тээвэр

Хөгжлийн 1 –р үе шат / 2011 -2015 он /

Тэргүүлэх зорилт-1: Бүсийн төвүүдийн доторх гудамж замыг сайжруулах, хатуу хучилттай замын хэмжээг нэмэгдүүлж, хот хоорондын тээврийн үйлчилгээг сайжруулж, орчины гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Бугантаас –Ерөө хүртэлх 75 км автозамыг хатуу хучилттай
- Хандгайтаас Баянголын уурхай хүртэл асфальтан зам тавих
- Хүдэр сумаас Ерөө хүртэлх замыг хатуу хучилттай
- Шарын голын гүүрээс Жавхлант сум хүртэлх 7.5 км замыг өргөсгөж, асфальтан зам болгох
- Гангын давааг засварлаж, мал бүхий иргэд алслагдсан бэлчээрийг ашиглах боломж нөхцлийг бүрдүүлэх
- Ерөө гол, Шандын гүүрүүдийг шинээр бетонон гүүр болгох
- Жавхлант сумын “Дунд гүүр”-ийг сэргээх
- Сумдын доторхи гэрэлтүүлэгүүдийг нэмэгдүүлж, иргэдийн тухтай орчинг бүрдүүлэх
- Сумдын хот доторхи нийтийн тээврийн зам талбайг тэгшилж, засварлах

Хүрэх үр дүн: Бүсийн хэмжээний зам, замын байгууламжийн чанар сайжирч, эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцсэн байна.

Хөгжлийн 2-р үе шат/ 2016-2021 он /

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Ерөө, Бугант, Хүдэр, Жавхлант-Дархан чиглэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн: Замын барилга байгууламжийн чанар сайжирч иргэдийн тав тухтай зорчих бололцоо нэмэгдэнэ. Тус сумын нутаг дэвсгэрт ажиллаж буй уул

уурхайн томоохон үйлдвэрүүдийг дагаж бий болох хот тосгоныг холбосон шинэ чиглэл маршрутаар хөгжинө.

8.2 Эрчим хүчний салбар

Хөгжлийн 1-р үе шат / 2011-2015/

Тэргүүлэх зорилт-1: Хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан эрчим хүчний үйлчилгээг хялбаршуулж эрчим хүчний хямд, төсөр үйлчилгээг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Шинээр олборлолт хийгдэх томоохон уул уурхайн ордууд руу 110, 35 квт-ын шугам татаж дэд станц барих
- Сумдын 0.4 кв-ийн цахилгаан шугамыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх
- “100000 нарны гэрэл” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж малчин өрхийг цахилгааны эх үүсгүүрээр бүрэн хангах

Хүрэх үр дүн: Хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангагдана.

Хөгжлийн 2-р үе шат/ 2016-2021/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Цахилгаан эрчим хүчний үйлчилгээг сайжруулаж, хямд өртгөөр хэрэглэх боломжийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Хэрэглэгчид хямд эрчим хүчээр бүрэн хангагдана.

8.3 Мэдээлэл харилцаа холбооны салбар

Хөгжлийн 1-р үе шат / 2011-2016 он/

Тэргүүлэх зорилт-1:Цахилгаан холбооны суурь, сүлжээг шинэчлэж, сумын төвд шилэн кабель сүлжээг нэвтрүүлж, мэдээлэл холбооны салбарын үйлчилгээг үйлдвэрлэл, хүн амын ахуйн хэрэглээнд өргөн хэрэглэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Монголын цахилгаан холбооны салбарыг шилэн кабельд холбох
- Интернэтийн сүлжээг өргөтгөн хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах, тоог нэмэгдүүлэх
- Улс орны хэмжээнд хэрэгжих нэгдсэн кодчлолын хүрээнд бүсийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх
- Бүсийн сумдын иргэдийг олон сувгийн телевиз үзэх боломж нөхцлөөр хангах үүднээс кабелийн телевизийн станцыг суурилуулах

Хүрэх үр дүн: Мэдээлэл цахилгаан холбооны орчин үеийн технологи нэвтэрч иргэдэд үйлчлэх үйлчилгээ өргөжнө.

Хөгжлийн 2-р үе шат / 2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Мэдээлэл холбооны суурь сүлжээг өргөтгөн, харилцаа холбооны дэвшилтэт технологи болох дүрстэй дуудлага хийх боломжийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Мэдээлэл холбооны салбар нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл болно.

8.4 Барилга, хот байгуулалтын салбар

Хөгжлийн 1-р үе шат / 2011 -2015/

Тэргүүлэх зорилт-1: Хүн амын суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлж, барилга хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлт бий болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутгийн хот суурин газруудын инженерийн дэд бүтэц, газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэж, холбогдох арга хэмжээг авах
- Гэр хорооллын хэтийн төлөвийг боловсруулж хэрэгжүүлэх
- Сум тосгоны экологийн цэвэр орчинг сайжруулах, экосистемийг хамгаалах, ландшафтыг барилгажилттай зөв хослуулан ашиглах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийгэх
- Орон сууц хөтөлбөрийг уул уурхайн цогцолбортой уялдуулж хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Барилгажилтын ажил нэгдсэн төлөвлөлтийн дагуу хийгддэг болно.

Тэргүүлэх зорилт-2: Орчин үеийн чанарын шаардлага хангасан барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүн амын орон сууцны хэрэгцээг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутгийн түүхий эдийн нөөцийг ашиглан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Орон сууцны барилгыг шинэ нэр төрлийн материал, хийц бүтцийг ашиглан, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологиор бариулах
- Орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, иргэдийг орон сууцны урт хугацаатай зээлд хамруулах
- Хүн амын худалдан авах чадварт тохирсон сууцны хангамжийг нэмэгдүүлэх
- Орон сууцны шинэ хотхон, хороолол бий болгоход иргэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Сумын төвүүд хөгжин иргэд орон нутагтаа тогтвор суурьшилтай амьдрах нөхцөл бүрдэнэ. Орон нутагт барилгын материалын үйлдвэрүүд бий болж барилгын өртөг хямдарч, ажлын байр нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат / 2016 -2021/

Тэргүүлэх зорилт-3: Иргэдийн амьдрах, сурах таатай орчинг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Худалдаа үйлчилгээний нэгдсэн төвийн барилгыг бүсийн бүх сумдад шинээр байгуулах
- 12 жилийн сургуулийн хичээлийн шинэ байрыг Жавхлант, Ерөө сумдад, дотуур байрыг Ерөө, Бугант тосгонд тус тус барих
- Спорт цогцолборын барилгыг бүсийн сумдад шинээр барьж, техник тоног төхөөрөмжөөр хангах
- Жавхлант, Ерөө, Бугант тосгонд шинээр хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барих
- Шинээр баригдаж буй барилга байгууламжуудын орчны тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх
- Орон сууцны шинэхэн хотхон, хорооллуудыг нэгдсэн журмаар зураг төслийн дагуу байгуулах

Хүрэх үр дүн: Хот төлөвлөлтийг зөв хийж чадсанаар газар ашиглалт сайжирч, иргэдийн ая тухтай амьдрах таатай орчин бүрдэнэ.

Хоёр: Ниймгийн бодлого

1. Боловсролын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат (2010-2015 он)

Тэргүүлэх зорилт: Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн 70% хувийг цэцэрлэгт хамруулан сургууль завсардалтгүй сум болж, суурь боловсролын хамран сургалтыг 99 хувьд хүргэх,
- Бугант тосгоны сургуулийн дотуур байр барих
- Тариаланчид малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой арга хэлбэрийг сонгож явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэгийг ажиллуулах
- Эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол эзэмших тэгш нөхцөл, боломжийг бий болгох
- Өндөр мэрэгжилтэй багш, удирдах ажилтныг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, эдийн засгийн урамшууллын шинэ хөшүүрэг бий болгох.
- Мэдээлэл харилцааны технологийг хөгжүүлж, ерөнхий боловсролын сургалтанд “цахим” сургалтын арга зүйг нэвтрүүлж компьютерийн хангамжийг нэмэгдүүлэх
- Сургууль цэцэрлэг дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- Албан бус болон зайны сургалтыг хүн амд бичиг үсэг сургах, боловсролын түвшингээ дээшлүүлэх, бизнес, зах зээлийн мэдлэг, зохистой хэрэглээний чадвар олгоход чиглүүлэх
- Албан бус боловсролын багш нарыг чадваржуулах, сургалтын орчинг стандартын түвшинд нийцүүлэн бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Иргэдэд тохиромжтой хэлбэрээр бололцоотой хугацаандаа боловсрол эзэмших нөхцөл бүрдэж иргэдийн боловсрол амьдралын түвшин дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх, хамгаалах, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах
- Бүсийн төвд сурагчдыг хөгжүүлэх ордонтой болох
- Хөрөнгө оруулалт шаардсан хичээлийн кабинетуудыг шаардлагын дагуу тохижуулж, сургалтыг чанартай явуулах нөхцөлийг бүрдүүлэх
- Сургууль бүрд биеийн тамирын иж бүрэн талбайтай болох
- Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн хүүхдийн зуслан, багш нарын амралт байгуулах

Хүрэх үр дүн: Хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх, хамгаалах, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны чанар хүртээмж сайжирна.

2. Хүн амын эрүүл мэндийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат /2011 -2015 он/

Тэргүүлэх зорилт-1 Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэн хүн амыг эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх.

- Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөлийн байдалд судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг тогтоон, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг чанартай хэрэгжүүлэх
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг идэвхижүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх сургалтын өрөөг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- “Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хүн амын ундны усанд химийн болон нян судлалын шинжилгээ хийлгэж дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулан хүн амыг чанартай баталгаатай, цэвэр ундны усаар хангах, ундны усны худаг, усан санг ариун цэврийн хамгаалалтын бүстэй болгож хашаажуулж тор татах асуудлыг шийдвэрлэх
- Дархлаажуулалтын хамрагдалт, нөхөн вакцинжуулалтыг чанартай зохион байгуулах
- Алслагдсан сум, тосгодын эмнэлэгт нарийн мэргэжлийн чадвартай эмч нарыг ажиллах сонирхлыг төрүүлэх үүднээс нөхцөл бололцоог хангах, материаллаг урамшуулалын механизмыг бий болгож, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх тал дээр орон нутгаас дэмжлэг үзүүлэх
- Бүсийн сумдын түргэний автомашинд парк шинэчлэлт хийх, багийн эмч нарыг ээлж дараатайгаар унаажуулах
- Хүдэр сумын нутагт эмийн ургамал ашиглах, боловсруулах жижиг цехийг байгуулж, төрөл бүрийн цай, эмчилгээний зориулалтын тан боловсруулах

Хүрэх үр дүн: Сумын хэмжээнд хүн амын эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин нөхцөл бүрдэх үндэс суурь тавигдана.

Тэргүүлэх зорилт-2 Эрүүл мэндийн бүх шатны тусламж үйлчилгээний оношлогоо, эмчилгээний хүртээмж чанарыг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Тусламж үйлчилгээний багцыг хэрэгжүүлэх замаар нийт хүн ам ялангуяа хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах .
- Жил бүр бүсийн сумын төвүүдэд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулж, бүсийн сумдын иргэдийг оношлогоо шинжилгээнд хамруулж, эрүүлжүүлэх бодлогыг авч хэрэгжүүлэх
- Бүсийн төвд “Ахмадын сувилал”, “Сувилалын ясли” -ийг нээн ажиллуулж, ардын уламжлалт эмчилгээ, бариа заслыг эмчилгээ оношлогоонд түлхүү хэрэгжүүлэх
- Ерөөгийн халуун рашаан, Баянголын рашааныг түшиглэн амралт, рашаан сувилалын газар байгуулж, эмийн бус эмчилгээг өргөжүүлэх зорилгоор бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах
- Хүн амд эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулж, ээлтэй таатай орчин бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Хүн амд үзүүлэх оношлогоо, эмчилгээ сувилгааны чанар, хүртээмж дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016 -2021 он/

Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг сайжруулж, хүний нөөцийг чадваржуулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сувилахуйн бакалавр, эх баригч бага эмч, их эмчийн мэргэжил дээшлүүлэх, эмэгтэйчүүдийн эмчийн мэргэжил дээшлүүлэх, вакцины сувилагчийн мэргэжил олгох сургалтанд эмч мэргэжилтнүүдийг хамруулж хосолмол мэргэжлээр сургах замаар хүний нөөцийг бэхжүүлэх.
- Лабораторийн үйлчилгээг иргэдэд ойртуулах биохимийн анализатор, зарим оношлогооны тест, дүрс оношлогооны аппараттай болох
- Тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай ашиглагдаж байгаа багаж тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах .
- Тохиолдож болзошгүй гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг сайжруулж, нөөц бүрдүүлж ажиллах
- Эмнэлгийн статистик мэдээллийг боловсронгуй болгох интернетийн сүлжээнд холбох
- Ерөөгийн эмнэлгийг бүсийн төвийн эмнэлэг болгож, эмчилгээ оношлогооны төвтэй болох
- Жавхлант суманд хүн эмнэлэгийн барилга шинээр барих
- Хүдэр суманд хачигт халдварын суурин судалгааны цэг байгуулах
- Олон улсын хөтөлбөр, төслийн байгууллагуудын дэмжлэг тусалцааг нэмэгдүүлж, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг зөв зохистой ашиглах

Хүрэх үр дүн:Эмч эмнэлгийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэгдэж, мэргэжилтэн чадавхуулснаар хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын түвшин сайжирна.

3. Соёл урлагийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат (2010-2015 он)

Тэргүүлэх зорилт: Соёл урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангаж соёл урлагийн байгууллагуудын менежментийг сайжруулах, ажиллагсдыг ажлын байраар нь дагалдуулан сургаж мэргэшүүлэх, тасралтгүй сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сумдын соёлын төвийн хөгжмийн зэмсэг техник хэрэгсэл тоног төхөөрөмжийг шинэчлэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг авах, гадаадын зээл, тусламж, төсөлд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Сумын соёлын төв, номын сан, орон нутгийг судлах кабинетын барилгыг шинээр барих, өргөтгөх засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- Бүсийн цахим номын сангийн үйлчилгээг бий болгох.
- Соёлын явуулын үйлчилгээг өргөтгөж чанаржуулан бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах нөхцлөөр хангах.
- Үйлчилгээний хүрээ хүртээмжийг өргөтгөх зорилгоор төрөл бүрийн сонирхогчдын клуб, уран бүтээлийн болон уран сайхны хамтлаг байгуулах нөхцлийг бүрдүүлж түүгээрээ дамжуулан ард иргэдэд соёлын чанартай бөгөөд оновчтой үйлчилгээг нэвтрүүлэх
- Хөрш орны хил орчмын аймгуудтай тогтоосон соёлын харилцааг улам өргөжүүлж, ард түмний найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх урлаг соёлын уламжлалаа сурталчлан таниулах нөхцлийг бүрдүүлэн хэрэгжүүлэх

- Орон нутаг судлах танхимыг сумын түүх, уламжлал, зан заншлыг сурталчлах үйл ажиллагааны төв болгон өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагын орчны стандарт бие даасан үйл ажиллагаа сайжирч иргэд, үзэгчдийн урлаг соёлын гоо зүйн боловсролын түвшин дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сумдын залуучуудын хөгжлийн төвийг байгуулан тогтворжуулахад төрийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын төвшинд хөгжүүлэх.
- Мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх, утга соёлын өвийн урын сангийн фондыг баяжуулах, дүрс бичлэгээр баримтжуулан хадгалах, шинэчлэх зорилгоор мэргэжлийн урлагийн байгууллагад дуу, дүрс, бичлэгийн студи байгуулж ажиллуулах нөхцлийг судлан хэрэгжүүлэх
- Бүсийн төвийн соёлын төвийг соёлын ордны хэлбэрээр ажиллуулах боломжийг судалж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах
- Орон нутагт байгаа түүх соёлын дурсгалт зүйл, утга соёлын өв байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн аялал, жуулчлалын бааз, сүлжээ байгуулах асуудлыг орон нутгийн онцлогт тохируулан шийдвэрлүүлэх

Хүрэх үр дүн: Залуучуудын хөгжлийн төв байгуулагдаж, сумын соёлын төв мэргэжлийн урлагийн байгууллага, ардын авъяастнуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжирч, хөдөөгийн хөдөлмөрчид малчдад хүргэх соёл урлагийн хүрээ хүртээмж нэмэгдэнэ.

4. Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015/

Тэргүүлэх зорилт: Сумын хүн амыг спортод сонирхолтой болгож эрүүл зан үйлд сургаж, биеийн тамирын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан дундаж наслалтыг уртасгана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн хүн бүрт спортын дасгал хөдөлгөөн түүний ач холбогдолыг сурталчлан ойлгуулах хөдөлгөөн өрнүүлж, сум орон нутгийнхаа засаг захиргааны байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллага хамт олон бүр ажилчдынхаа чөлөөт цагийг эрүүл мэндийнхээ төлөө зориулж спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэх
- Чийрэгжүүлэх, бялдаржуулах төвүүдийг нээн ажиллуулах
- Бүсийн иргэдийг үндэсний спортод дур сонирхолтой болгон тэдний үр хүүхэд, хойч үеийнхэндээ ёс заншил, зан үйлд суралцуулан нэр хүндтэй сайн тамирчин бэлтгэн гаргах зорилгоор төрөлжүүлсэн клубуудыг байгуулан хичээллүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангах
- Спорт цогцолборын заал, танхим, материаллаг баазад тулгуурлан спортын төрөл бүрийн секц дугуйлан хичээллүүлж, улс, олон улсын тэмцээнд аймаг, бүс, сумынхаа нэр хүндийг өндөрт өргөх тамирчин бэлтгэн гаргах
- Ерөө спорт цогцолборыг түшиглэн шинээр усан бассейн байгуулж, хүн амыг чийрэгжүүлэх, эрүүл бие бялдартай болох нөхцлийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Нийтийн биеийн тамир, спортын хүртээмж, өргөжин хүн амын эрүүл мэнд сайжирч тамирчдын чадвар дээшилж улс, тив, дэлхийн аварга тамирчин төрнө.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт-1: Биеийн тамир, спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж, хүртээмж чанарыг дээшлүүлэн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвар өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аж ахуй нэгж, байгууллагууд ажилчдынхаа эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийг сайжруулан дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлэх
- Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор спорт цогцолборын барилга байгууламжгүй сумдад спорт зал шинээр барьж байгуулах, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхэд, залуучууд, иргэд спортоор хичээллэх боломж нөхцлийг бүрдүүлэх
- Ерөө голын тохиромжтой газрыг тохижуулан наранд биеэ шарах, усанд орох талбай болгон тохижуулж, иргэд, хүүхэд залуучууд амарч, эрүүлжих боломж нөхцлийг бүрдүүлэх
- Спортын өндөр зэрэглэлийн дасгалжуулагч, мэргэжилтэнг орон нутагтаа зуны сургалтаар урилгаар авчрах замаар хүүхэд залуучуудын авъяас билгийг хөгжүүлэх
- Олон улсын спортын байгууллага, спортын холбоодуудаар дамжуулан тэдэнтэй хамтарсан бэлтгэл хийх орчин нөхцлийг бүрдүүлэн, тамирчдынхаа ур чадварыг нэмэгдүүлж, насанд хүрэгчид, тив дэлхийн томоохон тэмцээнээс медаль авах, орон нутаг, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөхөд нь дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн: Биеийн тамирын холбогдолтой ажил, үйлчилгээ нь бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн хөдөлгөөн, хувь хүн, албан байгууллагын санаачлага болон өрнөнө.

Тэргүүлэх зорилт-2: Үндэсний спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, үндэсний уламжлалт ёс заншилд тулгуурлан хөгжүүлж, биеийн тамирыг хүн амд бие бялдарын боловсрол олгох чиглэлээр нийтийн хүртээл болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Биеийн тамир, спортын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог оновчтой болгож аймаг, сумын төр олон нийт, бизнесийн байгууллагуудтай өргөн түншлэл бий болгон ажиллах
- Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлж, материаллаг орчин, техник хэрэгслээр ханган уралдаан тэмцээнийг тогтмолжуулах нийтийн хүртээл болгох ажил үйлчилгээг бүх талаар дэмжих

Хүрэх үр дүн: Үндэсний спорт хөгжиж, мэргэжлийн тамирчдыг бэлтгэх үйл ажиллагаа сайжирч, тамирчдын амжилт дээшилнэ.

5. Хөдөлмөр эрхлэлтийн хөгжил, хэрэгжүүлэх араг хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Тэргүүлэх зорилт-1: Хүн амыг байнгын ажлын байраар ханган орлогыг нэмэгдүүлж ажилгүйдлийг тогтвортой бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх
- Нийгмийн даатгалд хамрагдах иргэдийн хүрээг өргөжүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд бүсийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамруулах
- Ядуу, бага орлоготой иргэдийг амьдрах арга ухаанд сургаж, газар тариалан эрхлүүлэх, өрхийн уламжлалт мал маллагааны арга барилд сургах, малжуулах, өрхийн үйлдвэрлэл эрхлэх замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Олон малтай болон газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхөд, гэрээт тариаланч, ногоочин, малчны хэлбэрээр ядуу өрхийн иргэдийг хамруулах
- Хоршиж ажиллах замаар орлого багатай иргэдийг мал маллуулах, хүнсний ногоо тариулах, байгалийн дагалдах баялаг ашиглах, гахай, шувуу үржүүлэх зэрэг туслах аж ахуй эрхлэн орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Сумын төвд халуун ус, үсчин, оёдолчин, гутал засвар, зурагчин, гар утасны засварчин зэрэг ахуйн үйлчилгээний цэг салбар нээн ажиллуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилтөөс хамгаалах ойн зурвас байгуулах замаар газрын хөрс, бэлчээрийг хамгаалах, сумын төвд мод зүлэг, тарих зэрэг нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэд болон эмзэг бүлгийн иргэдийг хамруулан түр ажлын байраар хангах
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон хөдөлмөр эрхлэлт сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн бизнес төвүүдтэй хамтран хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжил олгох болон мэргэжлийн ур чадварын сургалтанд ажилгүй залуучууд болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулах
- Ажлын байр шинээр бий болгосон буюу ажилгүй иргэдэд шинээр мэргэжил олгох, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулсан ажил олгогчид дэмжлэг үзүүлэх
- Ажилгүй иргэдэд мэргэжил дадлага олгох сургалтуудыг зохион байгуулж шинээр ажилд орсон залуучуудад гарааны зээл тусламж олгох, иргэд байгууллагуудын идэвхи санаачлагыг дэмжих
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил хайгчдыг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн захын өдөрлөг зохион байгуулах, мэдээллээр хангах үйлчилгээний чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн: Жилд дунджаар 150-250 ажлын байр шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

Тэргүүлэх зорилт-2: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд чиглэсэн халамж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтэц, үр ашгийг сайжруулах бодлоготой уялдуулан хүн амын орлогыг нэмэгдүүлэх
- “Тогтвортой амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд нийгмийн дэмжлэг, тусламж шаардлагатай хэсэгт туслах зорилгоор банк, санхүүгийн үйлчилгээг

сайжруулах, бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг амьдрах ухааны сургалтанд хамруулах

- Ядуу иргэд орон гэргүй хүмүүсийг гэр, хашаа, орон сууц худалдан авах, барих, орон байраа өргөтгөх, засварлах боломж олгох зорилгоор орон сууцны зээлийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах
- Хоол тэжээлийн дутагдалд орж буй иргэдийн хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах, арга хэмжээг авах
- Ахмад настны нийгмийн хамгаалал, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээг өргөжүүлэх
- Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийг амьжиргаа дээшлүүлэх чадавхитай болгох, хамтарч ногоо жимс тарьдаг хамтын аж ахуйтай болоход нь дэмжлэг үзүүлэх
- Ахмад настан болон бага насны хүүхдийн эмгүй эмчигээний сувилалыг зуны улиралд тогтмол ажиллуулах

Хүрэх үр дүн: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах өрхийн орлого нэмэгдүүлэх бололцоог хангана

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт-1: Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгож нийгмийн хамгааллын хүртээмж үйлчилгээнд хамруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, фермерийн аж ахуйг байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг хамруулах
- Бичил аж ахуйн нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес инкубатор төвүүдтэй хамран ажиллах

Хүрэх үр дүн: Ажилгүй иргэдийн эзлэх хувь, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хувь хэмжээ буурсан байна.

Тэргүүлэх зорилт 2: Нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааны түвшин дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хөдөлмөр эрхлээгүй хүмүүс ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийг дэд бүтэц, сум, нийтийн аж ахуйн болон, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажлын хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоонд шилжих
- Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах амьдрах таатай орчинг бүрдүүлж, тэдэнд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Ахмад настанд үзүүлж байгаа тусламж хөнгөлөлтийн хүртээмжийг өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Ажлын байр нэмэгдэн нийгмийн халамж, асрамж үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.

Гурав: Засаглалын бодлого

1. Засаглалын бодлого,

хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015)

Тэргүүлэх зорилт-1 : Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг бэхжүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах замаар төрийн албыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн анхан шатны нэгж болох баг, тосгоны бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор төсвийг нэмэгдүүлэх
- Багийн тоог шинээр нэмж, ажиллах нөхцлийг сайжруулах үүднээс багийн төвүүдийг шинээр барих, багийн Засаг даргыг нарыг унаажуулах арга хэмжээг шат дараатайгаар шийдвэрлэж, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй шуурхай хүргэнэ.
- Бүсийн сумдын бүтэц, зохион байгуулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулан боловсронгуй болгож, төрийн албыг мэргэшлийн, чадварлаг албан хаагчдаар бэхжүүлнэ.
- Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг нийтэд ил тод , нээлттэй, хяналттай болгох чиглэлийг баримтлах
- Засаглалын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулж, шийдвэр боловсруулах үйл явцад иргэд, олон нийтийн оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн:Нутгийн захиргааны байгууллагуудын чадавхи дээшилж, төрийн үйлчилгээний үр нөлөө сайжирна.

Тэргүүлэх зорилт-2: Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар, ажиллах нөхцлийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Мэдлэгт суурилсан мэргэшлийг төрийн албан хаагчдад эзэмшүүлж, ажлын байран дээрээ суралцаж, хөгжих боломжийг бүх талаар хангана.
- Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.
- Жил бүр 3-5 албан хаагчийг Удирдлагын академид болон бусад чиглэлээр мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх чиглэлээр сургуульд суралцуулж, гадаад, дотоодод туршлага судлуулж, богино хугацааны сургалт семинарт хамруулах замаар мэдлэг боловсролыг нь дээшлүүлнэ.
- Төрийн албан хаагчдын ажлын арга туршлагыг харилцан солилцох бүсийн уулзалт, цугларалтыг жил бүр зохион байгуулж , бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар дээшилж, төрийн үйлчилгээний үр нөлөө дээшилнэ.

Тэргүүлэх зорилт-3: Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлийг буруулан , иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Иргэдэд чиглэгдсэн эрх зүйн болон хуулийн сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлж, үр нөлөөг дээшлүүлнэ.

- Иргэдэд хууль, эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлдэг “ Эрх зүйн туслалцаа”-ны төвийг багуудыг түшиглэн байгуулж, тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт сурталчилгааг өргөнөөр зохион байгуулах
- Хууль эрх зүйн зөвөлгөө, мэдээлэл лавлагааг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “ Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв”-ийг интернэтэд холбож, цахим үйлчилгээг нэвтрүүлэх
- Хууль эрх зүйн сургалт сурталчилгаа, мэдээ мэдээллийг баг , хөдөөд хүргэх бүтцийг боловсронгуй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах
- Өмчийн эсрэг гэмт үйлдэл, түүний дотор малын хулгайн эсрэг нутгийн захиргаа, хууль хяналт, иргэдийн хамтын үйл ажиллагааг идэвхижүүлэх
- Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийг бууруулах , хүүхэд болон хүн худалдаалах зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх , урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах
- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг багасгахад иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнд хүргэнэ.

Хүрэх үр дүн: Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, гэмт хэрэг, зөрчил буурна.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021)

Тэргүүлэх зорилт–1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даасан хөгжлийг хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг иргэдийн санал, газар зүйн байршил, хүн амын тоо, эдийн засгийн чадавхийг харгалзан боловсронгуй болгох
- Өөрийгөө тэтгэх эдийн засаг, нийгмийн үйлчилгээний стандартыг тогтоох замаар загвар сум, баг болох хөдөлгөөнийг өрнүүлж, орон нутгаа хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай бүс болгож хөгжүүлэх

Хүрэх үр дүн : Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даан хөгжих боломж бүрдэж эдийн засгийн чадавхи сайжирна.

Тэргүүлэх зорилт–2 .Нутгийн захиргааны байгууллагыг суралцагч байгууллага болгож, мэдлэгт суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болгон бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Засаг захиргааны нэгж багийг мэгдүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулна.
- Нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах зарчмыг баримтлна.
- Төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгож, онлайн сүлжээг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд мэдлэг, хүрэх үр дүнд суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болж бэхжинэ.

Тэргүүлэх зорилт-3 Иргэдийг орон нутаг, гэр бүл, ажлын байр, нийгэм хамт олны дунд амар тайван ажиллаж, амьдрах нийгмийн орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх
- Нийгмийн дэг журам сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд цахим мэдээллийн сүлжээ бий болгох

Хүрэх үр дүн: Гэмт хэрэг зөрчлийн тоо буурна.

2. Гадаад харилцааны хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн.

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Тэргүүлэх зорилт: Гадаадын улс орнуудтай түншлэлийн харилцааг хөгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сумын түүх, соёлын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засгийн давуу тал , онцлог, нөөц боломжийн талаар гадаад улс орнуудад сурталчилах ажлыг зохион байгуулах, энэ талаар хэтийн бодлого чиглэл боловсруулах
- Төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийг гадаад орнуудад сургах, мэргэшүүлэх, шаардлагатай боловсон хүчнүүдийг урилгаар авч ажиллуулах замаар орон нутгаа хөгжүүлэх бодлогыг баримтлах
- Гадаадад ажиллах хүч гэрээгээр илгээх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулан ажиллаж,
- Нийгмийн хамгааллын чиглэлээр гадаад орнуудын төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх

Хүрсэн үр дүн: Гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжиж, бүсэд орох хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хөгжлийн 1-р үе шат (2016-2021 он)

Тэргүүлэх зорилт: Гадаадын улс орнуудтай түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн баталгаажуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, орон нутгийн эдийн засагт тэдэгдэхүйц ахиц гаргах
- Бусалд улс орны муж, хотуудтай ах дүүгийн найрамдал, хөгжлийн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулж, гадаад харилцааг бэхжүүлэх

Хүрэх үр дүн: Гадаад улс орнуудын хатын ажиллагаа өргөжин, эдийн засгийн харилцаа сайжирна.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨГИЙН БҮСИЙН 2021 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙНХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ**

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2008	2009	2010	1-р үе шат 2015 он	2-р үе шат 2021 он	
1	ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	1. ДНБ /сая.төг/	19355.7	25985.0	29387.5	44081.3	58775.0
		2. Нэг хүнд ноогдох ДНБ мян.төг	1996.0	2483.9	2824.9	3935.8	4198.2
		3. Нийт хөрөнгө оруулалт /сая.төг/	217.2	241.1	285.2	500.0	1200.0
		4. Аж үйлдвэрийн НБ /сая.төг/	13742.5	18969.1	21452.9	32179.4	42905.8
		5. Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн НБ /мян.төг/	1417.2	1813.3	2062.2	2873.2	3064.7
		6. ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /сая.төг/	4430.5	4820.7	5676.4	8514.6	11352.8
		7. Нэг хүнд ноогдох хүнс ХАА-н бүтээгдэхүүн /мян.төг/	456.9	460.8	545.7	760.2	810.9
		8. Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн /сая.төг/	397.2	470.0	482.5	965.0	1447.5
		9.Өрхийн аж ахуйн нийт бүтээгдэхүүн /сая.төг/	374.6	295.2	334.9	502.4	753.5
		10.Аялал,жуулчлал, худалдаа,үйлчилгээний нийт бүтээгдэхүүн /сая.төг/	387.1	519.7	587.8	800.0	1200.0
		11. Малын тоо / мян.тол/	212973	245956	169317	180000	200000
		12. Өндөр ашиг шимт цэвэр,эрлийз шилмэл омгийн малын эзлэх хувь	11.8	12.7	19.9	35.0	70.0
		13. Хураан авсан ургац /тн/	Үр тариа	24974	36562	26716	30000
Төмс	4300		4684	5660	6500	8500	
Хүнсний ногоо	5369		5346	5966	6500	8500	
Малын тэжээл	35800		35600	35480	40000	45000	
2	НИЙГМИЙН	14. Нийт хүн ам	9697	10461	10403	11200	14000

ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	15. Үүнээс: хөдөлмөрийн насны		6288	6837	6752	7952	9940	
	16. Дундаж наслалт		65.4	65.8	65.6	66.0	68.0	
	17. Дунд сургуульд элсэгчдийн харьцаа /хувь/		57.7	58.1	58.4	59.0	59.0	
	18. ЕБС-д суралцагсдын нийт тоонд 1-р ээлжинд хичээллэгч сурагчдын эзлэх хувийн жин		99.8	99.8	99.8	99.9	99.9	
	19. Эхийн эндэгдэл/тоо/							
	20. Нялхасын эндэгдэл/ 1000хүүхдэд ноогдох/		15	15	10	5	2	
	21. Ажилгүйдлийн түвшин		29.3	19.8	17.4	2.5	2.0	
	22. Халдварт өвчин	А гепатит		10	5	15	7/20%/	6 /20%/
		Сүрьеэ		29	21	17	18 /20%/	14 /20%/
		БЗДХ		43	41	14	25 /20%/	20 /20%/
Нийт халдва рт өвчин			89	77	60	60 /20%/	48 /20%/	
3	БАЙГАЛЬ ОРЧИН, ДЭД БҮТЭЦ	23. Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь		-	-	14	-	-
		24. Ойжуулсан талбайн хэмжээ /га/		6	25	210	500	1000
		25. Шинээр ашиглалтанд орсон хатуу хучилттай замын урт /км/		-	-	-	41	112
		26. Уул уурхайн олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлт /га/		59.1	66.9	85.5	200	500
		27. Ашиглалтанд орсон барилгын нийт талбай /мян.м ² /			2.2	1.6	12.5	15.5
		28. Сэргээгдэх эрчим		18.8	16.1	20.5	70	100

	хүчээр хангагдах малчин өрхийн нийт өрхөд эзлэх хувь					
	29. Бэлчээрийн усжуулалт /хувь, өсөн нэмэгдсэн дүнгээр/	25	29	34	40	50
	30. Усалгаатай тариалангийн талбай /га, өсөн нэмэгдсэн дүнгээр/	320	480	540	750	1000

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 61

Сүхбаатар

Хог хаягдлын норматив, хог хаягдал үүсгэсний
төлбөрийн хэмжээ батлах тухай

Монгол Улсын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 9.1.2, Засгийн газрын 2007 оны 18 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээний байгууллага, айл өрхийн хог хаягдлын норматив, хог хаягдал үүсгэсний төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Сумдын Засаг дарга нарт **ДААЛГАХ нь:**

2.1. Байгууллага, айл өрхийн хог хаягдал үүсгэсний төлбөрийг баталсан хэмжээгээр хураан хог хаягдлын үйлчилгээний санд төвлөрүүлж, төв суурин газрын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ялгаж ангилах, боловсруулах, булж дарах үйл ажиллагааг санхүүжүүлэх

2.2. Сумын хог хаягдлын төвлөрсөн цэг болон хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийн байршлыг тогтоож, төв суурин газрын хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх үйлчилгээ, ялгаж ангилан булж устгах ажлыг одоо байгаа Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт хариуцуулах буюу шинээр байгуулах, тодорхой аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах зэргээр гүйцэтгүүлэх

2.3. Хөдөөгийн айл өрхөд үүсгэсэн хог хаягдлаа уламжлалт аргаар цэвэрлэж булж устгах үүрэг хүлээлгэж, хог хаягдал үүсгэсний төлбөрийн хэмжээг 50 хувь хөнгөлж байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 113 тоот тогтоолыг хүчингүйд тооцож, энэхүү тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ, ХОГ ХАЯГДАЛ
ҮҮСГЭСНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдал үүсэх эх үүсвэр	Хог хаягдлын төлбөр тооцоход мөрдөх норматив хэмжээ (1 сард)	Нормативоор тооцсон хог хаягдал үүсгэсний төлбөрийн хэмжээ (сард төгрөгөөр)	
1	Айл өрхөөс үүсэх хог хаягдал	Орон сууцны өрх	40-80	
		Хашаа байшинд амьдардаг өрх	60-120	
		Төв суурин газрын мал бүхий өрх	100кг-500кг	1500
		Хөдөөгийн малчин өрх		1000
Дэлгүүр /зах,барилга,хүнсний,барааны/				
1	Хүнс, барааны зах	5 тн	10000	
2	Түүхий эд авах цэг	1 тн	2000	
3	Мод, модон материалын зах	5 тн	10000	
4	Дэлгүүр /бөөний/100м ² -дээш	3 тн	6000	
5	Дэлгүүр 50-100м ² хүртэл	2,0 тн	5000	
6	Дэлгүүр 20-50м ²	1,0 тн	3000	
Нийтийн хоолны газар				
7	Ресторан	2.5 тн	5000	
8	Бар, кафе	2.5 тн	5000	
9	Гуанз, цайны газар	1.5 тн	3000	
10	Зочид буудал 20-дээш ортой	2.5 тн	5000	
11	Зочид буудал 20 хүртэл ортой	1.5 тн	3000	
Албан байгууллага, аж ахуйн нэгж				
12	Албан байгууллага	2 тн	4000	
13	Аж ахуйн нэгж/ХХК,ХК/	2 тн	4000	
Үйлдвэр, үйлчилгээний газар				
14	Жижиг үйлдвэрлэл	2 тн	4000	
15	ШТСтанц	0,5 тн	2000	
16	Банкны салбар	1 тн	3000	
17	Үсчин, оёдолчин, гуталчин	1 тн	3000	
18	Авто угаалга, засвар	2 тн	4000	
20	Бусад үйлчилгээний газар	2 тн	4000	
21	Дулааны станц	90 тн	18000	
Хүндийн жингээр тооцож авах хог хаягдлын төлбөрийн хэмжээ				
21	Барилгын хог	1 тн	6000	
22	Үйлдвэрлэлийн хог	1 тн	6000	

Тайлбар : Бусад үйлчилгээний газар гэдэгт үүрэн телефоны газар, нэгж зардаг цэгүүд, РС тоглоомын газар, нотариатын газар, гоо сайхны үйлчилгээ, канон, зурагчин, компьютерээр үйлчлэх, зарын цэг, ломбард, алт мөнгөний дархан, гар утасны засварын цэгүүд хамаарна.

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 62

Сүхбаатар

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны
төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д” заалт, Засгийн газрын 1998 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг мөрдүүлэх, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч, биелэлтэнд байнгын хяналт тавьж хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 19 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ
АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

д/д	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
1.	Шар шавар /тоосгоны/	тн	1500
2.	Тусгай зориулалтын шавар	тн	1500
3.	Элс	тн	500
4.	Голын хайрга	тн	2500
5.	Уулын хайрга	тн	1000
6.	Хар шороо	тн	5000
7.	Уулын чулуу	тн	1000
8.	Барилгын өнгөлгөөний чулуу /боржин, кварцит, алевролит/	тн	3000
9.	Хувирмал чулуулаг	тн	2000
10.	Шохойн чулуу /Доломит, мергель/	тн	2000
11.	Хужир шүү	тн	2000

Тайлбар: 1. Иргэд амины орон сууц барихад ашигласан бүх төрлийн хайрга, элсний үнийн 50%-ийг чөлөөлнө.

2. Аймаг орон нутгийн онцгой хэрэгцээнд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ашигт малтмалын үнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 50 хүртэл хувиар бууруулж болно.

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 63

Сүхбаатар

Байгалийн ургамал ашигласны төлбөрийн
хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулийн 6-р зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 145-р тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр нөөц, тархалт нь багасаж, түүж бэлтгэж байгаа арга нь байгаль орчин, газрын хөрсөнд сөрөг нөлөө үзүүлж байгааг нь харгалзан ховор ургамал Дэрэвгэр жиргэрүүг Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт түүж бэлтгэхийг 2 жилийн хугацаагаар хориглосугай.

3. Энэ тогтоолыг мөрдүүлэх, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

4. Энэ тогтоолыг гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 20-р тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Ургамлын төрөл	Хэмжих нэгж /кг/	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/	
			Иргэн	Аж ахуйн нэгж
А. Ховор ургамал				
1	Эмийн бамбай	кг	300	500
2	Эгэл бавран	кг	300	500
3	Урал чихэр өвс	кг	300	500
4	Цагаан дэгд	кг	200	500
5	Үндэслэмтгий зэгс	кг	200	500
6	Төлөгч өвс	кг	200	500
7	Анхилуун улаагана	кг	200	500
8	Тэмээн харгана	кг	200	500
9	Улбар хялгана	кг	200	500
10	Ягаан цээнэ	кг	200	500
11	Монгол хунчир	кг	200	500
12	Халиар	кг	200	500
13	Анхил сонгино /гогод/	кг	200	500
14	Бүйлс	кг	300	500
15	Хээрийн цагаан мөөг	кг	300	500
16	Тэхийн шээг	кг	200	500
17	Хөх нэрс	кг	200	400
18	Чацаргана	кг	200	400
19	Ганга	кг	200	400
20	Илдэн игүүшин	кг	200	400
21	Час улаан долоогоно	кг	200	400
Б. Элбэг ургамал				
1	Аньс	кг	200	300
2	Улаалзгана	кг	200	300
3	Гашуун банздоо	кг	100	300
4	Имт гичгэнэ	кг	100	300
5	Гүзээлзгэнэ	кг	200	300
6	Сибирь гүйлс	кг	100	300
7	Гялгар дэрс	кг	200	300

8	Ямаан зээргэнэ	кг	100	300
9	Үхрийн нүд	кг	200	300
10	Мойл	кг	200	300
11	Үрэл	кг	200	300
12	Нохойн хошуу	кг	200	300
13	Шар мөөг	кг	100	300
14	Хусны мөөг	кг	200	300
15	Бургасны мөөг	кг	200	300
16	Цайруулсан самар /хушны	кг	200	300
17	Нугын шимтэглэй	кг	200	300
18	Монгол сонгино /уулын/	кг	200	300
19	Өргөст сарнай	кг	100	300
20	Дагуур сарнай	кг	100	300
21	Эмийн сөд	кг	200	300
22	Их таван салаа	кг	200	300
23	Удвал навчит тавилгана	кг	100	300
24	Гоо улаагана	кг	200	300
25	Нумраа хунчир	кг	200	300
26	Эгэл цагаан түрүү	кг	200	300
27	Царван шармис	кг	100	300
28	Гүйлс /зэрлэг чангаанз/	кг	200	300
29	Одой сараана	кг	100	300
30	Юмдүүжин	кг	100	300
31	Гоньд	кг	100	300
32	Бусад	кг	150	300

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 64

Сүхбаатар

**Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн
 албан татварын хэмжээг батлах тухай**

Сэлэнгэ аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дугаар зүйлийн 5.3 дугаар зүйл, 2/5 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 1 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Тус аймагт мөрдөх автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг дараахь хэмжээгээр тогтоосугай.

Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн төрөл		Сэлэнгэ аймагт мөрдөгдөх албан татварын хэмжээ/төгрөгөөр/	
1	2 дугуйтай мотоцикл	2 300	
2	3 дугуйтай мотоцикл	3 500	
3	Суудлын автомашин /Цилиндрийн багтаамжийн нэг см ³ тутамд төгрөгөөр/		
	а. 2001 см ³	1см ³	1 8
	б.2001-3001 см ³ хүртэл	1см ³	20
	в.3001 см ³ болон түүнээс дээш	1см ³	25
4	Микроавтобус / 15 хүртэл суудалтай/	35 000	
5	Автобус	50 000	
6	Ачааны машин		
	1 хүртэл тн-ын даацтай	25 000	
	1-2 тн-ын даацтай	35 000	
	2-3 тн-ын даацтай	45 000	
	3-5 тн-ын даацтай	55 000	
	5-8 тн-ын даацтай	80 000	
	8-10 тн-ын даацтай	90 000	
	10-20 тн-ын даацтай	100 000	
	20-30 тн-ын даацтай	150 000	
	30-40тн-ын даацтай	200 000	
	40-50тн-ын даацтай	280000	

	50-60тн-ын даацтай	336000
	60-70тн-ын даацтай	392000
	70-80тн-ын даацтай	448000
	80-90тн-ын даацтай	532000
	90-100тн-ын даацтай	588000
	100 тн-оос дээш даацтай	616000
7	Тусгай зориулалтын автомашин	19 000
8	Трактор өөрөө явагч бусад хэрэгсэл	14 000
9	Бага оврын трактор	7 000
10	Чиргүүл/ даацын 1 тонн тутамд/	5000

Хоёр.Энэхүү тогтоолыг 2011 оны 4-р сарын 28-наас эхлэн мөрдөхийг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 65

Сүхбаатар

Дүрэм батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч нь улс төрийн албан хаагчийн хувьд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж хуулийн хүрээнд ажиллуулах, ашиг сонирхлын нөлөөллөөс хамгаалахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2 Хурлын Төлөөлөгч нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэн сахих, аливаа асуудалд шударга байр сууринаас хандах, бусдын нэр төр, алдар хүнд эрх, эрх чөлөө, аймгийн нийт иргэд, улс, аймаг орон нутгийн ашиг сонирхолыг эрхэмлэн хүндэтгэх, ил тод нээлттэй байх зарчим баримтална.

1.3 Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч / цаашид хурлын төлөөлөгч гэх / нь үйл ажиллагаандаа энэ дүрмийн тогтоосон ёс зүйн хэмжээг баримтлахын зэрэгцээ Монгол улсын ЗЗНДНТУ тухай, Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай, төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, аймгийн ИТХ-ын хуралдааны дэгийн тухай тогтоол болон холбогдох бусад хууль, тогтоомжид заасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.

Хоёр. Хурлын Төлөөлөгчийн хувьд баримтлах ёс зүйн хэм хэмжээ

2.1 Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална.

2.1.1 Хууль, Хурлын шийдвэрээр тогтоосон дэг журмыг сахин биелүүлэх

2.1.2 Хууль зөрчсөн, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх

2.1.3 Бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхолыг эрхэмлэн хүндэтгэх.

2.1.4 Хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төр, НӨУЁ-ны байгууллага-олон нийтийн холбоог бэхжүүлэхэд анхаарч иргэдэд ил тод ажиллаж үнэн бодитой мэдээлэл өгч байх.

2.1.5 Төлөөлөгч нь Хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалд мэдлэгтэй, бэлтгэлтэй, оролцож, хуульд нийсэн шударга шийдвэр гаргахын төлөө чармайн ажиллах.

2.1.6 Төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа хүлээн авсан, мэдсэн нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, ашиглахдаа нууцын талаарх хууль тогтоомжийг баримтлах.

2.1.7 Төлөөлөгч Хурлын нэрийн өмнөөс албан үүрэг гүйцэтгэх явцдаа эрх мэдлээ ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгохгүй, бусдын хууль бус нөлөөлөлд автахгүй байх.

2.1.8 Өөрийн болон гэр бүлийн гишүүн, садан төрлийн хувьд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх асуудлаар шийдвэр гаргах, санал хураах үйл ажиллагаанд оролцохгүй байх.

2.1.9 Төлөөлөгчийн албан үүргээ хэрэгжүүлснийхээ төлөө болон хэрэгжүүлэх гэж байгаа ажлын төлөө иргэн байгууллага аж ахуй нэгжээс элдэв элдэв төрлийн хөнгөлөлт эдлэхгүй, мөнгөн шагнал шан харамж, зээл, бэлэг авахгүй байх.

2.1.10. Хурлын нэрийн өмнөөс гадаадын байгууллага, албан тушаалтанд амлалт өгөхгүй, гэрээ хэлцэл хийхгүй байх.

2.1.11. Төлөөлөгчийн сонгуульт албан тушалын бүрэн эрх, үүрэг хариуцлагатай нь харшилсан санхүү худалдааны болон бусад хэлбэрийн хэлэлцээрт оруулахгүй байх.

Гурав. Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбогдсон

ёс зүйн хэм хэмжээ

3.1. Хурлын төлөөлөгч нь хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв гаргах үүргээ сахин баелүүлэх.

3.2. Хурлын төлөөлөгч нь төрийн захиргаа тарийн тусгай албанаас бусад ажил албан тушаал эрхэлж болох бөгөөд тэндээс олсон орлогоо хөрөнгө орлогын мэдүүлэгт заавал тусгаж байх.

Дөрөв. Бусад асуудал

4.1 Төлөөлөгч нь энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зарчсөн тухай асуудлыг Хурлын Нутгийн удирдлага, Хууль хяналтын Бодлогын хорооны хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргаж Хурлын хуралдаанд оруулна.

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 07-ны өдөр

Дугаар 66

Сүхбаатар

Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 18, 2007 оны 38 дугаар тогтоолуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх зорилтыг бүсийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиг баримжаа болгон, хэрэгжүүлэх стратеги зорилтуудыг бүсийн сумдын жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг бүсийн зөвлөл болон бүсийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.
3. Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖОЖАВ

УДИРТГАЛ

Аймаг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг орчин үеийн арга зүйн дагуу олон нийт, оролцогч талуудын өргөн оролцоонд тулгуурлан шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт хийж, хөгжлийн хэтийн төлвийг тооцож, урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийн дагуу “Сэлэнгэ аймгийн 2021 он хүртлэх хөгжлийн хөтөлбөр”-ийг үндэслэн “Бэлчирийн бүс”-ийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Бэлчирийн бүс нь нийт 2817.6 км² нутаг дэвсгэртэй Алтанбулаг, Сүхбаатар, Шаамар сум, 14 баг, Дулаанхан орон нутгийн 1 тосгонтой. 2010 оны байдлаар хүн амын тоо 31084 хүрсэн нь аймгийн нийт хүн амын 30.5 хувийг эзэлж байгаа бөгөөд хүн амын нягтшил нь 11.0, 2010 оны байдлаар 1000 хүнд ногдох төрөлт 30, нас баралт 6, цэвэр өсөлт 24 байна.

Бэлчирийн бүс нь жилд дунджаар 7.0 мянган тн үр тариа, 5,4 мянган тн төмс, 5.2 мянган тн хүнсний ногоо хураан авч аймгийн нийт төмсний ургацын 12,7 хувь, хүнсний ногооны 17.3 хувийг дангаараа үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж, байна.

Тус бүс нь бусад бүстэй харьцуулахад дэд бүтэц сайтар хөгжсөн, хилийн бүсэд хамаарагддаг тул иргэдийн амьдрах таатай нөхцөл боломж бүрдсэн, 2 мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд жилд дунджаар 170 гаруй мэргэжилтэй ажилчид бэлтгэн гаргаж байна.

Дээрх давуу тал, онцлог байдалд тулгуурлан Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн алсын харааг аж үйлдвэр, дэд бүтэц, худалдаа үйчилгээ, эдийн засгийн чөлөөт бүс, бөөний худалдааны сүлжээ, эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, ногооны аж ахуй, аялал жуулчлал, загасны аж ахуй, дээд болон мэргэжлийн тусгай дунд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх гэж тодорхойлж байна.

Иймд сум, орон нутаг болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэд байгаа нөөц боломжоо нутгийнхаа хөгжлийн төлөө бүрэн дүүрэн цогц, зөв зохистой ашиглах, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бүсийн түвшинд хангахад туслалцаа дэмжлэг авах, санхүүжилтийн эх үүсвэр олохын тулд хандивлагчид, хөрөнгө оруулагчдыг татах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, хөрөнгө босгох, эдийн засгийн үр ашгийг зүй зохистой ашиглах, нүдэнд үзэгдэхүйц ажил өрнүүлэх, түншлэл хамтын ажиллагааг орон нутгийн бизнес орчныг сайжруулах зэрэгт хандуулах хэрэгтэй.

Нутгийн өөрөө удирдах болон төрийн үйлчилгээний байгууллагуудаас орон нутгийн хөгжил цэцэглэл болон бизнес эрхлэгчдийн идэвхитэй үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангах, тэдэнд тулгарч буй асуудал, хүндэрлийг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллах, мөн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийг чадавхижуулах, шинээр биезнес эрхлэх, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах, иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх асуудлыг бүсийн хэмжээнд зохион байгуулан ажиллах ёстой.

Дээрх арга ажил арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг Эдийн засгийн бодлого, Нийгмийн бодлого, Засаглалын

бодлого гэсэн 3-н салбарт хуваан 2011-2015 он, 2016-2021 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөв.

НЭГ. Эдийн засгийн бодлого

Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн эдийн засгийн бодлогын гол зорилт нь сум орон нутгийн хөгжил, нийгэм, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлж, аймгийн 2021 он хүртлэх хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах явдал юм.

Бэлчирийн бүсийн хөгжлийн эдийн засгийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

1. Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
2. Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
3. Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөгжил, газар өмчлөлийн бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ
5. Худалдаа үйлчилгээний салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
6. Дэд бүтцийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1 Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт:Бэлчирийн бүсэд боловсруулах үйлдвэрүүдийг бий болгох, шинэ технологи нэвтрүүлэх, дотоод гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм.

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, зах зээлийн эрэлтэд нийцсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн шинэ салбарыг хөгжүүлэх
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг түшиглэн боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын зах зээлд өрсөлдөх
- “Сэлэнгэ” үйлдвэрлэл технологийн паркбайгуулж, “Үелээт картон хайрцагны үйлдвэр”, “Цаасан шошгоны үйлдвэр”, “Хүнсний ногоо даршлах үйлдвэр”, “Сүү боловсруулах үйлдвэр”, “Мах боловсруулах үйлдвэр”, “Хаймран хавтан бэлтгэх үйлдвэр” зэрэг хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий “Барилгын материалын үйлдвэрлэл”, “Мод боловсруулах үйлдвэр”, “Бордооны үйлдвэр”, “Шахмал түлшний үйлдвэр”-ийг байгуулах
- “Алтанбулаг худалдааны чөлөөт бүс”-ийн захиргаатай хамтран ажиллаж, чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ашиглалтад оруулах

Хүрэх үр дүн: Бүсийн хөгжлийн эдийн засгийн чадамж нэмэгдэж, боловсруулах аж үйлдвэрт дэвшилтэт технологи нэвтэрч, үйлдвэрлэл өсч, бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Мал, ургамлын гаралтай түүхий эдийг биотехнологийн аргаар боловсруулж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх
- Хүн, малын эм бэлдмэлийн үйлдвэрлэлийг бий болгох
- Төмс боловсруулах цардуулын үйлдвэрийг байгуулах

Хүрэх үр дүн: Аж үйлдвэрийн салбарт биотехнологийн үйлдвэр ашиглалтанд орсноор уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг орлох боломж бүрдэж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ нэмэгдэнэ.

1.2 Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.2.1 Газар тариалангийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Газар тариалангийн үйлдвэрлэлд газар ашиглалтыг сайжруулж, газарт оруулах хөрөнгө оруулалт, тухайлбал бордох, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, техникийн шинэчлэлийн бодлого зохицуулалтын арга хэмжээг зохион байгуулах, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Усны нөөцөд түшиглэн экологид хоргүй услалтын систем барих, шинэчлэх замаар усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэх
- Буудай, сагад будаа, төмс, хүнсний ногооны элит үрийн аж ахуй эрхлэх компанийг хувийн ба төрийн өмчийн оролцоотой байгуулах
- Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж таримлын ургалтын хугацааг хурдасгах, ногоочдын орлогыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх.
- Зоорийн аж ахуйг хөгжүүлж төмс, хүнсний ногооны хадгалалтын стандартыг сайжруулах
- МСҮТ-ийн сургалтын паркийг өргөжүүлэх, шинэ сортын хүнсний ногоо тариалж, туршин, үйлдвэрлэлд нэвтрүүлэн таримлын төрлийг олшруулж зах зээлд нийлүүлэх
- Тракторч, комбайнч, засвар үйлчилгээний мэргэжилтэй техникийн дунд боловсролтой мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх,
- Газар ашиглах, хөрс хамгаалах технологийн шинэчлэлийн бодлого зохицуулалтын арга хэмжээг үр ашигтай зохион байгуулж хэрэгжүүлэх
- Тэжээлийн ургамал тариалалтыг бодлогоор дэмжиж, таримал тэжээл ба хүчит тэжээл өвс бэлтгэлийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирч, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн чадавхи нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Тариалангийн үйлдвэрлэлд технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэх
- Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж, баталгаатай ургац авах нөхцлийг бүрдүүлэх
- Хүлэмжийн аж ахуйн тоог нэмэгдүүлэх замаар эрт ургацын ногооны төрлийг олшруулах

- Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийнхоршсон томоохон фермерүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, техник,тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй санхүүгийн түрээсээр нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэн чацарганы тариланг нэмэгдүүлэх
- Бүсийн төвд машин-трактор, дүүжин агрегатын засвар үйлчилгээний паркыг байгуулж, техник үйлчилгээний дундын өмчтэй компанийг газар эзэмшигчдийн хувьцаа, хөрөнгийн хоршилтоор байгуулах,
Хүрэх үр дүн: Хөдөө аж ахуйн машин техникийн хангамж, ашиглалт нэмэгдэж, техник технологийн нэвтрүүлэлт сайжирч нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдна.

1.2.2 Мал аж ахуйн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барьж, сайн үүлдрийн болон нутгийн шилмэл малыг тэжээл үйлдвэрлэлтэй хослуулан түлхүү хөгжүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өндөр ашиг шимт малын тоо толгойг 50 хувь хүртэл нэмэгдүүлж, ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах
- Эрчимжсэн мал аж ахуй, малын үүлдэрлэг чанар, ашиг шимийг дээшлүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, тэжээлийн баазыг бий болгох, таримал тэжээл ба хүчит тэжээл өвс бэлтгэхэд шаардагдах техник хэрэгслээр дэмжлэг үзүүлэх
- Цөм сүрэг, үржлийн хээлтүүлэгчийг өсгөх, бойжуулах, зохиомол хээлтүүлэгт гүн хөлдөөсөн үрийг ашиглах үйлчилгээг өргөжүүлэх.
- Мал эмнэлгийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулж, мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлж малын эм,вакцины хангамжийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Эрчимжсэн мал аж ахуй, суурин болон хагас суурин фермерийн тоо тогтмол нэмэгдэж, бэлчээрийн доройтол багасан, бэлчээр ашиглалт малын чанар сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Загас үржүүлэх аж ахуйг хөгжүүлэх
- Төв суурин газрын дэргэд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрчимжсэн фермерийн аж ахуйг дэмжих
- Малын тэжээл үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх
- Сумын мал эмнэлгүүдийн материаллаг бааз, багаж, тоног, төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулах

Хүрэх үр дүн: Эрчимжсэн суурин маллагаатай шинэ хэлбэрийн хувийн хэвшлийн мал аж ахуйн суурь тавигдаж мах, сүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

1.3 Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.3.1 Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж өргөжүүлэх, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, цэвэр өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх.

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг үйлдвэрлэл технологийн паркттай уялдуулан тодорхойлж хөгжүүлэн ажилгүйдлийн түвшинг бууруулах
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх банк ба банк бус санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн зүгээс үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож байгаа хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг сургалт семинарт хамруулж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах
- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа ажил үйлчилгээ худалдан авахад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах

Хүрэх үр дүн: Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдэж, албан секторт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдэж, татварын бааз суурь өргөжнө.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн томоохон үйлдвэрүүдийн хангамжийн материалыг жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах /шуудай, ажлын хувцас гэх мэт жижиг дунд үйлдвэрлэл/
- Жижиг, дунд үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Өндөр түвшинд хүрсэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ бий болж, ажлын байр нэмэгдэнэ.

1.3.2 Өрхийн аж ахуйн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх таатай орчинг бий болгож, ажилгүйдлийг бууруулж иргэдийн амьжиргааны чадавхийг дээшлүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн аж ахуйг эрхлэхэд төрийн зүгээс бүх талын дэмжлэг үзүүлэх, жижиг зээлийн үйлчилгээ буюу бичил санхүү, зээлийн зуулчлалын үйлчилгээг өрхийн үйлдвэрлэл руу чиглүүлэх бодлого хэрэгжүүлэх
- Сүү, төмс, хүнсний ногоо, мах боловсруулах, шахмал түлш, мал бордох, зоорины аж ахуй эрхлэх, жимс, жимсгэнэ тариалах, модны тарьц суулгац ургуулах, ноос боловсруулах, модон эдлэл, оёдлын үйлдвэрлэл эрхлэх өрхийн аж ахуйг хөгжүүлэх, дэмжих

- Өрхийн аж ахуй эрхлэгчдэд бизнес төлөвлөгөө боловсруулах, өрхийн аж ахуйг хөгжүүлэх арга хэрэгслүүд түүний хэрэглээний талаарх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж хамруулах
- Өрхийн үйлдэрлэлийг дэмжих зорилгоор баг бүрт хөгжлийн сан байгуулах
- Барилгын модон материалыг орлох тоосго, блокны жижиг оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж өрхийн үйлдвэрлэлд хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн : Ажлын байр шинээр нэмэгдэж, өрхийн аж ахуй эрхлэх, амьдралаа өөд нь татах хүсэл сонирхолтой иргэн бүрийн өмнө адил тэгш боломж нээгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Тогтвортой үйл ажиллагаатай өрхийн аж ахуйнуудад банк, санхүүгийн байгууллагуудтай харилцахад дэмжлэг үзүүлэх
- Өрхийн аж ахуйд бүтээгдсэн хүнсний бүтээгдэхүүнийг нийслэл, бусад аймгуудад борлуулах боломж бүрдүүлэх
- Өрхийн аж ахуй эрхлэгчид хорших, хамтрах замаар жижиг дунд үйлдвэр байгуулж, үйлдвэрлэлээ өргөжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн : Өрхийн аж ахуйг эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо, чанарт өөрчлөлт орж ажилгүйдэл эрс буурч, хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.

1.4 Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөгжил, газар өмчлөлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.4.1 Байгаль орчны хамгаалал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Байгаль орчны хяналтыг сайжруулж, хүрээг өргөтгөх, бохирдлын түвшинг стандартад нийцүүлэн бууруулна.

1.4.1.1 Агаар, ус, хөрс

Хөгжлийн 1-р үе шат / 2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Агаар, ус, хөрсний бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт тавьж ажиллах
- Хог хаягдал шатаах, ил задгай хог хаяхыг зогсоож, ландшафтын аргыг нэвтрүүлэх, иргэдийн дунд хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх
- Шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж модыг түлшинд хэрэглэхээс татгалзах
- Нам даралтын зуухаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд бүрэн хамруулах, уурын зуухны тоог цөөрүүлэх, дулааны нэгдсэн сүлжээнд аж ахуйн нэгж байгууллагуудыг холбох арга хэмжээ авах
- Хог хаягдлыг ялган зөөх, тээвэрлэх, устгах, боловсруулах үйл ажиллагааг эхлүүлэх
- Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, Карьерын аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж байгууллагыг бий болгож ажиллуулах
- Стандартад нийцсэн хог хаягдлын төвлөрсөн хогийн цэгийн тоог нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Ард иргэдийн цэвэр эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат / 2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Дулаанхан тосгоныг мод үржүүлгийн загвар аж ахуй болгон хөгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, агаарын бохирдлыг бууруулах

- Ус цаг уурын, орчны шинжилгээний байгууллагуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх
- Авто тээврийн хэрэгслээс гарч буй угаарын хийн зөвшөөрөгдөх хэмжээ, стандарт мөрдөлтөнд тавих мэргэжлийн хяналтын албадын хяналтын үйл ажиллагааг сайжруулах
- Хог хаягдлыг ялган боловсруулах үйлдвэр байгуулах
- Нам даралтын зуух бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийг төвлөрсөн халаалтын системд холбож дуусгах

Хүрэх үр дүн: Байгаль орчны болон уур амьсгалын төлөв байдалд тавих хяналт сайжирч бохирдлын түвшин буурна

1.4.1.2 Усны нөөц

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2015/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн нутаг дэвсгэрийн усны нөөцийг тогтоох усны эх үүсвэрийн тооллого явуулж уст цэгийн ашиглалтанд үзлэг судалгаа хийх
- Гадаадын хөрөнгө оруулалттай олон улсын болон ТББ-тай хамтран гадаргын усны бохирдолтын түвшинг тодорхойлох
- Ширгэж буй булаг шанд болон усны эх ундаргыг хашиж хамгаалах, сэргээх ажлыг зохион байгуулах
- Инженерийн хийцтэй уст цэгийг сэргээн засварлах шинээр гаргах замаар бэлчээр усжуулах ажлыг үе шаттайгаар явуулах
- Ус цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангах, хүчин чадлыг бүрэн нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Усны нөөц тогтоосноор хүн ам хөдөө аж ахуй, газар тариаланд усыг зөв зохистой ашиглах, усны чанарыг хамгаалах, хүн амыг цэвэр аюулгүй баталгаатай усаар хангагдах, усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төвлөрсөн усан хангамжийн хүчин чадлыг хэрэгцээг үндэслэн нэмэгдүүлэх
- Ус түгээх шугамын хүчин чадал, уртын хэмжээ нэмэгдүүлэх
- Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах хяналт зохион байгуулалтын бүтцийг бий болгох
- Рашааны усны үр ашгийг нэмэгдүүлж экологийн ач холбогдол бүхий усны эх үүсвэрийг хамгаалалтанд авах
- Орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хур тундас үерийн усыг хуримтлуулан газар тариаланд ашиглах

Хүрэх үр дүн: Усны нөөцийг байгалийн аясаар нөхөн сэргээх нөхцөл бүрдэнэ.

1.4.1.3 Ойн нөөц

Хөгжлийн 1-р үе шат:/2011-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ой мод ашигласны төлбөрийн тодорхой хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах
- Тарьц суулгац бэлтгэхэд шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, Дулаанхан тосгоныг мод үржүүлгийн загвар аж ахуй болгон хөгжүүлэх

- Ойн санг эзэмших, хамгаалах, нөхөн сэргээх иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх, нарс, бургас, гацуур, жодоон ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд ард иргэдийг өргөнөөр татан оролцуулах
- Хууль бус мод бэлтгэх, тээвэрлэхийг бүрэн зогсоох
- Жил бүрийн нийтээр мод тарих өдрийг хавар, намрын улиралд 2 удаа өрнүүлж, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээг авах
- Хуш, жодоо, гацуур зэрэг хөвч ой үүсгэхэд чухал үүрэгтэй модыг үржүүлэх, шилжүүлэн суулгах арга хэмжээг зохион байгуулах
- Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх
- Ойн хортонтой тэмцэх зорилгоор ойн шоргоолжны үүрийг хамгаалах, олшруулах, ойн түймэр, хөнөөлт шавьжийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх

Хүрэх үр дүн: Ойн нөөц нэмэгдэж, зөв зохистой ашиглалт, байгалийн аясаар нөхөн сэргээгдэх нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат: /2016-2021/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Уур амьсгалыг зөөлрүүлж хөрсний эвдрэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, ногоон зурвас байгуулах
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын чадавхийг дээшлүүлэх, шаардлагатай техник хэрэгслээр хангах
- Мод үржүүлгийн газрыг үе шат дараатайгаар хөгжүүлж, нэмэгдүүлэх
- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг нэвтрүүлэх
- Ойн нөөцийн ашиглалтыг сайжруулан дотоодын болон бусад орон нутгийн хэрэгцээг хангах
- Ойн дагалт баялаг болох жимс жимсгэнэ, мөөг, эмийн түгээмэл тархсан ургамлыг түүх, ашиглах ажлыг орон нутагтаа журамлах зорилгоор хяналт тавих ажлыг эрчимжүүлэх
- Тужийн нарсан ойг түймрээс хамгаалах зурвас байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Ойн нөөцийн хэвийн ургах нөхцөл бүрдэж, экологийн тэнцвэр хангагдана.

1.4.1.4 Биологийн төрөл

Хөгжлийн 1-р үе шат / 2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Нэн ховор ан амьтан, ургамлын судалгааг хийж, зориудаар өсгөж үржүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, тогтвортой байдал, хэвийн өсөлт, ургамалжилтыг хангахтай холбогдсон бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх
- Ан амьтан, ургамлыг хамгаалах хууль эрх зүйн хүрээнд тодорхой хугацаанд ан амьтан агнахыг хориглох, ургамлын нэрс, байршлыг заасан орон нутгийн шийдвэрийг гаргах

Хүрэх үр дүн: Устгах аюулд орсон ахуйн ач холбогдолтой ан амьтан, ургамлыг зориудаар өсгөж үржүүлэх ажилд ахиц гарна.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутгийн байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх судалгааг жил бүр зохион байгуулан явуулж, мэдээллийн санг бүрдүүлэх
- Биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Биологийн төрөл зүйл ач холбогдлын талаар ард иргэдийн мэдлэг, мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг хийх

Хүрэх үр дүн: Орон нутгийн байгалийн экосистемийн тэнцлийг хадгалах, нөхөн сэргээх, үржих нөхцөл бүрдэж зүй зохистой ашиглалт, хамгаалалт сайжирна.

1.4.1.5 Байгалийн гамшиг

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгалийн аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолж, ард иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй хүргэх
- Хорт ургамал, шавьжийн голомт, хүн малын гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хорио цээр тогтоох, хүн, мал эмнэлгийн ажилчдыг чадавхижуулах
- Байгалийн гамшиг, халдварт өвчин болон гэнэтийн аюул, хохирлоос сэргийлж ард иргэдийг амь насны даатгалд хамруулах
- Гамшгийн үед ажиллах менежментийн төлөвлөгөөг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түшиглэн боловсронгуй болгож, ард иргэдийг аюулгүй амьдрах, учрах хохиролоос урьдчилан сэргийлэх үүднээс сургалт сурталчилгааг тогтмолжуулах
- Байгаль цаг уурын онц ноцтой үзэгдлийн үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны тусламж болон хүнс, өвс тэжээлийн байнгын нөөцтэй болох
- Байгалийн гамшгийн талаарх хүн амын мэдлэгийг дээшлүүлэх, тусгай сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулах

Хүрэх үр дүн: Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлж, учирч болох эрсдлийг бууруулна.

Хөгжлийн 2-р үе шат. /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгалийн гамшиг ослын үед ажиллах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шинэчлэх
- Мэргэжлийн байгууллагын ур чадварыг дээшлүүлэх, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах

Хүрэх үр дүн: Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохиролыг бууруулах, шуурхай арилгах тогтолцоо бүрдсэн байна.

1.4.2 Аялал жуулчлал салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Гадаад, дотоодын аялагч, жуулчдыг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлэх, орон нутаг, ёс заншлаа сурталчилах, таниулах

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орхон-Сэлэнгийн бэлчир, Сайхны хөтөл, Гүн нуур, Хонд, Буур хээр, Тужийн нарс зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн жуулчны бааз, амралт сувилалын газар байгуулах

- Түүх соёлын дурсгалт газруудыг түшиглэн Сүхбаатар-Алтанбулаг-Шаамар гэсэн аялалын маршрут бий болгож, дотоодын болон гадаадын жуулчдыг татах
- Түүх, соёлын дурсгалт газар болон жуулчдад үзүүлэх үзмэрийг шинэчлэн засварлах, хадгалах, хамгаалах
- “Сэлэнгэ түмэн” жуулчны цогцолбор байгуулж, аялал жуулчлалын салбарт оруулах хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын шинэ төрлийн үйлчилгээ бий болгох /өвлийн спорт, усан аялал, морин аялал г.м/

- Сүхбаатар суманд цанын баазыг байгуулах

Хүрэх үр дүн: Орон нутагт аялал жуулчлал хөгжиж, бүсийн хөгжилд тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт: Стандартын шаардлага хангасан амралт, жуулчны баазуудыг байгуулж, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын шинэ төрлүүдийг хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасган, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх
- Улсын болон олон улсын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд хамруулах
- Жуулчдын аюулгүй байдлыг хангаж, үйлчилгээний чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн: Аялалын шинэ төрлүүдийг бий болгож жуулчдын тоо нэмэгдэн, бүсийн хөгжилд оруулах эдийн засгийн хувь нэмэр нэмэгдэнэ.

1.4.3 Газар өмчлөлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Тэргүүлэх зорилт: Бүсийн сумдын газрын ашиглалт хамгаалалт, газрын харилцаа, эрх зүйн мэдээллийн санг бүрдүүлэн хөтлөх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Иргэдийн аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй газрыг давуу эрхээр өмчлөх нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Тариалан болон хот суурин газар кадастрын зураглалыг хийлгэн эрх зүйн баталгаагаар ханган улсын бүртгэлд бүртгүүлж “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн системд оруулах, сүлжээ үүсгэх
- Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээрийн газрыг тусган малчдыг бүлэг болгон зохион байгуулж, бэлчээрийг хуваарилан гэрээгээр ашиглуулах
- Газар өмчлөлийг бүрэн дуусгах
- Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдлыг харуулсан зураг хийж талхлагдсан бэлчээрийг сайжруулах арга замыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Бүсийн газар зохион байгуулалтыг төлөвлөснөөр газар ашиглалт хамгаалалтын түвшин сайжрах ба мэдээллийг “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн системд оруулах боломж бий болно.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт: Бэлчээрийн талхагдал, тариалангийн талбайн элэгдэл эвдрэлд орсон талбайн ашиглалт хамгаалалт нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бэлчээр газар тариалангийн бүсийг шинэчлэн тогтоож, хамгаалах бодлого барьж ажиллах

- Тариаланд ашиглах боломжгүй талбайг эргэлтээс хасч, олон наст ургамлын үр тариалан таримал бэлчээр бий болгох
- Хот суурин газарт газар эзэмшигчдийн эзэмшил газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгох арга хэмжээг газар эзэмших гэрээнд тусгаж жил бүр дүгнэж байх
- Газрын рентийг тодорхойлж, иргэдэд мэдээллээр нээлттэй үйлчлэх

Хүрэх үр дүн: Газрын рентийг тодорхойлдог болж, татварын уян хатан бодлого хэрэгжиж, газрын харилцааны эрх зүйн орчин сайжирч эдийн засагт нөлөө үзүүлж, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг эдийн засгийн харилцаанд оруулна.

1.5 Худалдаа үйлчилгээний салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Бүсийн хэмжээнд хүнсний барааны хангамжийг нэмэгдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

Хөгжлийн 1-р үе шат (2011-2015 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ, түүхий эдийн зах, үйлчилгээний цогцолборуудыг хөгжүүлэх
- Сүхбаатар суманд худалдааны бичил бүсийг байгуулах, итгэмжлэгдсэн шинжилгээний лабораторийг байгуулж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах
- "Ногоон хувьсгал", "Цагаан хувьсгал", "Хүнсний баталгаат байдал" үндэсний хөтөлбөрүүдийг бүсийн хэмжээнд эрчимтэй хэрэгжүүлэх
- Баяжуулсан болон зориулалтын хүнсний бүтээгдэхүүн үйлчилгээ, гэрээт борлуулагчдын сүлжээг нэмэгдүүлэх
- Үйлчилгээний салбарт ажиллагсадын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах
- Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх иргэд, аж ахуйн нэгжийн санал, санаачлагыг дэмжих

Хүрэх үр дүн: Эрүүл ахуйн шаадлага хангасан хүнсний баталгаат байдал хангагдаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээ сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат (2016-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг бүрэн хангах
- Аж ахуйн нэгж өрхийн үйлдвэрлэлийг дэмжин хүнсний шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах
- Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг бүлгийн хүмүүсийн хоол тэжээлийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг бий болгох

Хүрэх үр дүн: Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хангамж, цөцгийн тос, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангагдана.

1.6 Дэд бүтцийн бодлогын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн

1.6.1 Зам тээвэр

Тэргүүлэх зорилт: Хотын доторхи гудамж замыг сайжруулах, хатуу хучилттай замын уртыг нэмэгдүүлэх

Хөгжлийн 1-р үе шат/2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн доторхи төв замуудыг дэс дараатайгаар хатуу хучилттай болгох
- Сүхбаатар, Шаамар сумдын авто зам болон төмөр замын нэгтүвшинд огтлолцсон гарцуудыг сайжруулах,
- Явган зорчигчийн зам барих, туслах зам, гудамжуудыг тохижуулах

Тэргүүлэх зорилт: Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх

Хөгжлийн 2–р үе шат /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд аж ахуй нэгжүүдийг татан оролцуулж, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Алтанбулаг- Сүхбаатар –Дархан-Улаанбаатар чиглэлийн нийтийн тээврийн үйлчилгээг бий болгох
- Хот хоорондын нийтийн тээврийн авто вокзал барих

Хүрэх үр дүн.Замын чанар сайжирч, тээврийн үйлчилгээ өргөжин амьдрах орчны нөхцөл чанар дээшилнэ.

1.6.2 Эрчим хүч

Тэргүүлэх зорилт: Хэрэглэгчдийг чанартай найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах.

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Цаашид хэрэглэгчдийн өсөн нэмэгдэх хэмжээгээр хаалттай дэд өртөө 4, агаарын дэд өртөө 4, 10 кв-ын кабель шугам 1.1 км, 10 кв-ын 2 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих.
- Бүсийн хэмжээнд байгаа 0.4, 0.22 кв-ын агаарын дамжуулах шугамуудын модон тулгууруудыг төмөр бетон хөлтэй тулгуураар солих
- Болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор 110 квт-ын нөөц цахилгаан эх үүсвэрийг бий болгох

Хүрэх үр дүн.Хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.

1.6.3 Дулаан хангамж

Тэргүүлэх зорилт: Дулааны эрчим хүч түгээлтийн байдалд шинжилгээ судалгаа хийж дулааны шугам сүлжээг нэмэгдүүлэх,

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сүхбаатар сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан дулааны станцын хүчин чадал, шугам сүлжээг өргөтгөх
- Хот төлөвлөлт, одоогийн газар олголттой уялдуулан шинээр дулааны эх үүсвэр барих
- Утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын жижиг, дунд үйлдвэрлэлийг бүсийн сумдын төвүүдэд байгуулах

- А зэрэглэлийн бүсэд нам даралтыг зуух ашиглахыг хориглох, хийн түлшний үйлдвэрийг Сүхбаатар суманд барьж байгуулан, хэрэглээг нэмэгдүүлж, агаарын бохирдлыг бууруулах

Хүрэх үр дүн. Дээрх ажил арга хэмжээг зохион байгуулан ажилласнаар дулааны алдагдалыг багасгаж, дулааны хүртээмж нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт: Дулааны шугам, сүлжээний найдвартай, хүртээмжтэй байх нөхцөлийг хангах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Дулааны ачаалал нэмэгдэж байгаатай уялдуулан шугам сүлжээг сүүлийн үеийн технологи, материал ашиглан шинэчлэх
- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ашиглалтын хугацаа хэтэрсэн шугам хоолойг шинэчлэх, өргөтгөх
- Шатдаг хий цэнэглэх цэгийг сумдад байгуулах

Хүрэх үр дүн. Дулааны асуудал шийдэгдсэнээр хот өргөжин тэлэх иргэд тав тухтай орчинд амьдрах, үйдвэрлэл үйлчилгээ өргөжих үндэс суурь тавигдана.

1.6.4 Усан хангамж, ариутгах татуурга

Тэргүүлэх зорилт: Усан хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэжээ:

- Насжилт хэтэрсэн шугам сүлжээг хэсэгчилсэн байдлаар үе шаттайгаар засварлан сольж бүрэн шинэчлэх
- Цэвэр ус, цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх
- “Урсгал ус” ОНӨУҮГ ус хангамжийн усан сангийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглох

Хүрэх үр дүн: Ард иргэдийн тав тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт: Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар хангах

Хэрэгжүүлэх арга хэжээ:

- Ус хангамжийн шугам сүлжээг нэмэгдүүлж, гэр хорооллыг ундны цэвэр усаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Ариутгах татуургын шугамын уртыг хот төлөвлөлттэй уялдуулан нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Хүн амын усан хангамж сайжирч, эрүүл орчинд амьдрах, нөхцөл бүрдэнэ.

1.6.5. Мэдээлэл харилцаа холбоо

Тэргүүлэх зорилт: Мэдээлэл харилцаа, холбооны орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж ажиллах,

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Монголын цахилгаан холбооны салбаруудыг шилэн кабельд холбох
- Монголын цахилгаан холбооны F-Zone үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх

- Дулаанхаан тосгонд орон нутгийн телевизүүд, утасгүй холбооны сүлжээнүүдийг оруулах
 - Интернетийн сүлжээг өргөтгөн хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах
- Хүрэх үр дүн:** Мэдээлэл цахилгаан холбооны орчин үеийн технологи нэвтэрч иргэдэд үйлчлэх үйлчилгээ өргөжинө.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт 2: Мэдээлэл, холбооны салбарын үйлчилгээг үйлдвэрлэл, хүн амын ахуйн хэрэглээнд өргөн хэрэглэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Мэдээлэл холбооны суурь сүлжээг өргөтгөн, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх
- Мэдээлэл, холбооны салбарын мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх,
- Шинээр байгуулагдах сууцны хорооллуудад үйлчлэх хүрээ, хүн амын өсөлтөөс хамааруулан холбооны салбарыг шинээр байгуулах,

Хүрэх үр дүн. Мэдээлэл холбооны салбар, нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл болно.

1.6.6 Барилга хот байгуулалт

Тэргүүлэх зорилт: Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний газруудыг нэмэгдүүлэх, орон сууцжуулах

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хүн амыг орон сууцжуулах ажлын хүрээнд инженерийн хийцтэй 1000 айлын орон сууцыг шинээр барих
- Шинээр баригдаж байгаа барилга байгууламжуудын орчны тохижилтыг сайжруулах

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт: Хүн амын өсөлттэй уяалдуулан олон нийтийн үйлчилгээний болон орон сууцны барилга, байгууламжуудыг барьж байгуулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Олон нийтийн зориулалттай үйлчилгээний барилга, байгууламжуудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж байгуулах
- Орон сууцны шинэ хотхон, хорооллуудыг бий болгох

Хүрэх үр дүн. Хот төлөвлөлтийг зөв явуулснаар газар ашиглалт сайжрахын зэрэгцээ иргэдийн амьдрах таатай орчин бүрдэнэ.

ХОЁР. Нийгмийн бодлого

Бэлчирийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн Нийгмийн бодлогын гол зорилт нь сум орон нутгийн хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт нийгмийн хамгаалалыг сайжруулах, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн чадамжийг нэмэгдүүлж, аймгийн 2021 он хүртлэх хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах явдал юм.

Бүсийн хөгжлийн нийгмийн салбарыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

1. Боловсролын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
2. Эрүүл мэндийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
3. Соёл, урлагийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

4. Биеийн тамир сортын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
5. Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

2.1 Боловсролын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ..

Хөгжлийн 1-р үе шат /2011-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сувиллын ясли, цэцэрлэг, 24 цагийн ажиллагаатай цэцэрлэг шинээр барих, асрамжийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай бүлгийг нээн цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах
- Сургуулиудыг интернет сүлжээнд холбож, цахим сургалтын тоног төхөөрөмжөөр тоноглох
- Багшлах боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлж, чадавхийг сайжруулан тогтвортой ажиллах, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх
- Сургууль, цэцэрлэгийн тавилга, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслэлийн хангамжийг нэмэгдүүлж, тэдгээрийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах
- Хөгжим, зураг, шатар, дизайны чиглэлээр мэргэжлийн сургалтыг явуулах
- “Гүн нуур” хүүхдийн зусланг түшиглэн мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн, ердийн зуны сургалтуудыг тогтмол зохион байгуулж, сурагчдын авъяас чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэх
- Сургуулиудыг олон улсын боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох
- “Цахим сургалт”-ын хэлбэрийг туршин зүгшрүүлэх лаборатор сургуулийн бүтцийг бий болгох
- Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох бодлого баримтлах
- Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллыг сайжруулах
- Удирдах ажилтан, багш нар ажлын байран дээрээ суралцах шаардлагатай мэдээлэл технологийн орчинг бүрдүүлэх
- Олон улсын сургагч багш нар болон улсад нэртэй багш нарыг урьж сургалт явуулах, нээлттэй болон теле хичээл заалгах, туршлага судлах ажлыг зохион байгуулах, гадаад болон дотоодын дэвшилтэт туршлага, арга зүйг судлах ажилд хамруулах
- Төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулийн салбар сургууль байгуулах санал санаачилгыг дэмжих
- Сургуулиудын шатрын болон IQ сургалтын дугуйлан, клубын үйл ажиллагаанд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх
- Сургууль, орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг баяжуулахад хөрөнгийн дэмжлэг үзүүлэх

- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн хувийн хэвшлийн байгууллагуудын эрэлт дээр тулгуурлан мэргэжлийн ажилчин бэлтгэх, иргэдэд мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах
- Албан бус Гэгээрлийн төвийг түшиглэн иргэдэд өрхийн орлого нэмэгдүүлэх, амьдрах арга ухаан, мэдээлэл, технологи, эрүүл мэнд, эрх зүй, экологи, эдийн засгийн сургалтанд хамруулах
- Уул уурхай, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад залуусыг сургах, сургалтын зардлыг төрөөс санхүүжүүлэх боломжийг олгох

Хүрэх үр дүн: Боловсролын тогтолцооболовсронгуй болж, олон улсын жишигт ойртуулахад төрөөс үзүүлэх дэмжлэг нэмэгдсэн байна. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдсэн байна.

2.2 Эрүүл мэндийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ

хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Монгол Улсын хүний эрүүл мэндийн хөгжлийн бодлого нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулж, хүн амын цэвэр өсөлтийг дэмжиж, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, хангамж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх
- Шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношилгоо, эмчилгээний арга технологийг сумын түвшинд нэвтрүүлэх
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эсэн мэнд амаржихуй, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэ өвчний талаар зөвлөгөө өгөх, шинжилгээ хийх нээлттэй нэг цэгийн үйлчилгээг бий болгох, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах
- Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх
- Бага насны хүүхдүүдийг дархлаажуулалтанд бүрэн хамруулах
- Хүн амын өсөлттэй уялдуулж, өрхийн эмнэлгийн тоог нэмэгдүүлэн өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлд өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх, техник тоног төхөөрөмж, унаагаар хангах
- Эрүүл мэндийн салбарт цахим мэдээллийн технологийг хөгжүүлэхэд эмнэлгүүдийг интернет сүлжээнд холбон, цаасгүй эмнэлэг болох
- Өвчний түүхийг цахим картын мэдээллийн санд оруулах
- Орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх
- Түргэн тусламжийн автомашинаар хангах, парк шинэчлэлийг сайжруулах
- Нарийн мэргэжлийн чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад эмч нарыг сургах сургалтын зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлэх
- Эмч, эмнэлгийн ажилтны нийгмийн батлагааг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх

- Нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны төрлүүдийг хөгжүүлэх
- Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх
- Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх
- Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх орон нутгийн удирдлагуудын чадавхийг бэхжүүлэх
- Хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчин бий болгох замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжцогц байдлаар хөгжих боломж бүрдсэн байна. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалт ахиж, эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйл төлөвшинө.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өргөжүүлж, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангаж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулна
- Эрүүл мэндийн хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх
- Хүнамын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлэн тусламж, үйлчилгээний нөөцийг шатлал бүрээр зохистой хуваарилан анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг тогтвортой нэмэгдүүлэх
- Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, биологийн идэвхитэй бодисын чанарын баталгаа, аюулгүй байдлыг хангах

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн салбарт удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоо бүрдсэн байна. Хүнамыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр ханган эрүүл мэндийн шаардлагатай, зохистой технологийг нэвтрүүлж, салбарын дэд бүтэц сайжирсан байна.

2.3 Соёл урлагийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ

хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт 1: Соёл урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангаж соёл урлагийн байгууллагуудын менежментийг сайжруулах, ажиллагсдыг ажлын байраар нь дагалдуулан сургаж мэргэшүүлэх, тасралтгүй сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулах

Хөгжлийн 1-р үе шат / 2010-2015 /

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрөөс баримтлах соёлын бодлого, хүний хөгжлийн цогц бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг үндэс болгон орон нутгийн өвөрмөц онцлогт тохирсон, биеэ даасан, чөлөөтэй хөгжих соёлын орчинг бий болгох
- Хөдөө орон нутагт ажиллах соёл урлагийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх

- Сумдын соёл, урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангахын тулд мэргэжлийн боловсон хүчнийг ЕБС-иас нь эхлэн бэлтгэж сургах замаар шийдвэрлэх
- Олон Улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд үе шаттайгаар бэлтгэж оролцох бодлого боловсруулах

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжлийг хангаж, чадварлаг хүний нөөцөөр хангагдаж, соёлын үйлчилгээний хүртээмж сайжирна.

Хөгжлийн 2-р шат / 2016-2021/

Тэргүүлэх зорилт 1: Соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд манлайлагч байх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутаг судлах музей шинээр барих, соёлын төвүүдийг стандартын шаардлагын хэмжээнд хүргэж тохижуулах, орчин үеийн техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр хангах
- Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүрээг өргөтгөх зорилгоор төрөл бүрийн төрөлжсөн дугуйлан /үндэсний хөгжмийн хамтлаг, биелгээ бүжгийн хамтлаг, язгуур хамтлаг, хүүхдийн морин хуурийн чуулга гэх мэт / хичээллүүлэх, уран бүтээлийн болон уран сайхны хамтлаг байгуулах нөхцлийг бүрдүүлж түүгээрээ дамжуулан ард, иргэдэд чанартай, оновчтой үйлчилгээг хүргэх.
- Хөрш орны хил орчмын аймгуудтай соёлын харилцаа холбоог хөгжүүлж харилцан туршлага судлах, язгуур урлаг соёлын уламжлалаа сурталчлан таниулах зэргээр найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Сумдын номын санг иргэдэд мэдээллээр үйлчлэх үүрэг бүхий номын сан, цахим мэдээллийн төв болгон өөрчлөн зохион байгуулах, электрон каталогит оруулан, сум, сургуулийн номын санг орчин үеийн компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн тоог нэмэгдүүлэх, хамгаалалтын оновчтой тогтолцоог бий болгох

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагууд стандартын хэмжээнд хүрч ажиллах ба бие даасан үйл ажиллагаа сайжирч, иргэд үзэгчдийг урлаг, соёлоор дамжуулан нийгэмшүүлнэ.

2.4 Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Хүн амыг спортод сонирхолтой болгож эрүүл зан үйлд сургаж, биеийн тамирын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан дундаж наслалтыг уртасгах

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015 он/

Хэрэгжүүлэх стратеги:

- Спорт ордны заал, танхим, материаллаг баазад тулгуурлан спортын төрөл бүрийн секц, дугуйлан хичээллүүлж улс, олон улсын тэмцээнд оролцох, туршлага солилцох
- Усан бассейн Сүхбаатар суманд байгуулж спортын шинэ төрөл усан сэлэлтийн спортыг хөгжүүлэх
- Биеийн тамир, спортын салбар клуб, холбоо хамтлагийн тогтолцоо бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, төсөв санхүүгийн оновчтой бодлого хэрэгжүүлж эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх

- Спортын бүрэн дунд сургуулийн багш дасгалжуулагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, гадаадын орны багш солилцоогоор дамжуулан туршлага солилцох

Хүрэх үр дүн: Нийтийн биеийн тамир, спортын хүртээмж, өргөжин хүн амын эрүүл мэнд сайжирч тамирчдын чадвар дээшилж улс тив, дэлхийн тэмцээн уралдаанд амжилттай оролцож, нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Тэргүүлэх зорилт: Биеийн тамир, спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж, хүртээмж чанарыг дээшлүүлэн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвар өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцлийг бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орхон, Сэлэнгэ мөрний тохиромжтой газарт хиймэл нуур хийж, тохижуулан усан спортыг хөгжүүлэх
- Бизнесийн байгууллагуудтай өргөн түншлэл тогтоож тамирчдад хөрөнгө оруулалт хийлгэх гэрээ хэлэлцээр байгуулах
- Олон улсын спортын байгууллага, спортын холбоодуудаар дамжуулан тэдэнтэй хамтарсан бэлтгэл хийх орчин нөхцлийг бүрдүүлэн, тамирчдынхаа ур чадварыг нэмэгдүүлж, насанд хүрэгчид, тив, дэлхийн томоохон тэмцээнээс медаль авах, орон нутаг, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөхөд тал бүрийн дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн: Биеийн тамирын ажил, үйлчилгээ нь бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн хөдөлгөөн, хувь хүн, албан байгууллагын санаачлага болон өрнөнө.

2.5 Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Хүн амыг байнгын ажлын байраар ханган орлогыг нэмэгдүүлж ажилгүйдлийг тогтвортой бууруулж амьжиргааны түвшинг дээшлүүлэх.

Хөгжлийн 1-р үе шат /2011-2015он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх
- Нийгмийн даатгалд хамрагдах иргэдийн хүрээг өргөжүүлж тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд бүсийн хүн амыг бүрэн хамруулах
- Ядуу, бага орлоготой иргэдийг амьдрах арга ухаанд сургаж газар тариалан эрхлүүлэх, уламжлалт мал маллагааны арга барилд сургах, малжуулах, бие даан өрхийн үйлдвэрлэл эрхлэн ажиллаж, амьдрах бололцоог өөрсдөө бий болгоход сургаж хэвшүүлэх замаар өрхийн амьжиргааг дэмжих
- Олон малтай мөн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг, хүн хүч дутагдалтай өрхөд гэрээт тариаланч, ногоочин, малчны хэлбэрээр ядуу өрхөөр туслуулан ажиллуулж фермерийн аж ахуй бий болгохыг дэмжих
- Байгаль орчныг хамгаалах ялангуяа цөлжилтээс хамгаалах ойн зурвас байгуулах замаар газрын хөрс бэлчээрийг хамгаалах сумын төвд мод, зүлэг тарих ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг оролцуулах ажлыг өргөнөөр зохион байгуулах.
- Ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг орон нутагт идэвхижүүлж уялдаа холбоог сайжруулах

- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Хөдөлмөр эрхлэлт сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн бизнес төвүүдтэй хамтран хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжил олгох болон мэргэжлийн ур чадварын сургалтанд ажилгүй залуучууд нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулж сургалтын чанар үр дүнг сайжруулах .
- “Тогтвортой амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд нийгмийн дэмжлэг, тусламж шаардлагатай хэсэгт туслах зорилгоор банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг байрлуулж хооллон сургалт явуулах халамжийн төвүүдийн үйлчилгээг нэмэгдүүлэн амьдралын арга ухааныг зааж сургах ажлыг өргөжүүлэх
- Ядуу иргэд, орон гэргүй хүмүүсийг гэр хашаа, орон сууц худалдан авах, барих, орон байраа өргөтгөх, засварлах боломж олгох зорилгоор орон сууцны зээлийн үйлчилгээнд хамруулах
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болгох, хамтарч ногоо, жимс тарьдаг хамтын аж ахуйтай болгоход нь зааж сургах, зөвлөлгөө өгөх

Хүрэх үр дүн: Ажлын байр шинээр бий болгосноор ажилгүй иргэдийн эзлэх хувь 28,5 хувь болж, ажилгүйдлийн түвшинг бууруулсан байна. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдийн нийгмийн хамгаалалын тогтолцоог боловсронгуй болгож тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж өрхийн орлого нэмэгдүүлэх бололцоог хангаж өгөх.

Тэргүүлэх зорилт: Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн талаас илүү хувийг амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгож нийгмийн хамгааллын хүртээмж үйлчилгээг сайжруулах.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бичил аж ахуйн нэгжүүдийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес-инкубаторын төвийн үйл ажиллагааг сайжруулан өргөжүүлэх
- Хөдөлмөр эрхлээгүй хүмүүс ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдийг авто зам болон нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажлыг хэсэгчлэн гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоонд шилжих
- Тахир дутуу иргэдийн ажиллах амьдрах таатай орчинг бүрдүүлж тэдэнд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Ахмад настанд үзүүлж байгаа тусламж хөнгөлөлтийг сайжруулж өрхийн тэтгэмжийн төрлийг шинээр бий болгох

Хүрэх үр дүн: Ажлын байр нэмэгдэн нийгмийн халамж, үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.

ГУРАВ: Засаглалын бодлого

3.1 Засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р шат /2011-2015 он/

Тэргүүлэх зорилт: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, хялбаршуулах чиглэлээр бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Багийн ажиллах нөхцлийг сайжруулах бодлого барьж төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй шуурхай хүргэх
 - Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, хяналттай байлгах чиглэл баримтлах
 - Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх
 - Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд цахим арга хэлбэрийн ашиглалтыг өргөжүүлэх
 - Төрийн албан хаагчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, гадаад оронд туршлага судлуулах, богино хугацааны сургалт семинарт хамруулах
- Хүрэх үр дүн:** Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар дээшилж төрийн үйлчилгээний үр нөлөө сайжирна.

Тэргүүлэх зорилт: Иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлийг бууруулан, иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах
- Өмчийн эсрэг гэмт үйлдэл, түүний дотор орон байрны хулгай, малын хулгайн эсрэг нутгийн захиргаа, хууль хяналт, иргэдийн хамтын үйл ажиллагааг идэвхижүүлэх
- Хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл лавлагааг шаардлагатай цаг үед шуурхай авдаг цахим үйлчилгээг бий болгох
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд болон хүн худалдаалах зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах
- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг багасгахад иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнд хүргэх

Хүрэх үр дүн: Хүүхдийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж гэмт хэрэг, зөрчил буурна.

Тэргүүлэх зорилт 1: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг эдийн засгийн чадавхи, хүн амын нөөцөд тулгуурлан боловсронгуй болгох.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг иргэдийн санал, газар зүйн байршил, хүн амын тоо, эдийн засгийн чадавхийг харгалзан боловсронгуй болгох
- Нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах зарчмыг баримтлах
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх
- Нийгмийн дэг журам сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулж, цахим мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох

Хүрэх үр дүн: Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

3.2 Гадаад харилцааны бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлнэ гэсэн Засгийн газрын зорилтыг үндэс суурь болгон зарим улс орнуудтай гадаад харилцааны бодлогын уламжлал болон залгамж чанарыг хадгалан түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлж, гадаадын хөрөнгө

оруулалтыг нэмэгдүүлэх замаар сумын эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж орон нутгаа хөгжүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат /2010-2015 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сумдын түүх, соёлын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засгийн давуу тал, онцлог, нөөц боломжийн талаар гадаад орнуудад сурталчилах
- Оюуны гадаад хөрөнгө оруулалтыг дэмжиж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг өргөн ашиглах үүднээс төрийн албан хаагч, бизнес эрхлэгчийг гадаад орнуудад сургах, мэргэшүүлэх
- Хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж тодорхой улс орнуудтай шинээр харилцаа тогтоох, богино болон урт хугацаагаар гэрээ байгуулах, харилцах хөтөлбөр боловсруулан ажиллах арга хэмжээг шат дараатай авах
- Нийгмийн хамгааллын чиглэлээр гадаад орнуудын төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх
- Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн барилга байгууламж, дэд бүтцийг бүрэн барьж байгуулах
- Хил гаалийн дүрэм, журмыг цэгцтэй, ил тод байлгах, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгох, хяналт хураамжийг багасгах зэрэг худалдааг хөнгөвчлөх замаар бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, саад тотгор, хүнд сурталыг багасгаж, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, хил орчмын бүс нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах нөхцлийг сайжруулах

Хүрэх үр дүн: Гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжиж, бүсэд орох хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2016-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангах
- Бусалд улс орны муж, хотуудтай ах дүүгийн найрамдал, хөгжлийн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулж, гадаад харилцааг бэхжүүлэх
- Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийг түшиглэсэн олон улсын худалдааны цогц үйлчилгээг бүсийн сумдад байгуулах

Хүрэх үр дүн: Гадаад улс орнуудын хатын ажиллагаа өргөжин, эдийн засгийн харилцаа сайжирна.

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ		2008	2009	2010	1-р үе шат 2015 он	2-р үе шат 2021 он
1	ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	1. ДНБ /сая.төг/	53765.95	72193.18	81631.8	95000.0	115000.0
		2. Нэг хүнд ноогдох ДНБ мян.төг	1897.9	2345.5	2626.2	2968.7	3484.8
		3. Нийт хөрөнгө оруулалт /сая.төг/	4405.9	19042.9	10817.3	20985.6	26394.2
		4. Аж үйлдвэрийн НБ /сая.төг/	37636.17	50535.22	57142.26	63000	64400
		5. Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн НБ /мян.төг/	1328.5	1641.8	1838.3	2739.13	2683.3
		6. ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /сая.төг/	10753.19	14438.64	16326.36	18000	18400
		7. Нэг хүнд ноогдох хүнс ХАА-н бүтээгдэхүүн /мян.төг/	379.6	469.1	525.2	782.6	786.7
		8. Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн /сая.төг/	542.0	550.0	564.0	600.0	750.0
		9. Өрхийн аж ахуйн нийт бүтээгдэхүүн /сая.төг/	420.0	462.0	481.0	600.0	700.0
		10. Аялал, жуулчлал, худалдаа, үйлчилгээн ий нийт бүтээгдэхүүн /сая.төг/	3763.6	5053.5	5714.2	6300	6440
		11. Малын тоо / мян.тол/	112305	114854	69088	70000	75000
		12. Өндөр ашиг шимт цэвэр, эрлийз шилмэл омгийн малын эзлэх хувь	16,9	18,1	27,9	35,7	53,3
		13. Хураан авсан ургац /тн/	Үр тари а	6900	11323	6954	7500
Төмс	7637		6694	5416	7000	9000	
Хүнс ний ного о	6719		6179	5242	7000	9000	
Мал ын тэжэ эл	25808		7145	19800	20000	22000	

2	НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	14. Нийт хүн ам	28329	30779	31084	32000	33000	
		15. Үүнээс: хөдөлмөрийн насны	21852	21982	22089	23000	24000	
		16. Дундаж наслалт	65.4	65.8	65.6	66.0	68.0	
		17. Дунд сургуульд элсэгчдийн харьцаа /хувь/	99.8	99.8	99.8	100.0	100.0	
		19. Эхийн эндэгдэл/тоо/	-	-	-	-	-	
		20. Нялхасын эндэгдэл/ 1000хүүхдэд ноогдох/	4	9	11	5	3	
		21. Ажилгүйдлийн түвшин	8.7	9.1	8.8	6.0	2.0	
		22. Халдварт өвчин	А гепати т	176	53	75	-	-
			Сүрье э	130	111	116	-	-
			БЗДХ	146	272	271	-	-
Нийт халдв арт өвчин	617		612	530	-	-		
3	БАЙГАЛЬ ОРЧИН, ДЭД БҮТЭЦ	23. Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	-	-	-	-	-	
		24. Ойжуулсан талбайн хэмжээ /га/	210	180	240	300	400	
		26. Уул уурхайн олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлт /га/	-	-	-	-	-	
		27. Ашиглалтанд орсон барилгын нийт талбай /мян.м ² /	-	-	920	20000	30000	
		28. Сэргээгдэх эрчим хүчээр хангагдах малчин өрхийн нийт өрхөд эзлэх хувь	20.8	19.1	21.2	100.0	100.0	
		29. Бэлчээрийн усжуулалт /хувь, өсөн нэмэгдсэн дүнгээр/	15	19	24	40	70	
		30. Усалгаатай тариалангийн талбай /га, өсөн нэмэгдсэн дүнгээр/	420	580	640	750	1000	

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 07-ны өдөр

Дугаар 67

Сүхбаатар

Тэмдэгтийн хураамжийн хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.20-ын “д”, Улсын тэмдэгтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 35 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Сэлэнгэ аймгийн төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

Хоёр.Аймаг, сумын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг 2011 оны 10-р сарын 7-наас эхлэн мөрдүүлэн хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбатад даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ЖАГСААЛТ

Улсын тэмдэгтийн хураамжийн төрөл	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1.Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход	500 000
2.Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход	200 000
3.Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход	200 000
4.Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход:	
гэрээний жил тутамд	30 000
гэрээг сунгахад	25 000
5.Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад	50 000
6.Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход	100 000
7.Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход	60 000
8.Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход	10 000
9.Ан амьтан болон ургамлын гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход	2 500
10.Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад	800 000
11.Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход:	
0-10 толгой мал бол	2 500
10-аас дээш тооны толгой мал бол 2500 төгрөг дээр 10-аас дээш тооны малын толгой тутамд	70 төгрөг нэмж
12.Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд	3 000
13.Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход	1 500
14.Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд	8 000
15.Ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход	
0-10 килограмм бол	2 000

10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд	80 төгрөг нэмж
16.Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн	
хуулийн этгээдэд олгоход	250 000
иргэнд олгоход	200 000
17.Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн олгоход	100 000
18.Мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход	2 500
19.Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход	250 000
20.Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах а/тусгай зөвшөөрөл олгоход	
аймгийн төвийн суманд	400 000
бусад суманд	250 000
б/тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:	
аймгийн төвийн суманд	150 000
бусад суманд	80 000
21.Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах а/тусгай зөвшөөрөл олгоход	
аймгийн төвийн суманд	150 000
бусад суманд	80 000
б/тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:	
аймгийн төвийн суманд	50 000
бусад суманд	30 000
22.Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх а/тусгай зөвшөөрөл олгоход	
аймгийн төвийн суманд	800 000
бусад суманд	500 000
б/тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:	
аймгийн төвийн суманд	300 000
бусад суманд	150 000
23.Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх а/тусгай зөвшөөрөл олгоход	
аймгийн төвийн суманд	300 000
бусад суманд	200 000
б/тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:	
аймгийн төвийн суманд	150 000
бусад суманд	100 000
24.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход	100 000
25.Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход	
6 м ³ хүртэл	3 000
6-10 м ³ хүртэл	4 500

10-20 м ³ хүртэл	6 000
20-60 м ³ хүртэл	15 000
26.Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:	
8 м ³ хүртэл	4 500
8-10м ³ хүртэл	6 000
10-20м ³ хүртэл	10 000
20-30м ³ хүртэл	15 000
27.Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:	
0-10 м ³	1 000
10-20 м ³	1 500
20-30 м ³	3 000
28.Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход	
0-10 куб метр бол	2 000
10 куб метрээс дээш бол 2000 төгрөг дээр 10-аас дээш сийрэг куб метр тутамд	150 төгрөг нэмж
29.Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход	
0-10 куб метр бол	2 000
10 куб метрээс дээш бол 2000 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд	150 төгрөг нэмж

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 07-ны өдөр

Дугаар 69

Сүхбаатар

Нэмэгдэл зардлыг санхүүжүүлэх тухай

Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “з”-г үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.2011 оны 5 дугаар сард аймгийн нутаг дэвсгэрт цаг агаар эрс хүйтэрсэнтэй уялдуулан аймгийн Онцгой байдлын комиссын шийдвэрээр 2011 оны 5 дугаар сарын 10-ныг дуустал хугацаанд аймгийн төвийн албан байгууллагуудыг дулаанаар хангахад гарсан 72.0 сая төгрөгийн нэмэгдэл зардлыг аймгийн төсвөөс санхүүжүүлсүгэй.

2.Дээрх зардлыг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын аймгийн төсөвт төлөх өглөгөөс хасаж тооцохыг аймгин Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Ж.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖОЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 70

Сүхбаатар

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг “Хангалттай” гэж үнэлсүгэй.

2.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

3.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2012 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

№	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хяналт тавих байгууллага
Нэг. Ниймийн бодлого			
1.Нийгмийн эрүүл мэндийн эмнэлгийн тусламж үйлчилгээг нийт хүн амд жигд, хүртээмжтэй чанартай хүргэж, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлнэ.			
1	Эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд хамруулах	ЭМГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
2	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг өргөжүүлэх	ЭМГ	Аймгийн ЗДТГ
3	Иргэдийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, хүн амын өвчлөл, нас баралтын түвшинг бууруулах	ЭМГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
4	Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулан өвчлөл эндэгдлээс сэргийлэх, өвчлөлийг бууруулах	ЭМГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
5	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	ЭМГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
6	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангах	ЭМГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
7	Монголын бүх ард түмний спартакиадад тамирчдыг амжилттай оролцуулах	БТСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ

8	Спортын холбоо клубүүдийн үйл ажиллагааг дэмжин, нийтийн биеийн тамир спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх	БТСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
9	Спортын гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн үйл ажиллагааг өргөжүүлэн сургалтын чанар, сурах орчинг сайжруулж, өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх	БТСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
10	Өвлийн спортыг орон нутагт хөгжүүлэх, хүн амыг чийрэгжүүлэх зорилгоор цанын бааз байгуулах	БТСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
11	Сүхбаатар суманд 20 ортой халдвартын эмнэлэг барих ажлыг дуусгах	ЭМГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
12	Сүхбаатар суманд спорт цогцолбор усан бассейн барих ажлыг дуусгах	Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
13	Цагааннуур сумын хүн эмнэлэгт их засвар хийх	Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
2.Боловсролын салбарын шинэчлэлийг хөгжүүлж, сургалтын таатай орчинг бүрдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.			
1	Сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг 97.5 хувьд хүргэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
2	Сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэйгээр зохион байгуулан суурь боловсролын хамран сургалтыг 98.9 хувьд хүргэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
3	Сургууль, цэцэрлэгийн “Багш хөгжлийн танхим”-ыг стандартын шаардлагад нийцүүлэн иж бүрэн тохижуулж, багш нарыг чадавхижуулах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
4	Сургалтанд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэн, бүх сургууль цэцэрлэгүүдийг интернетэд холбож, техник хэрэгслээр хангах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
5	Зарим сургуулиудын хими, биологи, газар зүй, физикийн лаборатори кабинетуудыг сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
6	ЕБС, цэцэрлэгийн 40 хувийг эмчтэй болгох	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
7	АББ-ын Гэгээрэл төвүүдийг иргэдэд үйлчлэх, боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаагаа	БСГ	Аймгийн

	өргөжүүлэхэд сум, орон нутгийн зүгээс хүрэлцээтэй байр танхим, материаллаг баазын дэмжлэг үзүүлэх	Сумдын ЗДТГ	ЗДТГ
8	Зарим сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэлийг шинэчлэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
9	Зарим сургуулийг зориулалтын цайны газартай болгож, сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
10	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүдийг бэхжүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
11	Мандал суманд 560 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг барьж дуусгах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
12	Сүхбаатар суманд 960 хүүхдийн сургууль, спорт заалыг барьж дуусгах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
13	Зүүнбүрэн, Сүхбаатар сумын спорт сургуулийн спорт залыг барьж ашиглалтанд оруулах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
14	Баянгол, Түшиг суманд 75 ортой цэцэрлэгийн барилгыг барьж дуусгах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
15	Мандал сумын Хэрх тосгоны цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
16	Алтанбулаг, Жавхлант сум, Дулаанхан тосгонд шинээр баригдах 75 ортой, Мандал, Шаамар суманд 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
17	Баруунбүрэн суманд спорт заал барих ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
18	Ерөө сумын Бугант тосгоны дотуур байрны засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
19	Орхонтуул сумын Рашаант тосгоны 12 жилийн дунд сургуулийн мэдээлэл зүйн кабинетийг тохижуулах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
20	Сүхбаатар сумын 6-р сургуулийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
21	Бугант тосгоны 12 жилийн сургууль, Баруунбүрэн	Сумын ЗДТГ	Аймгийн

	сумын цэцэрлэгийн барилгын цэвэр бохир усны их засварын ажлыг хийж гүйцэтгэх		ЗДТГ
22	Хүдэр сумын 23-р цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
23	Түшиг, Сүхбаатар сумын 1-р сургууль, Номгон тосгоны 12 жилийн дунд сургуулиудын их засварын ажлыг хийж гүйцэтгүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
24	Алтанбулаг суманд спорт зал барих ажлын зураг төслийг боловсруулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
25	Сант суманд 600 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг эхлүүлэх	ХБХ	Аймгийн ЗДТГ
3. Хүн амын оюуны эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, өмчийн олон хэлбэрт түшиглэсэн соёл, урлагийн ажил үйлчилгээг сайжруулна.			
1	Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио”, “Мөнгөн Хараа” чуулгыг мэргэжлийн уран бүтээлчээр хангаж, соёлын салбарт ажиллагсдын мэргэшлийг дээшлүүлэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
2	Соёлын төв, сургуулийн номын санчдыг цахим программ, цахим номоор үйлчлэх арга зүйг эзэмшүүлэх сургалтанд хамруулах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
3	Сумдын соёлын төвийн нийтийн номын сангийн номын фондын баяжилтыг нэмэгдүүлж, орон нутаг судлах танхимын ажиллагааг сайжруулах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
4	Түүх, соёлын эд зүйлсийн иж бүрэн мэдээллийн санг бүрдүүлж, иргэдэд гэрээгээр хариуцуулан өгч, урамшуулах ажлыг зохион байгуулах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
5	Сумдын соёлын төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хийх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
6	Улсын хэмжээний уралдаан наадамд мэргэжлийн уран бүтээлчид, ардын авъяастан, хүүхэд залуучуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлж, урлагийн наадамд оролцох төрлийг нэмэгдүүлэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
7	“Сэлэнгэ аймгийн нутаг дахь түүх соёлын дурсгалт зүйлс” номыг Соёлын өвийн төвтэй хамтран хэвлүүлэх	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ

8	Соёл, урлагийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, ардын авъяастнуудын тоглолтыг орон нутагт зохион байгуулах	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
9	Хүдэр, Шаамар, Сүхбаатар сумын 5-р баг, Орхонтуул сумын Рашаант тосгонд соёлын төв шинээр барих	БСГ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
10	Орхон сумын соёлын төвийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
4. Аймаг орон нутгийн онцлог, иргэдийн эрэлт, хүсэлтэд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэн, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.			
1	Ажилгүй эмзэг бүлгийн иргэдийг хамруулсан олон нийтийн ажил, арга хэмжээг зохион байгуулан түр ажлын байрыг бий болгох	ХХҮХ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
2	Иргэдийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургаж бэлтгэх, ур чадварыг нэмэгдүүлэх	ХХҮХ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
3	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 2.6 хувьд хүргэж бууруулах	ХХҮХ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
4	Иргэдэд арилжааны банкуудаар дамжуулан жижиг зээл олгож, шинэ ажлын байр бий болгох	ХХҮХ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
5	Малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	НДХ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
6	Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэлтэй нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуй нэгжийн судалгааг гаргаж, хамруулах ажлыг зохион байгуулах	НДХ Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын НХХ
Хоёр. Эдийн засгийн бодлого			
1.Үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлж, бүтээгдэхүүний төрлийг олшруулах, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.			
1	Алт, нүүрс, төмрийн хүдэр, цемент шохойн олборлолт, үйлдвэрлэлтийг дэмжиж, аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дундаж	ХБХ	Аймгийн ЗДТГ

	өсөлтийг 10 хувьд хүргэх		
2	Түшиг, Хүдэр сумдад зөгийн аж ахуйг эрчимжүүлж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, Сүхбаатар хотод Зөгий- 2012 хөтөлбөр хэрэгжүүлэх	ХБХ, Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, техник, технологийн шинэчлэл хийж бүтээгдэхүүний үйлдвэрлэл, чанарыг сайжруулах арга хэмжээ авах	ХБХ, Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
4	Ерөө, Цагааннуур сумдад бизнес мэдээллийн төв байгуулах	ХБХ, Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
5	Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг Сайхан суманд байгуулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
6	Орон нутгийн түүхий эдийн давуу талд тулгуурласан үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
7	“Чацаргана” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, жимс жимсгэний талбайн хэмжээг нэмэгдүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
8	Орхоны бүсэд өрхийн хэмжээнд үйлдвэрлэж байгаа төмс, хүнсний ногоог түшиглэн, боловсруулах үйлдвэрийг бүсийн төв Сайхан суманд байгуулах.	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
9	Бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын үйлдвэрийг Орхон суманд байгуулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
10	Загас үржүүлэх аж ахуйг Хүдэр, Мандал суманд байгуулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
11	Өрхийн амьжиргааг дэмжих "Үйлдвэрлэгч өрх-2012" хөтөлбөрийг 17 суманд хэрэгжүүлэх	ХБХ, Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
2. 147,0 тн үр тариа, 3,5 мян тн төмс 3,1 мянган тонн хүнсний ногоо үйлдвэрлэж, 150000 мян га уринш, 145,0 мян тн байгалийн хадлан бэлтгэнэ.			
1	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулан 158.0 мянган га-д уринш хийж, 147.0 мянган га-д үр тариа, 3500.0 га-д төмс, 2100 га-д хүнсний ногоо, 2000 га-д малын тэжээл тариалах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
2	Усалгаатай тариалан эрхлэх гадаргуугийн болон гүний усны нөөцийг үр дүнтэй ашиглах,	ХБХ,	Аймгийн

	усалгаатай тариалан эрхлэх үйл ажиллагааг дэмжих	ХХААЖДҮГ	ЗДТГ
3	Үр үржүүлэх, нутагшуулах иргэн, аж ахуйн нэгжийг сонгон тогтоож, энгийн болон усалгаатай нөхцөлд тариалах үрийн нөөц бий болгох, үрийг сортоор нь хадгалах зориулалтын агуулахтай болгоход дэмжлэг үзүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
4	Төмс, хүнсний ногооны үр үржүүлэх ногоочдыг сонгон, дээд үржүүлгийн үрээр хангаж, нутагшуулах ажлыг дэмжиж үрийн нөөц бүрдүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
5	Арвай, хүнсний бог будаа, сагагдай, гич, эрдэнэшиш зэрэг хүнсний зориулалтын ургамлын үрийг импортлон сэлгээнд ашиглах замаар хүнсний хангамжийг нэмэгдүүлж экспортлохыг дэмжих	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
6	Үр тариа эрхлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулдаг шалгуур үзүүлэлтүүдийг батлуулан, шалгуурыг хангасан аж ахуйн нэгжид газар эзэмшүүлж, үр тарианы үйлдвэрлэл эрхлэх эрхийг төсөл сонгон шалгаруулах замаар олгож, хөрсийг хамгаалах, сайжруулахад хяналт тавьж ажиллах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
7	Төмс, хүнсний ногоо эрхлэгчдэд туслах үйлчилгээтэй дундын үйлчилгээг хоршооны хэлбэрээр байгуулж, тоног төхөөрөмжөөр хангах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
8	Хөдөө аж ахуйн техник, машин механизмыг угсрах болон сэлбэгийн засварын цехийг Баянгол суманд байгуулах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
9	Үүлэнд зориудаар нөлөөлж хур тундасын хэмжээг нэмэгдүүлэх	ХХААЖДҮГ, УЦУОША	Аймгийн ЗДТГ-ын ХБХ
10	Тариалангийн болон бэлчээрийн зориулалтаар ашиглаж байгаа талбайн хэмжээг шинэчлэн тогтоож, нэгж талбайн хувийн хэрэг тус бүрийг цахим хэлбэрт шилжүүлэн мэдээллийн сан байгуулах	ХБХ, ГХБХБГ	Аймгийн ЗДТГ
3.Цэвэр эрлийз, нутгийн шилмэл омгийн малын тоог урьд оныхоос 10 хувиар өсгөж, иргэдэд төрөөс үзүүлэх мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг чанартай технологийн хугацаанд явуулж, малын тооны өсөлтөөс татгалзаж, эрүүл чанартай малтай болно.			
1	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг бүрэн хамруулах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ

2	Малчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах арга хэмжээг зохион байгуулах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
3	Бэлчээрт шинээр уст цэгийн хайгуул хийж, худаг уст цэгийн тоог нэмэгдүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
4	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг нэмэгдүүлэх, шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчээр хангах аж ахуйг байгуулж, нийт малд цэвэр эрлийз, нутгийн шилмэл омгийн малын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
5	Бэлчээр, хадлангийн эдлэн газрынхаа хөрсний үржил шимийг хадгалж, өвс тэжээлийн ургацыг нэмэгдүүлэхэд экологийн цэвэр бууцан бордоог ашиглах технологийг нэвтрүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
4. Худалдаа, ахуйн үйлчилгээний салбарт соёлч, шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.			
1	Төмс, хүнсний ногоо болон аймгийн “Бренд” бүтээгдэхүүнийг нийслэл болон хүн ам төвлөрсөн төв суурин газруудад худалдаалах, “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
2	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан төсөл санаачлагад дэмжлэг үзүүлэх	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
3	Ахуйн үйлчилгээг дэмжиж, чанар хүртээмжийг сайжруулах	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
4	Иргэд, аж ахуйн нэгжүүдийн тарьж ургуулсан төмс, хүнсний ногоог хүн ам төвлөрсөн төв суурин газруудад хадгалах, борлуулах сүлжээг бий болгох	ХБХ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
5	Түшиг, Ерөө сумын үйлчилгээний төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
6	Сүхбаатар суманд худалдааны төвийн байрыг шинээр барих ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
5. Байгаль орчныг хамгаалах талаар гарсан Монгол Улсын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлж уул уурхайн нөхөн сэргэлтийг нэмэгдүүлэн, цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.			

1	Ойн нөөцийг хамгаалах, ойн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулан улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгөөр 1500 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
2	Цөлжилтөөс сэргийлэх хяналт, шинжилгээг сайжруулж, сургалт, сурталчилгааг зохион байгуулан, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
3	Нутгийн иргэдийг түшиглэн ойн санг хамгаалах, гэрээгээр эзэмших тогтвортой менежментийг бий болгож, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх	ХБХ, БОАЖГ, ХХААЖДҮГ	Аймгийн ЗДТГ
4	Ойг хөнөөлт шавьж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг зохион байгуулах	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
5	Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй арга технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг хязгаарлаж, бүс нутаг, сумдын хүн амд ашигт малтмалын орд ашиглагчдаас үзүүлэх нийгэм, соёлын арга хэмжээ, ажлын байр бий болгох дэмжлэгийг нэмэгдүүлэх	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
6	Хүн, малын ундны усны хэрэглээний чухал эх үүсвэр булаг, шандын эхийг хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
7	Сэлэнгэ мөрний усыг хэмжих, агуулгыг тодорхойлох, хяналт тавих нөхцлийг бүрдүүлж техник, тоног төхөөрөмжөөр хангах	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
8	Аймгийн хэмжээнд ургамал, ан амьтны тооллого явуулж, мэдээллийн санг бий болгох	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
9	Орхон-Сэлэнгэ олон голын сав газрын сургалт, судалгааны төв байгуулах	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
10	Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлыг олборлолт явуулж буй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
11	Хариуцлагатай уул уурхайг дэмжиж, томоохон уурхайг түшиглэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар үзүүлэх сургалт зохион байгуулах	ХБХ, БОАЖГ, МХГ	Аймгийн ЗДТГ

12	Химийн бодисын нэгдсэн тооллого явуулж, мэдээллийн сан бүрдүүлэх	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
13	Хатуу хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу Мандал суманд ландфилл байгуулах	ХБХ, БОАЖГ	Аймгийн ЗДТГ
6.Дэд бүтцийн салбарын хүрсэн түвшинг бататгаж, улсын болон орон нутгийн төсөв, иргэн аж ахуйн нэгжийн болон дотоод гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.			
1	Аймгийн төв Сүхбаатар сумын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	ХБХ	Аймгийн ЗДТГ
2	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо, авто вокзалын барилга байгууламжийг барьж ашиглалтанд оруулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
3	Интернет техникийн боломжтой сумыг байнгын интернеттэй болгож, утасгүй интернетийг сүлжээг Сүхбаатар суманд байршуулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
4	Аймгийн цахилгаан эрчим хүчний үйлчилгээний чанарыг сайжруулж, айл өрх бүрийн тоолуурыг зориулалтын хайрцагаар хангах ажлыг эхлүүлэх	ХБХ	Аймгийн ЗДТГ
5	Аймгийн төв Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг бий болгох чиглэлээр холбогдох байгууллагад санал хүргүүлэх	ТАЗГ	ХБХ
6	Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн дэд, бүтэц, авто замыг барьж байгуулах	ХБХ	Аймгийн ЗДТГ
7	Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны байрыг шинээр барьж ашиглалтанд оруулах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
8	Зүүнбүрэн сумны Засаг даргын Тамгын газрын байрыг шинээр барьж ашиглалтанд оруулах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
9	Хушаат сумын Орхон голын 235 м төмөр бетон гүүрний ажлыг дуусгаж, гүүрний цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Дархан ТП-1-ээс Энхтал руу гарсан 6 кв-ын агаарын шугам өргөтгөх ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
10	Сүхбаатар сумын “Сэлэнгэ энерго” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дулааны цахилгаан станцын тоног төхөөрөмжийн	ХБХ	Аймгийн ЗДТГ

	шинэчлэх		
11	Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замаас Жавхлант сум хүртлэх 7 км авто замыг хатуу хучилттай болгох ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
12	Хүдэр сумын Хүдэрийн голын төмөр бетон гүүрний ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
13	Мандал, Сүхбаатар, Орхонтуул сумын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
14	Сайхан сумын гэр хорооллын цэвэр усны 2.8 км, бохир усны 2.4 км шугамыг шинээр барих	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
15	Баянгол сумын усны даралттай цамхагийн засвар шинэчлэлтийг хийж гүйцэтгэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
16	Аймгийн төв Сүхбаатар суманд газар хөдлөлтийг бүртгэх станцын барилгын ажлыг эхлүүлэх	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ
17	Ус цаг уур орчны шинжилгээний албаны барилгын өргөтгөлийг барьж ашиглалтанд оруулах	УЦУОША	Аймгийн ЗДТГ
7. Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах			
1	Төсвийн орлогыг нэмэгдүүлэх бололцоотой эх үүсвэрийг бүрэн дайчлах, төсвийн үргүй зардлыг багасган, төсвийн ил тод байдлыг хангах	СТСХ	Аймгийн ЗДТГ
2	Төсвийн орлого зарлагын харьцааг зохистой түвшинд байлган, хөрөнгө оруулалтыг ач холбогдолоор нь эрэмбэлж тэргүүлэх чиглэлүүдэд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх	СТСХ	Аймгийн ЗДТГ
Гурав: Засаглалын бодлого			
1. Төрийн үйлчилгээний шуухай байдал, чанар, хүртээмж, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж, гадаад харилцаа хамтын ажиллагааны залгамж чанарыг хадгалан хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.			
1	Аймгийн Засаг даргын нэрэмжит иж бүрэн үзлэгийг зарим сумын Засаг даргын Тамгын газар, агентлагийг хамруулан зохион байгуулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Аймгийн ЗДТГ
2	Аймгийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг сумдад хуваарийн дагуу зохион байгуулах	Хяналт-шинжилгээ,	Аймгийн ЗДТГ

		үнэлгээний алба	
3	Сүхбаатар сумын 6 дугаар багийг байр (контор)-той болгох асуудлыг холбогдох газартай хамтран шийдвэрлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Аймгийн ЗДТГ
4	Иргэдэд эрэлт хэрэгцээ ихтэй байдаг Хөдөлмөр магадлах комиссын хурал, эд хөрөнгийн эрхийн бүртгэл зэрэг төрийн үйлчилгээг бүсийн төвүүдэд тогтмолжуулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Аймгийн ЗДТГ
5	Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Аймгийн ЗДТГ
6	Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөрт явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Аймгийн ЗДТГ
7	Аймгийн ИТХ-аас батлагдсан нэр бүхий хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Аймгийн ЗДТГ
8	“Нэг цонхны үйлчилгээ”-ний үйл ажиллагааг тогтмолжуулан үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж тус нэгжид бизнес ширээний үйлчилгээг шинээр нэвтрүүлэх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Аймгийн ЗДТГ
9	Төрийн албан хаагчдыг гадаад, дотоодын сургалтанд хамруулан мэдлэг чадварыг дээшлүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Аймгийн ЗДТГ
10	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлж, зарим улсын муж, хотуудтай хамтран урлаг соёл, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулан шинэ түншлэлийн харилцааг нэмэгдүүлэх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Аймгийн ЗДТГ
11	Аймгийн хэмжээнд гамшгийн голомтод авралтын үйл ажиллагаа явуулах “Шуухай бүлэг-105” үйлчилгээг бий болгох	Онцгой байдлын газар	Аймгийн ЗДТГ
12	“Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Сэлэнгэ аймагт	Онцгой	Аймгийн

	хэрэгжүүлэх 2012-2015 оны ажлын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах	байдлын газар	ЗДТГ
13	Стандартчлал хэмжил зүйн хэлтсийн хорио цээрийн лабораторийн багаж, зарим тоног төхөөрөмжийг шинэчилж, авто машины граж шинээр барих	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс	Аймгийн ЗДТГ
14	Стандартын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт ISO-9001 үйл ажиллагааг нэвтрүүлж, төрийн үйлчилгээний байгууллагын чанарын тогтолцоог бүрдүүлэх	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс	Аймгийн ЗДТГ
2. Хүний эрх, нийгмийн дэг журмыг хангах ажилд ахиц гаргана.			
1	“Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагаа” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумдад “Иргэний зөвлөл” ажиллуулж, хөрөнгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	ХЗХ	Аймгийн ЗДТГ
2	Орхонтуул сумын Рашаант тосгонд цагдаагийн кабоны барилга шинээр барих	Цагдаагийн газар, Сумдын Засаг дарга	Аймгийн ЗДТГ
3	Мандал сумын Дарьтын 433-р хорих ангийн байр барих	ХЗХ	Аймгийн ЗДТГ
4	Сүхбаатар сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байр шинээр барих	ХЗХ	Аймгийн ЗДТГ
5	Архивын Ерөнхий газрын Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн цахим технологи нэвтрүүлэх сургалтанд аймгийн архивын хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын бичиг хэргийн ажилтнуудыг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлэх	ШША, ШШГА	Аймгийн ЗДТГ
6	Эрдэм шинжилгээний ач холбогдолтой болон мэдээлэл, лавлагааны ажилд ихээр ашиглагддаг 3068 хадгаламжийн нэгжийг тоон системд шилжүүлэх	ХЗХ	Аймгийн ЗДТГ
7	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг Үндэсний чуулганаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж зохион байгуулах	Архивын тасаг	Аймгийн ЗДТГ

8	Эрх зүйн сурталчилгааны хөтөлбөрийн нэгдүгээр үе шат /2010-2012/ хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж хоёрдугаар үе шатанд /2012-2016/ хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж аймгийн Засаг даргын хөтөлбөрт тусгах ажлыг хийх	Архивын тасаг	Аймгийн ЗДТГ
---	---	---------------	-----------------

_____оОо_____

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 71

Сүхбаатар

Аймгийн 2011 оны тодотгосон төсөв батлах тухай

Сэлэнгэ аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2011 оны тодотгосон төсвийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, 58 дугаар зүйлийн 58.2.2, 58.2.3, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дугаар заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн 2011 оны тодотгосон төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

	Нийт дүн /мянган төгрөгөөр/	
Аймгийн төсвийн орлого бүгд	19,397,561,4	
1.Татварын орлого	17,502,175,5	
1.1. Хүн амын орлогын албан татвар	3,856,430,0	
- Орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэний орлогын татвар	87 830.0	
-Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	4,148,600.0	
- Буцаан олголт		-380,000.0
1.2.Өмчийн татвар	490,000.0	
-Үл хөдлөх хөрөнгийн татвар	490,000.0	
1.3. Бараа ба үйлчилгээний татвар	385 600.0	
-Авто машин өөрөө явагч хэрэгслэлийн татвар	385,600.0	
1.4. Бусад татвар, төлбөрүүд	12,770,145,5	
-Улсын тэмдэгтийн хураамж	71,845.5	
- Газрын төлбөр	287,000.0	
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	684,800.0	
-Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	6,548,400.0	
-Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	4,161,100.0	
-Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	700 000,0	

-Ус ашигласны төлбөр	290,000.0
-Нэр зааж ангилагдаагүй орлого	27000.0
2.Татварын бус орлого	103 299,6
-Төсөвт газрын өөрийн орлого	103 299,6
3.Урьд оны үлдэгдэл	1792 086,3

Хоёр.Аймгийн тодотгосон төсвийн 2011 оны зарлагыг **16 447 314,2** мянган төгрөгөөр тогтоож баталсугай.

1	Аймгийн ИТХ	148 078,0
2	Аймгийн ЗДТГ	805 606,8
3	Аймгийн Аудитын газар	105 937,2
4	Хэвлэл мэдээллийн төв /Сэлэнгэ телевиз/	20 121,6
5	Аймгийн ахмадын холбоо	8 374,3
6	Аймгийн ТҮ-ний газар Сүхбаатар хотын гэрэлтүүлэг	287 772,5
7	Сэлэнгэ цөм сүрэг ОНӨУҮГ	20 000,0
8	Орон нутгийн өмчийн алба	14 652,0
9	Засаг даргын нөөц	441 134,8
10	Бугант тосгоны цэвэр ус,халаалтын алдагдал	185 000,0
11	Замын хөрөнгө оруулалт	385 600,0
12	Хөрөнгө оруулалт их засвар	3 409 440,0
13	МЭУСэргийлэх зардал	169 897,0
14	Махны нөөц бүрдүүлэх сан	50 000,0
15	Улсын төсөвт төвлөрөх	10,395,700,0
	Аймгийн төсвийн дүн	16,447,314,2

Гурав. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг дор дурьдсанаар баталсугай.

д.д	сумдын нэрс	Санхүүгийн дэмжлэг /мянган төгрөгөөр/
1	Алтанбулаг	140 505,8
2	Баруунбүрэн	156 263,2
3	Баянгол	175 126,9
4	Ерөө	92 338,3
5	Жавхлант	143 160,6
6	Зүүнбүрэн	159 631,5
7	Мандал	201 820,0
8	Орхон	138 588,4
9	Орхонтуул	216 301,2
10	Сант	143 565,0
11	Сайхан	290 079,2
12	Сүхбаатар	236 048,1
13	Түшиг	130 517,9
14	Хүдэр	162 083,1
15	Хушаат	144 224,9

16	Цагааннуур	196 058,0
17	Шаамар	223 935,1
	ДҮН	2 950 247,2

Дөрөв.2011 оны тодотгосон төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлөвлөгөөний жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав.Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж батлагдсан төсвийг зориулалтын зүйлд хэмнэлттэй зарцуулж, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 72

Сүхбаатар

Аймгийн 2012 оны төсөв батлах тухай

Сэлэнгэ аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2012 оны төсвийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, 58 дугаар зүйлийн 58.2.2, 58.2.3, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дугаар заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн 2012 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

	Нийт дүн /мянган төгрөгөөр/
Аймгийн төсвийн орлого бүгд	19,186,614,3
1.Татварын орлого	19 111,614,3
1.1. Хүн амын орлогын албан татвар	6 588 200,0
- Орлогыг нь тодорхойлох боломжгүй	
иргэний орлогын татвар	100 000.0
-Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	6,868,200,0
- Буцаан олголт	-380,000.0
1.2.Өмчийн татвар	600,000,0
-Үл хөдлөх хөрөнгийн татвар	600,000,0
1.3. Бараа ба үйлчилгээний татвар	410,000,0
-Авто машин өөрөө явагч хэрэгслийн албан татвар	410,000,0
1.4. Бусад татвар, төлбөрүүд	11,513,414,3
-Улсын тэмдэгтийн хураамж	70,000,0
- Газрын төлбөр	470,000,0
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	520,260,7
-Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	5 403 266,3
-Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны	

төлбөр	3,272,281,9
-Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1,317,605,4
-Ус ашигласны төлбөр	460,000,0

2.Татварын бус орлого	75,000,0
-Төсөвт газрын өөрийн орлого	75,000,0

Хоёр.Аймгийн төсвийн 2012 оны зарлагыг **15 246 473,1** мянган төгрөгөөр тогтоож баталсугай. Үүнд:

д.д		ДҮН
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	185 871,0
2	Аймгийн ЗДТГазар	911 886,0
3	Аймгийн Аудитын газар	148 088,3
4	Аймгийн ахмадын холбоо	12 319,5
5	Тохижилт үйлчилгээний газар Сүхбаатар хотын гэрэлтүүлэг	202 839,3
6	Орон нутгийн өмчийн алба	36 250,8
7	Сэлэнгэ телевиз	24 468,5
8	Сэлэнгэ цөм сүрэг	20 000,0
9	Нөөц хөрөнгө	441 450,0
10	Орон нутгийн Хурлын сонгуулийн зардал	168 000,0
11	Бугант тосгоны дулаан халаалтын алдагдал	185 000,0
12	Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	410 000,0
13	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засвар	2 047 914,0
14	Малыг вакцинжуулах зардал	547 727,0
15	Махны нөөц бүрдүүлэх сан	50 000,0
16	Улсын төсөвт төвлөрүүлэх	9 854 658,7
	Аймгийн төсвийн зарлагын дүн	15 246 473,1

Гурав. Аймгийн төсвөөс сумдын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг дор дурьдсанаар баталсугай.

д.д	сумдын нэрс	Санхүүгийн дэмжлэг /мянган төгрөгөөр/
1	Алтанбулаг	179 470,6
2	Баруунбүрэн	195 156,5
3	Баянгол	239 160,7
4	Ерөө	182 488,5
5	Жавхлант	184 226,7
6	Зүүнбүрэн	200 571,6
7	Мандал	399 043,4
8	Орхон	170 166,2
9	Орхонтуул	238 674,0
10	Сант	185 249,5
11	Сайхан	374 680,1
12	Сүхбаатар	363 145,5
13	Түшиг	140 817,6
14	Хүдэр	180 423,2
15	Хушаат	191 960,6
16	Цагааннуур	203 571,6
17	Шаамар	311 334,8
	ДҮН	3 940 141,2

Дөрөв.2012 оны аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлөвлөгөөний жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав.Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**АЙМГИЙН 2012 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төсөл арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөгийн дүн /сая төгрөгөөр/
Орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт их засвар		
1	Алтанбулаг сумын төвийн дулаан хангамжийн гадна шугамын засвар	50,00
2	Ерөө сумын тохижилт	20,00
3	Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын авто машины засвар	4,00
4	Зүүнбүрэн суманд бохир усны авто машин	20,00
5	Мандал сумын Хэрх тосгоны нийтийн орон сууцны барилгын засвар	100,00
6	Мандал сумын Түнхэл тосгоны Соёлын төвийн тоног төхөөрөмж	50,00
7	Мандал суманд гүний худаг гаргах	13,00
8	Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн авто машин	20,00
9	Орхон сумын цахилгаан хангамжийг сайжруулах	55,00
10	Орхон сумын цэцэрлэгийн барилгын сантехникийн засвар, халаалтын тогооны шинэчлэл	20,00
11	Сант сумын Соёлын төвийн дээвэр засвар, хувцас хэрэглэл	42,00
12	Сант сумын Хушаат багийн конторын барилга	15,00
13	Сант суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах	20,00
14	Цагааннуур суманд Боохой хэмээх Улсын арслан Данзангийн хүндэтгэлийн хөшөө барих	20,00
15	Цагааннуур сумын 2, 3-р багт гүний худаг гаргах	26,00
16	Цагааннуур сумын зам талбайн гэрэлтүүлэг	40,00
17	Баянгол сумын Ахмадын байрны засвар, тавилга хэрэгсэл	11,40
18	Баянгол сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн гадна тохижилт	20,00
19	Баянгол сумын гэр хорооллын худгуудын барилгын	10,00

	засвар, моторын шинэчлэлт	
20	Баянгол сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын авто машины засвар	5,80
21	Сайхан сумын 11-р цэцэрлэгийн сантехникийн засвар	30,00
22	Орхонтуул сумын төвийн халаалтын тогооны засвар	30,00
23	Орхонтуул сумын Рашаант тосгоны цагдаагийн кабоны барилга	30,00
24	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын өргөтгөл	70,00
25	Шаамар сумын Дулаанхан тосгоны сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж	33,40
26	Шаамар сумын Дулаанхан тосгоны Соёлын төвийн техник хэрэгсэл	8,00
27	Шаамар сумын Хүн эмнэлгийн барилгын дээвэр засвар	40,00
28	Хүдэр суманд жимс, жимсгэнэ, эмийн ургамал боловсруулах цех байгуулах	25,00
29	Сүхбаатар сумын 25-р байрны дээвэр засвар	30,00
30	Сүхбаатар сумын 2-р сургуулийн цахилгааны засвар	9,90
31	Сүхбаатар сумын 5-р багт Соёлын төв барих	90,00
32	Жавхлант сумын Соёлын төвийн халаалтын системийн засвар, шинэчлэлт	20,00
33	Жавхлант сумын ЗДТГ-ын авто машин	20,00
34	Түшиг сумын Хүн эмнэлгийн аж ахуйн хэсгийн барилгын засвар	30,00
35	Хушаат сумын Дуулга, Рашаант хороололд гүний худаг гаргах	26,00
36	Хушаат сумын төвд 80 тн-ын багтаамжтай ногооны зоорь барих	30,00
37	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын авто машин	35,00
38	Аймаг сурталчлах "Сэлэнгэ түмэн" арга хэмжээ	100,00
39	Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн барилгын засвар	20,00
40	Үүлэнд зориудаар нөлөөлж хур тундас нэмэгдүүлэх	25,00
41	Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албаны Сэлэнгэ мөрний усны харуул, лабораторыг багажаар хангах	30,00
42	Аймгийн Аудитын газарт авто машин	25,00

43	Хилийн цэргийн 0243-р ангийн үлээвэр хөгжмийн зэмсгийг шинэчлэх	20,00
44	Онцгой байдлын газрын Баянгол сум дахь ангийн орон сууцны засвар	30,00
45	"Тогтвортой амжиргаа II" төслийн орон нутгийн хөрөнгө оруулалт	16,864
46	Шүүхийн шинжлгээний албаны өрөөний засвар /Цагдаагийн газрын байранд/	10,00
47	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны авто машин	20,00
48	Хүүхдийн төлөө хэлтсийн авто машины засвар	5,00
49	Тээвэр, авто замын газрын авто машины засвар	4,00
50	Татварын хэлтсийн гаражийн барилгын засвар	4,50
51	Аймгийн Нэдсэн музейн барилгын хяналт, дохиоллын тоног төхөөрөмжийн шинэчлэлт	12,90
52	Хүнс, хөдөө аж ахуй жижиг, дунд үйлдвэрийн газрын Мал эмнэлгийн гадна дулааны шугам, гаражийн халаалтын дотор шугамын засвар	5,15
53	Тохижилт үйлчилгээний газрын нийтийн тээврийн автобусны шинэчлэлт	100,00
54	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардал	500,00
Дүн		2 047,914
Замын сангийн хөрөнгө оруулалт		
1	Алтанбулаг сумын зам засвар	36,00
2	Баянгол сумын төвийн зам засвар	25,00
3	Мандал сумын Зүүнхараа хот, Түнхэл тосгоны зам засвар	164,00
4	Ерөө сумаас Бугант тосгон хүртэлх зам, гүүрийн засвар	140,00
5	Сант сумын зам засвар	20,00
6	Цагааннуур сумын зам засвар	25,00
Дүн		410,00
НИЙТ ДҮН		2 457,914

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 73

Сүхбаатар

Сэлэнгийн бүсийн хөгжлийн хөтөлбөр
батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 18, 2007 оны 38 дугаар тогтоолуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Сэлэнгийн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх зорилтыг бүсийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиг баримжаа болгон, хэрэгжүүлэх стратеги зорилтуудыг бүсийн сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг бүсийн зөвлөл, бүсийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.
3. Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

УДИРТГАЛ

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан 2008-2021 он хүртэлх Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд аймаг, бүс, орон нутгийн хөгжлийн явц үр дүнд үнэлгээ дүгнэлт өгч, хөгжлийн хэтийн төлөвийг тооцож ирээдүйгээ сайн сайхнаар төсөөлж хүрэх ирээдүй, хөгжих боломжоо тодорхойлох урт дунд хугацааны хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлагын улмаас аймгийн ИТХ-аас гарсан шийдвэрийн дагуу “Аймгийн 2007 - 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр”-ийг үндэслэн “Сэлэнгэ бүс”-ийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулаад байна.

Сэлэнгэ бүсийн Цагааннуур, Зүүнбүрэн сумд нь 1924 онд, Түшиг сум нь 1931 онд тус тус байгуулагдсан. 751.7 мянган га нутаг дэвсгэртэй 3 сум, 8 багтай бөгөөд баруун талаараа Булган аймгийн Тэшиг, Сэлэнгэ сумтай, хойд талаараа ОХУ-тай, зүүн талаараа Сэлэнгэ аймгийн Бэлчирийн бүс, Дархан-Уул аймгийн Орхон сумтай тус тус хиллэн оршдог.

Аймгийн бүх газар нутгийн 18.2, ойн сангийн 15.5, усан сангийн 29.3 хувь нь энэ бүс нутагт ноогддог. 2010 оны жилийн эцсийн байдлаар 2516 өрх, 8222 хүн ам тоологдсон ба аймгийн нийт хүн амын 8.1 хувийг эзэлж байна. Үүнээс хөдөлмөрийн насны 5137 иргэн байна.

Бүсийн хэмжээнд 2010 оны жилийн эцэст 214346 толгой мал тоологдсоноос тэмээ 0.01, адуу 3.3, үхэр 11.3, хонь 51.8, ямаа 33.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт малд эзлэх цэвэр эрлийз малын тоо нэмэгдэж нийт малын 22,7 хувь буюу 48656 толгойд хүрсэн байна.

Сэлэнгэ бүс нь 82.4 мянган га тариалангийн эргэлтийн талбайтай ба эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж жилдээ 40.0 - 45.0 мян.га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо тариалж жилд дунджаар 50.0 – 60.0 мян.тн үр тариа, 5.0-5.5 мян.тн төмс, 2.8 - 3.5 мян.тн хүнсний ногоо хураан авч аймгийн нийт ургацын 40 орчим хувь, улсын нийт ургацын 15-20 орчим хувийг үйлдвэрлэж байгаа газар тариалангийн гол бүс нутаг юм.

Тус бүс нь эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн гол бүс нутаг төдийгүй Түшиг суманд орших Улаан овооны нүүрсний уурхайг түшиглэн уул уурхайн үйлдвэрлэлийг өргөжүүлж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэн дэд бүтцийг хөгжүүлэх бүрэн боломжтой юм.

Сэлэнгэ бүсийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохдоо “Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр”-т тусгагдсан зорилтуудыг үндэс болгон сумдын нийгэм эдийн засгийн чадавхи, бүс нутгийн онцлогт тулгуурсан болно.

Сэлэнгэ бүсийн ирээдүйн хөгжлийн алсын хараа нь “Хүний хөгжлийг дээдлэн хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн, орчин үеийн техник технологийн шинэчлэлд суурилсан эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйтай, хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлж, эдийн засгийн өндөр чадавхитай бүс” болоход оршино.

Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг Эдийн засгийн бодлого, Нийгмийн бодлого, Засаглалын бодлого гэсэн 3 салбарт хуваасан ба 2011-2016 он, 2017-2021 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Нэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Сэлэнгэ бүсийн онцлог, давуу талдаа тулгуурлан эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон хөгжүүлж, өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг тогтвортой хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж эдийн засгийн эрчимтэй өсөлтийг бий болгоно.

Сэлэнгийн бүсийн хөгжлийн эдийн засгийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

1. Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
2. Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
3. Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
4. Байгаль орчин, газар өмчлөлийн бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
5. Аялал жуулчлалын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
6. Худалдаа үйлчилгээний салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
7. Дэд бүтцийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.1. Аж үйлдвэрийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Сэлэнгэ бүсэд эдийн засгийн өндөр ач холбогдолтой ашигт малтмалыг олборлох үйлдвэрийг хөгжүүлэх, гурилын болон махны үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар бүсийн эдийн засгийн чадавхийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Уул уурхайн салбарыг хөгжүүлэх иж бүрэн техник, эдийн засгийн төлөвлөгөө боловсруулах
- Олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд мэргэжилтэй ажилчдыг бүс нутгаас бэлтгэх арга хэмжээг хэтийн зорилго чиглэлтэй болгох.
- Эдийн засгийн өндөр ач холбогдолтой ашигт малтмалын орд газрыг мэргэжлийн байгууллагын тусламжтай нээн илрүүлж ашиглах боломжийг судлах
- Махны үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулж, бүсийн малчид иргэдээс мал, мах нийлүүлэх зарчмийг баримтлан, эцсийн бүтээгдэхүүн боловсруулж дотоодын зах зээлд нийлүүлэх.
- Үр тарианы томоохон аж ахуйн нэгжүүдийг түшиглэсэн гурилын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр бүс, аймгийн эрэлт хэрэгцээг хангах бодлого баримтлах.
- Сүү, жимс, хүнсний ногоо боловсруулах жижиг үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх.
- Орон нутгийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг өргөжүүлэх.
- Ноос боловсруулах үйлдвэрийг өргөжүүлэх, шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн: Ашигт малтмал олборлох үйлдвэрлэл тогтворжин эдийн засагт аж үйлдвэрийн салбарын оруулах хувь нэмэр өсөн нэмэгдэж, бүсийн хөгжлийн эдийн засгийн чадамж дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Уул уурхайн салбарын хөгжлийг дагасан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- Уул уурхайн түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх.
- Барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх
- Ноос боловсруулах үйлдвэрийн техник технологийг шинэчлэн бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

Хүрэх үр дүн: Дэвшилтэт техник, технологи нэвтэрч, чанартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэнэ.

1.2. Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ

1.2.1. Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэн салбарын эдийн засгийн хөгжлийн таатай орчинг бий болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Газар тариалангийн үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэлийн бодлогыг үр ашигтай зохион байгуулж, тариалангийн талбайд хөрсний агрохимийн шинжилгээг хийж, талбайн ашиглалтын түүхийн дэвтэр хөтлүүлэх.
- Бүсийн хэмжээнд усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого баримтлах, элефатор байгуулах
- Төмс, хүнсний ногооны сортын үрийн асуудлыг шийдвэрлэж үрийг нутагшуулах ажлыг зохион байгуулах.
- Үр үржүүлэх эрх авсан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, буудайн чанар сайтай үрээр аймаг, бүсийн хэмжээнд хангах
- Тариалангийн талбайн чийгийн алдагдалыг багасгаж салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор сүрлэн хучлага бий болгох.
- Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж эрт ургацын ногооны төрлийг олшруулан хангамжийг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй санхүүгийн түрээсээр нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэн өрхийн аж ахуйг жижиг оврын техникээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Тариаланчдын залуу халаа болох трактор-комбайнч ба засвар үйлчилгээний мэргэжилтэн, техникийн дунд боловсролтой ажилчдыг сургалтанд хамруулах бодлого баримтлах
- Бүсийн хөдөө аж ахуйн техник, засвар үйлчилгээний парк байгуулах.

Хүрэх үр дүн: Газар тариаланд хөрс хамгаалал, техник шинэчлэл, үрийн асуудлыг бүрэн шийдвэрлэж га-гаас авах ургацын хэмжээ нэмэгдэн, улаан буудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний хангамж сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрс боловсруулах технологийн горимыг мөрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн техникийг хөрс хамгаалах системд тохируулан ээлж дараатай шинэчлэх, төмс, хүнсний ногоо эрхлэгчдийг жижиг оврын техникээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Төмс, хүнсний ногоо тариалдаг фермерүүдэд даршилсан ногооны үйлдвэрлэл эрхлэх нөхцөл боломжийг хангах, зах зээлд борлуулалт хийх нөхцөл бүрдүүлэх.
- Уринш боловсруулалтыг технологийн дагуу гүйцэтгэж, экологийн гаралтай болон бусад төрлийн бордооны хэмжээг жил бүр нэмэгдүүлэх арга хэмжээг авна.
- Тариалах талбайн эргэлтэнд таримлын олон төрөл бүхий системийг нэвтрүүлэх, өргөтгөх

Хүрэх үр дүн: Шинжлэх ухааны ололт, шинэ техник технологи нэвтэрч, тариалангийн газрын ашиглалт сайжирч, чанартай өндөр ургац авах нөхцөл бүрдэнэ.

1.2.2. Мал аж ахуйн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барьж шилмэл омгийн нутгийн малыг үржүүлэх ажлыг дэмжин ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлэх ажлыг сайжруулж, бэлчээрийн даац, тэжээлийн үйлдвэрлэл, нөөцийн хэмжээнд тохирсон эрчимжсэн болон хагас суурин мал аж ахуйг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн мал, тэжээвэр амьтдад үзлэг, ангилалт явуулж, ашиг шимийг тодорхойлон үржил селекцийн ажлыг зохион байгуулах
- Үхэр, хонины аж ахуйд эрчимжсэн, хагас суурин аж ахуйг хөгжүүлэх чиглэлийг баримтлан мах-сүүний ба махны чиглэлийн үхэр, нарийн ноосны үүлдрийн хонины аж ахуй шинээр эрхлэгчид, малчны бүлэгт эрх зүйн таатай орчин буй болгож, мэргэжил арга зүй, бусад дэмжлэг үзүүлэх
- Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний нэгжүүдийн чанар хүртээмжийг дээшлүүлж, материаллаг бааз, багаж тоног төхөөрөмж, эм урвалж, оношилгоо, үржлийн ажил үйлчилгээний хангамж чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх
- Байгалийн гэнэтийн аюул, ган зудаас сэргийлэх, хохирлыг бууруулах зорилгоор малыг даатгалд бүрэн хамруулах, даатгалын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Шилмэл малын бүртгэл мэдээлийн санг буй болгон, жил бүр баяжуулж үзэсгэлэн худалдааг бүсийн сумдын хэмжээнд зохион байгуулах.
- Алслагдсан болон ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор хөдөөд худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Малын тоо толгойн өсөлт зохистой хэмжээнд хүрч, бэлчээр ашиглалт сайжран, нэг малаас авах ашиг шимийн хэмжээ нэмэгдэн, малын эрүүл мэнд, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний чанар сайжирч, эрчимжсэн болон хагас суурин мал аж ахуйг хөгжүүлэх орчин бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Төрөлжсөн мал аж ахуйн суурин ба хагас суурин аж ахуй, малчдын албан ёсны бүлэг хоршоодын үйл ажиллагааг дэмжиж, мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулан, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Малчид, мал бүхий иргэн, аж ахуй нэгжүүдийн эцсийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг дэмжиж, гадаад дотоод харилцаагаа өргөжүүлэх, мэдээлэл авах, түгээхэд дэмжлэг үзүүлэх
- Эрчимжсэн, төрөлжсөн аж ахуйнуудыг бүсийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд оролцох сонирхол, эрх зүйн орчныг буй болгож, байгаль хамгаалах, тэжээлийн нөөц буй болгох, бусад сум, бүс, аймагт өвс тэжээлийн худалдаа үйлчилгээ явуулах нөхцлийг бүрдүүлэх
- Малын гаралтай түүхий эдийг эцсийн болон хагас боловсруулсан, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх

Хүрэх үр дүн: Эрчимжсэн фермерийн аж ахуйн тогтолцоо бүрдэж, эрүүл ахуйн болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

1.3. Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэх таатай орчинг бүрдүүлж, ажлын байр нэмэгдүүлэн, иргэдийн амьжиргааны чадавхийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгчдэд гадаад дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламж, төсөл хөтөлбөр, сумдын “Хөгжлийн сан”-гаар дамжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- Бүсийн хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх.
- Өрхийн аж ахуй эрхлэгчдийн бүсийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж шилдэг брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулан урамшуулж нийтэд сурталчлах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Иргэд, аж ахуйн нэгжид улсын төсөв, гадаадын зээлийн хөрөнгөөр бүсийн онцлогт тохирсон сортын тарьц суулгац, жимс жимсгэнэ үржүүлэх ажлыг дэмжих.
- Мах, сүү, төмс, хүнсний ногоо боловсруулах шахмал түлш, мал бордох, зоорины аж ахуй эрхлэх, жимс жимсгэнэ тариалах, модны тарьц суулгац ургуулах, ноос боловсруулах, модон эдлэл, оёдлын үйлдвэрлэл эрхлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг дэмжиж дотоодын зах зээлд нийлүүлэх ажлыг эхлүүлэх.
- Гахай, шувуу, загас, зөгийн аж ахуйг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлж бүтээгдэхүүний төрөл хэмжээг нэмэгдүүлж орон нутгийн хэрэгцээг хангах.
- Жимс, жимсгэнэ, самар, эмийн ургамал боловсруулах үйлдвэр, цехийг Түшиг суманд байгуулах.
- Шахмал түлш, барилгын модон материалыг орлох тоосго, блокны жижиг оврын үйлдвэрийг байгуулах,
- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа ажил үйлчилгээ худалдан авахад жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг оролцуулах.

Хүрэх үр дүн: Бүсийн хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэх таатай орчин бүрдэж өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн чадавхи дээшилсэн байна.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийг өргөжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж бүс, аймаг орон нутгийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг аймаг, хот, нийслэл, бусад суурин газруудад борлуулах боломж бүрдүүлэх.
- Өрхийн аж ахуй эрхлэгчид хорших, хамтрах замаар жижиг дунд үйлдвэр байгуулах, цаашлаад аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд орж үйлдвэрлэлээ өргөжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх.
- Бүсийн иргэдийг мод тарих, тарьц, суулгац худалдах, ойжуулалтын ажлын төсөлд хамрагдах санаачлагад дэмжлэг үзүүлж амьжиргааны түвшинг дээшлүүлэх.
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд /мах, ноос, ноолуур, арьс, шир/-ийг үндэсний томоохон үйлдвэрлэгчдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулах.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж төвлөрсөн зах зээлд нийлүүлэх.

Хүрэх үр дүн: Бүсийн хэмжээнд өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл өргөжиж, бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэн, чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд нийлүүлж үйлдвэрлэгчдийн санхүүгийн чадавхи тогтворжсон байна.

1.4. Байгаль орчин, газар өмчлөлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.4.1. Байгаль орчны бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад иргэд аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэн ашиглагч нь хамгаалагч байх зарчмыг мөрдүүлж, ой, усан сан, байгалийн баялагийг хамгаалах менежментийг дэмжиж хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж хамтын эзэмшлийн ойн нөхөрлөлүүдийг байгуулан байгалийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх.
- Мод үржүүлгийн газрыг байгуулж төв суурингийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тариалангийн талбайд ойн зурвас бий болгох ажлыг эхлүүлэх.
- Байгаль, цаг уурын өөрчлөлт, хүний сөрөг нөлөөллөөс үүдэн ойн сан, өвслөг ургамлын бүрхэвч, ан амьтны суурьшил, биологийн төрөл зүйлд гарч байгаа өөрчлөлтийг саармагжуулах, нөхөн сэргээх, хамгаалах ажлыг хууль, эрх зүйн хүрээнд мэргэжлийн байгууллага, төсөл хөтөлбөрийн газруудад хандан шийдвэрлэх, хамтарч ажиллах.
- Орчны бохирдлыг бууруулах, хөрсний бохирдлоос хамгаалах ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын оролцоотой шийдвэрлэх.
- Газар ашиглалтын бодлогод нийцүүлэн байгаль орчинд хоргүй технологийг нэвтрүүлэн нөхөн сэргээлтийг хуулийг дагуу хийлгүүлж, ус агаарын шинжилгээг тогтмолжуулж, хүн малд нөлөөлөх нөлөөллийг багасгана.
- Булаг шанд, рашааны эх ундрагыг хашиж хамгаалах, сэргээх ажлыг зохион байгуулах

Хүрэх үр дүн: Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны эсрэг хууль бус үйл ажиллагаа буурч иргэдийн үүрэг хариуцлага дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэн байгалийн дагалт баялгийг зохистой зөв ашиглах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгалийн баялагийг хууль, эрх зүйн хүрээнд зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх
- Ойг хамгаалах дэвшилтэт менежментийн аргыг нэвтрүүлэн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлж хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх,
- Байгалийн төрөл зүйл, газар түүний хэвлий, ан амьтан, усны нөөцийг судлан түүх соёлын дурсгалт газар, булаг, шанд, рашаан, ховордсон ан амьтдыг хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулах
- Ойг гал түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль цаг уурын гамшгийн аюулыг бууруулах, болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нөөц бололцоо, техникийн хүчин чадлыг бий болгох
- Ой, ургамлын хортон шавжийн голомт, нүүдэл, хүн мал амьтны гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх тэдгээртэй тэмцэх ургамал хорио цээр, хүн, мал эмнэлэгийн албаны чадавхийг дээшлүүлэх
- Төв суурингийн эзэмшил газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгож, цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээг авах.

Хүрэх үр дүн: Байгаль орчныг хамгаалахад иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын оролцоо сайжирч, байгалийн экосистемийн тэнцлийг алдагдуулахгүйгээр нөхөн сэргээх, үржих боломж бүрдсэн байна.

1.4.2. Газар өмчлөлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Газрын эзэмшил, ашиглалтыг сайжруулж, мэдээллийн санг бүрдүүлэн, газрын харилцааны асуудлыг төрийн зохицуулалтаар хөтлөнө.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газрын эрэлт хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх.
- Газрын нөөцийн менежментийг сайжруулах, орчин үеийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.
- Тариалан болон суурин газарт хийгдсэн кадастрын зураглалыг үндэслэн улсын бүртгэлд бүртгэж “Үндэсний газрын мэдээлэлийн сан”-г баяжуулах.
- Хадлангийн газрыг малчдын бүлэг, нөхөрлөлүүдэд гэрээгээр эзэмшүүлэн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах
- Эрчимжсэн мал аж ахуйн бүсийг тогтоож, фермерийн аж ахуй эрхлэгчдэд газар эзэмшүүлж дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн: Бүсийн сумдын газар зохион байгуулалт, газар ашиглалт, хамгаалалтын түвшин сайжирч газрын мэдээллийн сан бүрдсэн байна.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг эдийн засгийн харилцаанд оруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг кадастрын зурагт бүрэн хамруулж мэдээллийн санг баяжуулна.
- Газрын рентийг тодорхойлж иргэдэд мэдээлэлээр нээлттэй үйлчлэх, газар түрээслүүлэгч, түрээслэгчдийн хоорондын харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох.
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалтын төрөл тус бүрээр экологи-эдийн засгийн үнэлгээг хийж газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах.

Хүрэх үр дүн: Иргэд аж ахуйн нэгж газрын харилцааны мэдээллээр бүрэн хангагдаж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчин бүрдэнэ.

1.5. Аялал жуулчлал салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Гадаад дотоодын аялагч жуулчдыг хүлээж авах бааз, хотхоныг байгуулах, ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлэх, орон нутгийн онцлог, түүх дурсгал, үзэсгэлэнт газрууд болон уламжлалт ёс заншлыг сурталчлан тан иулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой газар нутгийн судалгаа гаргаж хэтийн төлөвлөгөө боловсруулан, энэ чиглэлийн санал, санаачлага гаргасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих
- Орон нутгийн онцлогт тохирсон шинэ төрлийн үйлчилгээ бий болгох нөхцлийг бүрдүүлэх, эхлүүлэх /өвлийн спорт, ан агнуур, загас агнуур, морин аялал, усан аялал гэх мэт/
- Түүх соёлын дурсгалт газар болон Сэлэнгэ мөрөн, Орхон, Зэлтэр гол, Цагааннуурын сав дагуу байгалийн өвөрмөц тогтоцтой үзэсгэлэнт газруудад орон нутгийн онцлог ёс заншлыг харуулсан аялал жуулчлалын бааз байгуулах
- Орон нутгийн онцлог, түүх соёл, зан заншлыг сурталчилж сумдын орон нутаг судлах танхимын үзмэрийг нэмэгдүүлж үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Хүрэх үр дүн: Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж нээгдэж, бүс нутгийн уламжлалт ёс заншил, унаган байгаль, дурсгалт газруудын талаарх мэдээлэл нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Аялал жуулчлалын салбарын хөгжлийн түвшинг дээшлүүлж үйлчилгээний чанарыг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аялал жуулчлалын салбарын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Жуулчдын аюулгүй байдлыг ханган, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Аялал жуулчлалын баазуудын танилцуулга, лавлах гарган сурталчилж, жуулчдын тоог нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Аялал жуулчлалын бүтээгдэхүүний шинэ төрлүүд бий болж, жуулчдын тоо нэмэгдэн ая тухтай аялах, амрах нөхцөл бүрдэнэ.

1.6. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Бүсийн хэмжээнд хүнсний барааны хангамж, ахуйн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ, мах , сүү, төмс, хүнсний ногоо, түүхий эдийн төрөлжсөн худалдааны төвтэй болох, үйлчилгээг хөгжүүлэх.
- Хүн амын хүнсний зохистой хэрэглээг бий болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжин, сургалт, сурталчилгааг зохион байгуулах
- Үйл ажиллагаа явуулж буй фермерийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж бүс, аймгийн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг бүрэн хангах
- Түүхий эдийн нөөцдөө тулгуурлан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх
- Стандартын шаардлага хангасан зочид буудал, зоогийн газар, ахуйн үйлчилгээний тоог хувийн хэвшлийн оролцоотой нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний баталгаат байдал хангагдаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээ сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Бүсийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж хэрэглээний бүтцийг нийгмийн эрүүл мэндийн шаардлагад нийцүүлэн боловсруулдаг болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг дунд үйлдвэрлэл өрхийн аж ахуйг дэмжин хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс барааны чанар, стандарт эрүүл ахуйн үзүүлэлтийг өндөр нарийвчлалтай баталгаажуулах тогтолцоог бий болгох
- Ундны усны шинэ эх үүсвэрийг судлан тогтоож, сумдын ундны усны худгуудад цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан усны чанар хангамжийг сайжруулах
- Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цөцгийн тосны үйлдвэрлэлийг өсгөн дотоодын зах зээлд загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтмол нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Хүн амын эрүүл мэндэд нийцсэн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл сайжирна.

1.7. Дэд бүтцийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт 1: Орон нутгийн авто зам, тээврийн үйлчилгээг өргөтгөх, эрчим хүчний хангамж үйлчилгээний чанарыг сайжруулах, мэдээлэл холбооны технологийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сүхбаатар-Дархан чиглэлийн замаас Түшиг сумын Улаан-Овооны нүүрсний уурхай хүртэл 135 км асфальт бетон зам тавих
- Авто замын засвар үйлчилгээ эрхлэх орон нутгийн байгууллагуудыг бий болгох
- Нийтийн тээврийн үйлчилгээний аюулгүй, баталгаат байдлыг хангаж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, соёлч, боловсон үйлчилгээ үзүүлэхэд нь хяналт тавьж, зохион байгуулалтанд оруулах
- Нар, салхины сэргээгдэх эрчим хүч бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар бүрэн хангах.
- Бүс, сум, багийн түвшинд интернетийн сүлжээ бүрдүүлж бүх шатны төрийн байгууллагуудыг интернетийн сүлжээнд холбон хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх,
- Хөдөлгөөнт холбооны үйлчилгээг нэмэгдүүлэх, өндөр хурдны тоон системийг нэвтрүүлэх

Тэргүүлэх зорилт 2: Сумдын суурин газруудын тохижилтыг сайжруулж, барилга хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлт хийнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн сумдын хот суурин газруудын инженерийн шугам сүлжээний ерөнхий төлөвлөлтийг хийлгэж холбогдох арга хэмжээг авах.
- Хүн амын өсөлттэй уялдуулан сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, соёлын төв зэрэг төсөвт байгууллагуудын барилгыг өргөтгөх, шинээр барих ажлыг зохион байгуулалттайгаар шийдвэрлэх
- Сумдын гудамж талбайн тохижилтыг сайжруулж гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
- Төвлөрсөн халаалтын орчмын аж ахуйн нэгж, өрхийн нам даралтын болон ердийн халаалттай барилгыг төв шугаманд холбох ажлыг эхлүүлэх

Хүрэх үр дүн: Зам, барилга байгууламжийн чанар сайжирч, иргэдийн тав тухтай амьдрах, зорчих бололцоо нэмэгдэн, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажилд ахиц гарч, мэдээлэл харилцаа холбооны орчин үеийн сүлжээний үндэс суурь тавигдана.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Авто болон төмөр замын сүлжээг өргөтгөн хөгжүүлж, тээврийн үйл ажиллагааг боловсронгуй болгон, цахилгаан, дулаан хангамжийн үйлчилгээний чанарыг сайжруулж, холбооны үйлчилгээнд тоон сүлжээг бүрэн нэвтрүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон сууцны шинэ хотхон хороолол байгуулахад иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж төв, суурин газруудыг эрчимтэй хөгжүүлэх
- Шаамар-Зэлтэрийн 140 км салаа төмөр зам тавих ажлыг эхлүүлэх
- Сумын төвүүдийг шилэн кабелийн сүлжээнд бүрэн холбох
- Түшиг сумын Улаан-Овооны нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станцыг КЭС /конденсационная электро станция/ барьж, өндөр хүчдлийн шугамаар эрчим хүчний нэгдсэн системд холбогдох судалгаа, төслийн зураглал боловсруулах
- Сум, суурингийн төвийг хатуу хучилттай замтай болгох ажлыг хэрэгжүүлэх
- Улаан-Овооны нүүрсний орд газарт түлш, эрчим хүч, нүүрсний үйлдвэр байгуулах

Хүрэх үр дүн: Дэд бүтцийн асуудал бүрэн шийдвэрлэгдэж, суурин газрууд цахилгаан, дулаанаар хангагдан мэдээлэл харилцаа холбооны оновчтой сүлжээ бий болж сумдын төвүүд хөгжин иргэд орон нутагтаа тогтвор суурьшилтай амьдрах нөхцөл бүрдэнэ.

Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГО

Сэлэнгэ бүсийн боловсролын байгууллагын тогтолцоо хэв шинжийг өргөтгөж албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж чанар үр ашгийг дээшлүүлж, хүн амыг байнгын ажлын байраар ханган өрхийн орлогыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг тогтвортой бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлж, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Сэлэнгийн бүсийн нийгмийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

1. Боловсролын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
2. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн
3. Эрүүл мэндийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
4. Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
5. Соёл урлагийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

2.1. Боловсролын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн нэгдүгээр үе шат. 2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Боловсролын салбарын шинэчлэлийг хөгжүүлж, стандарт хангалтын түвшинг нэмэгдүүлэн, албан бус боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Улирлын чанартай гэр цэцэрлэгийг тогтмол ажиллуулж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 95 хувьд хүргэх
- Сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэйгээр зохион байгуулан суурь боловсролын хамран сургалтыг 95 хувьд хүргэх
- Сургууль, цэцэрлэгийн “Багш хөгжлийн танхим”-ыг стандартын шаардлагад нийцүүлэн иж бүрэн тохижуулж, багш нарыг чадавхижуулах, Цагааннуур сумын сургуулийг түшиглэн загвар арга зүйн төвийг байгуулах
- Сургалтанд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэн, сургууль цэцэрлэгүүдийг интернетэд холбож, техник хэрэгслээр хангах
- Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, хамгаалах, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсролд тэгш хамруулах орчин, нөхцлийг сайжруулах
- Амьжиргааны түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн сурагчдыг хичээлийн хэрэглэл болон сурах бичгээр бүрэн хангах
- Ерөнхий боловсролын сургуульд шатар, цэцэрлэгт даамны чиглэлээр сургалтыг явуулж, үйл ажиллагаанд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх
- Албан бус боловсролын сургалтын орчинг стандартын түвшинд нийцүүлэн боловсролын чанар үр өгөөжийг дээшлүүлэх
- Сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилж, цэвэр, бохир усны асуудлыг шийдвэрлэн эрүүл ахуйн орчинг сайжруулах.
- Сургууль, цэцэрлэгийг компьютержуулах, интернетэд холбох, дотуур байрыг засварлах, цэцэрлэгийг өргөтгөх зэргээр байрны хүрэлцээг сайжруулж, чанартай боловсролын орчин бүрдүүлэх
- Зарим сумдын спортын залыг шинээр барьж, сургууль, цэцэрлэгийг их засварт оруулан сургалтын орчинг сайжруулах

Хүрэх үр дүн: Багш нарын мэргэжил, боловсролын түвшинд ахиц гарч, сургалтын чанар дээшилж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдан сургалтын орчин сайжирч, иргэдийн боловсролын түвшин дээшилнэ.

Хөгжлийн хоёрдугаар үе шат. /2017-2021он/

Тэргүүлэх зорилт: Сургуулийн өмнөх боловсролд бага насны хүүхдийг бүрэн хамруулж, сургуулийг олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэх боломжоор хангах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, бага насны хүүхэд сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцлийг бүрдүүлэх
- Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох бодлого баримтлах
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Кембрижийн боловсролын стандарт, хөтөлбөрийг нэвтрүүлэх
- Бүсийн шилдэг удирдах ажилтан, багшийг шалгаруулан урамшуулал олгож, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх
- Гүнзгийрүүлсэн сургалттай анги, бүлэг нээж суралцагчдын эрэлтэд нийцсэн боловсрол олгох хэлбэрийг өргөтгөх

- Сурагчдын зуны амралтыг зөв зохистой өнгөрүүлэх, амьдрах арга ухаанд сургах зорилгоор Хөдөлмөр амралтын зусланг байгуулах
Хүрэх үр дүн: Боловсролын байгууллагын сурч, ажиллах орчин сайжирч, үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

2.2.Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн Хөгжлийн нэгдүгээр үе шат /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт 1: Хүн амыг байнгын ажлын байраар ханган өрхийн орлогыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг тогтвортой бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх.
- Ядуу, бага орлоготой иргэдийг амьдрах арга ухаанд сургаж, газар тариалан эрхлүүлэх, малжуулах, өрхийн үйлдвэрлэл эрхлэх замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил идэвхитэй хайгчдыг ажлын байранд зуучлах, сургалтанд хамруулах, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн захын өдөрлөг зохион байгуулах, мэдээллээр хангах үйлчилгээний чанарыг сайжруулах.
- Бүсийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, хүн амын орлогыг тасралтгүй нэмэгдүүлснээр орон нутагтаа тогтвор суурьшилтай, суурин амьдрах нөхцлийг бүрдүүлж, хагас суурин хэлбэрээр амьдарч буй хүн амд хүргэх нийгмийн цогц үйлчилгээг сайжруулах.

Хүрэх үр дүн: Бүсийн хүн амын тогтвортой өсөлт хангагдаж, хөдөлмөр эрхлэлт ажлын байр нэмэгдэн ажилгүйдлийн түвшин буурч амьжиргааны түвшин дээшилнэ.

Тэргүүлэх зорилт 2: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд чиглэсэн халамж үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг ажлын байраар хангаж, ядуурал, ажилгүйдлийг бууруулах цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
- Ахмад настны нийгмийн хамгаалал, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээг өргөжүүлэх.
- Хоол тэжээлийн дутагдалд орж буй иргэдийн хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээг авах.

Хүрэх үр дүн: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж өрхийн орлого нэмэгдүүлэх бололцоог хангана.

Хөгжлийн хоёрдугаар үе шат /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт 1: Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгож нийгмийн хамгааллын хүртээмж үйлчилгээнд хамруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ хоршоо, фермерийн аж ахуйг байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг хамруулах.
- Бичил аж ахуйн нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес инкубатор төвүүдтэй хамтын ажиллагааг дээшлүүлэх
- Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих дэд хөтөлбөрийг хоршоо фермерийг дэмжих бодлоготой нягт уялдуулах.

Хүрэх үр дүн: Ажилгүй иргэдийн эзлэх хувь, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хувь хэмжээ буурсан байна.

Тэргүүлэх зорилт-2: Нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааны түвшин дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хөдөлмөр эрхлээгүй иргэд, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийг дэд бүтэц, сум, нийтийн аж ахуйн болон нийтийн эзэмшлийн зам талбайн арчлалт, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажлын хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоонд шилжих
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах, амьдрах таатай орчинг бүрдүүлж тэдэнд үзүүлэх дэмжлэг үйлчилгээний хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн хүртээмжийг сайжруулах

Хүрэх үр дүн: Ажлын байр нэмэгдэн нийгмийн халамж асрамж үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.

2.3.Эрүүл мэндийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн нэгдүгээр үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай хүргэж, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар өвчлөлийг бууруулж, хүн амын цэвэр өсөлтийг дэмжин, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөлийн байдалд судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг тогтоож, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг чанартай хэрэгжүүлэх
- Халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг сайжруулах, дархлаажуулалтанд хавсарсан вакцин нэвтрүүлэх замаар хатгалтын тоог цөөрүүлэх
- Эх хүүхдэд ээлтэй эрүүл бүс, сум болох санаачлагыг дэмжин, хүн амыг эрүүл аж төрөх зөв зан үйлд хэвшүүлэн сургах
- Нийгмийн ядуу эмзэг бүлэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх нөхцөл бололцоог сайжруулах
- Зарим сумдын эмнэлгийг их засварт оруулж, эмнэлгийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэн бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг байгуулах

Хүрэх үр дүн: Бүсийн хэмжээнд хүн амын эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчинд амьдрах үндэс суурь тавигдана.

Тэргүүлэх зорилт 2: Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Цахим мэдээллийн технологийг хөгжүүлж, интернет сүлжээнд холбогдож төвийн эмнэлгүүдтэй хамтран ажиллах
- ЭХО аппаратыг оношлогоонд нэвтрүүлж, эмч мэргэжилтнийг сургалтанд хамруулж мэргэшүүлэх
- Эмийн бус эмчилгээний хүрээг өргөжүүлэх, уламжлалт эмчилгээ нөхөн сэргээх болон сувилах эмчилгээг түлхүү хөгжүүлэх замаар бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах
- Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах төсөлд хамруулан өрхийн эмч, эмч мэргэжилтний ур чадварыг хөгжүүлэн орон сууц, нийгмийн баталгааг сайжруулах

Хүрэх үр дүн: Хүн амд ээлтэй эрүүл мэндийн салбарын тогтолцоог бүрдүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна.

Тэргүүлэх зорилт-3: Эмнэлгийн материаллаг баазыг сайжруулж, хүний нөөцийг чадваржуулах бодлого баримтална.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Эмнэлэгт зарцуулах төсвийн төлөвлөлтийг сайжруулан нөөцийн хуваарилалт, удирдлага, ня-бо бүртгэл ба санхүүгийн тайлангийн тогтолцоог боловсронгуй болгох
- Хүн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
- Бүсийн төвд шүдний эмчтэй болох асуудлыг шийдвэрлэх
- Сумдын түргэн тусламжийн автомашиныг дэс дараатай шинэчлэх

Хүрэх үр дүн: Оношлогоо, эмчилгээ, сувилгааны чанарыг дээшлүүлэх боломж нэмэгдэн үйлчилгээний хүртээмж сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт 1: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог төлөвшүүлэн эмнэлгийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж оношлогоо, эмчилгээний багаж тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулан олон улсын хөтөлбөр, төслийн байгууллагуудын дэмжлэг туслалцааг авч, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах
- Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлж, мэргэжлийн зэрэгтэй дээд, дунд мэргэжилтний тоог нэмэгдүүлэх
- Хүн амын өвчлөлийн талаархи мэдээллийн нэгдсэн санг үүсгэн электрон шуудан ашиглан үйлчлүүлэгчийн хүссэн мэдээллийг хүргэх, мэдээллийн шинэ тогтолцоог бүрдүүлэх
- Суурь өвчнийг эмчлэх сувиллын газрыг байгуулж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх

- Хөдөөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд мэдээлэл технологийн ололт дэвшлийг нэвтрүүлэх ажлыг дэс дараалалтай хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшлэхийн зэрэгцээ эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин бүрдэж, тусламж үйлчилгээний чанар сайжирна.

Тэргүүлэх зорилт 2: Эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг явуулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Эрүүл мэндийн салбар дахь хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх
- Ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газрын үйл ажиллагааг чанаржуулж хөгжүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нөхөн сэргээх, эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөж, материаллаг орчныг сайжруулан, хөдөлгөөний болон эмийн бус эмчилгээг өргөжүүлэх
- Эмч, эмнэлгийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- Хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагыг дэмжин хөгжүүлж, оновчтой тогтолцоог бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарын мэргэжлийн болон техникийн мэдлэг, боловсролын түвшин дээшлэн, тогтвор суурьшилтай ажиллах боломж нэмэгдэж, хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар сайжирна.

2.4.Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Бүсийн хүн амд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн эрүүл зан үйлд сургаж биеийн тамирын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан дундаж наслалтыг уртасгана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Спортын дасгал хөдөлгөөний ач холбогдолыг сурталчлан иргэдийн спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэх
- Чийрэгжүүлэх, бялдаржуулах төвүүдийг нээн ажиллуулах.
- Спорт цогцолборын заал, танхим, материаллаг баазад тулгуурлан үндэсний болон спортын төрөл бүрийн секц дугуйлан хичээллүүлж, мэргэжлийн тамирчдыг бэлтгэн гаргах
- Мэргэжлийн дасгалжуулагч боловсон хүчнийг бэлтгэж хүний нөөцөөр хангах ажлыг зохион байгуулах
- Бүс, аймаг, улсын хэмжээний уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах.
- Аймаг, улс, тив, дэлхийн хэмжээнд зохиогдох тэмцээнд оролцох баг тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, амжилт гаргасан баг тамирчдыг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх
- Сумдад спортын тоглоомын талбайг шинээр байгуулах
- Зарим сумдад спорт залыг барих, материаллаг баазыг бэхжүүлэх

Хүрэх үр дүн: Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдэж, тамирчдын ур чадвар дээшлэн, хүн амын эрүүл мэнд сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат: /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Биеийн тамир спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж хүртээмж чанарыг дээшлүүлэн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвар, өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Биеийн тамир спортын байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын тогтолцоог оновчтой болгож төр олон нийт, бизнесийн байгууллагуудтай түншлэлийн холбоо бий болгон ажиллах.
- Спортын өндөр зэрэглэлтэй дасгалжуулагч, мэргэжилтэнг бэлтгэн хүүхэд залуучуудын авъяасыг нээн хөгжүүлэх.
- Улсын болон олон улсын спортын байгууллага, спортын холбоодуудаар дамжуулан хамтарсан бэлтгэл хийх орчин нөхцлийг бүрдүүлэн, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлж, өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийг улс, тив дэлхийн тэмцээнд амжилт гаргахад дэмжлэг үзүүлэх.
- Биеийн тамир спортын стандартын заал талбайг тохижуулж, өвлийн спортоор хичээллэх материаллаг баазыг бэхжүүлэх.
- Улсын хэмжээний тэмцээн уралдааныг бүсийн төвд зохион байгуулах.
- Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлж материаллаг орчин, техник хэрэгслээр ханган уралдаан тэмцээнийг тогтмолжуулах нийтийн хүртээл болгох ажлыг дэмжих.

Хүрэх үр дүн: Үндэсний болон нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх материаллаг бааз бэхжиж, мэргэжлийн ур чадвар, өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэгдэх таатай нөхцөл бүрдэнэ.

2.5.Соёл урлагийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. / 2010-2015 /

Тэргүүлэх зорилт 1: Соёл урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангаж, менежментийг сайжруулах, ажиллагсдыг мэргэшүүлэх, тасралтгүй сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрөөс баримтлах соёлын бодлого, хүний хөгжлийн цогц бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг үндэс болгон орон нутгийн өвөрмөц онцлогт тохирсон, биеэ даасан, чөлөөтэй хөгжих соёлын орчинг бий болгох
- Хөдөө орон нутагт ажиллах соёл урлагийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- Сумдын соёл, урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангахын тулд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Олон Улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд үе шаттайгаар бэлтгэж оролцох
- Сумын соёлын төв, номын сан, орон нутгийг судлах кабинетын барилгыг шинээр барих, өргөтгөх засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжлийг хангаж, чадварлаг хүний нөөцөөр хангагдаж, соёлын үйлчилгээний хүртээмж сайжирна.

Хөгжлийн 2-р шат. / 2017-2021/

Тэргүүлэх зорилт: Соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Соёлын төвүүдийг стандартын шаардлагын хэмжээнд хүргэж тохижуулах, орчин үеийн техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр хангах
- Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүрээг өргөтгөх зорилгоор төрөл бүрийн төрөлжсөн дугуйлан /үндэсний хөгжмийн хамтлаг, биелгээ бүжгийн хамтлаг, язгуур хамтлаг, хүүхдийн морин хуурийн чуулга гэх мэт / хичээллүүлэх, уран бүтээлийн болон уран сайхны хамтлаг байгуулах нөхцлийг бүрдүүлж түүгээрээ дамжуулан ард, иргэдэд чанартай, оновчтой үйлчилгээг хүргэх.
- Хөрш орны хил орчмын аймгуудтай болон хамтын ажиллагаатай улс орнуудтай соёлын харилцаа холбоог хөгжүүлж харилцан туршлага судлах, язгуур урлаг соёлын уламжлалаа сурталчлан таниулах зэргээр хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Сумдын номын санг иргэдэд мэдээллээр үйлчлэх үүрэг бүхий номын сан, цахим мэдээллийн төв болгон өөрчлөн зохион байгуулах, электрон каталогит оруулан, сум, сургуулийн номын санг орчин үеийн компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн тоог нэмэгдүүлэх, хамгаалалтын оновчтой тогтолцоог бий болгох
- Утга соёлын өвийг өвлөн тээгчдийн бүртгэл судалгааны мэдээллийн сан бий болгох, утга соёлын өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билэг авъяастны жагсаалтанд бүртгүүлж урамшуулах алдаршуулах ажлыг зохион байгуулах
- Орон нутаг судлах танхимыг сумын түүх, уламжлал, зан заншлыг сурталчлах үйл ажиллагааны төв болгон өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагууд стандартын хэмжээнд хүрч ажиллах ба бие даасан үйл ажиллагаа сайжирч, ард иргэдэд урлаг, соёлын чанартай үйлчилгээ үзүүлдэг болно.

Гурав. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Орон нутагт үр нөлөө бүхий шуурхай, ил тод үйл ажиллагааг төрийн ажил үйлчилгээнд төлөвшүүлж, гадаадын улс орнуудтай түншлэлийн харилцааг хөгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Сэлэнгийн бүсийн засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

1. Засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
2. Гадаад харилцааны бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

3.1.Засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт 1: Орон нутагт үр нөлөө бүхий шуурхай, ил тод үйл ажиллагааг төрийн ажил үйлчилгээнд төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, хялбаршуулах баг, сумын Засаг дарга, Тамгын газраас иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээ хүнд суртал, чирэгдэлгүй, ил тод нэг цэгээс үйлчлэх бүтэц, зохион байгуулалт хийх
- Бүсийн сумдын бүтэц зохион байгуулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн онцлогт уялдуулан боловсронгуй болгож төрийн албыг мэргэшлийн чадварлаг албан хаагчдаар бэхжүүлэх
- Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, мэдээлэл технологийн шинэ ололтыг нэвтрүүлэх,

- Засаглалын бодлого шийдвэрийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулж, шийдвэр боловсруулах үйл явцад иргэд, олон нийтийн оролцох оролцоог нэмэгдүүлэх.
- Нийгмийн эрэлттэй уялдуулж төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар, ажиллах нөхцлийг дээшлүүлэх, мэдлэгт суурилсан мэргэшлийг төрийн албан хаагчдад эзэмшүүлэх, ажлын байран дээрээ суралцаж хөгжих боломжийг бүх талаар хангах.

Тэргүүлэх зорилт 2: Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлж гэмт хэрэг, зөрчлийг бууруулан иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Иргэдэд хууль эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлдэг “Эрх зүйн туслалцаа”-ны төвийг багуудад байгуулж иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт, сурталчилгааг зохион байгуулах.
- Гэмт хэрэг зөрчлийг бууруулж, иргэдийг ая тухтай тайван амьдрах нөхцлөөр ханган, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх.
- Хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл лавлагааг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх зорилгоор сумдын ЗДТГазрын “Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв”-ийг интернетэд холбож, цахим үйлчилгээг нэвтрүүлэх.
- Өмчийн эсрэг гэмт үйлдэл, малын хулгайн эсрэг төр, төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх.
- Гэмт хэргийг бууруулах, хүүхэд болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах
- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг багасгахад иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж үр дүнд хүргэх

Хүрэх үр дүн: Нутгийн захиргааны байгууллагын чадавхи сайжирч, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөө, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж гэмт хэрэг буурна.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт 1: Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн бие даасан байдлыг хангаж, нутгийн захиргааны байгууллагыг мэргэшсэн захиргааны байгууллага болгон бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өөрийгөө тэтгэх эдийн засаг, санхүүгийн боломжийг бүрдүүлж улсын загвар бүс, сум, баг болох хөдөлгөөнийг өрнүүлж үр дүнд хүрэх
- Орон нутгийн төсөв санхүүгийн чадавхийг бэхжүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах талаар төрийн байгууллагаас анхааран ажиллаж үр дүнд хүрэх
- Иргэн бүрт төр, бизнесийн үйлчилгээг эрх тэгш, ил тод, хөнгөн шуурхай байдлаар хүргэх
- Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын өөрчлөлт шинэчлэлтийг эрчимжүүлж, менежментийг сайжруулах
- Хүний хөгжлийг хангах, гэр бүл, айл өрхийн амьдралын таатай орчинг бүрдүүлэхэд нутгийн захиргааны байгууллагын бодлого үйл ажиллагааг чиглүүлэх

Тэргүүлэх зорилт 2: Иргэдийг орон нутаг, гэр бүл, ажлын байр, нийгэм хамт олны дунд амар тайван ажиллаж, амьдрах нийгмийн орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх.

- Нийгмийн дэг журам сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд цахим мэдээллийн сүлжээ бий болгох

Хүрэх үр дүн: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даан хөгжих боломж бүрдэж эдийн засгийн чадавхи сайжран, нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага болж бэхжинэ.

3.2.Гадаад харилцааны бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн Хөгжлийн 1-р үе шат. /2011-2016 он/

Тэргүүлэх зорилт: Гадаадын улс орнуудтай түншлэлийн харилцааг хөгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн түүх, соёлын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засгийн давуу тал, онцлог, нөөц боломжийн талаар гадаад улс орнуудад сурталчлах ажлыг зохион байгуулах, энэ талаар хэтийн бодлого чиглэлийг тодорхойлох
- Төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийг гадаад орнуудад сургах, мэргэшүүлэх шаардлагатай боловсон хүчнүүдийг урилгаар авч ажиллуулах замаар орон нутгаа хөгжүүлэх бодлогыг баримтлах.
- Гадаадад ажиллах хүч гэрээгээр илгээх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулан ажиллах.
- Нийгмийн хамгаалал, эдийн засгийн чиглэлээр гадаад орнуудын төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх
- Гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, Зэлтэрийн боомтыг байнгын ажиллагаатай болгох.

Хүрэх үр дүн: Гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжиж бүсэд орох хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Гадаадын улс орнуудтай түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн баталгаажуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, орон нутгийн эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх.
- Бусад улс орны муж хотуудтай хөгжлийн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулж гадаад харилцааг бэхжүүлэх.

Хүрэх үр дүн: Гадаад улс орнуудын хамтын ажиллагаа өргөжин, эдийн засгийн харилцаа сайжирна.

Дөрөв. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

“Сэлэнгэ бүс”-ийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэний үр дүнд бүсийн эдийн засгийн гол үндэс болох газар тариалан, мал аж ахуйн салбарын хөгжил эрчимжиж, шинжлэх ухаан, техник технологийн шинэчлэл бүрэн нэвтэрч үр тариа, төмс, хүнсний ногоо, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр тэргүүлэх бүс нутаг болно.

Уул уурхай, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлснээр дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлэж иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдэнэ.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж нээлттэй, ил тод, шударга засаглалыг бэхжүүлж, хүн ам тогтвортой өсөж, эрүүл мэнд, биеийн тамир спорт, боловсрол, соёлын үйлчилгээний үр нөлөө дээшилнэ.

Сэлэнгэ бүсийн хөгжлийн хөтөлбөр нь 4 бүлэг, 40 тэргүүлэх зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдүгээр үе шат буюу 2011-2016 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны 128 арга хэмжээ зорилт, хоёрдугаар үе шат болох 2017-2021 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны 80 арга хэмжээ зорилт нийт 217 үйл ажиллагааны зорилтыг улс, аймаг, орон нутгийн төсөв, гадаад дотоодын төсөл хөтөлбөр, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, алдаа дутагдалыг залруулж, хүндрэл, бэрхшээлийг арилган хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэхэд оршино.

Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үе шатны хяналт-шинжилгээ, үнэлгээг 2016 онд, хөтөлбөрийн хоёрдугаар шатны хэрэгжилтийн үр дүнг 2021 онд тус тус гаргана.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СЭЛЭНГЭ БҮСИЙН 2021 ОН ХҮРТЭЛХ
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

№	Үзүүлэлт	2008 он	2009 он	2010 он	1-р үе шат 2016 он	2-р үе шат 2021 он	
1	Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт	1.ДНБ/сая төг/	25835.1	23466.2	31202.3	38000.0	45000.0
		2.Нэг хүнд ноогдох ДНБ /мян,төг/	3171.9	2754.9	3802.3	4418.6	5000.0
		3.Нийт хөрөнгө оруулалт /сая,төг/	122.5	1321.8	255.6	1500.0	2500.0
		4.Аж үйлдвэрийн НБ /сая,төг/	18084.6	16426.3	21841.6	26600.0	31500.0
		5.Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн НБ /мян,төг/	2220.3	1928.4	2661.6	3093.0	3500.0
		6.ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /сая, төг/	5167.0	4693.2	6240.5	7600.0	9000.0
		7.Нэг хүнд ноогдох хүнс ХАА-н бүтээгдэхүүн /мян,төг/	634.4	550.9	760.5	883.7	1000.0
		8.Жижиг дунд үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн /сая,төг/	391.7	422.8	814.8	1000.0	1200.0
		9.Өрхийн аж ахуйн нийт бүтээгдэхүүн /сая, төг/	1367.3	1486.2	2322.2	3000.0	3500.0
		10.Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний нийт бүтээгдэхүүн /сая, төг/	1033.4	938.6	1248.1	1520.0	1800.0
		11.Малын тоо /мян, тол/	236838	244897	214346	190000	190000
		12.Өндөр ашиг шимт цэвэр эрлийз шилмэл омгийн малын эзлэх хувь	24.8	25.0	29.7	35.0	50.0
		13.Хураан авсан ургац /тн/	Үр тариа	53777	83504	52640	85000
Төмс	3724		5927	5362	6200	7200	
Хүнсний ногоо	3007		2782	3080	3500	4500	
Малын тэжээл	21000		24065	41813	45000	50000	
2	хөгжил	14.Нийт хүн ам	8145	8518	8206	8600	9000
		15.Үүнээс: Хөдөлмөрийн насны хүн ам	5220	5449	5137	5418	5670

		16.Дундаж наслалт	68.18	68.87	68.93	70.0	72.0
		17.Эхийн эндэгдэл /тоо/	-	1	-	-	-
		18.Нялхасын эндэгдэл /1000 хүүхдэд ноогдох/	2.6	2.6	1.7	1	-
		19.Ажилгүйдлийн түвшин	1.26	2.17	1.74	1.0	0.7
	20. Халдварт өвчний прогноз	А гепатит	12	7	30	-	-
		Сүрьеэ	20	22	12	-	-
		БЗДХ	45	61	23	-	-
		Нийт халдварт өвчин	87	109	68	-	-
3	Байгаль орчин, дэд бүтэц	21.Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	6.2	6.2	6.2	-	-
		22.Улсын тусгай хэрэгцээний газар/Улсын хадлан, тэжээлийн сангийн талбай /га/	21000	21000	21000	25000	25000
		23.Ойжуулсан талбайн хэмжээ /га/	-	120	55	200	400
		24.Шинээр ашиглалтанд орсон хатуу хучилттай,, болон сайжруулсан замын урт /км/	-	-	48.5	135	175
		25.Уул уурхайн олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлт /га/	-	-	-	-	-
		26.Ашиглалтанд орсон барилгын нийт талбай /мян, м ² /	750	900	300	600	1200
		27.Сэргээгдэх эрчим хүчээр хангагдах малчин өрхийн нийт өрхөд эзлэх хувь	15.7	14.1	23.1	30	34
		28.Бэлчээрийн усжуулалт /хувь, өсөн нэмэгдсэн дүнгээр/	6	1	12	20	30
		29.Усалгаатай тариалангийн талбай /га, өсөн нэмэгдсэн дүнгээр/	1500	1500	1800	2400	3200

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 74

Сүхбаатар

Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөр
батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 18, 2007 оны 38 дугаар тогтоолуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх зорилтыг бүсийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиг баримжаа болгон, хэрэгжүүлэх стратеги зорилтуудыг бүсийн сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг бүсийн зөвлөл, бүсийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.

3. Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖОКОВ

УДИРТГАЛ

Аймаг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг орчин үеийн арга зүйн дагуу олон нийт, оролцогч талуудын өргөн оролцоонд тулгуурлан шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт хийж, хөгжлийн хэтийн төлвийг тооцож, урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагын үүднээс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийн дагуу “Сэлэнгэ аймгийн 2021 он хүртлэх хөгжлийн хөтөлбөр”-ийг үндэслэн “Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдах болсон.

Орхоны бүс нь нийт 11770.7 км² нутаг дэвсгэртэй Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Хушаат сум, 13 баг, Номгон, Рашаант орон нутгийн 2 тосгонтой. 2010 оны байдлаар хүн амын тоо 21553 хүрсэн нь аймгийн нийт хүн амын 21.2 хувийг эзэлж байгаа бөгөөд хүн амын нягтшил нь 1.83, 1000 хүнд ногдох төрөлт 7.4, нас баралт 5.4, цэвэр өсөлт 2.0 байна.

Орхоны бүс нь 2010 оны байдлаар 75.7 мянган тн үр тариа, 14.2 мянган тн төмс, 7.1 мянган тн хүнсний ногоо хураан авч аймгийн нийт үр тарианы 42.6 хувь, төмсний 33.2 хувь, хүнсний ногооны 23,5 хувийг хангаж байгаа газар тариалангийн бүс нутаг юм.

Бүсийн хэмжээнд 2010 оны байдлаар 581179 толгой тоологдсоноос тэмээ 563, адуу 28236, үхэр 49430, хонь 283861, ямаа 219089 толгой, сүргийн бүтэц адуу 4.9 хувь, үхэр 8.5 хувь, хонь 48.8 хувь, 37.7 хувь байна.

Нутгийн өөрөө удирдах болон төрийн үйлчилгээний байгууллагуудаас орон нутгийн хөгжил цэцэглэл болон бизнес эрхлэгчдийн идэвхитэй үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангах, тэдэнд тулгарч буй асуудал, хүндэрлийг шийдвэрлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлж хамтран ажиллах, мөн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийг чадавхижуулах, шинээр биез бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах, иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх асуудлыг бүсийн хэмжээнд зохион байгуулан ажиллах ёстой.

Орхоны бүсийн хөгжлийн алсын харааг “Хүний хөгжлийг дээдлэн, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжсэн, орчин үеийн техник, технологид суурилсан эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, ногооны аж ахуй, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлнэ” гэж тодорхойлж байна.

Тус бүс нь газар тариалан эрчимжсэн мал аж ахуйн бүс төдийгүй Сайхан сумын Хөтөлийн цемент шохой ХК-г түшиглэн барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор болон хөгжих дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэх бүрэн боломжтой.

Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөрийг Эдийн засгийн бодлого, Нийгмийн бодлого, Засаглалын бодлого гэсэн 3-н салбарт хуваан 2012-2016 он, 2017-2021 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Нэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөрийн эдийн засгийн бодлогын гол зорилт нь сум орон нутгийн хөгжил, нийгэм, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлж, аймгийн 2021 он хүртлэх хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах явдал юм.

Орхоны бүсийн эдийн засгийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

7. Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
8. Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
9. Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
10. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөгжил, газар өмчлөлийн бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ
11. Худалдаа үйлчилгээний салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ
12. Дэд бүтцийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ

1.4 Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Орхоны бүсэд боловсруулах үйлдвэрүүдийг бий болгох, шинэ технологи нэвтрүүлэх, дотоод гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Хөгжлийн 1-р үе шат (2012-2016 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, зах зээлийн эрэлтэд нийцсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн шинэ салбарыг хөгжүүлэх
- Бүсийн төв Сайхан суманд “Гурилын үйлдвэр”, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий “Барилгын материалын үйлдвэр”, “Цементийн үйлдвэр”, “Хөнгөн бетоны үйлдвэр”, “Шахмал түлшний үйлдвэр” зэрэг үйлдвэрийг хөгжүүлэх
- Орхон суманд “Сав баглаа бодлын үйлдвэр”, Хүнсний ногоо даршлах үйлдвэр” байгуулах
- Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг Сайхан суманд байгуулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын зах зээлд өрсөлдөх
- Рашаан усыг савлах, жимс жимсгэнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хүрэх үр дүн: Бүсийн хөгжлийн эдийн засгийн чадамж нэмэгдэж, боловсруулах аж үйлдвэрт дэвшилтэт технологи нэвтэрч, үйлдвэрлэл өсч, бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2017-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Мал, ургамлын гаралтай түүхий эдийг биотехнологийн аргаар боловсруулж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх
- Хүн, малын эм бэлдмэлийн үйлдвэрлэлийг бий болгох
- Төмс боловсруулах цардуулын үйлдвэрийг байгуулах

Хүрэх үр дүн: Аж үйлдвэрийн салбарт биотехнологийн үйлдвэр ашиглалтанд орсноор уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг орлох боломж бүрдэж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ нэмэгдэнэ.

1.5 Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.2.1. Газар тариалангийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Газар тариалангийн үйлдвэрлэлд газар ашиглалтыг сайжруулж, газарт оруулах хөрөнгө оруулалт, тухайлбал бордох, дэвшилтэт технологийг

нэвтрүүлж, техникийн шинэчлэлийн бодлого зохицуулалтын арга хэмжээг зохион байгуулах, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх

Хөгжлийн 1-р үе шат (2012-2016 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Усны нөөцөд түшиглэн экологид хоргүй услалтын систем барих, шинэчлэх замаар усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэх
- Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж таримлын ургалтыг хурдасгах, ногоочдын орлогыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх.
- Зоорийн аж ахуйг хөгжүүлж төмс, хүнсний ногооны хадгалалтын стандартыг сайжруулах
- Үр тариа, төмс, хүнсний ногооны талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, нэмэгдүүлэх, бордох технологийн шинэчлэлтийн бодлого зохицуулалтын арга хэмжээг шинжлэх ухааны байгууллагатай хамтран зохион байгуулах.
- Үр тарианы эргэлтийн талбайг эдийн засгийн эргэлтэнд бүрэн оруулах
- Хөдөө аж ахуйн паркийг аж ахуйн нэгжид тулгуурлан байгуулж техникгүй иргэдэд санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр үйлчлэх замаар аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжих.
- Улаан буудайн нутагшсан сортын үрийг үржүүлэх, үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулах
- Сант сумын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн бааз суурийг түшиглэн бүсийн газар тариалангийн үйлдвэрлэлийн машин механизмын тоног төхөөрөмж сэргээн засварлах үйлчилгээний төвийг бий болгож, иргэд, аж ахуйн нэгжийн техникийн нөхцлийг сайжруулах.
- Сайхан суманд үр тариа хадгалах стандартын шаардлага хангасан агуулах байгуулах

Хүрэх үр дүн: Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирч, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн чадавхи нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат (2017-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэжээ:

- Тариалангийн үйлдвэрлэлд технологиогийн шинэчлэлтийг үргэлжлүүлэх
- Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж, баталгаатай ургац авах нөхцлийг бүрдүүлэх
- Хүлэмжийн аж ахуйн тоог нэмэгдүүлэх замаар эрт ургацын ногооны төрлийг олшруулах
- Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн хоршсон томоохон фермерүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй санхүүгийн түрээсээр нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэн чацарганаы тариаланг нэмэгдүүлэх
- Хөдөө аж ахуйн паркийн үйл ажиллагааг өргөтгөх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх
- Нутагшсан сортыг баталгаажуулж үр үржүүлдэг аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Хөдөө аж ахуйн машин техникийн хангамж, ашиглалт нэмэгдэж, техник технологийн нэвтрүүлэлт сайжирч нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдна.

1.2.2 Мал аж ахуйн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барьж, сайн үүлдрийн болон нутгийн шилмэл малыг тэжээл үйлдвэрлэлтэй хослуулан түлхүү хөгжүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат (2012-2016 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гахай, шувуу үржүүлэх чиглэлээр өрхийн болон фермерийн аж ахуйг хөгжүүлэх
- Мах ноосны хэвшлийн нарийвтар ноост “Орхон” үүлдрийн хонины генофондыг хадгалж тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлэх, “Сэлэнгэ” үүлдрийн чанар ашиг шимийг нэмэгдүүлэх үржлийн ажлын төлөвлөгөө боловсруулан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
- Мах, сүүний чиглэлийн фермерийн үйл ажиллагааг дэмжиж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх
- Бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээх, хашиж хамгаалах, үндсэн сайжруулалт хийх
- Өндөр ашиг шимт малын тоо толгойг 40 хувь хүртэл нэмэгдүүлж, ямаа сүргийн тоо толгойг хязгаарлах
- Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, тэжээлийн баазыг бий болгох, таримал тэжээл ба хүчит тэжээл өвс бэлтгэх шаардагдах техник хэрэгслээр дэмжлэг үзүүлэх
- Цөм сүрэг, үржлийн хээлтүүлэгчийг өсгөх, бойжуулах, зохиомол хээлтүүлэгт гүн хөлдөөсөн үрийг ашиглах үйлчилгээг өргөжүүлэх
- Мал эмнэлгийн оншлогоо, шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлж малын эм, вакцины хангамжийг нэмэгдүүлэх.
- Бүсийн хадлангийн талбайн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Эрчимжсэн мал аж ахуй, суурин болон хагас суурин фермерийн тоо тогтмол нэмэгдэж, бэлчээрийн доройтол багасан, бэлчээр ашиглалт, малын чанар сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бэлчээрийг сайжруулах хашаалсан, нөхөн сэргээсэн бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг боловсронгуй болгох.
- Төв суурин газрын дэргэд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрчимжсэн фермерийн аж ахуйг дэмжих
- Малын тэжээл үйлдвэрлэх, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх
- Сумын мал эмнэлгүүдийн материаллаг бааз, багаж, тоног, төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулах

Хүрэх үр дүн: Эрчимжсэн суурин маллагаатай шинэ хэлбэрийн хувийн хэвшлийн мал аж ахуйн суурь тавигдаж мах, сүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

1.6 Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.3.1 Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж өргөжүүлэх, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, цэвэр өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх.

Хөгжлийн 1-р үе шат (2012-2016 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг үйлдвэрлэл технологийн паркттай уялдуулан тодорхойлж хөгжүүлэн ажилгүйдлийн түвшинг бууруулах
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх банк ба банк бус санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн зүгээс үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож байгаа хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг сургалт семинарт хамруулж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах
- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа ажил үйлчилгээ худалдан авахад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах

Хүрэх үр дүн: Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдэж, албан секторт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдэж, татварын бааз суурь өргөжнө.

Хөгжлийн 2-р үе шат (2017-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн томоохон үйлдвэрүүдийн хангамжийн материалыг жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах
- Жижиг, дунд үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Өндөр түвшинд хүрсэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ бий болж, ажлын байр нэмэгдэнэ.

1.3.2. Өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх таатай орчныг бий болгож, ажилгүйдлийг бууруулж иргэдийн амьжиргааны чадавхийг дээшлүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат /2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа ажил үйлчилгээ худан авахад орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах
- Өрхийн аж ахуйг эрхлэхэд төрийн зүгээс бүх талын дэмжлэг үзүүлэх , жижиг зээлийн үйлчилгээ буюу бичил санхүү, зээлийн зуучлалын үйлчилгээг өрхийн үйлдвэрлэлрүү чиглүүлэх бодлого хэрэгжүүлэх
- Сүү ,төмс, хүнсний ногоо , мах боловсруулах , шахмал түлш, мал бордох , зоорины аж аж ахуй эрхлэх жимс, жимсгэнэ тариалах, модны тарьц суулгац ургуулах , ноос боловсруулах, модон эдлэл, оёдолын үйлдвэрлэл эрхлэх өрхийн аж ахуйг хөгжүүлэх, дэмжих,
- Өрхийн аж ахуй эрхлэгчдэд бизнес төлөвлөгөө боловсруулах, өрхийн аж ахуйг хөгжүүлэх арга хэрэгслүүд түүний хэрэглээний талаарх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж хамруулах
- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор баг бүрт хөгжлийн сан байгуулах
- Барилгын модон материалыг орлох тоосго, блокны жижиг оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, өрхийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Ажлын байр шинээр нэмэгдэж, аж ахуй эрхлэх , тогтвортой үйл ажиллагаа үйлдвэрлэл бий болж , амьдралаа өөд нь татах хүсэл сонирхолтой иргэн бүрийн өмнө адил тэгш боломж нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Тогтвортой үйл ажиллагаатай өрхийн аж ахуйдад банк, санхүүгийн байгууллагуудтай харилцахад дэмжлэг үзүүлэх
- Өрхийн аж ахуйд бүтээгдсэн хүнсний бүтээгдэхүүнийг нийслэл, бусад аймгуудад борлуулах боломж бүрдүүлэх
- Өрхийн аж ахуй эрхлэгчид хорших, хамтрах замаар үйлдвэрлэлээ өргөжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Өрхийн аж ахуйг эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо, чанарт өөрчлөлт орж ажилгүйдэл эрс буурч, хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.

1.4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөгжил, газар өмчлөлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

1.4.1 Байгаль орчны хамгаалал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Байгаль орчны хяналтыг сайжруулж, хүрээг өргөтгөх, бохирдлын түвшинг стандартад нийцүүлэн бууруулна.

1.4.1.1 Агаар, ус, хөрс

Хөгжлийн 1-р үе шат / 2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Уул уурхайн олборлолтын талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийлгүүлэх ажлыг эрчимжүүлэх, хяналтыг сайжруулах
- Агаар, ус, хөрсний бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт тавьж ажиллах
- Хог хаягдал шатаах, ил задгай хог хаягхыг зогсоож, хог хаягдлын төвлөрсөн цэгийг ландфилын аргаар тохижуулах
- Шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж модыг түлшинд хэрэглэхээс татгалзах
- Нам даралтын зуухаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд бүрэн хамруулах, уурын зуухны тоог цөөрүүлэх, дулааны нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авах
- Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, карьерын аж ахуй эрхлэх байгууллага бий болгож ажиллуулах
- Стандартад нийцсэн хог хаягдлын төвлөрсөн хогийн цэгийн тоог нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Ард иргэдийн эрүүл, аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат / 2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ус цаг уурын, орчны шинжилгээний байгууллагуудын тоног төхөөрөмжийг шинчлэх
- Хог хаягдлыг ялган боловсруулах үйлдвэрийг сумдад барьж байгуулах
- Нам даралтын зуух бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийг төвлөрсөн халаалтын системд холбож дуусгах

Хүрэх үр дүн: Байгаль орчны болон уур амьсгалын төлөв байдалд тавих хяналт сайжирч бохирдлын түвшин буурна

1.4.1.2 Усны нөөц

Хөгжлийн 1-р үе шат. /2012-2016/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн нутаг дэвсгэрийн усны нөөцийг тогтоох усны эх үүсвэрийн тооллого явуулах уст цэгийн ашиглалтанд үзлэг судалгаа хийх
- Сумдын эрдэсжилт өндөр болон хатуулаг ихтэй усны чанарт хяналт-шинжилгээ хийх, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах
- Гадаадын хөрөнгө оруулалттай олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран гадаргын усны бохирдолын түвшинг тодорхойлох
- Ширгэж буй булаг шанд болон усын эх ундаргыг хашиж хамгаалах, сэргээх ажлыг зохион байгуулах
- Инженерийн хийцтэй уст цэгийг сэргээн засварлах шинээр гаргах замаар бэлчээр усжуулах ажлыг үе шаттайгаар явуулах
- Ус цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангах, хүчин чадлыг бүрэн нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Усны нөөц тогтоосноор хүн, ам хөдөө аж ахуй, газар тариаланд усыг зөв зохистой ашиглах, усны чанарыг хамгаалах, хүн амыг цэвэр аюулгүй баталгаатай усаар хангагдах, усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ус түгээх шугамын хүчин чадал, уртын хэмжээ нэмэгдүүлэх
- Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах хяналт зохион байгуулалтын бүтцийг бий болгох
- Орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хур тундас, үерийн усыг хуримтлуулан газар тариаланд ашиглах
- Экологийн ач холбогдол бүхий усны эх үүсвэрийг хамгаалалтанд авах

Хүрэх үр дүн: Усны нөөцийг нөхөн сэргээх нөхцөл бүрдэж, экологийн ач холбогдолтой усны эх үүсвэр хамгаалагдана.

1.4.1.3 Ойн нөөц

Хөгжлийн 1-р үе шат: /2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ой мод ашигласны төлбөрөөс ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах
- Ойн санг эзэмших, хамгаалах, нөхөн сэргээх иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх нарс, бургас, гацуур, жодоон ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд ард иргэдийг өргөнөөр татан оролцуулах
- Хуш, жодоо, гацуур зэрэг хөвч ой үүсгэхэд чухал үүрэгтэй модыг үржүүлэх, шилжүүлэн суулгах арга хэмжээг зохион байгуулах
- Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх
- Ойн хортонтой тэмцэх зорилгоор ойн шоргоолжны үүргийг хамгаалах, олшруулах, ойн түймэр, хөнөөлт шавьжийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх
- Сант суманд ойн ангийг байгуулж, бүсийн сумдад ойжуулах нөхөн сэргээхэд шаардагдах тарьц суулгацаар хангах

Хүрэх үр дүн: Ойн нөөц нэмэгдэж, зөв зохистой ашиглалт, байгалийн аясаар нөхөн сэргээгдэх нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат: /2017-2021/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын чадавхийг дээшлүүлэх, шаардлагатай техник хэрэгслээр хангах
- Орхон, Сант сумдад мод үржүүлгийн газрыг үе шат дараатайгаар хөгжүүлж, нэмэгдүүлэх
- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг нэвтрүүлэх
- Ойн нөөцийн ашиглалтыг сайжруулан дотоодын болон бусад орон нутгийн хэрэгцээг хангах
- **Хүрэх үр дүн:** Ойн нөөцийн хэвийн ургах нөхцөл бүрдэж, экологийн тэнцвэр хангагдана.

1.4.1.4 Биологийн төрөл

Хөгжлийн 1-р үе шат / 2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Нэн ховор ан амьтан, ургамлын судалгааг хийж, зориудаар өсгөж үржүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, тогтвортой байдал, хэвийн өсөлт, ургамалжилтыг хангахтай холбогдсон бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх

- Ан амьтан, ургамлыг хамгаалах хууль эрх зүйн хүрээнд тодорхой хугацаанд ан амьтан агнахыг хориглох, ургамлын нэрс, байршлыг заасан орон нутгийн шийдвэрийг гаргах
- Хүрэх үр дүн:** Устгах аюулд орсон ахуйн ач холбогдолтой ан амьтан, ургамлыг зориудаар өсгөж үржүүлэх ажилд ахиц гарна.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутгийн байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх судалгааг жил бүр зохион байгуулан явуулж, мэдээллийн санг бүрдүүлэх
- Биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Биологийн төрөл зүйл ач холбогдлын талаар ард иргэдийн мэдлэг, мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг хийх

Хүрэх үр дүн: Орон нутгийн байгалийн экосистемийн тэнцлийг хадгалах, нөхөн сэргээх, үржих нөхцөл бүрдэж зүй зохистой ашиглалт, хамгаалалт сайжирна.

1.4.1.5 Байгалийн гамшиг

Хөгжлийн 1-р үе шат. /2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгалийн аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолж, ард иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй хүргэх
- Хорт ургамал, шавьжийн голомт, хүн малын гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, арилгах, хорио цээр тогтоох, хүн, мал эмнэлгийн ажилчдыг чадавхижуулах
- Байгалийн гамшиг, халдварт өвчин болон гэнэтийн аюул, ослоос сэргийлж ард иргэдийг амь насны даатгалд хамруулах
- Гамшгийн үед ажиллах менежментийн төлөвлөгөөг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түшиглэн боловсронгуй болгож, ард иргэдийг аюулгүй амьдрах, учрах хохиролоос урьдчилан сэргийлэх үүднээс сургалт сурталчилгааг тогтмолжуулах
- Байгаль цаг уурын онц ноцтой үзэгдлийн үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны тусламж болон хүнс, өвс тэжээлийн байнгын нөөцтэй болох
- Байгалийн гамшгийн талаарх хүн амын мэдлэгийг дээшлүүлэх, тусгай сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулах

Хүрэх үр дүн: Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлж, учирч болох эрсдлийг бууруулна.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Байгалийн гамшиг ослын үед ажиллах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, шинэчлэх
- Мэргэжлийн байгууллагын ур чадварыг дээшлүүлэх, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах

Хүрэх үр дүн: Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах.

1.4.2 Аялал жуулчлал салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Гадаад, дотоодын аялагч, жуулчдыг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлэх, орон нутаг, ёс заншлаа сурталчилах, таниулах

Хөгжлийн 1-р үе шат /2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүрэнхан уул, Амарбаясгалант хийд болон байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн жуулчны бааз, амралт сувиллын газар байгуулах
- Түүх соёлын дурсгалт газруудыг түшиглэн аяллын маршрут бий болгож, дотоодын болон гадаадын жуулчдыг татах
- Түүх, соёлын дурсгалт газар болон жуулчдад үзүүлэх үзмэрийг шинэчлэн засварлах, хадгалах, хамгаалах
- Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын шинэ төрлийн үйлчилгээ бий болгох /өвлийн спорт, усан аялал, морин аялал г.м/

Хүрэх үр дүн: Орон нутагт аялал жуулчлал хөгжиж, бүсийн хөгжилд тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Стандартын шаардлага хангасан амралт, жуулчны баазуудыг байгуулж, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын шинэ төрлүүдийг хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасган, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх
- Улсын болон олон улсын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд хамруулах
- Жуулчдын аюулгүй байдлыг хангаж, үйлчилгээний чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн: Аялалын шинэ төрлүүдийг бий болгож жуулчдын тоо, бүсийн хөгжилд оруулах эдийн засгийн хувь нэмэр нэмэгдэнэ.

1.4.3 Газар өмчлөлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат /2012-2016 он/

Тэргүүлэх зорилт: Бүсийн сумдын газрын ашиглалт хамгаалалт, газрын харилцаа, эрх зүйн мэдээллийн санг бүрдүүлэн хөтлөх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Иргэдийн аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй газрыг давуу эрхээр өмчлөх нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Тариалан болон хот суурин газар кадастрын зураглалыг хийн эрх зүйн баталгаагаар ханган улсын бүртгэлд бүртгүүлж “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн системд оруулах, сүлжээ үүсгэх
- Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээрийн газрыг тусган малчдыг бүлэг болгон зохион байгуулж, бэлчээрийг хуваарилан гэрээгээр ашиглуулах
- Газар өмчлөлийг бүрэн дуусгах
- Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдлыг харуулсан зураг хийж талхлагдсан бэлчээрийг сайжруулах арга замыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Бүсийн газар зохион байгуулалтыг төлөвлөснөөр газар ашиглалт хамгаалалтын түвшин сайжрах ба мэдээллийг “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн системд оруулах боломж бий болно.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Бэлчээрийн талхагдал, тариалангийн талбайн элэгдэл эвдрэлд орсон талбайн ашиглалт хамгаалалт нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бэлчээр газар тариалангийн бүсийг шинэчлэн тогтоож, хамгаалах бодлого барьж ажиллах

Хүрэх үр дүн: Газрын рентийг тодорхойлж, татварын уян хатан бодлого хэрэгжүүлснээр, газрын харилцааны эрх зүйн орчин сайжирч эдийн засагт нөлөө үзүүлж, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг эдийн засгийн харилцаанд оруулна.

1.5 Худалдаа үйлчилгээний салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Бүсийн хэмжээнд хүнсний барааны хангамжийг нэмэгдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

Хөгжлийн 1-р үе шат (2012-2016 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ, түүхий эдийн зах, үйлчилгээний цогцолборуудыг хөгжүүлэх
- Үйлчилгээний салбарт ажиллагсадын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах
- Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх иргэд, аж ахуйн нэгжийн санал, санаачлагыг дэмжих

Хүрэх үр дүн: Эрүүл ахуйн шаадлага хангасан хүнсний баталгаат байдал хангагдаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээ сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат (2017-2021 он)

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг бүрэн хангах
- Аж ахуйн нэгж өрхийн үйлдвэрлэлийг дэмжин хүнсний шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах
- Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг бүлгийн хүмүүсийн хоол тэжээлийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг бий болгох

Хүрэх үр дүн: Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хангамж, цэцгийн тос, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангагдана.

1.6 Дэд бүтцийн бодлогын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг чанартай найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, дулааны эрчим хүч түгээлтийн байдалд шинжилгээ судалгаа хийж дулааны шугам сүлжээг нэмэгдүүлэх

Хөгжлийн 1-р үе шат /2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бүсийн доторх төв замуудыг дэс дараатайгаар хатуу хучилттай болгох
- Явган зорчигчийн зам барих, туслах зам, гудамжуудыг тохижуулах
- Бүсийн хэмжээнд байгаа 0.4, 0.22 кв-ын агаарын дамжуулах шугамуудын модон тулгууруудыг төмөр бетон хөлтэй тулгуураар солих
- Хот төлөвлөлт, одоогийн газар олголттой уялдуулан шинээр дулааны эх үүсвэр барих
- Утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын жижиг, дунд үйлдвэрлэлийг бүсийн сумдын төвүүдэд байгуулах
- Насжилт хэтэрсэн шугам сүлжээг хэсэгчилсэн байдлаар үе шаттайгаар засварлан сольж бүрэн шинэчлэх
- Цэвэр ус, цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх

- Монголын цахилгаан холбооны салбаруудыг шилэн кабельд холбон, Орхонтуул, Сант, Баруунбүрэн сумдыг интернетийн сүлжээнд холбох
- Хүн амыг орон сууцжуулах ажлын хүрээнд инженерийн хийцтэй орон сууцыг шинээр барих
- Шинээр баригдаж байгаа барилга байгууламжуудын орчны тохижилтыг сайжруулах

Хүрэх үр дүн: Замын чанар сайжирч, тээврийн үйлчилгээ өргөжин амьдрах орчны нөхцөл сайжирч, хэрэглэгчид найдвартай цахилгаан эрчим хүчээр бүрэн хангагдаж, дулаан хангамж сайжирч, ард иргэдийн тав тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2–р үе шат /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Нийтийн тээврийн үйлчилгээнд аж ахуй нэгжүүдийг татан оролцуулж, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Дулааны ачаалалтай уялдуулан шугам сүлжээг сүүлийн үеийн технологи, материал ашиглан шинэчлэх
- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ашиглалтын хугацаа хэтэрсэн шугам хоолойг шинэчлэх, өргөтгөх
- Ус хангамжийн шугам сүлжээг нэмэгдүүлж, гэр хорооллыг ундны цэвэр усаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Ариутгах татуургын шугамын уртыг хот төлөвлөлттэй уялдуулан нэмэгдүүлэх
- Мэдээлэл холбооны суурь сүлжээг өргөтгөн, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх
- Мэдээлэл, холбооны салбарын мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх,
- Олон нийтийн зориулалттай үйлчилгээний барилга, байгууламжуудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж байгуулах

Хүрэх үр дүн. Замын чанар сайжирч, тээврийн үйлчилгээ өргөжин, дулаан, усан хангамж сайжирч, эрүүл орчинд амьдрах, нөхцөл бүрдэнэ.

Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГО

Орхоны бүсийн хөгжлийн хөтөлбөрийн нийгмийн бодлогын гол зорилт нь сум орон нутгийн хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт нийгмийн хамгаалалыг сайжруулах, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн чадамжийг нэмэгдүүлж, аймгийн 2021 он хүртлэх хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах явдал юм.

Бүсийн хөгжлийн нийгмийн салбарыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

6. Боловсролын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
7. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн
8. Эрүүл мэндийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
9. Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
10. Соёл урлагийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

2.1. Боловсролын салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2012-2016 он/

Тэргүүлэх зорилт 1: Бүх шатны боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанар, үр өгөөжийг тогтмол дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Улирлын чанартай гэр цэцэрлэгийг тогтмол ажиллуулж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 97 хувьд хүргэх
- Сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэйгээр зохион байгуулан суурь боловсролын хамран сургалтыг 93 хувьд хүргэх
- Боловсролын салбар дахь хувийн хэвшлийг дэмжих
- Сургууль, цэцэрлэгийн “Багш хөгжлийн танхим”-ыг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулж, багш нарыг хөрвөх чадвартай болгон хөгжүүлэх
- Сайхан сумын сургуулийг түшиглэн “Англи хэлний зайны сургалтын төв”-ийг байгуулах
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг бэхжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Ерөнхий боловсролын сургуульд шатар, цэцэрлэгт даамны чиглэлээр сургалтыг явуулах
- Гүнзгийрүүлсэн сургалттай анги, бүлэг нээж суралцагчдын эрэлтэд нийцсэн боловсрол олгох хэлбэрийг өргөтгөх
- “Цахим сургалт”-ын хэлбэрийг туршин зүгшрүүлэх лаборатори сургуулийг бий болгох
- Сургууль, цэцэрлэгүүдийн тавилга, сургалты н тоног төхөөрөмж, техник хэрэгслэлийн хангамжийг нэмэгдүүлж, тэдгээрийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах
- Боловсрол нөхөн эзэмшихэд дэмжлэг үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг боловсролд хамруулж, эмзэг бүлгийн өрхийн сурагчдыг хичээлийн хэрэглэл, сурах бичгээр бүрэн хангах
- Сурч боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс зарим сумдад сургуулийн хичээлийн байрыг шинээр барих, цэцэрлэгийн цэвэр бохир усны асуудлыг шийдвэрлэх, сургууль, цэцэрлэгүүдийг их засварт оруулах, мэдээлэл зүйн кабинетыг стандартын дагуу байгуулах

Хүрэх үр дүн: Багш сурагчдын сурч, ажиллах орчин сайжирч, үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

Хөгжлийн 2-р үе шат. /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Сургуулийн өмнөх боловсролд бага насны хүүхдийг бүрэн хамруулж, сургуулийг олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэх боломжоор хангах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, бага насны хүүхэд сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх
- Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох бодлого баримтлах
- Сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог нэмэгдүүлэх
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Кембрижийн боловсролын стандарт, хөтөлбөрийг нэвтрүүлэх
- Сургуулийн бага, дунд ахлах ангийн сурагчдын авъяас билгийг тодруулан хөгжил төлөвшлийг дэмжиж ажиллах
- Боловсрол нөхөн эзэмшихэд дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн : Боловсролын бүх шатны стандарт, сургалтын хөтөлбөр суралцагчийн хэрэгцээнд нийцэж, олон улсын жишигт нийцүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг нэмэгдсэн байна.

2.2. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2012-2016/

Тэргүүлэх зорилт: Хөдөлмөрийн насны ажил, хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг ажлын байраар ханган орлогыг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Нийгмийн даатгалд хамрагдах иргэдийн хүрээг өргөжүүлж тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд бүсийн хүн амыг жигд хамруулах
- Хоршоо, нөхөрлөл байгуулахыг дэмжиж ядуу бага орлоготой өрхийг туслах аж ахуй эрхлэх орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Ядуу, бага орлоготой иргэдийг амьдрах арга ухаанд сургаж газар тариалан эрхлүүлэх, малжуулах, бие даан өрхийн үйлдвэрлэл эрхлэн ажиллаж, амьдрах бололцоог өөрсдөө бий болгоход сургаж хэвшүүлэх замаар өрхийн амьжиргааг дэмжих
- Нийтийг хамарсан ажлыг байгаль орчин хамгаалах, ялангуяа цөлжилтөөс хамгаалах ойн зурвас байгуулах, газрын хөрс бэлчээрийг хамгаалах, сумын төвд мод зүлэг тарих ажлыг түлхүү зохион байгуулж түр ажлын байраар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх
- Хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн албаар дамжуулан сул чөлөөтэй ажлын байранд зуучлах зөвөлгөө өгөх, мэргэжил олгох сургалтуудад хамруулах

Хүрэх үр дүн: Ажлын байр нэмэгдэж, өрхийн амьжиргаа дээшилж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмж сайжирна

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021/

Тэргүүлэх зорилт: Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлэн хөнгөлөлттэй зээлд хамруулан ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлэн хөнгөлөлттэй зээлд хамруулан ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах орчинг сайжруулахад дэмжлэг үзүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Ахмад настанд үзүүлж буй хөнгөлөлт тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж өрхийн тэтгэмжийн төрлийг шинээр бий болгох

Хүрэх үр дүн: Нийгмийн халамж үйлчилгээний чанар сайжирч ажлын байр нэмэгдэнэ.

2.3. Эрүүл мэндийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р үе шат. /2012-2016 он/

Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулж, хүн амын цэвэр өсөлтийг дэмжиж, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сайхан сумын Сум дундын эмнэлгийг түшиглэн бүсийн хүн амд үйлчлэх оношлогоо, шинжилгээний төв лабораторийг байгуулах
- Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, хангамж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эсэн мэнд амаржихуй, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэ өвчний талаар зөвлөгөө өгөх, шинжилгээ хийх нээлттэй нэг цэгийн үйлчилгээг бий болгох
- Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх
- Алслагдсан малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдийн бага насны хүүхдүүдийг дархлаажуулалтанд бүрэн хамруулах
- Хүн амын өсөлттэй уялдуулж, өрхийн эмнэлгийн тоог нэмэгдүүлэн өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлд өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх, техник тоног төхөөрөмж, унаагаар хангах
- Эрүүл мэндийн салбарт цахим мэдээллийн технологийг хөгжүүлэх, сумын эмнэлгүүд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газартай интернет сүлжээнд холбогдох
- Орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх
- Сумдын түргэн тусламжийн автомашиныг дэс дараатай шинэчлэх
- Нарийн мэргэжлийн чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад суралцах эмч нарын сургалтын зардалд төрөөс дэмжлэг үзүүлэх
- Эмч, эмнэлгийн ажилтны нийгмийн батлагааг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- Нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны төрлүүдийг хөгжүүлэх
- Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх
- Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх
- Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх, чадавхийг бэхжүүлэх
- Хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчин бий болгох замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нөхөн сэргээх, эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөж, материаллаг орчныг сайжруулан, хөдөлгөөний болон эмийн бус эмчилгээг өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, эрүүл мэндийг хамгаалах чадамж цогц байдлаар хөгжих боломж бүрдсэн байна. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалт ахиж, эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйл төлөвшинө.

Хөгжлийн 2-р үе шат (2017-2021 он):

Тэргүүлэх зорилт: Сайхан сумын Сум дундын эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өргөжүүлж, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангаж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Эрүүл мэндийн хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлэн тусламж, үйлчилгээний нөөцийг шатлал бүрээр зохистой хуваарилан анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг тогтвортой нэмэгдүүлэх
- Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах

- Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, биологийн идэвхитэй бодисын чанарын баталгаа, аюулгүй байдлыг хангах
 - Өвчний түүхийг цахим картын мэдээллийн санд оруулах
 - Хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагыг дэмжин хөгжүүлж, оновчтой тогтолцоог бүрдүүлэх
 - Ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газрын үйл ажиллагааг чанаржуулж, хөгжүүлэх
 - Хөдөөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд мэдээлэл технологийн ололт дэвшлийг нэвтрүүлэх ажлыг дэс дараалалтай хэрэгжүүлэх
- Хүрэх үр дүн:** Эрүүл мэндийн салбарт удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоо бүрдсэн байна. Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр ханган эрүүл мэндийн шаардлагатай, зохистой технологийг нэвтрүүлж, салбарын дэд бүтэц сайжирсан байна.

2.4. Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Хүн амыг спортод сонирхолтой болгож эрүүл зан үйлд сургаж, биеийн тамирын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан дундаж наслалтыг уртасгах

Хөгжлийн 1-р үе шат /2012-2016 он/

Хэрэгжүүлэх стратеги:

- Спорт ордны зал, танхим, материаллаг баазад тулгуурлан спортын төрөл бүрийн секц, дугуйлан хичээллүүлж улс, олон улсын тэмцээнд оролцох, туршлага солилцох
- Биеийн тамир, спортын салбар клуб, холбоо хамтлагийн тогтолцоо бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, төсөв санхүүгийн оновчтой бодлого хэрэгжүүлж эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх
- Хүн бүрт биеийн тамирын үндсэн дасгал, хөдөлгөөний ач холбогдлыг сурталчилан ойлгуулах хөдөлгөөн өрнүүлж тэдэнд үзүүлэх дэмжлэг үйлчилгээг өргөжүүлэх
- Сум орон нутгийн Засаг захиргааны байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллага, хамт олон бүр ажилчдынхаа чөлөөт цагийг эрүүл мэндийнхээ төлөө зориулах, биеийн тамир спортын таатай орчин бүрдүүлэх
- Багш дасгалжуулагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, гадаадын орны багш солилцоогоор дамжуулан туршлага солилцох
- Сумдад спортын тоглоомын талбайг шинээр байгуулах
- Зарим сумдад спорт заалны барилга барих, материаллаг баазад тулгуурлан спортын төрөл бүрийн секц, дугуйлан хичээллүүлж улс олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн: Нийтийн биеийн тамир, спортын хүртээмж, өргөжин хүн амын эрүүл мэнд сайжирч тамирчдын чадвар дээшилж улс тив, дэлхийн тэмцээн уралдаанд амжилттай оролцож, нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Тэргүүлэх зорилт: Биеийн тамир, спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж, хүртээмж чанарыг дээшлүүлэн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвар өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Бизнесийн байгууллагуудтай өргөн түншлэл тогтоож тамирчдад хөрөнгө оруулалт хийлгэх гэрээ хэлэлцээр байгуулах

- Олон улсын спортын байгууллага, спортын холбоодуудаар дамжуулан тэдэнтэй хамтарсан бэлтгэл хийх орчин нөхцлийг бүрдүүлэн, тамирчдынхаа ур чадварыг нэмэгдүүлж, насанд хүрэгчид, тив, дэлхийн томоохон тэмцээнээс медаль авах, орон нутаг, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөхөд тал бүрийн дэмжлэг үзүүлэх
 - Бялдаржуулах, чийрэгжүүлэх, клуб, төвүүдийг нээж ажиллуулж үйлчилгээг өргөжүүлэх, ахмад настан, ард иргэдэд хийн дасгалыг сумын хэмжээнд нийтийн хүртээл болгон хөгжүүлэх
 - Тамирчид, дасгалжуулагчид, дэмжигчид, ивээн тэтгэгчид, хандивлагчидтай хамтран ажиллаж, биеийн тамир, спортын мэргэжлийн болон сонирхогчдын эвлэл, холбоо, клуб, нөхөрлөл, хамтлаг, баг байгуулж хувь хүн, хамт олон нийгэмд нөлөөтэй биеийн тамир, спортын үйл ажиллагаа явуулахыг дэмжих
- Хүрэх үр дүн:** Биеийн тамирын ажил, үйлчилгээ нь бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн хөдөлгөөн, хувь хүн, албан байгууллагын санаачлага болон өрнөнө.

2.5. Соёл урлагийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн Хөгжлийн 1-р үе шат. /2012-2016/

Тэргүүлэх зорилт: Соёл урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангаж, менежментийг сайжруулах, ажиллагсдыг мэргэшүүлэх, тасралтгүй сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрөөс баримтлах соёлын бодлого, хүний хөгжлийн цогц бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг үндэс болгон орон нутгийн онцлогт тохирсон, биеэ даасан, чөлөөтэй хөгжих соёлын орчинг бий болгох.
- Хөдөө орон нутагт ажиллах соёл урлагийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- Сумдын соёл, урлагийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангахын тулд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Олон улсын чанартай уралдаан тэмцээнд үе шаттайгаар бэлтгэж оролцуулах нөхцлийг бүрдүүлэх
- Сайхан сумын соёлын ордны бүтцийг өөрчлөн “Хөгжимт драмын театр” болгон өргөжүүлэх
- “Бүсийн төв- цахим номын сан”-гийн үйлчилгээг бий болгох
- Сумдын соёлын төв, номын сан, музей, орон нутгийг судлах кабинетын барилгыг шинээр барих, өргөтгөх засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжлийг хангаж, чадварлаг хүний нөөцөөр хангагдаж, соёлын үйлчилгээний хүртээмж сайжирна.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021/

Тэргүүлэх зорилт 1: Соёл урлагийн байгууллагын ажиллагсдыг ажлын байрандаа мэргэшил мэдлэгээ дээшлүүлж, морин хуур хөтөлбөрийг төгс хэрэгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Орон нутаг сурталчлах танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж баяжилтыг сайжруулан, орчин үеийн техник хэрэгсэл хөгжмийн зэмсэгээр хангаж материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, төрөл бүрийн дугуйлан секцийг ажиллуулж уран бүтээлийн болон уран сайхны хамтлаг байгуулах нөхцлийг бүрдүүлэх
- Мэргэжлийн урлагийн байгууллага, сумдын соёлын төв, ардын авъяастнуудын уялдаа холбоог сайжруулах, хөдөөгийн малчдад соёлын үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын оновчтой тогтолцоог бий болгох

Хүрэх үр дүн: Соёл урлагийн байгууллагууд стандартын хэмжээнд хүрч ажиллах ба бие даасан үйл ажиллагаа сайжирч, ард иргэдэд урлаг, соёлын чанартай үйлчилгээ үзүүлдэг болно.

Гурав. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Орон нутагт үр нөлөө бүхий шуурхай, ил тод үйл ажиллагааг төрийн ажил үйлчилгээнд төлөвшүүлж, түншлэлийн харилцааг хөгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Орхоны бүсийн засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

3. Засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн
4. Гадаад харилцааны бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

3.3 Засаглалын бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Хөгжлийн 1-р шат /2012-2016 он/

Тэргүүлэх зорилт 1: Төрийн үйлчилгээг ард иргэдэд ойртуулах, хялбаршуулах, бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Багийн ажиллах нөхцлийг сайжруулах бодлого барьж төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй шуурхай хүргэх
- Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх
- Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд цахим арга хэлбэрийн ашиглалтыг өргөжүүлэх
- Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалт семинарт хамруулах, бусад улс оронд туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах

Хүрэх үр дүн: Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар дээшилж төрийн үйлчилгээний үр нөлөө сайжирна.

Тэргүүлэх зорилт 2: Иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлийг бууруулан, иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах
- Өмчийн эсрэг гэмт үйлдэл, түүний дотор орон байрны хулгай, малын хулгайн эсрэг нутгийн захиргаа, хууль хяналт, иргэдийн хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл лавлагааг шаардлагатай цаг үед шуурхай авдаг цахим үйлчилгээг бий болгох
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд болон хүн худалдаалах зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах
- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг багасгахад иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах

Хүрэх үр дүн: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж гэмт хэрэг, зөрчил буурна.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг иргэдийн санал, газар зүйн байршил, хүн амын тоо, эдийн засгийн чадавхийг харгалзан боловсронгуй болгох

- Нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах зарчмыг баримтлах

Хүрэх үр дүн: Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

3.4 Гадаад харилцааны бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт: Гадаад харилцааны бодлогын хүрээнд уламжлалт болон шинэ түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар сумын эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж орон нутгаа хөгжүүлнэ.

Хөгжлийн 1-р үе шат /2012-2016 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сумдын түүх, соёлын өнөөгийн байдал, нийгэм, эдийн засгийн давуу тал, онцлог, нөөц боломжийн талаар гадаад орнуудад сурталчилах
- Оюуны гадаад хөрөнгө оруулалтыг дэмжиж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг өргөн ашиглах үүднээс төрийн албан хаагч, бизнес эрхлэгчийг гадаад орнуудад сургах, мэргэшүүлэх
- Хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж тодорхой улс орнуудтай шинээр харилцаа тогтоох, богино болон урт хугацаагаар гэрээ байгуулах, харилцах хөтөлбөр боловсруулан ажиллах арга хэмжээг шат дараатай авах
- Нийгмийн хамгааллын чиглэлээр гадаад орнуудын төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжиж, бүсэд орох хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хөгжлийн 2-р үе шат /2017-2021 он/

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангах
- Бусад улс орны муж, хотуудтай хөгжлийн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулж, гадаад харилцааг бэхжүүлэх

Хүрэх үр дүн: Гадаад улс орнуудын хатын ажиллагаа өргөжин, эдийн засгийн харилцаа сайжирна

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН БҮСИЙН 2021 ОН ХҮРТЭЛХ
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

№	Үзүүлэлт		2008 он	2009 он	2010 он	1-р үе шат 2016 он	2-р үе шат 2021 он
1	Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт	1.ДНБ/сая төг/	50003,4	45418,4	60931,6	68600	76400
		2.Нэг хүнд ноогдох ДНБ /мян,төг/	2532,4	2189,5	2802,0	3118,2	3321,7
		3.Нийт хөрөнгө оруулалт /сая,төг/	-	505,1	873,8	1200,0	1500,0
		4.Аж үйлдвэрийн НБ /сая,төг/	35002,4	31792,9	42652,1	48020	53480
		5.Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн НБ /мян,төг/	1772,7	1532,6	1978,9	2182,7	2325,2
		6.ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /сая, төг/	10000,7	9083,7	12186,3	13720	15280
		7.Нэг хүнд ноогдох хүнс ХАА-н бүтээгдэхүүн /мян,төг/	506,5	437,9	565,4	880,0	1120,0
		8.Жижиг дунд үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн /сая,төг/	361,8	350,2	372,1	500,0	800,0
		9.Өрхийн аж ахуйн нийт бүтээгдэхүүн /сая, төг/	343,7	332,7	353,5	450,0	750,0
		10.Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний нийт бүтээгдэхүүн /сая, төг/	2000,1	1816,7	2437,3	2744,0	3056,0
		11.Малын тоо /мян, тол/	605016	637391	581179	560000	540000
		12.Өндөр ашиг шимт цэвэр эрлийз шилмэл омгийн малын эзлэх хувь	6,1	7,2	8,0	20	40
		13.Хураан авсан ургац /тн/	Үр тариа	43445	63612	75671	85000
Төмс	14618		14725	14184	16000	18000	

			Хүнсний ногоо	6597	6522	7111	8200	9500
			Малын тэжээл	44900	47100	71500	75000	80000
2.	Нийгмийн хөгжил	14.Нийт хүн ам		19745	20744	21553	22000	23000
		15.Үүнээс: Хөдөлмөрийн насны хүн ам		12780	13693	13932	15600	16900
		16.Дундаж наслалт		68,18	68,87	68,93	70,0	71,5
		19.Эхийн эндэгдэл /тоо/		1	1	1	-	-
		20.Нялхасын эндэгдэл /1000 хүүхдэд ноогдох/		1,3	1,2	0,8	0,5	-
		21.Ажилгүйдлийн түвшин		4,0	3,45	2,42	1,8	1,0
		22. Халдварт өвчний прогноз	А гепатит	52	40	30	-	-
			Сүрьеэ	37	38	37	-	-
БЗДХ	98		57	41	-	-		
Нийт халдварт өвчин	214		143	111	-	-		
3.	Байгаль орчин, дэд бүтэц	23.Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь		-	-	-	-	-
		Улсын тусгай хэрэгцээний газар/Улсын хадлан, тэжээлийн сангийн талбай /га/		15000	15000	15000	-	-
		24.Ойжуулсан талбайн хэмжээ /га/		-	80	60	120	200
		25.Шинээр ашиглалтанд орсон хатуу хучилттай, болон сайжруулсан замын урт /км/		-	-	-	160	125
		26.Уул уурхайн олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлт /га/		-	3,5	3,5	-	-

	27.Ашиглалтанд орсон барилгын нийт талбай /мян, м ² /	-	200	320	400	600
	28.Сэргээгдэх эрчим хүчээр хангагдах малчин өрхийн нийт өрхөд эзлэх хувь	14,2	16,5	18,1	22,0	28,0
	29.Бэлчээрийн усжуулалт /хувь, өсөн нэмэгдсэн дүнгээр/	4,0	3,4	5,1	8,0	12,0
	30.Усалгаатай тариалангийн талбай /га, өсөн нэмэгдсэн дүнгээр/	1500	1635	1760	2100	2600

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 75

Сүхбаатар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны ажлын тайлангийн тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2011 онд ажлаа Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100, Ардын хувьсгалын 90, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн түүхэн тэмдэглэлт ойнуудыг угтаж хийх ажлыг бодлого шийдвэрээрээ дэмжиж сум байгууллага, олон нийт, ард иргэдийг уриалан тэдний идэвх, санаачилгыг энэ ажилд хандуулах, аймгийн эдийн засаг, аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлогын хороодын ажлыг тогтмолжуулах, гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хангахад түлхүү анхаарах зорилт дэвшүүлж хэрэгжүүлэх ажлыг Тэргүүлэгч, Төлөөлөгчдийн идэвхтэй оролцоотойгоор аймгийн Засаг дарга, түүний Тамгын газартайгаа хамтран зохион байгуулж үр дүнтэй ажилласан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2011 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг 3 удаа, Тэргүүлэгчдийн хуралдааныг 17 удаа бэлтгэлийг ханган хуралдуулж, хурлын хуралдаанаар аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцын тайлан, Аймгийн бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, Хог хаягдал үүсгэсний төлбөр, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, зарим тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай асуудлуудыг, Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Ахуйн үйлчилгээ”, “Сэлэнгэ чацаргана”, “Ойг хамгаалах, нөхөн сэргээх” хөтөлбөр зэрэг аймгийн эдийн засаг, нийгмийн амьдралын бүх салбар чиглэлийг хамарсан 130 гаруй асуудал хэлэлцэн тогтоол шийдвэр гаргасан байна.

Хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж ажлын хэсэг томилон Болд төмөр Ерөө гол компаний үйл ажиллагаа, Сэлэнгэ аймагт ажиллаж байгаа сүм хийдүүдэд холбогдох хууль тогоомжийн хэрэгжилтийг шалгаж, Хурлын Тэргүүлэгчид Ерөө, Хүдэр, Орхон, Хушаат сум, Бугант тосгонд ажиллаж гаргасан шийдвэрийнхээ биелэлт, хэрэгжилт сум орны ажил байдалтай танилцаж иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонсож дүнг хуралдаанаараа хэлэлцсэн байна.

Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Бодлогын хороодын ажлыг тогтмолжуулах, Хурлын ажилд иргэдийн оролцоог хангах чиглэлээр тодорхой үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 онд хийсэн ажлыг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд ДААЛГАХ нь:

1.2012 оныг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Төлөөлөгчид сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хийхээр төлөвлөсөн, амласан ажлаа дүгнэж тайлагнах, мэдээлэх жил болгох;

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008-2012 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж биелэлтийг бүрэн хангах;

3.Монгол Улсын Их Хурлын болон Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн бэлтгэлийг хангаж явуулах талаар хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож туслалцаа дэмжлэг үзүүлэх;

4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны ажлын тайлантай холбогдуулан Хурлын Төлөөлөгчдөөс гаргасан санал зөвлөмж шүүмжлэлийг цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол
Сүлд

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 01 сарын 13-ны өдөр

Дугаар 06

Сүхбаатар

2011 оныг Бүтээн байгуулалт, ажлын байр
нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай

Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2011 оныг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгохоор дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтаж хийх бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2011 оныг Бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдүүлэх жил болгон зарласугай.

2.Бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдүүлэх жилд хийх ажлын чиглэл төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 01 сарын 31-ний өдөр

Дугаар 07

Сүхбаатар

Аймгийн хурдан морины бүсийн уралдаан
зохион байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн хурдан морины бүсийн уралдааныг жилд 1 удаа их 3 нас, бага 3 нас гэсэн ангиллаар зохион байгуулж байхаар тогтоосугай.

2.Бүсийн уралдааныг дээрхи ангиллаар бүсийн сумдтай хамтран ээлж дараатайгаар зохион байгуулж явуулахыг “Буган халиун-Ажнай” МСУХ-нд даалгасугай.

3.Бүсийн уралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулахыг тухайн жилийн уралдааныг явуулах сумдын дарга нар болон “Буган халиун-Ажнай” МСУХ-нд, дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг бүсийн сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Аймгийн бүсийн уралдааныг зохион байгуулахад хөрөнгийн болон зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 01 сарын 31-ний өдөр

Дугаар 08

Сүхбаатар

Хурдан моринд аймгийн цол олгох журам
батлах тухай

Сэлэнгэ аймгийн “Буган халиун ажнай” морин спорт уяачдын холбооноос оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1.Хурдан моринд аймгийн цол олгох журмыг хавсралтаар баталсугай.
- 2.Хурдан моринд аймгийн цол олгох журмыг мөрдөж ажиллахыг “Буган халиун ажнай” морин спорт уяачдын холбооны тэргүүн /Г.Бямбаа/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУРДАН МОРИНД ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

Энэхүү журмыг Сэлэнгэ аймгийн хэмжээнд хурдан моринд цол олгоход дагаж мөрдөнө.

Хоёр.Цолны ангилал

- 1."Сэлэнгэ дархан түмний эх" цол
- 2."Сэлэнгэ түмний эх" цол
- 3."Сэлэнгэ идэр түмний эх" цол

Гурав.Цол олгох журам

1.Хурдан моринд цол олгох талаар сумын уяачдын холбооноос ирүүлсэн тодорхойлолтыг аймгийн "Буган халиун ажнай" морин спорт уяачдын холбооны тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд саналаа 7 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргад өргөн барина.

2.Аймгийн Засаг дарга "Буган халиун ажнай" морин спорт уяачдын холбооны саналыг хянан үзээд "Сэлэнгэ дархан түмний эх", "Сэлэнгэ түмний эх", "Сэлэнгэ идэр түмний эх" цол олгох шийдвэр гаргана.

3.Сэлэнгэ аймгийн баяр наадам, аймгийн бүсийн уралдаанд 3 түрүүлсэн азарга, их насны моринд "Сэлэнгэ түмний эх" цол, 5 түрүүлсэн азарга, их насны моринд "Сэлэнгэ дархан түмний эх" цол тус тус олгож шар торгон жолоо, батламжаар шагнана.

4.Сэлэнгэ аймгийн баяр наадам, аймгийн бүсийн уралдаанд бага дөрвөн насандаа тасралтгүй түрүүлсэн моринд "Сэлэнгэ идэр түмний эх" цол олгож, мөнгөн торгон жолоо, батламжаар шагнана.

5.Бага 4 насандаа 3-аас доошгүй удаа түрүүлсэн морь их насандаа 2 удаа түрүүлсэн бол "Сэлэнгэ түмний эх" цол олгож болно.

6.Дээрх цолыг зөвхөн аймгийн баяр наадам, аймгийн хэмжээний бүсийн хурдан морьдын уралдааны амжилтыг үндэслэн олгоно.

7.Цолны батламжийг аймгийн Засаг дарга, шар, мөнгөн торгон жолоог аймгийн морин спорт уяачдын холбоо олгоно.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 01 сарын 31-ний өдөр

Дугаар 09

Сүхбаатар

Аймгийн хурдан морины эрсдлийн үнэлгээ
тогтоох тухай

Сэлэнгэ аймгийн “Буган халиун ажнай” морин спорт уяачдын холбооноос оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1.Аймгийн хурдан морины эрсдлийн үнэлгээг хавсралтаар баталсугай.
- 2.Энэхүү эрсдлийн үнэлгээ нь уг адууны амжилт гаргаснаас хойшхи 5 жилдээ хүчинтэй үйлчилнэ.
- 3.Хурдан морийг хулгайлсан, санаатайгаар уг адуунд гэмтэл согог учруулж дахин уралдуулах боломжгүй болгосон болон нядалж устгасан нь хуулийн байгууллагаар тогтоогдсон тохиолдолд үнэлгээнд хамрагдана.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ХУРДАН МОРЬДЫН ҮНЭЛГЭЭ

МЯН.ТӨГ

№	Морьны нас	Улс бүсийн наадамд түрүүлсэн	Улс бүсийн наадамд айрагдсан	Аймаг, бүсийн баяр наадамд 3-аас дээш түрүүлсэн	Аймаг, бүсийн баяр наадамд 3-аас дээш айрагдсан	Аймаг, бүсийн баяр наадамд 1-2 удаа түрүүлсэн	Аймаг, бүсийн баяр наадамд 1-2 удаа айрагдсан	Сумдын баяр наадамд түрүүлсэн	Сумын баяр наадамд айрагдсан
1	Азарга	20000,0- 25000,0	18000,0- 20000,0	20000,0- 25000,0	18,0000- 20000,0	12000,0- 15000,0	10000,0- 12000,0	5000,0- 7000,0	3500,0- 4500,0
2	Их нас	20000,0- 25000,0	18000,0- 20000,0	20000,0- 25000,0	18,0000- 20000,0	12000,0- 15000,0	10000,0- 12000,0	5000,0- 7000,0	3500,0- 4500,0
3	Соёолон	15000,0- 20000,0	13000,0- 18000,0	15000,0- 20000,0	13000,0- 16000,0	11000,0- 13000,0	9000,0- 11000,0	4000,0- 5000,0	2500,0- 3500,0
4	Хязаалан	12000,0- 13000,0	10000,0- 12000,0	12000,0- 15000,0	10000,0- 13000,0	8000,0- 10000,0	7000,0- 9000,0	3500,0	2000,0- 2500,0
5	Шүдлэн	10000,0- 12000,0	8000,0- 10000,0	10000,0- 12000,0	8000,0- 10000,0	7000,0- 9000,0	4000,0- 7000,0	3000,0	1500,0- 2000,0
6	Даага	8000,0- 10000,0	6000,0- 8000,0	8000,0- 10000,0	5000,0- 8000,0	5000,0- 7000,0	3000,0- 4000,0	2500,0	1000,0- 1500,0

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 01 сарын 31-ний өдөр

Дугаар 10

Сүхбаатар

2011 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт,
байршил, хэмжээг батлах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасныг үндэслэн аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг сум тус бүрээр хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.2011 онд аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг сум тус бүрээр 1 дүгээр хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

2011 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт

№	Сумын нэр	Тогтоолын дугаар, он, сар, өдөр	Өмчлүүлэх газрын байршил	Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-гаар/	Өмчлүүлэх газрын зориулалт /га-гаар/							
					Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар	Үүнээс		
						Одоо эзэмшиж, ашиглаж байгаа газрын нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Улсын чанартай авто замын дагуух газрыг өмчлүүлэх газрын нийт хэмжээ		Үр тарианы	Төмс, хүнсний ногоо	Газар тариалангийхаас бусад
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	Алтанбулаг		Сумын төвд Найрамдалын гудамж	7.21	4.1	4.1			3.11			3.11
			Солдат толгойн өвөр хэсэг	173	173		173		0			
			Баруун хиагт, Солдат толгой, Хонд	16	0				16		16	
			Хөх өндөр, Хутаг өндөр, Хадат-д	248	0				248	248		
			Сумын дүн	444.21	177.1	4.1	173	0	267.11	248	16	3.11
2	Баруунбүрэн	2010.12.27-ны 16 тоот	Фермийн хороолол	9.33	9.33	0.33	9					
			Шар хад хороолол	5.7	5.7	2.5	3.2					
			Далан дагуу	11.6	11.6		11.6					
			Өндөр хороолол	1	1	1						
			Сумын дүн	27.63	27.63	3.83	23.8					

3	Баянгол	2010.12.24-ны 06 тоот	Сумын төвд	16.04	14.72	0.4	14.32		1.32			1.32	
			212-р зөрлөг	3.5	3.5		3.5						
			179-р зөрлөг	8	8	3	5						
			Эрхэт	7	7	2	5						
			221-р зөрлөг	2.98	2.98		2.98						
			212-р зөрлөг, 221-р зөрлөг	3.5	3.5	3.5							
			Төмөр замын 196-р км-ын замын зүүн хойд талд	1.82	1.82			1.82	0				
			Гүүрний урагшаа 88 дугаартай тариалангийн талбайн харалдаа хар замын урд	0.42	0.42			0.42	0				
			Баянголын гүүрний орчимд хар замын зүүн талд	4.2	4.2			4.2	0				
			Баянголын гүүрний орчимд хар замын баруун талд	2.8	2.8			2.8	0				
			Сэтэрхий хөтөлийн урд	1.75	1.75			1.75					
Сумын дүн	52.01	50.69	8.9	30.8	10.99	1.32	0	0	0	1.32			
4	Ерөө	2010.12.27-06 тоот	Тавин 1-р баг Гангын тохой	39	39	8	31		0			0	
			Буурагчин 2-р баг Ногоон дов, Дарь эх, Энх талд	43.55	43.55	32	11.55		0			0	
			Бугант тосгонд	88.6	88.6	29.8	58.8		0			0	
			Сумын дүн	171.15	171.15	69.8	101.35		0	0	0	0	
5	Жавхлант	2010.12.27-ны 04 тоот	Жавхлант уулын баруун энгэрээс сайжруулсан шороон зам хүртэл	1.75	1.75			1.75	0				
			Сумын төвд	4.75	4.7	2	2.7		0.05			0.05	
			Шарын гол, Ерөөгийн гол, Хүйтэний голд	113	0				113			113	
			Буйлааст, Ханан, Хөх чулуут, Мангиртын хөндий	251	0				251	251			

			3-р баг Номгон тосгон	26.3	26.3	3.6	22.7		0			
			3-р баг Ширээ нуруунд	6.3	6.3	6.3			0			
			3-р баг Ногоон модны гүүрний хороололд	0.6	0.6	0.6			0			
			Сумын дүн	62.6	62.6	11.9	50.7	0	0	0	0	0
11	Сант		Сумын төвд	20.2	20.2	8.2	12					
			Сумын дүн	20.2	20.2	8.2	12	0	0	0	0	0
12	Сүхбаатар		1-р баг Хонгор морьт	13	13	8	5		0			
			2-р баг Могойтийн ам	1	1	1			0			
			3-р баг Салхитын ам	4	4	4			0			
			4-р баг	12	12	12			0			
			5-р баг Бор гүвээ, Бойны тохой	4	4	4			0			
			Сумын дүн	34	34	29	5	0	0	0	0	0
13	Түшиг	2010.12.27-ны 34 тоот	1-р багийн 1.2.3.4-р хэсэг 2-р баг 1.2.3.4.-р хэсэг	4.1	4.1	4.1			0			
			2-р багийн айлуудын ард талд	4	4		4		0			
			1-р багийн айлуудын зүүн талд	12	12		12		0			
			Сумын дүн	20.1	20.1	4.1	16	0	0	0	0	0
14	Хушаат	2010.12.29-ны 9 тоот	Сумын төв	0.48	0				0.48			0.48
			1-р баг	53	53		53		0			
			2-р баг Орхоны 2-12	0.18	0.18	0.18			0			
			Сумын дүн	53.66	53.18	0.18	53	0	0.48	0	0	0.48
15	Хүдэр	2010.12.28-ны 31 тоот	Сумын төвд	16.5	16	13.5	2.5		0.5			0.5
			Сумын дүн	16.5	16	13.5	2.5	0	0.5	0	0	0.5
16	Цагааннуур	2010.12.24-ны 21 тоот	Сумын төв	1	0				1			1
			Хуурч 2-р баг Голын баруун талд шинээр 2-р багт нуурын ард үр тарианы	710.1	110.1	60.1	50		600	600		
			Тийрэг, 3-р баг Хонхороос зүүн тийш шинээр, Тийрэг, Оргих, Баянхангай, Гангат	208.6	198.6	23.6	175		10		10	
			Сумын дүн	919.7	308.7	83.7	225	0	611	600	10	1
17	Шаамар		Наадмын талбай	11.5	11.5		11.5		0			

		Сумын төв	20.5	20.5	10.5	10		0			
		1-р багт	50	0				50	50		
		2-р багт	157	0				157	150	7	
		Сүхбаатар сум хорооллын урд хогийн хонхороос урагш талбай	50	50		50		0			
		4-н зам	12	10			10	2			2
		Дэнж	5	5		5		0			
		Ногооны талбай	5	5		5		0			
		Хонхор	5	5		5		0			
		Дулаанхаан Дэнж	5	5		5		0			
		Сумын дүн	321	112	10.5	91.5	10	209	200	7	2
		Аймгийн дүн	2851.65	1398.19	510.45	862.2	25.54	1453.46	1299.0	146.0	8.46

оОо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 02 сарын 22-ны өдөр

Дугаар 16

Сүхбаатар

Аймгийн “Хүндэт тэмдэг” бий болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулан хөдөлмөрийн гарамгай амжилт гаргасан, онцгой гавьяа байгуулсан хүмүүсийг шагнах аймгийн “Хүндэт тэмдэг”-ийг бий болгосугай.

2.Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнах журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3.Хүндэт тэмдгийн загвар, тодорхойлолтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар энэ оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ЭЭР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг” /цаашид хүндэт тэмдэг гэнэ/-ээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан хөдөлмөр, бүтээлийн /гарамгай/ амжилт гаргасан хүнийг шагнана.

1.2. “Хүндэт тэмдэг”-ээр аймгийн хөгжилд хувь нэмэр оруулсан гадаадын иргэн, гадаад, дотоодын өндөр хэмжээний зочин төлөөлөгчийг шагнаж болно.

Хоёр. “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулахаар нэр дэвшүүлэх, шагнах

2.1 Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан, хөдөлмөр бүтээлийн гарамгай амжилт гаргасан, онцгой гавьяа байгуулсан хүнийг шагнуулах саналыг байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олны хурлаар хэлэлцэн гаргана. .

2.2 “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулахаар аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг дарга санал гаргаж болно.

3. “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулахаар байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олны хурлаар хэлэлцэж нэр дэвшүүлсэн хүний тодорхойлолт материалыг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал бүрдүүлэн сумын Засаг даргад хүргүүлнэ. Үүнд:

а/ Байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олны хурлын тэмдэглэл

б/ Шагнуулах хүний товч анкет

в/ Ажил байдлын тодорхойлолт

4. Сумын Засаг дарга шагнуулах хүмүүсийн материалыг хүлээн авч хянаж үзээд тодорхойлолт, анкет, байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олны хурлын тэмдэглэлийг өргөн мэдүүлсэн албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

5.Аймгийн Засаг даргын Тамгын газар материалыг хүлээн авч баримт бичгийн бүрдэл, шагнуулах үндэслэлийг хянаж үзээд аймгийн Засаг даргад танилцуулна.

6. Аймгийн Засаг дарга аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулна.

7. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид аймгийн Засаг даргын оруулсан саналыг хэлэлцээд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай тогтоол гаргана.

8. Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан хүнд тэмдэг, үнэмлэх, мөнгөн шагнал олгоно. Энэ журмын 1.2-д заасан хүмүүст тэмдэг, үнэмлэх олгоно.

9. “Хүндэт тэмдэг” –ийн үнэмлэх дээр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нар гарын үсэг зурна.

10. “Хүндэт тэмдэг”-ийг дагалдах мөнгөн шагналын хэмжээ 30.0 мянган төгрөг байна.

оОо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 02 сарын 22-ны өдөр

Дугаар 17

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх болон гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дулаанхаан тосгон байгуулагдсаны 50 жилийн ойг 2011 оны 7 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойгоо угтаж тосгоныхоо байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэн тосгоны гудамж талбай, байгууллага орчноо тохижуулах талаар тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг тосгоны захирагч /Ж.Ганболд/-д даалгаж, тосгоны нийт иргэдэд уриалсугай.

3. Ой угтсан болон ой тэмдэглэх арга хэмжээнд удирдлага зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 02 сарын 22-ны өдөр

Дугаар 18

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх болон гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг үндэслэн Дулаанхаан тосгоны иргэдийн Нийтийн Хурал, Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас тавьсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Гончигийн Бумцэндийн мэндэлсний 130 жилийн ойг түүний төрсөн нутаг Шаамар сумын Дулаанхаан тосгонд 2011 оны 8 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ой угтаж Г.Бумцэнд агсны амьдрал, түүх, алдар гавьяаг сурталчлан алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэхэд чиглэсэн ажил арга хэмжээ зохион байгуулахыг Дулаанхаан тосгоны захирагч, Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга нарт даалгасугай.

3.Ой угтсан болон ойг тэмдэглэх ажил арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д зөвлөсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 03 сарын 15-ны өдөр

Дугаар 21

Сүхбаатар

**Зарим эхчүүдийг Алдарт эхийн
одонгоор шагнуулах тухай**

“Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 148 дугаар зарлигаар баталсан БНМАУ-ын цол, одон медалийн тухай дүрмийн 17, 29 дэх ззалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж 6-аас доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн, 6 ба түүнээс дээш хүүхэд нь эсэн мэнд байгаа 1 дүгээр хавсралтад дурдсан 1370 эхийг Алдарт эхийн I одонгоор, 4-5 хүүхэд төрүүлж 4-өөс доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн бөгөөд 4-өөс доошгүй хүүхэд нь эсэн мэнд байгаа 2 дугаар хавсралтад дурьдсан 2572 эхийг Алдарт эхийн II одонгоор тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 03 сарын 15-ны өдөр

Дугаар 24

Сүхбаатар

2011 онд агнах, барих ан амьтны
тоо хэмжээг тогтоох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Ан агнуурын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны А-06 тоот тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1.Аймгийн нутаг дэвсгэрээс 2011 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолоор баталсан дээд хязгаарт багтаан зөвшөөрөл олгож, зохион байгуулан ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нар болон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Батзоригт тус тус даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга / Д.Энхсайхан /-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 03 дугаар сарын
15-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт

АХУЙН ЗОРИУЛАЛТААР 2011 ОНД АГНАХ, БАРИХ АГНУУРЫН
АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Сумын нэр	Агнуурын амьтны зүйл / толгой /						
		Бор гөрөөс	Зэрлэг гахай	Загас	Хар хур	Нургийн сойр	Дагуурын ятуу	Шивэр хөтүү
1	Алтанбулаг	4	3	100			5	
2	Баруунбүрэн	5	4	100			5	
3	Баянгол	4	2	100				
4	Ерөө	6	5	300			5	
5	Жавхлант	2	-	100				
6	Зүүнбүрэн	2	2	300				
7	Мандал	6	4	200			5	5
8	Орхон	2	-	300				
9	Орхонтуул	2	-	200				
10	Сайхан	-	-	200				
11	Сант	3	2	200				
12	Түшиг	6	5	300	5	5		5
13	Хушаат	5	5	200	5			
14	Хүдэр	6	5	200	5	5	5	5
15	Цагааннуур	5	3	200	5		5	5
16	Шаамар	2	-	200				
17	Сүхбаатар	-	-	300				
	Дүн:	60	40	3500	20	10	30	20

..... оОо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 19-ний өдөр

Дугаар 27

Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “а” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сэлэнгэ аймагт 2011-2016 онд хэрэгжүүлэх “Ахуйн үйлчилгээ” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажил арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган аймаг сумын жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 150 иргэн, аж ахуйн нэгж ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа тогтвортой явуулж, энд 240 хүн ажлын байраар хангагдаж байна.

Аймгийн хэмжээнд албан бус хэвшил дэх ахуйн үйлчилгээний хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсон хүчний тоо, жилийн борлуулалтын нийт хэмжээ бүрэн гүйцэт гарахгүй байна.

Ахуй үйлчилгээний салбаруудыг сумдаар авч үзвэл:

Үс засах үйлчилгээ – Мандал, Сайхан, Сүхбаатар зэрэг томоохон сумдад 650-1900 хүнд нэг үсчин ноогдож байхад 2200-2800 хүн амтай Сант, Баруунбүрэн, Орхон зэрэг сумд байхгүй байна.

Гоо заслын үйлчилгээ – Сүхбаатар, Алтанбулаг, Ерөө, Мандал, Баянгол гэсэн 5-н суманд үйл ажиллагаа явуулж байна.

Гутал засварын үйлчилгээ – Сүхбаатар, Алтанбулаг, Сайхан, Мандал, Баянгол, Жавхлант, Хушаат гэсэн 7 суманд л үйл ажиллагаа явуулж байна.

Гэрэл зургийн үйлчилгээ – Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын хувьд 3-5 цэг үйл ажиллагаа явуулж байхад Хүдэр, Баруунбүрэн, Орхонтуул Сант, Хушаат, Түшиг сумдад байхгүй байна.

Халуун ус, сауны үйлчилгээ – Сант, Хушаат, Түшиг суманд байдаггүй, цаг засвар, хими цэвэрлэгээний үйлчилгээ аймагт огт байхгүй зэрэг ахуйн үйлчилгээний хүртээмж харилцан адилгүй байна.

Мөн сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа ахуй үйлчилгээний цэгүүд тогтвортой ажиллаж чадахгүй, сумдын удирдлагууд ч энэ салбарыг муу анхаардаг бөгөөд Үсчин гоо засалчдын холбоо Сүхбаатар суманд ажилладагийг эс тооцвол мэргэжлийн салбар холбоод ч байхгүй ахуй үйлчилгээний салбар урсгалаараа явж байна.

Ахуй үйлчилгээний салбарын нэр төрөл, хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, эрх зүй, эдийн засгийн орчныг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Судалгааг хавсаргав.

Сэлэнгэ аймгийн ахуй үйлчилгээний салбарын үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгаа

	Сумын нэр	Хүн амын тоо 2010 оны жилийн эцсийн байдлаар	Ахуйн үйлчилгээний нэр төрөл																			
			Үс засах үйлчилгээ		Гоо заслын үйлчилгээ		Хувцас захиалга засварын үйлчилгээ		Гутал засварын үйлчилгээ		Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ		Гар утас засвар		Гэрэл зургийн үйлчилгээ		Алт мөнгө, үнэт эдлэлийн захиалга засвар		Халуун ус, сауны үйлчилгээ		Бусад	
			Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо	Цэгийн тоо	Ажиллагсадын тоо
1	Сүхбаатар	22065	14	34	6	7	4	12	4	6	1	2	2	4	5	7	1	1	5	12	4	7
2	Алтан булаг	5051	2	3	1	1	2	3	1	1	0	0	0	0	1	1	0	0	1	3	0	0
3	Шаамар	3968	1	1											1	1			1	1		
4	Ерөө	6374	2	2	1	1	1	3					1	1	1	1			1	1	1	1
5	Хүдэр	2119																	1	2		
6	Жавхлант	1910	1	1					2	6					1	1			1	1	1	
7	Сайхан	8809	4	8			2	3	1	2			1	2	3	6			2	4	1	2
8	Орхон	2298					2	2							1	1			1	1		
9	Баруун бүрэн	2850																	1	1		
10	Орхонтуул	3617	1	1															1	1		
11	Сант	2225					2	2														
12	Хушаат	1754	1	2			3	3	1	1												
13	Цагаан нуур	4065	2	3			2	3							1	1			2	3	5	7
14	Түшиг	1476																				
15	Зүүнбүрэн	2665	1	1			1	2			1	1			1	1			1	1	1	1
16	Мандал	25009	9	13	1	2	4	8	1	2					3	3			4	5		
17	Баянгол	5497	2	3	1	1	1	1	1	2	1	1			1	2			2	2	1	1
Нийт дүн		101752	40	72	10	12	24	42	11	20	3	4	4	7	19	25	1	1	24	38	14	19

1.1. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага

1.1.1 Аймгийн ахуй үйлчилгээний салбарын статискикийн нэгдсэн мэдээ мэдээлэл байхгүй, энэ салбарын талаар төрөөс харьцангуй бага анхаарч, бодлогоор дэмжиж туслах үйл ажиллагаа сул.

1.1.2 Ахуй үйлчилгээний нэр төрөл, хүртээмж, чанар харилцан адилгүй.

1.1.3 Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт үүссэн нөхцөл байдлыг сайжруулах, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

1.2. Хөтөлбөрийг боловсруулсан үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, тэрчлэн аймгийн ахуйн үйлчилгээний салбарын өнөөгийн байдлыг сайжруулах, удирдлага арга зүйгээр хангах, ахуй үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахаар “Ахуй үйлчилгээ” дэд хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх, ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын түншлэлийг бэхжүүлэх замаар хүний хөгжлийг дэмжих, үйлчилгээний чанар, хүртээмж, соёлыг дээшлүүлэхэд оршино.

Энэхүү зорилгыг дараахь зорилтоор хэрэгжүүлнэ:

1. Ахуйн үйлчилгээний онцлогийг тусгасан салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож таатай орчинг бүрдүүлэх
2. Ахуйн үйлчилгээний салбарыг бодлогоор дэмжин, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж, хүрэлцээ хангамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

3. Ахуйн үйлчилгээний салбар дахь хүний нөөцийг бэхжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Ахуйн үйлчилгээний онцлогийг тусгасан салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож таатай орчинг бүрдүүлэх хүрээнд:

-Сумын Засаг дарга нар:-Сум бүр ахуйн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, биелэлтэнд нь байнгын хяналт тавьж ажиллах.

-Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар:-Мэргэжлийн холбоодыг байгуулах санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах.

-Уралдааны болзол журам боловсруулж нийтэд зарлаж мэдээлэх, дүгнэх.

-Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Үсчин гоо засалчдын холбоо, Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбооны Сэлэнгэ дэх салбар:-Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн аймгийн ажил мэргэжлийн уралдаан тэмцээн зохиож хэвших, улсын ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцуулах.

-Тус салбараас 2 жилд нэг удаа аймгийн ажил мэргэжлийн аварга шалгаруулах.

-Монгол Улсын Ахуйн үйлчилгээний “Мастер” цол олгуулахаар тодорхойлох.

3.2. Ахуйн үйлчилгээний салбарыг бодлогоор дэмжин санхүүгийн дэмжлэг, туслалцаа, хөнгөлөлт үзүүлж, хүрэлцээ хангамжийг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

Сумдын Засаг дарга нар:- Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг гадаад болон дотоодын төсөл, хөтөлбөр, зээл тусламжинд хамруулах.

-Үйлчилгээний нэр төрлийг олшруулах, чанарыг сайжруулах.

-Ажлын байрыг нэмэгдүүлэх нэг хөшүүрэг болгон суманд ашиглагдахгүй байгаа барилгын судалгааг гаргаж, хөрөнгө оруулалт хийх замаар ахуйн үйлчилгээний салбарыг шинээр нээх буюу одоо байгаа ахуйн үйлчилгээний цэгээ тогтвортой ажиллуулах.

-Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв хорооны Сэлэнгэ дэх салбар:-Тус салбарт нэвтэрч буй шинэ техник, технологийн мэдээллээр хангах.

-Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулан ахуйн үйлчилгээний төв, жижиг сумдад салбарыг бий болгож ажлыг нь тогтмолжуулах.

-Ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн санг бүрдүүлэх.

Аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар:-Ахуйн үйлчилгээний салбарын болон ажлын байрны стандартыг хангуулах.

Үсчин гоо засалчдын холбоо:-Үсчин, гоо засалчдыг аттестатчилалд оруулах.

-Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар:-Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтын орлого үйл ажиллагааны статистик мэдээллийг бий болгох.

3.3 Ахуйн үйлчилгээний салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

-Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Үсчин гоо засалчдын холбоо, Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбооны Сэлэнгэ дэх салбар:-Ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохих хугацаа хүрээнд зохион байгуулах.

-Ахуйн үйлчилгээний салбарын ажиллагсадын статистик мэдээлэлтэй болох.

-Мэргэжилтэй ажилтны судалгааг нарийвчлан гаргаж, өнөөгийн эрэлт, цаашдын хандлагыг тодорхойлох.

-Бүсүүдийн хэмжээнд ахуйн үйлчилгээний тэргүүний ажиллагаатай төв, салбарын туршлагыг судлуулан дэлгэрүүлэх.

Боловсрол, соёлын газар:-Аймгийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд ахуйн үйлчилгээний мэргэжлийн ангиудын тоог нэмэгдүүлэх, ажиллагсдыг сургах.

Аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтэс:-Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг улсын стандарт болон үйлчилгээний чанарын холбогдолтой мэдээллээр хангах, тохирлын баталгаажуулалтанд хамруулах замаар стандартын

шаардлага хангасан ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв хорооны Сэлэнгэ дэх салбар:-Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг сургалтанд оролцуулах.

-Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

4.1.1.Улсын болон орон нутгийн төсөв

4.1.2.Засгийн газрын холбогдох тусгай сан болон аймгийн хөгжлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө

4.1.3.Олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл, хөтөлбөр

4.1.4.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

4.2. Хөтөлбөрийг 2011-2016 онд хэрэгжүүлнэ.

Тав. Үр дүн

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

5.1. Ахуйн үйлчилгээ эрхлэх эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ;

5.2. Сумдын ахуйн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

**Хөтөлбөр хэрэгжих хугацаанд сумдад шинээр бий болгох ахуйн
үйлчилгээний цэг, салбарын тоо**

№	Сумын нэр	Ахуйн үйлчилгээний төв байгуулах	Ахуйн үйлчилгээний нэр төрөл								Нэмэг дэх ажлын байр ны тоо
			Зайлшгүй шаардлагатай				Хэрэгцээтэй				
			Үсчин	Халуун ус, саун	Хувцас захиалга засвар	Компьютер, гар утасны засвар	Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ	Гоо засал	Гэрэл зургийн үйлчилгээ	Гутал захиалга засвар	
1	Сүхбаатар	+		2	1	1	1			1	10
2	Алтанбулаг		1	1		1	1				6
3	Шаамар			1	1	1					4
4	Ерөө	.+		1		1	1	1		1	7
5	Хүдэр		1		1	1	1		1	1	8
6	Жавхлант			1	1	1				1	6
7	Сайхан	.+		1		1	1	1	1	1	8
8	Орхон		1			1					4
9	Баруунбүрэн		1	1	1	1					6
10	Орхонтуул		1	1	1	1	1	1			8
11	Сант		1			1			1		4
12	Хушаат			1		1			1		5
13	Цагааннуур	.+		1	1	1	1			1	7
14	Түшиг		1		1	1			1		5
15	Зүүнбүрэн			1		1					5
16	Мандал	.+	2	1	1	1	1	2		2	10
17	Баянгол				1	1	1	1			5
Нийт дүн			10	13	10	17	9	5	6	8	108

Хөтөлбөр хэрэгжсэнээр 78 ахуйн үйлчилгээний салбар нээгдэж, нийт 108 ажлын байр шинээр бий болно.

5.3. Ажиллагсдын ур чадвар, өрсөлдөх чадвар дээшилнэ.

5.4. Ахуйн үйлчилгээний чанар сайжирч, тохирлын баталгаатай, ажлын байрны стандартын шаардлага хангасан ахуйн үйлчилгээний тоо өснө.

5.5. Шинээр ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл ядуурал буурна.

5.6. Сумдад тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн үйлчилгээний салбаруудын болон ажиллагсадын мэдээллийн сантай болно.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6. Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

6.1. Үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээний өсөлт

6.2. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ болон ажлын байрны өсөлт / Хавсралт хүснэгтээр гаргав./

6.3. Улс бүсийн уралдаан тэмцээнд хамрагдсан үзүүлэлт, үзүүлсэн амжилт

6.4. Тохирлын баталгаатай ахуй үйлчилгээний нэр төрөл, тооны өсөлт

6.5. Сайн дурын баталгаажуулалтанд хамрагдсан ахуйн үйлчилгээний нэр төрөл, цэгийн тоо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 19-ний өдөр

Дугаар 28

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10.1-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс Төрийн бус байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид /цаашид аймгийн Хурал гэнэ /-ээс Төрийн бус байгууллагуудтай харилцах хамтран ажиллах талаарх харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

2. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлж аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай харилцах хамтран ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгон тогтмолжуулж үр өгөөжийг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

3. Аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай харилцах хамтран ажиллах үйл ажиллагаандаа ардчилсан шударга ёс, хууль дээдлэх, харилцан бие биеэ хүндэтгэх, нээлттэй ил тод байх, үндэсний эв нэгдлийг хангах, орон нутаг иргэдийн эрх ашгийг хамгаалах зарчим баримтлана.

Хоёр. Аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай харилцах

Аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай доорхи арга хэлбэрээр харилцана. Үүнд:

1. Төрийн бус байгууллагуудын дарга, тэргүүлэгчдийг улиралд 1 удаа цуглуулан уулзаж хурлын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, тэдний санал бодлыг сонсож, ярилцаж байна.

2. Төрийн бус байгууллагуудын дарга нарыг тус тусын чиглэлээр урьж уулзах, тэднийг хүсэлтээр нь хүлээн авч уулзах ажлыг тогтмолжуулах

3. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж хамтран ажиллах зорилгоор аймгийн Хурлын дэргэд Төрийн бус байгууллагуудын

Зөвлөлийг тэдний хамтран санал болгосон төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4. Аймгийн Хурлаас нийтлэг асуудлаар Төрийн бус байгууллагуудтай харилцахдаа Хурлын дэргэдэх Төрийн бус байгууллагуудын Зөвлөлөөр дамжуулан харилцана.

5. Аймгийн Хурал, Төрийн бус байгууллагууд үйл ажиллагааныхаа талаар болон хийх гэж байгаа ажлынхаа талаар бие биедээ харилцан мэдээлэл өгч байна.

Гурав. Аймгийн Хурлаас

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл

Аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай доорхи чиглэлээр хамтран ажиллана Үүнд:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар санал солилцох, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого боловсруулахад төрийн бус байгууллагуудыг оролцуулах, санал авах

2. Хууль тогтоомж, хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд холбогдох төрийн бус байгууллагуудыг оролцуулах

3. Аймгийн хэмжээнд иргэд, олон нийтийг хамарсан зарим томоохон ажил, арга хэмжээг хамтран зохион байгуулах

4. Аймгийн төсвийн төслийг ил тод болгож төрийн бус байгууллагууд танилцах, санал өгөх боломж бүрдүүлэх

5. Аймгийн төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийх ажлын хэсэгт Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулж байх.

6. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон аймгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар Улсын Их хурал, Засгийн газарт тавих санал боловсруулахад холбогдох төрийн бус байгууллагуудыг оролцуулах, саналыг авах

7. Улсын хэмжээнд болон тус аймагт хэрэгжиж байгаа төслүүдийн талаарх мэдээллийг харилцан солилцож, тэдгээрт оролцох аймгийн оролцоог нэмэгдүүлэх талаар талууд хамтын хүчин чармайлт гаргах

8. Хууль, тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд сурталчилан, ойлгуулах ухуулга сурталчилгаа, сургалтын ажлыг хамтран зохион байгуулах, гэрээгээр гүйцэтгүүлэх

9. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, зарим арга хэмжээнд төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулж байх

10. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран ажиллах талаар Төрийн бус байгууллагуудаас тавьсан санал хүсэлтийг тухай бүр судлан шийдвэрлэж байна.

11. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай харилцах, хамтран ажиллах талаар санаачилга, гаргах үр дүнтэй ажилласан Төрийн бус байгууллагуудыг шагнан урамшуулах

Дөрөв. Аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах механизм

1. Аймгийн Хурлаас Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нэгдсэн гэрээг төрийн бус байгууллагуудын Зөвлөл / сүлжээ /-тэй байгуулна.

2. Гэрээний төслийг аймгийн Хурлын ажлын алба Төрийн бус байгууллагуудаас санал авсны үндсэн дээр Төрийн бус байгууллагуудын Зөвлөлтэй хамтран боловсруулна.

3. Гэрээний төслийг аймгийн Хурлын Тэргүүлэгчид Төрийн бус байгууллагуудын Зөвлөл / сүлжээ/ тус тусын хуралдаанаар хэлэлцэж зөвшөөрсний дараа гэрээнд аймгийн Хурлын дарга, Төрийн бус байгууллагуудын Зөвлөлийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

4. Гэрээний хэрэгжилтийн явц байдлын талаар талууд улирал бүр харилцан мэдээлж байх ба гэрээний биелэлтийг хагас жил дутам аймгийн Хурлын Тэргүүлэгчид, Төрийн бус байгууллагуудын Зөвлөл тус тусын хуралдаанаар хэлэлцэж дүгнэж байна.

5. Аймгийн болон бүсийн, салбарын урт дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төсвийн төслийг холбогдох Төрийн бус байгууллагуудад хүргүүлж саналыг авсан байна.

6. Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх аймгийн эдийн засаг, нийгмийн бодлогын чанартай томоохон шийдвэр, иргэдийн амьдрал эрх ашгийг хөндсөн асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд холбогдох төрийн бус байгууллагаас санал авах ажлыг Хурлын ажлын алба хариуцан зохион байгуулна.

7. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба аймгийн Хурлын дараа оны ажлын төлөвлөгөө боловсруулахдаа төрийн бус байгууллагуудаас санал авч судлан хэрэгжүүлэх боломжтой асуудлыг төсөлд тусгана.

8. Аймгийн Хурлын Тэргүүлэгчид тодорхой асуудлыг судлан боловсруулах, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хянан шалгах чиглэлээр ажлын хэсэг байгуулахдаа шаардлагатай гэж үзвэл бүрэлдэхүүнд нь холбогдох Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулж байна.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 19-ний өдөр

Дугаар 29

Сүхбаатар

Иргэний танхим ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс Орон нутгийн хөгжлийн бодлого, ажил амьдралын тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахдаа иргэд олон нийтийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэг явуулж иргэдийн саналыг авч тусгах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд “Иргэний танхим” нээн ажиллуулсугай.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Иргэний танхим”-ын ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 04 сарын 19-ны
өдрийн 29 дүгээр дүгээр тогтоолын хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ТАНХИМЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Бүх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон аймгийн ИТХ-ын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж зэрэг шийдвэрт иргэдийн байр суурь, санал санаачилгыг тусгах, орон нутгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотой нээлттэй хэлэлцэх зорилгоор Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дэргэд ажиллах Иргэний Танхимын /цаашид Иргэний Танхим гэх/ үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Зорилго, үйл ажиллагааны зарчим

2.1 “Иргэний танхим”-ын зорилго нь тогтоол, захирамж, шийдвэрийн төсөлд тусгахаар иргэд, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан санал болон шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай хүсэлт мэдээллийг хүлээн авах замаар орон нутгийн түвшинд гарах шийдвэрийн төслийг сайжруулах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах явдал юм.

2.2 “Иргэний танхим”-д болох аливаа хэлэлцүүлэг нь хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн тодорхой шийдвэр, баримт бичгийн төслийг иргэдээр нээлттэй хэлэлцүүлэн тэдний саналыг сонсох, авах, шийдвэрт тусгах зорилгыг агуулна.

2.3 “Иргэний танхим”-ын бүх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байна.

Гурав. Иргэний Танхимын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт

3.1 Иргэний Танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг байна. Нээлттэй хэлэлцүүлэг нь оролцогч тал, асуудал оруулагч тал, болон зохион байгуулагчаас тус тус бүрдэнэ.

3.2 Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогч нь Сэлэнгэ аймгийн иргэн байх бөгөөд тус аймагт бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагын төлөөлөл байж болно.

3.3 Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон олон улсын байгууллага, ААН-ийн төлөөллийг хэлэлцүүлэг зохион байгуулагч болон даргалагчийн урилгаар оролцуулж болно.

3.4 Нээлттэй хэлэлцүүлэгт асуудал оруулагч нь аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч, Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч байна.

3.5 Хэлэлцүүлэгт асуудал оруулагч болон ажлын хэсгийг ахлагч нь тухайн асуудлаар явагдаж буй нээлттэй хэлэлцүүлгийн даргалагч байна.

3.6 Иргэний Танхимын үйл ажиллагааг зохион байгуулагч нь ИТХ-ын тэргүүлэгчдийн Ажлын алба /цаашид “ажлын алба” гэх/ байна.

3.7 Ажлын алба нь нээлттэй хэлэлцүүлгийг олон нийтэд зарлах, иргэдээс санал мэдээлэл хүлээж авах, хэлэлцүүлгийг зохион байгуулах, хэвлэлээр мэдээлж сурталчлах, мэдээллийг цуглуулж эмхэтгэх, саналыг ангилж бэлтгэх, асуудал оруулагч талд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх бичиг техникийн бэлтгэлийг хангахад туслах ажлыг гүйцэтгэнэ.

Дөрөв. Иргэний Танхимд хэлэлцэх төслийг олон нийтэд зарлах

4.1 Нээлттэй хэлэлцүүлэгт асуудал оруулагч нь төслийн анхны эх, түүний товч агуулга, төслийн үндэслэлийн танилцуулгыг бэлэн болгож ИТХ-ын Ажлын албанд хүлээлгэн өгнө.

4.2 Ажлын алба Иргэний танхимд хэлэлцэх төслийн анхны эх, хэлэлцүүлэг болох он сар өдөр, байр, цаг, үргэлжлэх хугацаа, иргэдийн санал хүлээж авах хаяг, электрон шуудан, лавлагаа авах, хэлэлцүүлэгт биечлэн оролцохоор бүртгүүлэх утасны дугаар, хаягийг дурдсан албан ёсны зарыг нээлттэй хэлэлцүүлэг болохоос ажлын 10 хоногийн өмнө хэвлэл мэдээлэл, интернэтээр зарлана.

Тав. Хэлэлцүүлэгт саналаа ирүүлэх

5.1 Хэлэлцүүлэгт оролцогч нь хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр хэлэлцүүлэг зарлагдмагц дараахь хэлбэрээр санал шүүмжлэл, байр сууриа илэрхийлж болно. Үүнд:

5.1.1 Иргэний танхимд болох хэлэлцүүлэгт биечлэн ирж оролцох хэлбэрээр

5.1.2 Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба” гэж хаягласан захидлаар

5.1.3 Аймгийн ИТХ-ын Ажлын албаны факсаар

5.1.4 Аймгийн ИТХ-ын Ажлын албаны электрон шуудангаар

5.1.5 Аймгийн албан ёсны веб сайтад санал ирүүлэх хэлбэрээр

5.2 Хэлэлцүүлэгт биечлэн оролцох иргэд ажлын албанд хэлэлцүүлэг болохоос 2-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж бүртгүүлнэ.

5.3 Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлэгт өөрийн санал, байр суурийг томъёолоход хангалтгүй мэдээлэлтэй байна гэж үзвэл иргэд төсөл боловсруулагч нарт хандан асуулт тавьж, хариулт авч болно. Төсөл боловсруулагч нар асуултуудад Иргэний танхимын хэлэлцүүлгийн үеэр хариулт өгнө.

5.4 Төсөл оруулж буй ажлын хэсэг төслийн талаар ирсэн саналыг нэгтгэж, ирсэн санал бүрийг тайлбарын хамт төсөлд хавсарган Танхимын хэлэлцүүлэгт бэлтгэнэ. Танхимын хэлэлцүүлэг эхлэхээс өмнө төсөлд өөрчлөлт орсон бол уг ажлын хэсэг өөрчлөлтийн талаар хэлэлцүүлгийн эхэнд мэдээлэл хийж тайлбарлана.

Зургаа. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим ба хэлэлцүүлэгт оролцох дараалал

6.1 Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим үйлчилнэ.

6.2 ИТХ-ын Ажлын алба нь хэлэлцүүлэгт биечлэн оролцохыг хүссэн иргэдийг бүртгэн нээлттэй хэлэлцүүлэг даргалагчид хэлэлцүүлэг эхлэхээс 24 цагийн өмнө танилцуулна.

6.3 Нээлттэй хэлэлцүүлгийг Иргэний танхимын хэлэлцүүлэг явуулахаар зарласан байранд зарласан цагт эхлүүлнэ.

6.4 Хэлэлцүүлэгт оролцохоо илэрхийлсэн иргэдийн тоо байрны багтаамжаас хамааран шаардлагатай гэж үзвэл хэлэлцүүлгийг хэд хэдэн ээлжээр хийх буюу эсвэл өөр байранд хийж болно.

6.5 Хэлэлцүүлэгт үнэ цэнэтэй мэдээллээр хувь нэмэр оруулж чадах төрийн албан хаагчид, судлаач, шинжээч, гадаадын болон судалгааны байгууллагын төлөөлөгчийг урилгаар оролцуулж болно.

Долоо. Хэлэлцүүлгийн бэлтгэл хангах

7.1 Иргэний Танхимын хэлэлцүүлгийн байрыг бэлтгэх, хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөх, хэлэлцүүлэг даргалагчийн хүсэлтээр хэлэлцүүлгийн дэгийг сахиулах, дэг зөрчсөн иргэдийг танхимаас гаргах, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллээр дамжуулах, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг урьж оролцуулах ажлыг Ажлын алба хариуцна.

7.2 Хэлэлцүүлгийн үеэр аудио болон видео материал үзүүлж сонсох, зураг үзүүлэн таниулах материал байрлуулах, компьютерээр материал үзүүлж танилцуулах оролцогчдын материалыг хэлэлцүүлэг эхлэхээс 1-2 цагийн өмнө Ажлын алба хүлээн авч техникийн бэлтгэл хангана.

7.3 Ажлын алба нээлттэй хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах, хэлэлцүүлэгт сэтгүүлч, сурвалжлагч, ажиглагч нарыг оролцуулах тэдэнд суудал, байрлал хуваарилах зэрэг бэлтгэл ажлыг нээлттэй хэлэлцүүлэг эхлэхээс өмнө хийж гүйцэтгэнэ.

7.4 Хэлэлцүүлэгт оролцохоор ирсэн хүмүүсийг бүртгэж үг хэлэх дарааллыг тогтооно.

Найм. Хэлэлцүүлгийн дэг

8.1 Хэлэлцүүлэх төслийн нэр, хэлэлцүүлэг зарласан огноо, хэлэлцүүлэгт оролцохоор бүртгүүлсэн болон ирсэн иргэдийн тоо төсөл боловсруулагч баг төслийг танилцуулах ажилтаны нэрийг хэлэлцүүлгийг даргалагч танилцуулж хэлэлцүүлгийг нээнэ.

8.2 Даргалагч хэлэлцүүлгийн дэгийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хэлэлцэх асуудлын цар хүрээг харгалзан хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацаа, нэг оролцогчийн үг хэлэх хугацааг тогтооно. Хугацааг 3-5 минутаар тогтооно.

8.3 Төсөл боловсруулсан багийн гишүүн оролцогчдод төслийн талаар танилцуулна.

8.4 Хэлэлцүүлгийн эхэнд хөндлөнгийн шинжээч, эксперт, төрийн болон олон улсын байгууллагын холбогдох албаны хүмүүсийн тайлбар мэдээллийг сонсож болно.

8.5 Оролцогчид бүртгүүлсэн дарааллаар саналаа хэлж дууссаны дараа асуудал оруулагч талаас шаардлагатай гэж үзвэл оролцогчдод болон урилгаар оролцож буй гэрч, шинжээч, төрийн албан хаагч, судлаач, бусад зочдод хандан асуулт тавьж болно.

8.8 Асуулт, хариулт дууссаны дараа хэлэлцүүлэгт оролцогчид болон асуудал оруулагчдын зүгээс санал дүгнэлт хэлнэ. Ингэхдээ нэг хүнд нэг минутын хугацаа олгоно.

8.9 Хэлэлцүүлгийг даргалагч хэлэлцүүлгийг хааж үг хэлнэ.

8.10 Хэлэлцүүлэгт оролцогч зочин бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, яриаг нь таслах, өмнөөс нь үг хэлэх, хашгирах зэрэг бусдын үгээ чөлөөтэй хэлэхэд нь саад учруулсан үйлдэл гаргавал хэлэлцүүлэг даргалагч дэг баримтлахыг шаардах бөгөөд шаардлагыг үл биелүүлбэл оролцогчийг танхимаас гаргаж болно.

Ес. Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг шийдвэрт тусгах

9.1 Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлгийг бүх хэлбэрээр санал авч дууссаны дараа төсөл боловсруулсан багийнхан төслийн эхийг ажлын 7 хоногт багтаан эцэслэн боловсруулж ИТХ-ын Тэргүүлэгчдэд оруулна.

9.2 Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулахаар шинэчлэн боловсруулсан төсөлд Иргэний Танхимд төслийн талаар ирүүлсэн болон хэлэлцүүлэг дээр гарсан бүх санал, үүнээс төсөлд туссан, эс туссаныг тайлбарласан жагсаалтыг хавсаргасан байна.

9.3 Энэ журмын 9.2 дахь заалтын дагуу боловсруулсан төслийг үндэслэн ИТХ, түүний тэргүүлэгчдээс гарсан тогтоол, шийдвэрийг аймгийн болон ИТХ-ын веб сайтад байрлуулна.

9.4 Энэхүү журам нь хүн бүрийн саналыг ИТХ, түүний тэргүүлэгчдээс гарсан тогтоол, шийдвэрт заавал тусгах үндэслэл болохгүй. Харин шийдвэр гаргахаас өмнө иргэд байр суурь, саналаа чөлөөтэй иэлрхийлж, сонсох илүү өргөн боломж бий болгоход үйлчилнэ.

Арав. Бусад зүйл

10.1 Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгааны улмаас Иргэний Танхимд болох хэлэлцүүлгийг ИТХ-ын дарга хойшлуулах буюу цуцалж болно. Хойшлогдсон хэлэлцүүлгийг зохион байгуулах тухай зарыг энэхүү журмын дөрөвдүгээр зүйлийн дагуу олон нийтэд мэдээлнэ.

10.2 Иргэний танхимын хэлэлцүүлэг монгол хэл дээр явагдана.

Сүлд

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 19-ний өдөр

Дугаар 32

Сүхбаатар

Сүм байгуулах зөвшөөрөл олгох тухай

Баянгол сумын зарим иргэдээс гаргасан хүсэлт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баянгол суманд Христийн шашны “Эзний давалгаа” Баптист сүм байгуулах зөвшөөрлийг тус сумын иргэн Г.Шараа нарын иргэдэд 1 жилийн хухгацаатай олгосугай.

2.Сүмийн дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэж, үйл ажиллагааныхаа талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр таинлцуулга мэдээлэл ирүүлж байхыг сүмийн ахлагч /Г.Шараа/-д зөвлөсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 05 сарын 11-ний өдөр

Дугаар 37

Сүхбаатар

Таван хан уулсыг тахиx тухай

Эх болсон байгаль дэлхийгээ шүтэж, хайрлан хамгаалдаг өвөг дээдсийнхээ өнө эртний заншил, түүх соёл, төрт ёсны уламжлалаа дээдлэн хан уулсаа тахиx тахилгын ёслолыг Хүннү гүрэн үүссэний 2220, Ардын хувьсгалын 90, аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан үйлдэж, цаашид уламжлал болгох нь зүйтэй хэмээн үзэж Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Сэлэнгэ нутгийнхаа шүтээн болсон Таван хан /Дэлгэрхан, Товхонхан, Дулаанхан, Баянхан, Бүрэнхан/ уул, Хараагийн Ноён уулыг тахиx тахилгын ёслолыг үйлдэн, аймгийнхаа төрийн гурван одонт тугийг ёслол төгөлдөр залж хүндэтгэл үзүүлэхээр тогтоосугай.

2.Хан уулсыг тахиx тахилга, аймгийн тугийг залах ёслолын бэлтгэлийг сайтар хангаж, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн ард иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр оролцуулан тухайн хайрхныг тахиж ирсэн уламжлалт ёс заншил, дэг жаягийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 17-ны өдөр

Дугаар 40

Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1.Сэлэнгэ аймагт 2011 -2016 онд хэрэгжүүлэх “Чацаргана” дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган чацаргана тариалах, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх аливаа санал, санаачилгыг дэмжин орон нутгийн төсөв, сум хөгжүүлэх сан, төсөл хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэхийг аймаг, сумын Засаг дарга даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

“ЧАЦАРГАНА” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Жимс, жимсгэний хэрэглээ, өнөөгийн байдал

Жимс, жимсгэнэ нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, сахар, эрдсийн элемент болон биологийн идэвхт бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн төдийгүй бут сөөг нь ойн зурвас, ногоон байгууламж байгуулах замаар хөрс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, элсний нүүдлийг зогсооход хамгаалалт болдог олон талын ашиг тустай. Манай орны байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон 60 гаруй зүйлийн зэрлэг жимс, жимсгэнэ ургадагаас манай аймаг 10 гаруй зүйлийн зэрлэг жимс ургадаг юм байна.

Насанд хүрсэн хүн жилд дунджаар 65.7 кг, өдөрт 180 гр жимс, жимсгэнэ хэрэглэх нь зохистой гэж үздэг. Манай аймагт нэг хүн 1990 онд 12 кг жимс, жимсгэнэ хэрэглэж байсан бол 2010 онд 9.5 кг болж буурсан бөгөөд сүүлийн үед жимс, жимсгэний тариалалт импортын жимс, жимсгэний хангамж нэмэгдэж байгаа ч шаардлага хангахгүй байгаа нөгөө талаар жимс, жимсгэний хэрэгцээ огцом өсч байна. Байгалийн жимсийг олон хэлбэрээр ашиглаж байгаа ч, статистик судалгаа байхгүй учраас таримал жимс, жимсгэний нөөцийг нь арвижуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

2010 оны байдлаар аймгийн хэмжээгээр 198.3 га-д жимс жимсгэнэ тариалсны 75.0 хувь буюу 148.8 га – д чацаргана тариалж 35 тн ургац /өчүүхэн бага / хураан авч байгаа нь манай аймгийн жимс, жимсгэнэ хэрэгцээний дөнгөж 0.5 хувьтай тэнцэж 108 ажлын байр шинээр бий болсон гэсэн мэдээлэлтэй байна.

Чацаргана хөтөлбөр хэрэгжихээс өмнө Ерөө, Орхон, Сант, Түшиг, Жавхлант, Баруунбүрэн сумд чацаргана тариалдаггүй байсан бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Орхон сумдаас бусад сумд нь бага хэмжээний чацаргана тариалаад байна. Хөтөлбөр хэрэгжүүлэхээр бүх суманд жимс, жимсгэнэ тариалахаар тооцоог хийсэн болно. Ингээд хөтөлбөр хэрэгжснээр нийт 876.7 га

чацаргана тариалж 2016 он гэхэд нийт 546.6 мянган суулгацаас 3279.6 тн чацаргана авч нэг хүнд дундажаар 32.8 кг жимс ноогдож байна. Цаашид ч энэ тоо өснө. Ингэснээр аймгийнхаа хүн амын жимс, жимсгэний физиологийн норм, хэрэгцээ 50 хувиар хангах юм.

Ийм учраас Чацаргана дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж жимс, жимсгэний хүрэлцээ хангамжийг сайжруулах шаардлагатай байна.

Мөн “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд ч “Чацаргана” дэд хөтөлбөр чухал ач холбогдолтой юмаа.

14 бүлэг 51 заалт бүхий хөтөлбөр боловсрууллаа

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

Нэг га талбайд 1200-1600 чацарганы суулгац суулгаж нэг бутнаас 7-10 кг жимс хурааж, 1 тонн жимснээс 20-50 кг тос, 600 л цэвэр шүүс, бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах бололцоотой бөгөөд нийт зарцуулсан хөрөнгийг 2-3 жилд нөхөж ашигтай ажиллах тооцоог эрдэмтэд гаргасан байна. Жимс, жимсгэнэ, түүний дотроос чацаргана тариалах хөдөлгөөнийг дэмжих, хүмүүсийн амьдрал ахуйгаа дээшлүүлэх, ажлын байр бий болгохын зэрэгцээ боловсруулах үйлдвэр байгуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотооддоо хэрэглэх, гадаад зах зээлд нийлүүлэх тодорхой бодлоготой ажиллах зайлшгүй шаардлага гарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Чацаргана хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд 20 мянган га хүртэл талбайд чацаргана тариалж, түүнийг боловсруулах үйлдвэр байгуулна” гэж заасныг болон Засгийн газраас 2010 онд Чацаргана үндэсний хөтөлбөр боловсруусныг хэрэгжүүлж аймаг орон нутагтаа дээрхи шийдвэрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатайг үндэслэн энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулав.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ногоон эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурлан дараахь зарчмыг баримтална.

Гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын аль ч дамжлагад стандарт, эрүүл ахуйн шаардлагыг чанд баримтлах.

Экспортын баримжаатай экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих.

Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны ололтыг ашиглах;

Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын харилцан ойлголцол, иж бүрэн түншлэлийг чухалчлах.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго

Дэд хөтөлбөрийн зорилго нь чацарганыг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр чацаргана тариалж, цөлжилтийг сайжруулах, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангахад оршино.

Тав. Хөтөлбөрийн зорилт

5.1.Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ.

1. Чацаргана болон бусад жимс жимсгэний аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх.
2. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд усалгаатай нөхцөлд чацаргана тариалж, өөрийн хэрэгцээг хангах, цаашид зах зээлд борлуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх, технологийг боловсронгуй болгох арга зүйг эзэмшүүлэх,
3. Бусад төрлийн жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж импортыг бууруулах.
4. Хөтөлбөрийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүлэмж, хүлэмжийн нийлэг хальс, био бордоо, ургамал хамгааллын бодис, арвин ургацтай сортын үр, суулгац олж нийлүүлэх, зуучлах,
5. Хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, жимс жимсгэнэ, түүгээр боловсруулсан бүтээгдэхүүний борлуултын сүлжээг бий болгох

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Нэгдүгээр зорилтын хүрээнд

6.1. Чацаргана болон бусад төрлийн жимс жимсгэний аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

6.1.1. Аймаг, сумдад салбар зөвлөл байгуулж, дэд хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээг аймгийн салбар зөвлөлд ирүүлж байх.

6.1.2. Чацаргана, жимс жимсгэнэ тариалж байгаа, түүний үр жимс, түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлт, даатгалд хамруулах арга хэмжээ авах

6.1.3. Чацаргана, жимс жимсгэнэ тариалсан талбай, хураасан ургац, үйлдвэрлэсэн суулгац, боловсруулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг статистикийн мэдээнд бүрэн хамруулах

6.1.4. Чацаргана бусад төрлийн жимс жимсгэний тариалан, эрхэлж байгаа аж ахуйн нэгж иргэдийг хөнгөлөлттэй зээл, төсөлд хамруулах

6.1.5. Хувиараа болон өрхийн, нөхөрлөл хоршооны хэлбэрээр жимс жимсгэний аж ахуй эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх.

Долоо. Хоёрдугаар зорилтын хүрээнд

7.1. Иргэд аж ахуйн нэгжүүд усалгаатай нөхцөлд чацаргана тариалж өөрийн хэрэгцээг хангах, цаашид зах зээлд борлуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх, технологийг боловсронгуй болгох, арга зүйг эзэмшүүлэх зорилтын хүрээнд:

7.1.1. ШУ-ны байгууллагуудтай хамтран ажиллаж орон нутгийн хөрс цаг уурын нөхцөлд тохирсон шилмэл сорт сонгож, тарьж ургуулах агротехник боловсруулж мөрдүүлэх

7.1.2. Жимс жимсгэний аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдийг арга зүйгээр хангаж, сургалтанд хамруулах, харилцан туршлагыг нь солилцуулах арга хэмжээ авах

7.1.3. Усалгаатай тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас хэлбэрээр, худгийн дэргэд болон иргэд хувийн хашаа талбайд, голын сав дагуу чацарганыг дангаар нь буюу бусад хүнсний ногоотой зэрэгцүүлэн тариалах хөдөлгөөнийг өрнүүлэн боломжтой бүх газар чацаргана тариалах газар олгох.

7.1.4. Төв суурин газрын цэцэрлэгжүүлэлт, хөрс нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах, элсний нүүдлээс хамгаалах зэрэг чиглэлээр чацаргана тариалах үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих.

Найм. Гуравдугаар зорилтын хүрээнд

8.1. Бусад төрлийн жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх замаар дотоодыг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах импортыг бууруулах зорилтын хүрээнд:

8.1.1. Орон нутагт тариалж буй болон байгалийн жимс жимсгэний нөөц, төрлийн тооллого хийж тогтоох, аймаг сумын хяналтанд авч мэдээ мэдээлэлд хамруулах.

8.1.2. Жимс жимсгэнэ тариалж ирсэн уламжлалд тулгуурлан үхрийн нүд, мойл, улаалзгана, бөөрөлзгөнө, долоогоно, нохойн хошуу, тошлой, нэрс, аньс, гүзээлзгэнэ, тэс, өрөл, алим, давжаа алим, чавга зэрэг жимс жимсгэнийг нутагшуулан тариалахыг дэмжих, үр суулгац олж нийлүүлэх.

8.1.3. Хамгаалагдсан хөрсөнд нимбэг, жүрж, алим, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ зэрэг арвин ургацтай жимс жимсгэнэ тариалах санаачлагыг бүх талаар дэмжих, арга зүйгээр хангах.

Ес. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

9.1. Хөтөлбөрийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүлэмж, хүлэмжийн нийлэг хальс, био бордоо, ургамал хамгааллын бодис, арвин ургацтай сортын үр, суулгац олж нийлүүлэх, зуучлах зорилтын хүрээнд

9.2. Шилмэл сортын чацаргана, жимс жимсгэний суулгац үржүүлэн зах зээлд нийлүүлэх аж ахуйн нэгжид бодлогоор дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч жимс жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэх.

9.3. Ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис бордоо, чацаргана тариалах, арчлах, хураах, боловсруулахад шаардагдах техник тоног

төхөөрөмжийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ийм үйл ажиллагаа явуулж буй иргэд аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжих.

9.4. Ногоон мөчир, суулгац бойжуулах иргэн, аж ахуйн нэгжийн санаачлагыг дэмжиж ургац арвинтай сорт, хүлэмж, хүлэмжийн нийлэг хальс, дуслын усалгаа зэрэг дэвшилтэт техник тоног төхөөрөмжийг олж нийлүүлэх, зуучлах.

Арав. Тавдугаар зорилтын хүрээнд

10.1. Хөтөлбөрийн ач холбогдлыг нийтэд сурталчлах, жимс жимсгэнэ, түүгээр боловсруулсан бүтээгдэхүүний борлуултын сүлжээг бий болгох.

10.2. Жимс жимсгэний ач холбогдол түүний зохистой хэрэглээ болон бүтээгдэхүүний ашигт чанарыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлан таниулах

10.3. Жил бүр зохион байгуулагддаг “Алтан намар” үзэсгэлэн худалдаанд жимс жимсгэнэ, суулгац үйлдвэрлэгчдийг оролцуулж үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёрыг ойртуулах, шалгаруулалтын номинацид оруулах.

10.4. Цэцэрлэг сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллын газрууд болон “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд дотоодын үйлдвэрлэлийн стандарт, чанарын шаардлага хангасан жимс, жимсгэнэ тэдгээрийг боловсруулсан бүтээгдэхүүнийг өргөн хэрэглэх.

10.5. Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийг түшиглэн чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалах, арчлах, боловсруулах талаар иргэд аж ахуйн нэгжүүдийн туршлага, санаачлагыг дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах,

Арван нэг. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат хийгдэх ажлууд

11.1. “Чацаргана” дэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2016 он хүртэл хэрэгжүүлнэ.

11.1.1. **1-р үе шат 2011-2012 он** Хөтөлбөрийг сурталчлах, чацаргана болон бусад төрлийн жимс жимсгэний аж ахуйг эрхлэх хөтлөх нөхцлийг бүрдүүлэх,

тариалах арга зүйг эзэмшүүлэх Чацаргана, бусад төрлийн жимс жимсгэнэ тариалах талбайн хэмжээг 383.3 га-д хүргэн тариалж ажлын байраар 180 доошгүй хүнийг хангаж нэг хүнд ноогдох жимс, жимсгэний хангамжийг дээшилнэ.

11.1.2. Техник тоног төхөөрөмжийн боломжтой, дадлага туршлагатай аж ахуйн нэгжүүдийг түшиглэн орон нутагтаа суулгац, ногоон мөчир үржүүлж иргэд аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэх, чацарганаас бусад төрлийн жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, нийт жимс жимсгэний тариалалтын 30 хувиар нэмэгдүүлнэ.

11.1.3. Аймагтаа Чацаргана боловсруулах үйлдвэртэй болж импортын шаардлагад нийцсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх

11.2. II үе шат 2013-2016 он

11.2.1. Аймгийн хэмжээгээр бүх сумдад жимс жимсгэний аж ахуйтай болж, нийт 1000 доошгүй га талбайд тариалахаас чацарганыг 876.7 га талбайд тариалах

11.2.2. Аймагтаа чацарганы боловсруулах үйлдвэртэй болох, стандарт шаардлагад нийцсэн экологийн цэвэр нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж брэнд бүтээгдэхүүнтэй болно.

11.2.3. Ажлын байрыг 600 хүнээр нэмэгдүүлж нэг хүнд ноогдох жимс, жимсгэний хэрэгцээнийхээ 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.

Арван хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

12.1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах салбар зөвлөлийг байгуулж, тухайн шатны Засаг дарга эсвэл Засаг даргын орлогч ахалж, орон нутгийн төр захиргааны, ТББ, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл орж ажиллана. Хүнс, хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар

мэргэжил арга зүйгээр хангаж дэмжлэг туслалцаа үзүүлж тэргүүлэх үүрэгтэй оролцоно.

12.2. Хөтөлбөрийг төр захиргаа, төрийн бус байгууллага мэргэжлийн байгууллагууд, хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвүүд хамтран албан ба албан бус сургалтын тогтолцоог ашиглан иргэдийн идэвхи санаачилгад тулгуурлан хэрэгжүүлнэ.

12.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж, шаардагдах төсвийг тухайн оны төсөвт суулгаж хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

12.4. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгуулагад тайлагнана.

Арван гурав. Хөтөлбөрийн санхүүжилт

13. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

13.1. Иргэн аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө

13.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

13. 3. Жижиг дунд үйлдвэрийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Тариаланг дэмжих сангаас олгох хөрөнгө

13.4. Ойжуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлийн сан болон уг зориулалтаар улсын төсөвт тусгагдсан хөрөнгө

13.5. Олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө

13. 6. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, эзэмшигч аж ахуйн нэгжийн байгаль орчныг сэргээхэд зарцуулж байгаа хөрөнгө

13.7. Бусад эх үүсвэр

Арван дөрөв. Хүлээгдэж байгаа үр дүн

14.1. Чацаргана болон бусад төрлийн жимс жимсгэний талбайг 1000 га, үүнээс чацаргана 876.7 га –д хүргэж боловсруулах үйлдвэртэй болно.

14.2. Экологийн цэвэр бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ өсч аймгийнхаа хэрэгцээт жимс, жимсгэнийхээ 50 хувийг хангана.

14.3. Экологийн нөхөн сэргээлт хийх, мод суулгац үржүүлэх, цэцэрлэгжүүлэлт, жимс жимсгэний аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжинө.

14.4. Жимс жимсгэний аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлтэй болсноор 600 –аас доошгүй ажлын байр бий болно.

14.5. Байгалийн жимс жимсгэний талбайг хамгаалалтанд аван нөхөн сэргээж, байгалийн жимс жимсгэнийг зохистой ашиглах тогтолцоо бүрдэнэ.

14.6. Таримал жимс жимсгэний нэр төрөл нэмэгдсэнээр хүн ам аюулгүй, экологийн цэвэр жимс жимсгэнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэдэг болно.

Арван тав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоогийн байдал / хөтөлбөр эхлэхээс өмнө /	Хүрэх түвшин		Бүгд
				I үе шат /2010-2012/	II үе шат / 2013-2016/	
1	Чацаргана тариалах талбай	га	163.3	383.3	330.1	876.7
2	Суулгах суулгацын тоо	ш	163290	383300	330100	876690
3	Хураан авах ургац	тонн	35	3279.6		
4	Бэлтгэх суулгац	мян/ш	72306	150000	200000	422306
5	Дотоодын үйлдвэрлэлийн жимс, жимсгэний хангамж	хувь	0.5	20	30	50.5
6	Шинээр бий болох ажлын байрны тоо	хүн	108	383	331	822
7	Элсний нүүдлээс хамгаалах, байгаль нөхөн сэргээх зориулалтаар чацарганыг ашигласан байдал	га	104.6	191.5	165	461.1

Тайлбар:

Хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа буюу 2016 онд 876.7 га чацаргана тариалж үүнээс 546.6 тн чацаргана нь жимсээ өгнө гэж үзвэл 546.6 га х 1000 ширхэг =546600 чацаргана х 6 кг = 3279.6 тн Сэлэнгэ аймгийг дундажаар 100000 хүн амтай гэвэл нэг хүнд дундажаар 32.8 кг жимс ноогдоно. Энэ нь нийт жимс, жимсгэний $32.8 : 65.7 = 50$ хувийг хангана гэж тооцлоо.

ЧАЦАРГАНА" ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУМДЫН СУДАЛГАА

д/д	Сумын нэр	Одоогийн түвшин / хөтөлбөр эхлэхээс өмнө /		Хүрэх түвшин					
				1-р үе шат			2-р үе шат		
		Чацаргана тариалсан талбай,га	Суулгасан суулгацын тоо	Чацаргана тариалсан талбай,га	Суулгасан суулгацын тоо	нэмэгдүүлэх ажлын байрны тоо	Чацаргана тариалсан талбай,га	Суулгасан суулгацын тоо	нэмэгдүүлэх ажлын байрны тоо
1	Алтанбулаг	1.4	1400	13	13100	12	19	19000	19
2	Ерөө			24	24200	24	22	22000	22
3	Мандал	10.8	10800	26	26320	27	26.6	26600	27
4	Зүүнбүрэн	100.5	100500	107	107480	107	43	43000	43
5	Орхон			9	9000	9	9	9000	9
6	Сант			5	5300	5	8	8000	8
7	Түшиг			8	7920	8	6	6000	6
8	Баянгол	28.4	28400	20	20440	20	20	20000	20
9	Сайхан	1.8	1800	6	5720	6	24	24000	24
10	Жавхлант	2.7	2700	17	17400	18	14	14000	14
11	Орхонтуул	2.2	2200	10	9800	10	13.5	13500	14
12	Баруунбүрэн	2	2000	16	15740	16	17	17000	17
13	Цагааннуур			11	10800	11	31	31000	31
14	Хушаат			23	22900	23	13	13000	13
15	Шаамар	0.23	230	33	33050	33	23	23000	23
16	Хүдэр	5.8	5750	8	8000	8	11	11000	11
17	Сүхбаатар	7.5	7500	46	46120	46	30	30000	30
ДҮН		163.3	163280	383	383290	383	330.1	330100	331

oOo

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 17-ны өдөр

Дугаар 42

Сүхбаатар

Зөвшөөрөл олгох тухай

Сүм байгуулах зөвшөөрөл хүссэн Мандал сумын зарим иргэдийн өргөдлийг хянан хэлэлцээд Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Мандал сумын 1 дүгээр багт Христийн шашны “Амьд чулуу” сүм, мөн сумын Хэрхийн 4 дүгээр багт Христийн шашны “Мөнхийн шинэ” сүм тус тус байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Сүмийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тухай бүр мэдэгдэж, үйл ажиллагааныхаа талаар жил бүр мэдээлж байхыг дээрх сүмийн удирдах байгууллагад зөвлөсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 17-ны өдөр

Дугаар 44

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан журмын 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн Ахмадын хорооноос тавьсан хүсэлтийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Ахмадын байгууллагын 80 жилийн ойг Олон улсын Ахмадын өдөртэй хамтатган 10 дугаар сарын 01-нд тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 17-ны өдөр

Дугаар 47

Сүхбаатар

Ашиглалтгүй барилгуудыг актлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн буюу цаашид ашиглах боломжгүй хавсралтад дурдсан барилгуудыг үндсэн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн акталж үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 06 сарын 17-ны өдрийн
47 дугаар тогтоолын хавсралт

АШИГЛАЛТГҮЙ БАРИЛГУУДЫГ АКТЛАХ, ДАНСНААС ХАСАХ ЖАГСААЛТ

№	Байгууллага, аж ахуйн нэр	Хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтанд орсон он	Дансны анхны үнэ мян.төг	Байгуулсан элэгдэл мян.төг	Үлдэгдэл үнэ мян.төг	Үндсэн байгууллагын санал	Аймгийн Засаг даргын санал	Аймгийн ИТХТ-ийн шийдвэр
1	Сант сумын Соёлын төв	Жижиг байшин	1977	2340,0	2148,1	191,9	актлах	актлах	актлах
2	Аймгийн Цагдаагийн газар	Автограж	1995	2267,0	554,1	1712,9	актлах	актлах	актлах
3	Мандал сумын ЕБ-ын 2-р сургууль	Ногооны зоорь	1997	160,0	160,0	0,0	актлах	актлах	актлах
4	Ерөө сумын Бугант тосгон	Автограж	1985	1500,0	1053,0	447,0	актлах	актлах	актлах

оОО

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 17-ны өдөр

Дугаар 49

Сүхбаатар

Үндсэн хөрөнгийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Үндсэн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн 6 байгууллагын 42 ширхэг тавилга, эд хогшил, 8 ширхэг тоног төхөөрөмж, 22 ширхэг нийтийн эзэмшлийн байгууламж, 15 нэрийн авто машиныг 1 дүгээр хавсралтанд дурдсан байгууллагуудын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 06 дугаар сарын
17-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллага, аж ахуйн нэр	Шилжүүлэх байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Ашиглалтанд орсон он	Дансны анхны үнэ мян.төг	Байгуулсан элэгдэл мян.төг	Үлдэгдэл үнэ мян.төг	Үндсэн байгууллагын санал	Аймгийн Засаг даргын санал	Аймгийн ИТХТ-ийн шийдвэр
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Сэлэнгийн долгио чуулга	Сэлэнгэ телевиз	Машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	34 ширхэг		35824,8			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
2	Аймгийн ЗДТГ	Орхонтуул сумын Рашаант тосгонд	Хонда маркийн 00-10 СЭА	1 ширхэг	2009	12000,0	3984,0	8016,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
3	Аймгийн ЗДТГ	Орхон сумын ЗДТГ	Марк II 00-09 СЭА	1 ширхэг	2006	6467,1	5367,7	1099,4	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
4	Аймгийн ЗДТГ	Баруунбүрэн сумын байгаль орчны улсын байцаагчийн мэдэлд	УАЗ-31512 маркийн 26-08 СЭА	1 ширхэг	2006	7500,0	6225,0	1275,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
5	Тохижилт үйлчилгээний газар	Мандал сумын ЗДТГ	Мицебуши кантер маркийн 16-05 СЭА	1 ширхэг	2009	8500,0	2822,0	5678,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх

0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
6	Аймгийн Боловсрол соёлын газар	Хүдэр сумын ЗДТГ	Прадо ланд -70 00-15 СБА	1 ширхэг	2006	13857,5	11501,7	2355,8	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
7	Хүдэр сумын ЗДТГ	Аймгийн Боловсрол соёлын газар	Ланд круйзер-80 10-00 СББ	1 ширхэг					Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
8	Сант сумын ЗДТГ	Сант сумын ИТХ	Мицебуши пажеро 93-23 УБА	1 ширхэг	2008	10000,0	4980,0	5020,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
9	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Портер 85-16 СБА	1 ширхэг	2005	4318,1	4318,1	0,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
10	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Портер 85-21 СБА	1 ширхэг	2005	3945,8	3948,8	0,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
11	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	ГАЗ-53 маркийн 77-54 СБА	1 ширхэг	1981	1320,6	1320,6	0,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
12	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Бага оврын трактор	1 ширхэг	2005	2084,6	2084,6	0,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
13	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Чиргүүл	1 ширхэг	2008	300,0	149,4	150,6	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх

0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
14	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Пронтер маркийн 16-81 СБА	1 ширхэг	2009	4200,0	1394,4	2805,6	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
15	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Пронтер маркийн 16-83 СБА	1 ширхэг	2009	4200,0	1394,4	2805,6	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
16	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Мазда маркийн 14-47 СБА	1 ширхэг	2009	15500,0	5146,0	10354,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
17	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	DUNA маркийн 19-47 СБА	1 ширхэг	2009	14000,0	4648,0	9352,0	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
18	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Барилга байгууламж	6 ширхэг		58348,6			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
19	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Тоног төхөөрөмж	8 ширхэг		3240,4			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
20	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Тавилга эд хогшил	8 ширхэг		1050,0			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
21	Тохижилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Нийтийн эзэмшлийн барилга байгууламж	22 ширхэг		2769984,3			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх

0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
22	Тохжилт үйлчилгээний газар	Сүхбаатар сумын ЗДТГ	Бараа материал	138 ширхэг		4830,2			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
23	Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга		Тавилга эд хогшил	12 төрлийн 14 ширхэг		1005,9			Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 60

Сүхбаатар

Г.Бумцэндийн нэрэмжит болгох тухай

Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журмын 6.4 дэх хэсэгт заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1.Шаамар сумын Дулаанхаан тосгоны Ерөнхий боловсролын дунд сургуулийг төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Гончигийн Бумцэндийн нэрэмжит болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 65

Сүхбаатар

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ийн загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 16 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн “Хүндэт тэмдэг”-ийн загварыг 1 дүгээр хавсралтаар, түүний тайлбарыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 06 сарын 29-ний
өдрийн 65 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ийн тайлбар

Тэмдгийн суурийг нуман хэлбэртэй хийж гурван сумыг шигтгэн найман зүгт байрлуулсан нь аймгийнхаа түүх соёлын уламжлалт онцлогт бат бэх хөгжлийг бэлгэдсэн утга санааг илэрхийлнэ. Мөн суурин дээр байрлах хөх дэвсгэртэй сэмжин хээ нь хур бороо элбэг, тариалангийн ургац арвин байхыг бэлгэдсэн утгатай.

Тэмдгийн гол хэсэгт аймгийн бэлгэ тэмдгийг байрлуулсан байна. Бэлгэ тэмдэг нь мөнх ногоон навчин дээр бүхнийг уриалан дуудагч эгшиглэнт дунг цэнхэр хадгаар ороон залсан, тэгш өнцөгт суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлж, дээд хэсэгт нь гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ байрлуулсан дугариг хэлбэртэй, төв хэсэг нь Сэлэнгэ түмний шүтээн болсон Таван хан уул, тариан талбай, Сэлэнгэ их мөрнийг уран сайхны аргаар өнгө хослуулан дүрсэлсэн байна.

Тэмдгийн дээд хэсэгт чандмань эрдэнийн 2 талд “Сэлэнгэ аймаг”, төв хэсэгт ногоон дэвсгэр дээр “Хүндэт тэмдэг” гэсэн үгийг байрлуулсан байна.

Тэмдгийн диаметр 45 мм-ийн хэмжээтэй байна.

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 66

Сүхбаатар

Баяр наадмын төсөв батлах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1.Ардын Хувьсгалын 90 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэх төсвийг 556500,0 мянган төгрөгөөр баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 67

Сүхбаатар

Хөрөнгө зөвшөөрөх тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1.Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Сүхбаатар хотын төв замын засварт зориулан 200000,0 мянган төгрөгийг аймаг хөгжүүлэх сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гарган зарцуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 68

Сүхбаатар

Хөрөнгө зөвшөөрөх тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1.Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Сүхбаатар сумын зам талбайн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлд замын сангаас 60000,0 мянган төгрөг гарган зарцуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дараагийн хуралдаанд оруулан батлуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 69

Сүхбаатар

Төсвөөс хөрөнгө гаргах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн түүхийн ном, гэрэл зургийн цомог, аймгийн “Хүндэт тэмдэг”-ийг аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн өмнө хэвлүүлж, хийлгэх шаардлагатай байгааг харгалзан аймгийн төсвөөс 52500,0 мянган төгрөг гарган зарцуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дараагийн хуралдаанд оруулан батлуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 70

Сүхбаатар

Төлбөрийн хэмжээг бууруулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 62 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Зам, гүүр барилгын “Төгс зам” ХХК-ний гүйцэтгэж байгаа аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэн, Сүхбаатар хотын төв замын засварын ажилд ашиглах уулын болон голын хайрганы төлбөрийн хэмжээг 50 хувиар бууруулан тооцохыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 73

Сүхбаатар

Мэргэжлийн комисс байгуулах тухай

Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 17-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Монгол Улсын засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийг солбицолжуулах, баталгаажуулах” ажлыг аймгийн хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангаж зохион байгуулах үүрэг бүхий мэргэжлийн комиссыг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Мэргэжлийн комиссын дарга: Ж.Эрдэнэбат /Аймгийн Засаг дарга/

Комиссын нарийн бичгийн дарга: Д.Батдэлгэр /Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга/

Гишүүд: Ж.Отгонхүү/ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга /

Б.Батзориг/Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн/
Сумдын Засаг дарга нар

2.Сумдын засаг даргаар ахлуулсан багийн Засаг дарга, газрын Даамал, иргэний төлөөлөл оролцсон салбар комисс байгуулж ажиллахыг сумдын ИТХТэргүүлэгчдэд даалгасугай.

3.Сумдын салбар комисс, ажил гүйцэтгэгч компанийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажлын явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн мэргэжлийн комисст даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 06 сарын 29-ний өдөр

Дугаар 74

Сүхбаатар

Зарим эхчүүдийг Алдарт эхийн
одонгоор шагнуулах тухай

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3,2, 3,3 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж 6-аас доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлж бага хүүхэд нь нэг нас хүрэхэд зургаа ба түүнээс дээш хүүхэдтэй байсан 1 дүгээр хавсралтад дурьдсан 250 эхийг Алдарт эхийн I одонгоор, 4-5 хүүхэд төрүүлж 4-өөс доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлж бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан 2 дугаар хавсралтад дурьдсан 258 эхийг Алдарт эхийн II одонгоор тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 07 сарын 19-ний өдөр

Дугаар 75

Сүхбаатар

**Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр
өргөмжлөх тухай**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1997 оны 72 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгэм, соёлын салбарын хөгжил, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулан, хөдөлмөр, урлаг, спортын гарамгай амжилт гаргаж олон түмэнд хүндлэгдсэн дор дорьдсан хүмүүсийг Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилсүгэй. Үүнд:

- | | |
|---------------------------|---|
| 1. Намжилын Бямбацогт | - Сэлэнгэ аймгийн Ерөө сумын харъяат, Монгол улсын Газар тариалангийн ууган Хөдөлмөрийн баатар |
| 2. Рэгжийбуугийн Нямсүрэн | - Сэлэнгэ аймгийн Мандал сумын харъяат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх |
| 3. Гунаажавын Эрхэмбаяр | - Сэлэнгэ аймгийн Мандал сумын харъяат Сэлэнгэ “Таван хан-Ноён уул” дэвжээ, Сүлд спорт хороо, Ноёд группын бөх, Монгол Улсын арслан |

2. Аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжлөгдсөн дээрх хүмүүсийн шагналыг аймгийн төсвөөс гаргахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 09 сарын 21-ний өдөр

Дугаар 85

Сүхбаатар

Татварын орлогын бүрдүүлэлтийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Татварын орлогын бүрдүүлэлтийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай аймгийн Татварын хэлтсийн дарга Ш.Отгонбаярын мэдээллийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргад ДААЛГАХ нь:

1.Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжиж хөгжүүлэх замаар татварын бааз суурийг нэмэгдүүлэх бодлогын чанартай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, татварын орлогыг бодитой бүрэн тооцон төлөвлөж, биелэлтийг хатуу тооцож байх.

2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй өндөр төлөвлөснөөс биелэх боломжгүй байгааг тодорхой тооцоо судалгаагаар нотолж Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд санал тавьж шийдүүлэх.

3.Газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн НӨАТ-аас чөлөөлөхөөс өмнө үүссэн өрийг чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тавих.

4.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээ бага байгаа талаар аймгийн Татварын хэлтсээс тавьж байгаа саналыг судлан үзэж шаардлагатай гэж үзвэл шинэчлэн тогтоох саналаа аймгийн ИТХ-д оруулах.

Хоёр. Аймгийн Татварын хэлтэс /Ш.Отгонбаяр/-т ДААЛГАХ нь:

1. 2011 онд аймгийн төсөвт орох татварын орлогын төлөвлөгөөний зарим нэр төрөл тасарч байгаад дүгнэлт хийж тодорхой ажил зохион байгуулах.

2. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг бүртгэлд бүрэн хамруулж, хуулиар тогтоосон татвар төлбөрийг бүрэн ноогдуулж хураахад онцгой анхаарч ажиллах.

Гурав. Тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хуулийн дагуу улсын төвлөрсөн төсөвт төлж байгаа татварын орлогын мэдээг сар бүр авч нэгтгэн гаргаж байхыг аймгийн татварын хэлтэс /Ш.Отгонбаяр/, Статистикийн хэлтэс /Д.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 09 сарын 21-ний өдөр

Дугаар 86

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Өргөн хэрэглээний хүнс, бараа тэжээлийн нөөц бүрдүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ХҮНС, БАРАА, ӨВС ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Энэхүү журмын зорилго нь Гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед хүн амыг өргөн хэрэглээний хүнс, малыг өвс тэжээлээр тэргүүн ээлжинд тодорхой хугацаанд хангах хэмжээний нөөцийг аймаг суманд бий болгож хадгалахад оршино.

Хоёр. Нөөц бүрдүүлэх журам

2.1 Аймаг, сум нь Гамшгийн болон онцгой нөхцөл байдла үүссэн үед хэрэглэх өргөн хэрэглээний хүнс, малын өвс тэжээлийн нөөцтэй байна.

2.2 Хүн амын хүнсний нөөцөд:

- мах, махан бүтээгдэхүүн
- гурил
- будаа
- элсэн чихэр
- цай
- давс
- ургамлын тос байна.

Малын тэжээлийн нөөцөд өвс байна.

2.3 Хүнсний нөөцийг аймагт аймгийн хүн амын 30 хувийн наад захын хэрэгцээг 10 хоног хангахаар, суманд хүн амын 30 хувийн наад захын хэрэгцээг 3 хоног хангахад хүрэлцэх хэмжээгээр бүрдүүлнэ.

Малын тэжээлийн нөөцийг нийт малын 50 хувийг 7 хоног тэжээхэд хүрэлцэх хэмжээгээр бүрдүүлнэ.

2.4 Аймаг, сумын нөөцийн бараа бүтээгдэхүүнийг тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг тухайн нутаг дэвсгэрт эрхэлдэг аж ахуйн нэгжийг сонгон тохиролцож гэрээгээр гүйцэтгүүлнэ.

2.5 Хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх гэрээг аймгийн Онцгой байдлын газрын дарга, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх гэрээг аймгийн ХХААЖДҮГ-ын дарга тус тус сонгон авсан аж ахуйн нэгжүүдтэй байгуулж аймгийн Онцгой комиссын даргаар батлуулна.

2.6 Гэрээнд энэ журамд заасан нэр төрөл, тоо хэмжээний бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэн гамшгийн болон онцгой байдал үүссэн үед тухайн үеийн зах зээлийн ханшаар худалдан авахаар тусгана.

Гэрээнд дараах нөхцлийг тусгасан байна:

- Бэлтгэх хүнсний бараа, өвс тэжээлийн төрөл, хэмжээ
- Бэлтгэн нийлүүлэх үнэ, нийлүүлэх хуваарь
- Хүнсний бараа бүтээгдэхүүн хадгалах агуулахын байршил, нөхцөл
- Хүнсний бараа бүтээгдэхүүнд тавигдвал зохих чанар, стандартын шаардлага

- Хадгалах, тээвэрлэх нөхцөл, хугацаа

Гурав. Өргөн хэрэглээний хүнс, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд дараах шаардлага, нөхцлийг тавина:

3.1. Нөөцийн хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

3.1.1. Стандартын шаардлага бүрэн хангасан байна.

3.1.2. Гарал үүслийн гэрчилгээ болон бусад чанар, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдаж баталгаажуулалт хийгдсэн байна.

3.1.3. Үйлдвэрийн аргаар бэлтгэж, боловсруулсан байх.

3.1.4. Стандартын дагуу ангилж, савласан, хаяг шошготой байна.

3.1.5. Өвсний жин нь 20 кг-аас доошгүй, 18 хувиас доошгүй чийгтэй стандартын дагуу боогдсон тухайн жилийн намар бэлтгэсэн байна.

3.1.6. Импортын хүнсний бүтээгдэхүүн нь шинжилгээний бичиг баримттай.

3.2. Нөөцийн хүнсний бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжүүдэд тавигдах шаардлага:

3.2.1. Тухайн барааг үйлдвэрлэх, импортлох бэлтгэн нийлүүлэх өөрийн сүлжээтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулж технологийн дагуу хадгалах, тээвэрлэх нөхцөл бүрдсэн байх

3.2.2. Энэ журамд заасан хэмжээний бүтээгдэхүүний үлдэгдэлтэйгээр үйл ажиллагаа нь тогтмол үргэлжилж ажиллах чадвартай байх

3.2.3. Бараа, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх байнгын түншүүдтэй байх

3.2.4. Хүнсний бүтээгдэхүүн бэлтгэх боловсруулах стандартын шаардлага хангаж, мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, агуулах, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн байх.

3.2.5. Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлээр бүрэн хангагдсан.

3.2.6. Бүтээгдэхүүнийхээ чанар байдлыг мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан байх.

3.2.7. Эрүүл орчинд бэлтгэсэн гарал үүслийн гэрчилгээ баталгаажуулалт бүхий бүтээгдэхүүнийг уламжлалт аргаар боловсруулалт хийдэг малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, бирж байж болно.

Дөрөв. Өргөн хэрэглээний хүнс бараа, өвс тэжээлийн нөөцийн бараа бүтээгдэхүүнийг бэлтгэх, хадгалахад тавих хяналт

4.1. Хүнсний нөөцийн бараа, бүтээгдэхүүнийг бэлтгэх, үйлдвэрлэх явцад тухайн бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэр дотоод хяналтыг тавина.

4.2. Мэргэжлийн хяналтын байцаагч нар засаг захиргаа нутаг дэвсгэрийнхээ харьяаллын дагуу хүнсний нөөцийн бараа бүтээгдэхүүний бэлтгэл, үйлдвэрлэл, тээвэрлэлт хадгалалт, бараа бүтээгдэхүүний чанар байдалд хөндлөнгийн хяналт тавина.

4.3. Аймаг, сумын Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт байрлаж байгаа хүнсний нөөцийн бараа, бүтээгдэхүүний батлагдсан хэмжээ, хадгалалт, хамгаалалт чанар байдалд хяналт тавина.

4.5. Аймгийн Онцгой байдлын хэлтэс Нөөцийн хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх гэрээний биелэлтийг, аймгийн ХХААЖДҮГ нөөцийн өвсний хэмжээг улирал бүр гарган Аймгийн Засаг даргад танилцуулна.

4.6. Өргөн хэрэглээний хүнс бараа, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, хадгалахаар сонгогдсон аж ахуйн нэгж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.

_____oOo_____

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 09 сарын 21-ний өдөр

Дугаар 88

Сүхбаатар

Удирдамж батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Сумын ИТХ-ын ажилтнуудыг харилцан туршлага судлуулах ажлын үлгэрчилсэн удирдамж”-ийг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сумын ИТХ-ын ажилтныг харилцан туршлага судлуулах ажлын үлгэрчилсэн удирдамж

Зорилго: Тухайн сумдын Хурлын ажлын тэргүүн туршлага, ажлын сайн арга барилаас харилцан суралцах замаар сумдын ИТХ-ын ажилтнуудыг сургах дадлагажуулахад оршино.

1. Хурлын ажилтныг харилцан туршлага судлуулах ажлын хэлбэр:

Сэлгэн ажиллуулах гэж 2 сумын Хурлын ажилтныг харилцан туршлага солилцуулах зорилгоор тодорхой хугацаагаар ажлын байран дээр нь сольж ажиллуулахыг ойлгоно.

Дагалдуулан туршлага судлуулах гэж шинээр ажилд томилогдсон, эсвэл ажлын дадлага туршлага багатай шинэ ажилтнуудыг өөр сумын ижил албан тушаалын, туршлагатай ажилтны дагалдуулан туршлага судлуулан дадлагажуулахыг хэлнэ.

2. Сэлгэн ажиллуулах, дагалдуулан туршлага судлуулах санал гаргах, шийдвэрлэх

1.Сэлгэн ажиллуулах, дагалдуулан туршлага судлуулах асуудлыг тухайн сумдын Хурлын Нарийн бичгийн дарга нарын ажлын дадлага, туршлагыг харгалзан аймгийн ИТХ-ын ажлын албаны санал болгосноор сумдын Хурлын дарга нар харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

2.Ажилтнуудыг сэлгэн болон дагалдуулан туршлага судлуулах хугацаа 7-14 хоног байна.

3. Ажилтныг сэлгэн ажиллуулж, дагалдуулан туршлага судлуулж байгаа сумдын Хурлын дарга нарын хүлээх үүрэг

3.1 Сэлгэн болон дагалдан туршлага судлаж байгаа ажилтны цалин хөлсийг үндсэн байгууллагаас нь олгоно. Ажилтанд сэлгэн болон дагалдан туршлага судлах хугацаанд нь томилолтын зардал олгоно.

3.2 Сэлгэн болон дагалдан туршлага судлаж байгаа ажилтныг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, байрлах байрны тусалцаа үзүүлнэ.

3.3 Хурлын ажилтныг сэлгэн ажиллуулах тухай тус тусын Хурлын Тэргүүлэгчдэд болон ЗДТГ-т урьдчилан мэдэгдсэн байна.

3.4 Сэлгэн ажиллуулах хугацаанд тухайн ажилтнаар хийлгэх болон судлан танилцах ажил асуудлын жагсаалтыг гаргана.

4. Сэлгэн ажиллаж байгаа ажилтны хүлээх үүрэг

4.1 Сэлгэн болон дагалдан туршлага судлах ажилтан нь тухайн сумын хурлын даргын удирдлагад, тухайн байгууллагын дотоод журмыг мөрдөж ажиллана.

4.2 Сэлгэн болон дагалдан туршлага судлах ажилтан нь хувийн болон тухайн хугацаанд хийхээр төлөвлөсөн ажлын бэлтгэлийг бүрэн хангаж очно.

4.3 Очсон сумынхаа Хурлын ажилтны ажил үүргийн хуваарьт заагдсан ажил болон тухайн хугацаанд хийхээр төлөвлөсөн ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

4.4 Тухайн сумын Хурлын дотоод ажил / бичиг баримт /-тай танилцаж Хурлын дарга, Нарийн бичгийн даргатай уулзан ярилцаж арга барилаас суралцахыг хичээнэ.

4.5 Тухайн Хурлын дотоод асуудалд дур мэдэн орж болохгүй бөгөөд байгууллагын нууцыг чандлан хадгална.

4.6 Ажиллах хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаар тэмдэглэл хөтлөн, илтгэх хуудас бичиж тухайн сумын Хурлын дарга, Нарийн бичгийн даргад танилцуулан санал солилцоно.

4.7 Сэлгэн болон дагалдан туршлага судлах хугацаанд тухайн сумаас олж мэдсэн, өөрийн суманд авч хэрэглэх, нэвтрүүлэх ажлын туршлага, арга барилын жагсаалт гаргаж Хурлын дарга Тэргүүлэгчдэдээ танилцуулна.

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 10 сарын 19-ний өдөр

Дугаар 93

Сүхбаатар

Ашиглалтгүй барилгыг худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Бугант тосгонд ашиглалтгүй байгаа Монгол Росцветмет нэгдлээс орон нутгийн өмчид шилжиж ирсэн Дамжуулах цэгийн 56 м/кв талбай бүхий тоосгон барилгыг 1000,0 мянган төгрөгөөр үнэлэн тус тосгонд “Нийтийн халуун ус ажиллуулах” төсөл хэрэгжүүлэх хүсэлт гаргасан иргэн Б.Баяраад худалдахыг зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 10 сарын 19-ний өдөр

Дугаар 101

Сүхбаатар

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1."Сэлэнгэ аймгийн Эх нярайн эрүүл мэндийг хамгаалах стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган зохион байгуулж биелэлтийн явц, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар /Ж.Од /-д даалгасугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг тус тусын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж, шаардагдах төсөв хөрөнгийг жил жилийн төсөвт тусган шийдвэрлэж, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратегийн зорилго: Эх, нярайн өвчлөл эндэгдлийг бууруулж, Мянганы хөгжлийн дөрөв, тав дахь зорилтод хүрнэ.

	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа					Шалгуур үзүүлэлт
			2011	2012	2013	2014	2015	
Стратегийн зорилт: 1. Гэр бүл, хамт олон, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид, зорилтот бүлгийнхний Эсэн мэнд амаржихуйн талаарх мэдлэгийг сайжруулж, нийгэм, улс төр, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн, нийгмийн нөөцийг дайчлах.								
1	Бүх шатны шийдвэр гаргагч нар болон Иргэний бүртгэл мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнууд НҮЭМ, Эсэн мэнд амаржихуйн чиглэлээр сургалтад хамруулан, ухуулга сурталчилгаа хийх	АЗДТГ –НХХ Аймгийн Эрүүл мэндийн газар	+	+	+			Сургалтын тоо Сургалтанд хамрагдсан хүний тоо
2	Аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, давтан үр хөндөлтийг бууруулах, сургалт сурталчилгааг зохион байгуулах	Аймгийн ЭМГ, Аймаг, сумдын эмнэлэгүүд		+	+	+		Сурталчилгааны тоо Сургалтанд хамрагдсан хүний тоо
3	Үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч нарт сургалт зохион байгуулах	Аймгийн эрүүл мэндийн газар ЭТАлба Нэгдсэн эмнэлэг		+	+			Сургалтын тоо Сургалтанд хамрагдсан хүний тоо
4	Өсвөр үеийнхэнд чиглэсэн НҮЭМ-ийн мэдээллийг тэдний хэрэгцээ сонирхолд нийцүүлэн	Аймгийн эрүүл мэндийн газар		+	+	+	+	Шинээр нэвтрүүлсэн

	орчин үеийн дэвшилтэт арга хэрэгслэлээр дамжуулан хүргэх	НЭМАлба Сум өрхийн эмнэлэг БСГазар						арга, мэдээ сургалт сурталчилгаа
5	Эх нярайн эрүүл мэнд, өвчлөл эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлийг судалж баримтын хуудас, мэдээ сурталчилгааны материал боловсруулан түгээх	Аймгийн эрүүл мэндийн газар ЭТАлба НЭМАлба Нэгдсэн эмнэлэг		+	+			Хэвлэгдэж тараагдсан сурталчилгааны материал
6	Эх, нярайд нэн шаардлагатай бичил элемент эрдэс бодисоор баяжуулсан хүнс аминдэмээр хангах ажлыг өргөжүүлж нийгмийн эмзэг хэсгийн эх нярайн хооллолтод дэмжлэг үзүүлэх, тэжээлийн дутагдлаас сэргийлэх ажлыг үргэлжлүүлэн явуулах.	Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба ЭТАлба	+	+	+			Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа зардал
Стратегийн зорилт: 2. Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүрэх саад бэрхшээлийг /унааны зардал, бүртгэл, даатгалд хамрагдалт, санхүүгийн болон ёс заншлын саад, алслалт/ бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх.								
7	Мандал сумын нэгдсэн эмнэлэгт эх нярайн зайн оношлогоог нэвтрүүлэх	ЭМЯ ЭНЭШТ Аймгийн эрүүл мэндийн газар	+	+	+	+	+	Зайн оношлогоог нэвтрүүлсэн байдал
8	Эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тусламж, алсын дуудлаганд зарцуулах төсөв, эх, нярайд дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх болон буцаах зардлыг бодитойгоор тооцон, санхүүжүүлэх	ЭМЯ-СХОГ Орон нутгийн ЗДТГ		+	+	+	+	Санхүүжилтийн тооцоо Төсөвт тусгасан санхүүжилт
9	Сум орон нутгийн хүний нөөцийг чадавхижуулж тоног төхөөрөмжөөр хангах	Сумын эмнэлгүүд Орон нутгийн ЗДТГ		+	+	+	+	НҮЭМ-ийн загвар эмнэлгийн тоо

10	Цагааннуур, Баянгол, Бугант тосгоны эмнэлгийг НҮЭМ-ийн загвар эмнэлгийн жишигт хүргэх.	Сумын эмнэлгүүд Орон нутгийн ЗДТГ		+	+	+	+	НҮЭМ-ийн загвар эмнэлгийн тоо
11	Эх нярайд үзүүлэх алсын дуудлага, түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг дээшлүүлэх, багаж тоног төхөөрөмж, эмийн байнгын бэлэн байдлыг хангах./Тоноглогдсон автомашинтай болох/	ЭМЯ Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба		+	+			Тоноглогдсон автомашины хангамж
12	Батлагдсан стандарт удирдамжийн дагуу НҮЭМ-Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, мэргэжилтнийг тогтмол сургах	Аймгийн эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэг	+	+	+	+	+	Сургалтанд хамрагдсан хүний тоо Сургалтын хөтөлбөр
13	Өрх, сум, баг, алслагдсан бүс нутгийн эх, нярайн тусламж үзүүлэгч нарыг оновчтой байршуулж тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг идэвхжүүлэх.	Аймаг сумын ЗДТГ	+	+	+	+	+	Сургагдсан эмч нарын тоо Эмчийн хамгамж
14	Өрх, сум, багийн эмч, эх баригчдыг эх нярайн яаралтай болон нэн шаардлагатай тусламж үйлчилгээний чиглэлээр богино хугацааны сургалтанд бүрэн хамруулж дадлагажуулна.	Аймгийн эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэг	+	+	+	+		Сургалтын хөтөлбөр Сургалтын тоо Сургагдсан хүний тоо
15	Эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүртээмж чанарыг дээшлүүлэхэд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, ТББ-н оролцоог	Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба ЭТАлба	+	+	+			Эх барихуйн тусламж үзүүлж буй хувийн хэвшлийн

	нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах							эрүүл мэндийн байгууллага
Стратегийн зорилт: 3. Эх, нярай эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, нотолгоонд тулгуурласан анагаах ухааны дэвшилтэт шинэ арга технологийг нэвтрүүлэх.								
16	50 ортой амаржих газрын Аймгийн төвд шинээр ашиглалтанд оруулах	Аймгийн эрүүл мэндийн газар		+	+			Ашиглалтанд орсон амаржих газар
17	Амаржих газруудын “Амаржих газруудын бүтэц үйл ажиллагааны стандарт”-ийн дагуу хүний нөөцийг шат дараалалтай бэлтгэх/эмэгтэйчүүдийн эмч 2, нярайн эмч 1, нярайн сувилагч 8/	АЗДТГ Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба		+	+	+		Стандартын хэрэгжилт
18	Амаржих газруудын “Амаржих газруудын бүтэц үйл ажиллагааны стандарт”-ийн дагуу багаж тоног төхөөрөмжийн хэрэгцээг тогтоож хангалтыг хийх	ЭМЯ-СХОГ Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба		+	+	+		Стандартын хэрэгжилт
19	Сумдад төрөхийн өмнөх байруудыг тохижуулан үйл ажиллагааг тогтмолжуулах Пренатал оношлогоо эмчилгээнд орчин үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх	АНЭ Мандал СНЭ		+	+	+	+	Шинээр нэвтрүүлсэн арга технологи
20	Эх нярайн эмнэлгийн тусламжинд шаардагдах нэг удаагийн хэрэгслэлээр бүрэн хангах	Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба Нэгдсэн эмнэлгүүд	+	+	+	+	+	Хангалт
21	Эх, нярайн амь насанд заналхийлсэн ноцтой хүндрэлийн тохиолдлыг бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, жил тутамд үнэлж, зөвлөмжийг хэрэгжүүлэх	Аймгийн эрүүл мэндийн газар ЭТАлба	+	+	+	+	+	Ноцтой хүндрэлийн сан бий болсон байдал, үнэлгээ хийсэн

								тайлан, зөвлөмж
22	Халдварт өвчинтэй жирэмсэн эхэд үзүүлэх өвөрмөц тусламжийг чанаржуулж, хүний нөөцийг чадавхижуулах	Аймгийн эрүүл мэндийн газар ЭТАлба АНЭ	+	+	+			Сургалтын тоо
23	Шинэ хөлдөөсөн сийвэнгийн Мандал, Хөтөл сум дундын нэгдсэн эмнэлэгт нөөцийг бүрдүүлэх	Орон нутгийн ЗДТГ Мандал СНЭ Хөтөл СДНЭ		+	+			2 нэгдсэн эмнэлэгт нөөц бүрдсэн байдал
24	Эх, нярайд тусламж үзүүлж буй эмнэлгийн байгууллагуудын эрүүл ахуй, халдвар хамгааллын журмын мөрдөлтийг тогтмол хянаж эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээг шуурхай авч хэвших.	Аймгийн эрүүл мэндийн газар НЭМАлба ЭТАлба	+	+	+			Үндэсний стандартууд ЭМС-ын тушаалуудын хэрэгжилтийн байдал
25	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн цусны АВО болон резус бүлгийг тодорхойлох, жирэмсэн эмэгтэйчүүдэд давтан тодорхойлох ажлыг бүрэн хийж хэвшүүлэх.	Аймаг, сумын эмнэлгүүд Аймгийн Цусны банк	+	+	+			Үйл ажиллагаа тогтмолжсон байдал
26	Эмч, эмнэлгийн мэргэжилтний цусны аюулгүй байдлын талаархи мэдлэгийг дээшлүүлэх сургалтанд хамруулах	Аймгийн эрүүл мэндийн газар ЭТАлба Аймгийн цусны банк	+	+	+	+	+	Сургалтын хөтөлбөр Сургалтанд хамрагдсан хүний тоо Сургалтын тоо
27	Сумын эмнэлэгт болон яаралтай	Аймгийн эрүүл мэндийн		+	+	+	+	Эмнэлэгүүд дэх цусны

	тохиолдолд, цусны үл нийцэлтэй тохиолдолд хэрэглэх цус орлох бэлдмэлүүдийн нөөцийг бий болгох	газар ЭТАлба Аймгийн цусны банк						үл нийцэлтэй тохиолдолд хэрэглэх цус орлох бэлдмэлийн нөөц бүрдүүлсэн байдал
28	Үргүйдэл, перинатологи, эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэг, андрологи, дурангийн мэс заслын чиглэлээр эмч, мэргэжилтнийг гадаад улс оронд сургах.	ЭМЯ Аймгийн эрүүл мэндийн газар Аймгийн НЭ	+	+	+	+	+	Суралцсан эмч мэргэжилтний тоо
29	Гамшиг осол, онцгой үеийн НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний байнгын бэлэн байдлын төлөвлөгөө"-г орон нутгийн засаг захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрт боловсруулан нөөцийг бүрдүүлэх.	Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба ЭТАлба Аймгийн онцгой байдлын газар АНЭ	+	+	+	+	+	Орон нутаг бүрт нэгдсэн төлөвлөгөө бий болж хэрэгжсэн байдал Нөөц бүрдүүлсэн бэлэн байдлыг хангасан байдал
Бусад								
30	Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлж буй ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг тооцох ажлыг тогтмолжуулах	Аймгийн эрүүл мэндийн газар ЭЗУМАлба ЭТАлба		+	+	+	+	Үнэлгээний тайлан, зөвлөмж

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 11 сарын 15-ны өдөр

Дугаар 108

Сүхбаатар

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлыг сайжруулах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас иргэдтэй ажиллах, иргэдийн санал өргөдөл гомдлыг хүлээн авч судалж шийдвэрлэх талаар хэрхэн ажиллаж байгаа тухай” Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Базаргарьдын мэдээлэл, “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар хийж байгаа ажлын тухай” Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ү.Отгонбаяр нарын мэдээллийг сонсоод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТЭМДЭГЛЭХ НЬ:

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс иргэдтэй ажиллах, иргэдийн санал, хүсэлт гомдлыг барагдуулах чиглэлээр Багийн иргэдийн Нийтийн Хуралд сумын Хурлын Төлөөлөгчдийг оролцуулах, Төлөөлөгчдийн өдөрлөг зохион байгуулж төлөөлөгчдийн ажлын мэдээлэл, тайланг тавиулж, иргэдээс гарсан саналыг нэгтгэн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан байна.

Мөн сумын ИТХ-ын Тэргүүлэгчид сумын нутаг дэвсгэрт Ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн ажлын тайланг хагас бүтэн жилээр сонсон, тэднээс ирүүлсэн санал хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэж холбогдох хууль тогтоомжинд заасан эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түшиг сумын ИТХ, Засаг даргаас гаргасан зарим тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн сумын ИТХ-аас иргэд, аж ахуйн нэгжийн малын бэлчээрийн газрыг хуваарилан сумын нутагт Эрчимжсэн мал аж ахуйн бүсийг тогтоосон, тариан талбайг тойруулан ухсан 6,3 км урт шуудууг булуулсан зэрэг арга хэмжээ авсан байна.

Гэвч эдгээр сумдын ИТХ-ын ажлыг дээрх чиглэлүүдээр шалган танилцахад Алтанбулаг сумын ИТХ нь иргэдтэй ажиллаж, сонгогчидтойгоо уулзсан талаар ажлын тайлан мэдээгээ баримтжуулаагүй, иргэдийн санал, өргөдөл гомдлын бүртгэл хагас дутуу, хяналтын хуудас хөтөлдөггүй зэрэг холбогдох тогтоомж журмыг хэрэгжүүлэх талаар дутагдалтай ажиллаж байна.

Түшиг сумын ИТХ нь аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс гарсан тогтоол шийдвэрийн хүлээн авсан бүртгэлгүй, хяналт сул, албан хэрэг хөтлөлтийн наад захын шаардлага хангаагүй, тогтоол шийдвэрийг иргэдэд сурталчилах таниулах биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тооцож дүгнэх, хариу мэдээлэх талаар хангалтгүй ажиллаж байгааг анхааруулан тэмдэглэж Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2

дахь заалтыг удирдлага болгон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг.Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Д.Базаргарьд/-д даалгах нь:

1.Иргэдээс ирүүлсэн санал өргөдөл гомдлын бүртгэл хяналтыг архив бичиг хэргийн үндсэн шаардлагын дагуу хөтөлж хэвших, өргөдөл гомдлын барагдуулалтын явц байдалд байнгын хяналт тавьж ажиллах,

2. Хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдээ сонсох, тэдний санал бодлыг хурлын шийдвэрт тусгах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээгээ баримтжуулж, хагас бүтэн жилийн тайлан мэдээнд бүрэн тусган тайлагнах,

3. Сумын төвийн болон хилийн боомт орчмын тохижилт, ариун цэвэр, эмх цэгцийг сайжруулах, хил орчмын хүн, машины хөдөлгөөнийг журамтай болгох талаар иргэдээс гарч байгаа саналыг анхааралдаа авч тодорхой ажил зохион байгуулах

Хоёр.Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ү.Отгонбаяр/-т даалгах нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийг нэг бүрчлэн бүртгэлд авч, хяналтын карт хөтлөх, албан хэрэг хөтлөлтийн шаардлагыг ханган, бичиг хэргийн эмх цэгц, боловсруулалтанд анхаарч ажиллах,

2.Тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан биелэлтийг гаргуулж, сум, багийн иргэдийн Хурал, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж, тодорхой төлөвлөгөө хуваарь гарган ажиллаж биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж байх,

Гурав. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт:

1.Нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудлаар иргэдээс амаар болон бичгээр гаргасан саналыг ИТХ, Засаг дарга түүний Тамгын газартайгаа хамтран судлан боловсруулж эрх хэмжээндээ шийдвэрлэх буюу холбогдох байгууллага албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлж хариуг заавал өгч хэвших,

2. Аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэр, иргэдийн өргөдөл гомдлын бүртгэл хяналтыг сайжруулж, биелэлтийн явцад байнгын хяналт тавьж, үр дүнг тооцон хяналт шинжилгээ хийж дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн хагас бүтэн жилээр мэдээлж байх,

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн 2009 оны 82 дугаар тогтоолоор баталсан “Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих журам”-ыг чанд мөрдөж хэрэгжүүлэх

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 11 сарын 15-ны өдөр

Дугаар 110

Сүхбаатар

Ой тэмдэглэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан журмын 3.3-т заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Орхонтуул сумын Ерөнхий боловсролын 12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургуулийн 70 жилийн ойг 2012 оны 11 дүгээр сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойгоо угтаж хамт олны идэвх санаачлагыг өрнүүлэн байгууллага, орчноо тохижуулах, хүүхдийн өсч хөгжих сурах орчин, ажиллагсдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах талаар тодорхой бүтээлч ажил зохион байгуулахыг тус сургуулийн удирдлагад даалгаж, хамт олонд уриалсугай.

3. Ой угтсан ажил болон ой тэмдэглэх арга хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 12 сарын 01-ний өдөр

Дугаар 113

Сүхбаатар

“Ойн дэд хөтөлбөр” батлах тухай

Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Сэлэнгэ аймагт 2012-2021 онд хэрэгжүүлэх “Ойн дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажил арга хэмжээг сонгуулийн бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

ОЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэр томъёоны тайлбар:

Арчилгааны огтлолт: ой бүрэлдүүлж байгаа сайн чанарын модны өсөлтийн тохиромжтой нөхцлийг бүрдүүлж, өндөр бүтээмжтэй ой ургуулах, ойн экологийн үүрэг ач холбогдлыг дээшлүүлэх, завсрын ашиглалтын явцад нэмэлт модыг огтолж ашиглах зорилгоор ой үүсэн бүрэлдсэн үеэс эхлэн үндсэн ашиглалтын нас гүйцэх хүртэл тодорхой давтамжтай хийдэг түүвэрлэсэн огтлолт.

Ашиглалтын ойн бүс: Ойн экологийн ач холбогдлыг хадгалж үндсэн ашиглалтын огтлолт хийх зориулалттай ой. Ашиглалтын ойн бүсэд хамгаалтын бүсээс бусад ой хамаарна.

Ой зохион байгуулалт: ойн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүний хэмжээ, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагаа.

Ой менежментийн төлөвлөгөө: Тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичиг.

Ойн нөхөрлөл: Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилгоор зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй иргэдийн сайн дурын байгууллага.

Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ: Ойн нөөцийн чанар, хэрэглээний экологи-эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг.

Нэг: Сэлэнгэ аймгийн ойн сангийн өнөөгийн байдал

Талбай. Ойн сангийн нийт талбай 1931156 га

Ойн сангийн талбайг газрын төрлөөр ангилахад байгалийн ой 1441041 га, таримал ой 1534 га, бут сөөг 42109 га, түймэрт нэрвэгдсэн ой 256929 га, тармаг модод 93863га, мод бэлтгэсэн талбай 28198 га, ойжуулсан 5424 га, байгалийн аясаар ойжиж байгаа 20403 га, хөнөөлт шавжид нэрвэгдсэн 282 га, салхи цасанд унасан 893 га, ашигт малтмалын олборлолт явагдсан 3654 га, цагаан энгэр 75976 га, намаг 714га, таг царам 3729 га, түймрийн болон цахилгаан дамжуулах шугамын халз зурвас 41 га, МҮГ 9 га талбайг эзэлж байна.

Ойн сангийн талбай аймгийн нийт нутаг дэвсгэрийн 43.6 хувийг эзэлж байна.

Нөөц. Байгалийн ойн нийт нөөц 168315520 шоометр бөгөөд зонхилогч модны төрөл тус бүрээр авч үзвэл: Шинэс 59372500 шоометр, Хуш 32411620 шоометр, Нарс 36355490 шоометр, Гацуур 873910 шоометр, Жодоо 236280 шоометр, Хус 38223560 шоометр, Улиас 137970 шоометр, Улиангар 322030 шоометр, Хайлаас 950 шоометр, Бургас 381210 шоометр нөөцтэй байна. Нийт нөөцийн 67,8 хувь буюу 114 134 640 шоометрийг нас гүйцсэн ой эзэлж байна.

Ашиглалтын бүсийн байгалийн ойн нийт талбай 902199 га, нөөц 116739610 шоометр бөгөөд жилд түүвэрлэх огтлолтоор 2971 га талбайгаас 63308 шоометр мод бэлтгэх боломжтой.

Ойн аж ахуйн арга хэмжээ

Тус аймагт арчилгааны огтлолтыг 19746 га, цэвэрлэгээг 253814 га, ойжуулалтыг 207968 га, байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээг 200259 га талбайд тус тус хэрэгжүүлэх шаардлагатай.

Ойн сангийн ерөнхий төлөв байдлаар сайн мэт харагдавч цаашид зайлшгүй ойн сангийн талбайд ойн арчилгаа, цэвэрлэгээ хийж уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон таваарлаг чанар сайтай ой бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлж байгаль орчин, ойн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход оршино.

Хөтөлбөрийн зорилт:

Нэг. Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хохирлыг арилгах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, ойн үр өгөөжийг дээшлүүлэх, ойг хамгаалах ажилд дэвшилтэт технологи нэвтрүүлэх.

Хоёр. Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлэх, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбайг нэн тэргүүнд ойжуулах, цөлжилт элсний нүүлтэнд өртсөн талбайд ногоон зурвас байгуулах, тариалангийн талбайг салхи, ус, элсний нүүлтээс хамгаалсан хамгаалалтын ногоон зурвас байгуулах, ойжуулалт нөхөн сэргээлтийг өөрийн

хөрөнгөөр хийсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах, урамшууллын системийг боловсронгуй болгох.

Гурав. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор урт богино хугацааны аян, хөдөлгөөнийг өрнүүлж олон нийтийг энэ ажилд өргөнөөр татан оролцуулах.

Дөрөв: Ойн нөөцийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, мод боловсруулах шинэ техник технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Тав: Ойн салбарын менежмент, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн чадавхийг дээшлүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх.

Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Үүнд:

1 дүгээр үе: 2012-2016 он

2 дугаар үе :2016-2021 он

Дөрөв: Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

1.1.Ойн сангийн өөрчлөлтийг тогтмол бүртгэж өөрчлөлтийг ой зохион байгуулалтын материалд тусгаж байх.

1.2.Ой зохион байгуулалтын материалыг иж бүрэн ашиглаж ойн алба /нэгж/, ойн ангийн үйл ажиллагаа бүтэц орон тоог нэмэгдүүлж,тэдгээрийг чадавхжуулах олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэх, дэмжиж ажиллах.

1.3. Модны өсөлт, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээг ойн мэргэжлийн болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад түшиглэн ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг хамруулах замаар гүйцэтгэх.

1.4. Түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх.

1.5. Улсын хилийн бүс, зарим шаардлагатай газруудад түймрээс хамгаалах харлуулсан шороон зурвас татах, ойн унанги болон шатах материалыг нэн даруй

цэвэрлэх ажлыг зохион байгуулах зэргээр түймрийн гаралт, тархалтыг хязгаарлах арга хэмжээ авах.

1.6. Сансраас тандах судлах судалгааны зургийг ашиглах сургалтанд холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулах, шинээр гарсан, шинэчлэгдсэн программ хангамж, техник тоног төхөөрөмжийг цаг үетэй холбон түргэн шуурхай шинэчлэх.

1.7. Сумдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх харуул, хэсэг зохион байгуулж, холбооны болон түймэр унтраах техник, багаж хэрэгслээр хангах, түймрийн харуулын цамхаг босгох.

1.8. Түймрийн аюултай үед байнгын морьт эргүүл ажиллуулах, нутгийн иргэдэд түшиглэсэн ой хамгаалах менежментийг хөхүүлэн дэмжих, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах.

1.9. Ойн хөнөөлт шавжийн тархалт, олшролын судалгааг тогтмол хийлгэж хөнөөлийн хэмжээ, хохирлыг нарийвчлан тогтоож урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх.

1.10 ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлыг эхний ээлжинд хөнөөлт шавж, ойн түймэрт өртсөн талбайд хийх, ойн хөнөөлт шавжийн тухай сургалт, сурталчилгааг тогтмол хийж, гарын авлага, зөвлөмжөөр мэргэжлийн байгууллага, ард, иргэдийг хангаж ажиллах.

1.11. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийн ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар ойн хөнөөлт шавжийн тархалт, олшролын анхан шатны мэдээллийг авах.

1.12 Мод орлуулах эх үүсвэрийг бий болгох бүхий л гарцыг хайх, барилгын материал, төмөр замын дэр модонд мод ашиглахыг жил бүр бууруулах, түлшний нөөц багатай, ойгүй сумдад хийн түлш, шахмал түлш, хөрзөн зэрэг түлш орлуулагчийг ашиглахыг нэмэгдүүлэх, түлш орлуулагчийг үйлдвэрлэж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг хөхүүлэн дэмжиж, урамшуулах.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.1 Аймгийн ой зохион байгуулалтын материал, газрын хянан баталгааны дүн, газрын нэгдмэл сангийн тайлан, цөлжилтийн судалгаа зэргийг үндэслэн ойжуулалт нөхөн сэргээлт хийх шаардлагатай газрын судалгаа гаргаж, түүнийг

үндэслэн байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувийг ойг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөх, хэрэгжүүлж ажиллах.

2.2 Чанар сайтай тарьц, суулгацын нөөц бий болгох зорилгоор байгуулсан мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг бодлого болон материаллаг талаар дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулах.

2.3. Өөрийн орон нутагт нутагшсан сайн чанарын тарьц суулгацаар ойжуулалт, ойн зурвас байгуулах, тариалангийн талбай хамгаалах зурвас байгуулах ажиллагааг хангаж ажиллах.

2.4 Жил бүр нийтээр мод тарих өдрийг хавар, намрын улиралд өрнүүлж төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, автозамын дагуу хамгаалалтын зурвас байгуулах.

2.5 Байгаль цаг уурын дулааралтай холбоотойгоор үрийн чанарыг сайжруулах зорилгоор үрийн плантаци байгуулах асуудлыг жил бүрийн нийгэм эдийн засгийн хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган шийдвэрлэж байх.

2.6 Бэлчээр тариалангийн талбайг хөрсний элэгдэл, цөлжилтөөс хамгаалах бэлчээрийн болон хөдөө аж ахуйн таримал ургамлыг нэмэгдүүлэх зорилго бүхий ойн зурвас, төгөл, ногоон хаалт ургуулахад ашиглах ганд тэсвэртэй модны төрөл зүйлийг сонгож, тэдгээрийг тарьж ургуулах агротехникийг боловсруулан хэрэгжүүлж ажиллах.

2.7 Тусгай хамгаалалтай газар нутгийн ойн менежментийг хөгжүүлэх, ойтой нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, ойн хөрс, ус хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар судалгаа явуулж, үр дүнг нэвтрүүлж ажиллах.

2.8 Хөтөлбөрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгийг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх замаар авч ажиллах.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

3.1 Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд олон нийтийн оролцоог хангаж ажиллах.

3.2. Гудамж талбайг алдартай хүмүүсийн нэрэмжит болгон ногоон байгууламж бий болгох, байгаа ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.3. Шинээр баригдсан барилга байгууламжийг ногоон байгууламжийн хамт хүлээн авч хэвших.

3.4 бүтээн байгуулалтаар хийгдсэн томоохон цогцолборуудын ногоон байгууламжийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хуваарилан цэцэрлэгжүүлэх.

3.5 Өөрийн хөрөнгөөр ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг урамшуулах, урамшуулалын системийг боловсронгуй болгох.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.1 Ойн сангийн талбайд ойн аж ахуйн арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлэх чадвар, техник технологи бүхий аж ахуйн нэгж байгуулагад ойн санг гэрээгээр эзэмшүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

4.2 Ашиглалтын насанд хүрээгүй болон болц гүйцээгүй залуу ойд огтлолт явуулах үйл ажиллагааг таслан зогсоох.

4.3 Ойн нөөц багатай болон ойн нөөцгүй сумдын түлшний модны асуудлыг ой бүхий сумдаас “Ногоон ажлын байр”, “Цэвэр ой” хөтөлбөрүүдийн хүрээнд ойд цэвэрлэгээ хийх замаар бэлтгүүлэн хангах.

4.4 Ашиглалтын бүсийн ойн зам барьж байгуулах ажлыг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих замаар хэрэгжүүлэх.

4.5 Мод, модон материалын импортыг дэмжих бодлого баримталж ажиллахын зэрэгцээ импортын мод, модон материалыг нэмүү өртгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан холбогдох газарт хүргүүлэх.

4.6 Хөдөөгийн малчид, иргэдийн өргөн хэрэгцээний модон эдлэл, гэрийн мод үйлдвэрлэх уламжлалт аргыг орчин үеийн технологитой хослуулсан жижиг, дунд үйлдвэр байгуулахыг дэмжих.

4.7 Ойн химийн үйлдвэрлэлийн бүхий л талаар дэмжин ажиллахын зэрэгцээ наамал, зүүмэл хавтан, фанер, мебелийн хуулга үйлдэрлэх дэвшилтэт технологи бүхий үйлдвэр шинээр байгуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх.

4.8 Байгалийн дагалт баялгийн нэр төрөл нөөцийг тогтоож, тэдгээрийг ашиглах, боловсруулах заавар зөвлөмж гарын авлага боловсруулан олон нийтэд хүргэж өрхийн орлого нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах.

Тавдугаар зорилтын хүрээнд:

5.1 Ойн салбарын орон нутаг дахь бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох шат дараалсан арга хэмжээ авах.

5.2 Ойн салбарын боловсон хүчнийг ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллага, ойн аж ахуй, ойн анги, ойн алба /нэгж/- ны хэмжээнд бэлтгэн чадавхижуулах.

5.3 Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудыг ойн мэргэжлийн боловсон хүчнээр хангах.

5.4 Ойн ашиг тус, хүлэмжийн хийн хэмжээг багасгах, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийн ойд учруулах хор хөнөөлийг бууруулах талаар хийж буй ажлуудыг судлах, туршлага солилцох, энэ чиглэлээр гадаад дотоодын туршлага судлах.

5.5 Ойн сангийн талбайд хууль бус ашиглалт явуулахыг таслан зогсоож, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, идэвхтэн байгаль хамгаалагчийн ажлын уялдааг хангаж ажиллах.

5.6 Хууль бус мод бэлтгэл, ашиглалтыг таслан зогсоох зорилгоор байгаль хамгаалагчдыг богино холбооны хэрэгсэл, бие хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажиллахын зэрэгцээ иргэдийг байгаль хамгаалах ажилд татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох.

Зургаа: Биологийн төрөл зүйлийг хамгаалах

6.1 Ойн нөөц болон ангийн нөөцийг хамгаалах ажлыг нутгийн иргэдэд түшиглэн хөгжүүлж, ойн санг гэрээгээр эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч бүхий л талаар дэмжиж ажиллах.

6.2 Агнуурын амьтныг хамгаалах биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6.3 Аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, ан амьтны тархалт, байршлын судалгаа хийлгэх, амьтны тоо толгойн өсөлт, хорогдлыг тодорхой болгож, хамгаалах, зүй зохистой ашиглах

бодлогыг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ажиллах.

6.4 Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар олон нийтэд сургалт сурталчилаа явуулах.

Долоо: Хөтөлбөрийн үр дүн

7.1 Ойн салбарын бүтэц зохион байгуулалт сайжирч, ойн мэргэжлийн боловсон хүчин чадавхин, ойн мэргэжлийн байгууллагууд чанаржина.

7.2 Ойн түймэр, хөнөөлт шавж, тэдгээртэй тэмцэх хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг багасгах нөхцөл бүрдэнэ.

7.3 Ойжуулалт нөхөн сэргээлтийн ажилд шинэ техник технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон бодлоготой уялдуулан хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа хангагдана.

7.4 Ойн нөөцийн ашиглалт хамгаалалт сайжирч зохистой хэрэглээ бий болж огтолсон модны ашиглалтын түвшин дээшилж, бүтээгдэхүүний чанар, нэр төрөл нэмэгдэнэ.

7.5 Ойн салбарын үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоо, идэвхи санаачлага дээшилж, ногоон ажлын байр бий болж, өрхийн орлого нэмэгдэнэ.

7.6 Мод сөөгний үрийн байнгын нөөцтэй болж, ойжуулалтанд шаардагдах тарьц, суулгацын хэрэгцээг бүрэн хангана.

7.7 Шинээр мод бэлтгэсэн талбайг бүрэн ойжуулахын зэрэгцээ ойн түймэр, хөнөөлт шавж өвчин, түймэрт нэрвэгдсэн талбайн 20 хүртэл хувийг ойжуулна.

7.8 Бэлчээр, тариалангийн талбайг хөрсний элэгдлээс хамгаалах, ургац нэмэгдүүлэх, цөлжилтийг сааруулах экологи, нийгэм, эдийн засгийн тааламжтай нөхцөл бүрдэнэ.

7.9 Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогын тодорхой хэсгийг ойжуулалт, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулдаг болно.

Долоо: Санхүүжилт, хяналтын тогтолцоо

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

7.1. Улс, аймгийн төсвийн хөрөнгө

7.2. Гадаад дотоодын хөрөнгө оруулалт

7.3.Ойжуулалт, нөхөн сэргээлтийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдах замаар санхүүжигдэх

7.4. "Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээ" хуулинд заагдсан хөрөнгийн тодорхой хувиар санхүүжих

7.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахдаа "Байгаль хамгаалах сан" байгуулах замаар ойжуулалт, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах

7.6 Хөтөлбөрийн хэрэгжилтийг стратегийн зорилт болон үйл ажиллагааг хүрсэн үр дүнгээр нь үнэлэх бөгөөд шалгуур үзүүлэлтийг суурь мэдээ, зорилтот нөхцөл, гарах үр дүнгийн тоон үзүүлэлтийг үе шат бүрт нийцүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

oOo

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 12 сарын 01-ний өдөр

Дугаар 118

Сүхбаатар

Сүм хийдийн талаар авах зарим арга
хэмжээний тухай

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдүүдэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТЭМДЭГЛЭХ нь:

Шалгалтад тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Буддын шашны 14, Христийн 31 нийт 45 сүм хийд хамрагдсанаас зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа 9, зөвшөөрлийн хугацаагаа сунгуулаагүй 19 сүм хийд байна.

Шалгалтаар зарим сүм хийдийн ахлагч, удирдлагууд сүм хийдийн үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх хууль тогтоомжийн талаар мэдлэг, ойлголтгүй, ямар ч зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах, зөвшөөрлийн хугацаагаа сунгуулаагүй, шаардлагатай бичиг баримтын хөтлөлт, бүрдэл дутуу, сүм хийдийн дотоод журам болон удирдлага, зохион байгуулалтанд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгддэггүй зэрэг зөрчил дутагдал байгааг тэмдэглэн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт **ДААЛГАХ** нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа 1 дүгээр хавсралтад дурдсан сүм хийдүүдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авах;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан боловч зөвшөөрлийн хугацаагаа сунгаалаагүй 2 дугаар

хавсралтад дурдсан сүм, хийдүүдийн удирдлагад албан ёсоор мэдэгдэл шаардлага өгч зөвшөөрлийн хугацааг 2012 оны эхний улиралд багтаан сунгуулах;

3.Нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдүүдийн үйл ажиллагаанд шашны төрөл, урсгал, номлолыг үл харгалзан орон нутгийн зүгээс тавих бүртгэл хяналтыг сайжруулах, сүм хийдүүдтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцаж хамтран ажиллах;

Хоёр.Сүм хийдүүдийн ахлагч, удирдлагуудад ДААЛГАХ нь:

1.Сүм хийд, шашны үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж дагаж мөрдөн, шаардлагатай бичиг баримт, дүрэм, журмын бүрдлийг ханган ажиллаж, тухайн нутаг дэвсгэрийнхээ засаг захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллах;

2. Дотоод дүрэм, журам, сүм хийдийн удирдлага, зохион байгуулалтад орсон өөрчлөлтийг тухай бүр, үйл ажиллагааны тайланг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 148 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлж хэвших.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 119

Сүхбаатар

Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх талаар байгууллага дээрээ зохиож байгаа ажлын тухай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Д.Батдэлгэр, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Энхсайхан нарын мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь байгууллагынхаа дэргэд Авлигатай тэмцэх орон тооны бус зөвлөлийг 11 хүний, Ёс зүйн хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж “Авлигаас ангид ёс зүйтэй хяналтыг төлөвшүүлэх” мэдэгдлийг ёсчлон мөрдүүлэхээр улсын байцаагчаар гарын үсэг зуруулан, авлигаас урьдчилан сэргийлэх, албан хаагчийн ёс зүйн асуудлаар сургалт сурталчилгааны ажлыг тогтмол хийж хэвшсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган сургалт сурталчилгаа тогтмол хийж, төрийн албаны ёс зүйтэй холбоотой зөрчил дутагдал гаргасан зарим сумын газрын даамалд арга хэмжээ авч хариуцлага тооцсон байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх талаар байгууллага дээрээ зохиож байгаа ажлаа улам эрчимжүүлж ажил үйлчилгээгээ нээлттэй, ил тод явуулж, авлигаас ангид аливаа хардлага сэрдлэгэд өртөхгүй байхаар зохион байгуулан ажилтнууддаа ёс зүйн өндөр шаардлага тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга нарт даалгасугай.

Хоёр. Аймгийн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын дарга нарт ДААЛГАХ нь:

1.Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулан ажиллах;

2.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм болон тус тусын салбар байгууллагын ёс зүйн дүрмийг ажилтан албан хаагчиддаа чанд мөрдүүлэн ажиллах;

3.Байгууллага дээрээ мөрддөг дүрэм, журам, явуулж байгаа үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй болгох;

4.Албан хаагчдынхаа хөрөнгө орлогын мэдүүлэгийг хуулиар тогтоосон хугацаанд үнэн зөв гаргуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэх мэдээлэх ажлыг сайжруулах;

5.Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэдтэй эелдэг, хүндэтгэлтэй харьцаж, ялгаваргүй адил тэгш хандаж хүнд суртал, чирэгдэлгүй шуурхай үйлчлэх соёлыг ажилтнууддаа төлөвшүүлэх.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 120

Сүхбаатар

2012 онд үйлдвэрлэлийн зориулалттай хэрэглээний
мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай

Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-321 тоот тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрээс 2012 онд арчилгааны огтлолтоор үйлдвэрлэлийн зориулалттай бэлтгэх хэрэглээний мод, цэвэрлэгээний журмаар бэлтгэх модны дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Мандал сумын нутагт цэвэрлэгээний журмаар бэлтгэх түлээний модыг ойн санг эзэмшигч нөхөрлөлүүдээр өөрийн ойн сандаа цэвэрлэгээ хийх замаар бэлтгүүлэхийг Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд даалгасугай.

3.Сумын хэмжээнд үйлдвэрлэлийн зориулалтаар /арчилгааны огтлолт/ бэлтгэсэн модны 20-иос доошгүй хувийг хэрэглээний модны зөвшөөрөлгүй бусад сумдын иргэдийн хэрэгцээнд худалдан борлуулахаар мод бэлтгэх гэрээнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Мандал, Ерөө, Хүдэр, Алтанбулаг,Түшиг сумдын Засаг дарга, мод бэлтгэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4.Ойн сангийн нөөцгүй Сүхбаатар, Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул Сайхан, Шаамар зэрэг сумдын Засаг дарга нар нутаг дэвсгэрээс нь мод бэлтгэхээр энэ тогтоолд заасан хөрш зэргэлдээ сумдын Засаг дарга нартай тохиролцон түлшний мод бэлтгэх гэрээ хийж харилцан үүрэг хүлээж хамтран ажилласугай.

5.2012 онд бэлтгэх модны хуваарь хийхдээ Ойн тухай хуулийн 27.2 дүгээр зүйлд заасны дагуу өмнөх онуудын мод бэлтгэсэн талбайдаа өөрийн хөрөнгөөр хийсэн ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд дэмжих ажлын гүйцэтгэлийг

харгалзан үзэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга нарт даалгасугай.

6.Энэ тогтоолд заасан хэрэглээний модны баталсан хязгаарт багтаан зөвшөөрөл олгож, зөвхөн ойн мэргэжлийн байгууллагуудаар бэлтгүүлэн хяналт тавьж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/ нарт тус тус үүрэг болгосугай.

7.Энэ тогтоолын биелэлтэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

8.Ойгоос мод бэлтгэх ажлыг холбогдох заавар журмын дагуу гүйцэтгүүлж, бэлтгэсэн модны 100 м³ тутамд өөрийн хөрөнгөөр 2 га талбайд ойг тарьж ургуулах, 3 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг гүйцэтгүүлэхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт үүрэг болгосугай.

9.2012 онд сумдад хуваарилсан үйлдвэрлэлийн зориулалттай хэрэглээний модны бэлтгэл, зарцуулалтын дүнг нэгтгэж 2011 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын
27-ны өдрийн 120 дугаар тогтоолын хавсралт

СУМДАД 2012 ОНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН АХУЙН ЗОРИУЛАЛТАЙ
ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭХ ХУВААРЬ

№	Сумын нэр	Бэлтгэх сумын нэр	Үндсэн ашиглалтын огтлолтоор бэлтгэх үйлдвэрлэлийн зориулалтай хэрэглээний мод/шоо.метр/			Үүнээс /шоо метр/				Нийт модны хэмжээ Шоо.метр				Ойжуулах талбайн хэмжээ /га/	
						Арчилгааны огтлолтоор бэлтгэх мод /шоо.метр/		Цэвэрлэгээни й огтлолтоор бэлтгэх мод /шоо.метр/							
						Нарс	Шинэс	хус	Хэрэглээний нойтон мод	Түлээ	Хэрэглээний хуурай мод	Түлээ	Хэрэглээний нойтон мод		
1	Алтанбулаг	өөрийн нутгаас						4000	4000		4000	4000	8000	80	120
2	Баруунбүрэн	өөрийн нутгаас						1000	3000		1000	3000	4000	20	30
3	Баянгол	өөрийн нутгаас							4500			4500	4500		
4	Ерөө	өөрийн нутгаас	5000	6000	2000	1000	5000	1000	6000	14000	1000	11000	26000	300	450
5	Жавхлант	Ерөө сумын нутгаас							2000			2000	2000		
6	Зүүнбүрэн	Цагааннуур, Түшиг сумаас							4000			4000	4000		
7	Мандал	өөрийн нутгаас		6400		2000	5000	12900	11000	8400	12900	16000	37300	426	639
8	Орхон	Сант сумын нутгаас							1000			1000	1000		
9	Орхонтуул	Баруунбүрэн сумаас							3000			3000	3000		
10	Сайхан	Баруунбүрэн сумаас							5000			5000	5000		

11	Сант	Өөрийн нутгаас						1000	2000		1000	2000	3000	20	30
12	Сүхбаатар	Алтанбулаг, Түшиг сумаас							30600			30600	30600		
13	Түшиг	Өөрийн сумаас				3000	2000	3000	2500	3000	3000	4500	10500	120	180
14	Хушаат	өөрийн нутгаас							2500			2500	2500		
15	Хүдэр	өөрийн нутгаас	2000		1000			3000	5000	3000	3000	5000	11000	120	180
16	Цагааннуур	өөрийн нутгаас				1000		1000	3500	1000	1000	3500	5500	200	300
17	Шаамар	Цагааннуур сумаас							3500			3500	3500		
18	Улсын төвлөрсөн хэрэгцээнд	Ерөө сумын нутгаас	5000	10000						15000			15000	300	450
	Нийт		12000	22400	3000	7000	12000	26900	93100	44400	26900	105100	176400	1586	2379

Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 121

Сүхбаатар

Аймгийн “Аялал жуулчлалын хөтөлбөр”-ийг
хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хууль, төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлого болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудыг хангах, аймгийн “Аялал жуулчлалын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аялал жуулчлалын салбарын хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн Газраас аялал жуулчлалын талаар баримтлах бодлого чиглэлийг аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах зорилго бүхий аймгийн аялал жуулчлалын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Алтанбулаг сумын “Сайхны хөтөл”, Баруунбүрэн сумын “Амарбаясгалант хийд”, Мандал сумын “Ноён уул”, Шаамар сумын “Ээж мод” зэрэг байгалийн үзэсгэлэнт болон түүхт соёлын дурсгал, уламжлалт зан үйлтэй холбоо бүхий аялал жуулчлалын стратегийн нөөцүүдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын стратегийн нөөцийг нөхөн сэргээн тохижуулж, хамгаалан ашиглах, менежментийг сайжруулах ажлыг холбогдох сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэхийг аймгийн Аялал жуулчлалын зөвлөлд даалгасугай.

3. Сумын бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан бүсийн сумдын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ, маршрутыг бий болгон хамтран хэрэгжүүлэхийг Бүсийн зөвлөл, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Экотуризмыг хөгжүүлэх замаар орон нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалын төрөл бүрийн үйлчилгээг дэмжин хөгжүүлэхийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.

5. Гадаад дотоодын хандивлагч, хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн баримт бичигт аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэмжих талаар тусган хэрэгжүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 27-ны
өдрийн 121 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН БАТЛАХ ТУХАЙ

Аймгийн аялал жуулчлалын зөвлөлийн тэргүүн:

- Аймгийн Засаг даргын орлогч

Аймгийн аялал жуулчлалын зөвлөлийн нарийн бичгийн дарга:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн аялал жуулчлалын зөвлөлийн гишүүн:

- Аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- ХХЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь Хилийн төлөөлөгч
- Аймгийн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дарга
- Аймгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын захирал
- Аймгийн Боловсрол, соёлын газрын дарга
- Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
- Тужийн Нарсны БЦГ-ын Хамгаалалтын захиргааны дарга
- Аялал жуулчлал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөлөл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 27-ны
өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хууль, тогтоомж, аялал жуулчлалын талаар баримтлах бодлого, чиглэлийг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах зөвлөлийн харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын зөвлөл /цаашид зөвлөл гэх/ нь Монгол Улсын аялал жуулчлалын тухай хууль, тогтоомж, аялал жуулчлалын харилцааг зохицуулахтай холбоотой гарсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэр түүнчлэн энэхүү журмыг мөрдлөгө болгон ажиллана.

Хоёр. Зөвлөлийн эрх

- 2.1. Аялал жуулчлал эрхлэхтэй холбоотой аливаа асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын тамгын газарт санал оруулах
- 2.2. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны биелэлтэнд хяналт тавих, санал дүгнэлт гаргах, хэрэгжүүлэх шатанд шаардлага тавих
- 2.3. Аялал жуулчлалын үйл ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх үүсгэл санаачлага, оролцоог нь үнэлэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах
- 2.4. Аймгийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг аялал жуулчлалын нөөц бүсэд хамруулах талаар аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал оруулах
- 2.5. Зөвлөл нь дэргэдээ аялал жуулчлалын сан байгуулаж аялал жуулчлалын талаар баримтлах аливаа бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ, олон талт үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

Гурав. Зөвлөлийн үүрэг

- 3.1. Монгол Улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын хэрэгжилт орон нутагт ямар байгаа талаар хяналт тавьж, шаардагдах арга хэмжээ авах талаар зөвлөмж гаргах
- 3.2. Аялал жуулчлал эрхлэх, түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачлагыг дэмжих
- 3.3. Тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих талаар тодорхой асуудал, арга хэмжээг тусгаж, санал дүгнэлт гаргах, зарцуулах хөрөнгийг тусгах
- 3.4. Аймгийн аялал жуулчлалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

Дөрөв. Зөвлөлийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 4.1. Зөвлөл нь аймгийн төр, захиргааны байгууллага болон аялал жуулчлал эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлөх эрх бүхий төрийн бус байгууллага, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9-12 гишүүнтэй байна.
- 4.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал байх бөгөөд гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэйгээр хуралдан, 51-ээс доошгүй хувийн саналаар хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.3. Хэлэлцэж буй асуудлуудтай холбогдуулан мэргэжлийн хүмүүс, ажлын хэсгийг хуралдаанд оролцуулж болно.
- 4.4. Зөвлөл нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг үндэслэн санал, дүгнэлт, зөвлөмж гаргана.

Тав. Зөвлөлийн хамтын ажиллагаа

Зөвлөл нь аялал жуулчлалын асуудлаар аялал жуулчлалын байгууллага, бүс нутаг, олон улсын түвшинд дурдсан хэлбэрээр хамтран ажиллана.

- 5.1. Аялал жуулчлалын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох, хэлэлцүүлэг хийх, хамтарсан сургалт зохион байгуулах;
- 5.2. Аялал жуулчлалын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;

- 5.3. Аялал жуулчлалын асуудлаар бүс нутгийн хамтын ажиллагааны үндэс суурийг тавьж, цаашид хамтын ажиллагаагаа хөгжүүлэх;
- 5.4. Олон улсын түвшинд ялангуяа хилийн боомтоор иргэд харилцан зорчдог ОХУ-ын Буриад улсын төр, захиргааны байгууллагуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцээр хийх, тохиоролцоонд хүрэх, хамтран ажиллах талаар санаачлагатай ажиллах.

_____оОо_____

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 122

Сүхбаатар

**Сүхбаатар сумын иргэдийн түлшний хэрэгцээг
хангах зарим арга хэмжээний тухай**

Сүхбаатар сум нь 6000 шахам өрхтэй бөгөөд тэдгээрийн 70 хувь нь галладаг орон сууцанд амьдарч байна.

Сүхбаатар сум нь нутаг дэвсгэр багатай ойн нөөцгүй учир түлшний модоо Алтанбулаг, Түшиг сумын нутгаас талдаа 60-100 км зайтай газраас бэлтгэдэг, ихэнх айл өрх өөрийн унаагүй, худалдан авах гэхээр үнэ өртөг өндөр зэргээс иргэд түлээ түлшээ бэлтгэхэд хүндрэл бэрхшээл учирсаар байна.

Сүхбаатар сумын албан байгууллага, айл өрх, иргэдийн өсөн нэмэгдэж байгаа түлшний хэрэгцээг хангах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тужийн нарсны байгалийн цогцолборт газраас ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх замаар түлшний мод бэлтгэж иргэдийн түлшний хэрэгцээнд нийлүүлэх асуудлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тавьж шийдвэрлүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт даалгасугай.

2.Алтанбулаг сумын нутаг Хонгорморьтоос Хайлаастын ам хүртэлх улсын хилийн дагуух ойгоос арчилгаа, цэвэрлэгээний журмаар унанги мөчир, хожуул бэлтгэн зөвхөн ердийн хөсгөөр тээвэрлэн түлээнд ашиглахыг зөвшөөрч энэ талаар журам боловсруулан батлуулж хатуу хяналттайгаар хэрэгжүүлэхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/-д даалгасугай.

3.Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

а.Түлээ нүүрсийг ард иргэдэд харьцангуй хямд үнээр бэлтгэн худалдах, шахмал түлш үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжин ажиллах;

б.Аргал хөрзөн түлэх, хийн түлш хэрэглэх асуудлаар сургалт сурталчилгаа хийж айл өрх, иргэдийн түлшинд модны хэрэглээг багасгахад чиглэсэн ажил зохион байгуулах;

в.Түлшний зарцуулалт багатай, утаагүй зуухаар айл өрхийг хангах арга хэмжээг одооноос дэс дараатай хэрэгжүүлж эхлэх;

4.Сүхбаатар хотын дулааны станц, дулааны шугам сүлжээг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргад даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 123

Сүхбаатар

**Аймгийн Аудитын газрын 2011 оны ажлын
тайлангийн тухай**

Төрийн Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтыг үндэслэн аймгийн Аудитын газрын 2011 оны ажлын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Аймгийн Аудитын газар 2011 онд аймгийн болон бүх сумын төсвийн тайлан, орон нутгийн өмчийн болон салбарын төсвийн 236 байгууллагын санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийж гүйцэтгэсэн, Үндэсний аудитын газрын захиалгаар болон өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн аудитын шалгалтыг 13 удаа хийж, 3,335,2 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлэн, 277,6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулахаар 53 акт, 3204,4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 29 албан шаардлага өгч актын биелэлтийг 67,4 хувиар, албан шаардлагын биелэлтийг 100 хувиар хангуулсан байна.

Аймгийн Ерөнхий аудитор Төрийн аудитын орон нутгийн байгууллагыг чадварлаг, шударга боловсон хүчнээр бэхжүүлэх, тэднийг сургаж дадлагажуулах, ажиллах нөхцөл боломжоор хангах талаар санаачилгатай ажиллаж үр дүнд хүрсэн байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Аймгийн Аудитын газраас 2011 онд хийсэн ажлыг хангалттай сайн гэж дүгнэсүгэй.

2.Ажлын ололт амжилтаа улам бататган Төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн ажлыг сайжруулан үрэлгэн зардлыг багасгах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарч, хяналт шалгалтын ажлаа чиглүүлэн ажиллахыг аймгийн Ерөнхий аудитор /Ч.Насанбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 124

Сүхбаатар

Ахмадын талаар авах зарим арга хэмжээний тухай

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн төв Сүхбаатар хотын нийтийн тээврийн /таксинаас бусад/ хэрэгслээр тус аймгийн харъяат ахмад настан /60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй/-уудад харъяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй үйлчилж байхаар тогтоосугай
2. Ахмад настан үнэ төлбөргүй зорчих болсонтой холбогдуулан шаардагдах зардлын тооцоог нарийвчлан хийж Тохижилт үйлчилгээний газрын жил бүрийн төсөвт тусгаж байхыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 125

Сүхбаатар

Барилга шилжүүлэх тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Сүхбаатар сумын “Сэлэнгэ-Эрчим” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1 дүгээр хавсралтанд дурдсан конторын зориулалттай барилга, дулаан болон цэвэр бохир усны шугам, нийтийн эзэмшлийн талбай зэрэг нийт 327419.2 мянган төгрөгийн хөрөнгийг “Сэлэнгэ энерго” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын балансад шилжүүлсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын
27-ны өдрийн 125 дугаар тогтоолын хавсралт

БАРИЛГА БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ

№	Байгууллага аж ахуйн нэр	Шилжүүлэх байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Ашиглалтанд орсон он	Дансны анхны үнэ /мян.төг/	Байгуулсан элэгдэл /мян.төг/	үлдэгдэл үнэ	Үндсэн байгууллагын санал	Аймгийн Засаг даргын санал	Аймгийн ИТХТ-ийн шийдвэр
1	Сэлэнгэ-Эрчим ОНӨААТҮГазар	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазарт	Конторын барилга	754м2	1978 он	322583,6	152904,6	169679	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
2	Сэлэнгэ-Эрчим ОНӨААТҮГазар	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазарт	Дулааны шугам	100м2	1997 он	2300,0	1297,2	702,8	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
3	Сэлэнгэ-Эрчим ОНӨААТҮГазар	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазарт	Цэвэр усны шугам	50м2	1997 он	230,0	129,7	100,3	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
4	Сэлэнгэ-Эрчим ОНӨААТҮГазар	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазарт	Бохир усны шугам	60м2	1997 он	372,0	209,8	162,2	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
5	Сэлэнгэ-Эрчим ОНӨААТҮГазар	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазарт	Зам талбай	808м2	1997 он	1008,0	483,8	524,2	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
6	Сэлэнгэ-Эрчим ОНӨААТҮГазар	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазарт	Торон хашаа	160м	1997 он	925,6	444,3	481,3	Шилжүүлэх	Шилжүүлэх	Шилжүүлэх
Дүн						327419,2					

**Сүлд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 12 сарын 27-ны өдөр

Дугаар 127

Сүхбаатар

Ашиглалтгүй барилгыг худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй хавсралтанд дурьдсан Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хуучин клубын зориулалтаар ашиглагдаж байсан барилгыг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч дуудлага худалдааны доод үнийг баталсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын
27-ны өдрийн 127 дугаар тогтоолын хавсралт

ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ БАРИЛГА

№	Байгууллага аж ахуйн нэр	Хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтанд орсон он	Дансны анхны үнэ /мян.төг/	Байгуулсан элэгдэл /мян.төг/	үлдэгдэл үнэ	Үндсэн байгууллагын санал	аймгийн Засаг даргын санал	Аймгийн ИТХТ-ийн шийдвэр
1	Хүдэр сумын Засаг даргын Тамгын газар	БАМ-ын модон барилга	1972 он	30068,5	22671,6	6585,1	дуудлага худалдаагаар худалдах	500.0 мянган төгрөгөөр Дуудлага худалдаагаар худалдах	500.0 мянган төгрөгөөр Дуудлага худалдаагаар худалдах

оОо